

АУДАЛ
ЯВДА

МИХАИЛ СЕРЕГИН

ӨР
ДАГАСАН
ДЭЭРЭМ

Өр дагасан дээрэм

Зохиолч: Михаил Серегин

Эрхлэн гаргасан: "Урлах Эрдэм" хэвлэлийн компани

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Оршил бүлэг

Машины шил арчигч савлан нүүрний шилэнд тасралтгүй буух борооны өтгөн дуслыг хаман зайлуулах болгонд хотын баргар дүр төрхийг тодруулан харагдуулах ажээ.

Үдшийн харуй бүрий болох үед хүмүүсийн бухимдлыг хөдөлгөж, тав тохийг алдагдуулам борооны жижигхэн ширхэг бүхий дусал хотыг бүхлээр нь хучин далдлах мэт. Валерий Лобников өөрийн шинэхэн “АУДИ”-г борооны усанд гялтганатлаа угаагдсан хар замаар хурдлуулж явлаа. Тэрээр зүүн гараараа жолоогоо барьж, баруун гараараа цувныхаа халааснаас гар утсаа гарган түрүүчийн дуудах гэж оролдсон дугаарыг давтан залгав. Энэ удаа утас нь ашгүй нэг залгагдан нэгэнт танил болсон Андрей Капустины дуу гарлаа.

-Валерий байна хэмээн Лобников бага зэрэг болгоомжилсон өнгөөр дуугараад Андрей чи сонсож бай. Энд юу болж байгааг чи мэдэж байна уу? Миний албан газар руу цагдаа нар нэгжлэг хийхээр дайрч орсон гэлээ.

-Мэдэж байна. Бүгдийг нь би мэдэж байна хэмээн Капустин бухимдан хариулаад хамгийн гол нь чи бүү сандар. Бүх юм зүгээр болно. Би сая энэ талаар зохих хүмүүст нь мэдэгдээд байгаа гэв.

-Юу гэсэн үг вэ? Чи хожуу мэдэгдсэн байна! Намайг бүх талаас минь довтолж эхэлсэн. Өнөөдөр гэхэд л миний “Ромакс”, “Брасск” гэдэг хоёр пүүсэнд минь халдлаа! гэж Лобников хилэгнэн хашгирав.

-Чи юундаа ингэж бачимдаж гайхаад байгаа юм бэ. Би чамд шалгалт ирнэ гэж сануулсан шүү дээ хэмээн Капустин түүнийг ойлгож ядан хариу хэллээ.

-Чи мужийн захиргаанаас ёс төдий шинжтэй үзлэг хийхээр ямар нэгэн комисс ирнэ гэж л надад хэлсэн шүү дээ гэж Лобников хэлээд, гэтэл намайг Москвагаас ирсэн прокуророор толгойлуулсан цагдаа болон Холбооны аюулгүйн албаныхнаас бүрдэх тусгай ангийнхан бусниулж орхиж байна. Ингэнэ гэж надад яагаад хэн ч урьдчилан сануулсангүй вэ? А? гэж асуулаа.

-Чи түүрүүний ярилцсан ёсоор пүүснүүдийнхээ данс бүртгэлийг далдалж амжсан биз? хэмээн Капустин түүний бухимдлыг анзаарсан шинжгүй асуув.

-Далдалж чадсан. Найдвартай газар нуусан гэж Лобников дурамжхан байдалтай хариу хэлэв.

-Сайн байна. Маш сайн! гэж Капустин санаа нь амран дуугарлаа.

-Энэ бол юуг ч өөрчлөхгүй. Юу болж байгааг би тодорхой мэдмээр байна хэмээн Лобников үргэлжлүүлэн шаардаад, өчигдөр би Лешка Петров руу ярьсан. Ээж нь түүнийг хоёр хоног гэртээ ирсэнгүй, утсаар ч ярьсангүй гэж хэлсэн гэв.

-Би түүнийг яасныг нь мэдэхгүй. Лешкатай мантай болоод байна гэж Капустин тайвнаар дуугараад тэр хаашаа л холдов гэж. Урьдын адил ямар нэгэн охин бяруутай зууралдаж хэвтээ

биз гэлээ.

-Тийм ээ, тэр тэгдэг. Гэвч онц шаардлага гарвал түүнийг хаанаас олж болохыг заавал мэдэгддэг байсан.

-Тэр удахгүй хаана байгаагаа мэдэгдэж л таараа. Харин би данс бүртгэлээ хаана нуусныг чинь мэдмээр байна гэж Капустин тайвнаар асуув.

-Харин би Лешка Петров хаана байгааг болон чи бизнесийн нэг түншээ алга болсонд яагаад санаа чинь зовохгүй байгааг мэдмээр байна?

-Валерий минь. Энэ бол утсаар ярилцаж болох асуудал биш хэмээн Андрей түүнийг тайтгаруулахыг хичээн хэлээд, чи тэр данс бүртгэлээ авах гэж очих манай хүмүүст өгөх хэрэгтэй. Чиний өөрийн чинь аюулгүй байдлыг хангах зорилгоор ингэж байгаа юм. Би ч гэсэн өөрийнхөө аюулгүй байдалд ингэж санаа тавина. Тэгсний дараа бид бүгдээрээ энэ ноцтой хэрэг намжтал энэ хотоос зайлж нуугдан хүлээх хэрэгтэй гэлээ.

-Энэ холион бантан чухам хаанаас эх үүсвэртэй, бидэнд ямар уршигтай болохыг бүрэн мэдэхээс нааш би данс бүртгэлүүдийг хэнд ч өгөхгүй хэмээн Лобников шийдмэг дуугаар хариу хэллээ.

-Энэ бол утсаар ярилцах асуудал биш гэж би хэлж байна шүү дээ. Бидний ажлыг өндөр албаны хүмүүс сонирхож байгаа. Тийм учраас тэд бид хоёрын яриаг чагнах бүрэн боломжтой...

-Тэгвэл бид хоёр тун яаралтай биеэр уулзах хэрэгтэй байна гэж Лобников хэлэв. Капустин хэсэг дуугүй байсны эцэст:

-Сайн байна. Одоо манайд хүрээд ир. Би Савицкийн гудамжин дахь байрандаа байгаа. Чи мэднэ биз гэлээ.

-Мэднэ...

-Би арван минутын дараа очсон байна. Энэ хугацаанд чи ирж амжих уу?

-Амжина гээд Валерий утсаа салгалаа.

Тэрээр замын хамгийн зүүн талын эгнээнд орж гудамжны нойтон замаар улам хурдтай давхилаа. Нөмрөн авч байгаа харанхуйтай тэмцэх зориулалттай гудамжны бүдэгхэн гэрэл бүх чадлаараа сүүмийх боловч тус багатай ажээ. Гудамжинд явган зорчигчид цөөн үзэгдэх бөгөөд тааралдсан зарим нь хүйтэн бороонд аль болох бага шавшуулахын тулд гэрийн зүг яаран шогшино. Лобников хааяа нэг тааралдах машиныг чадварлаг залан тойрч өөрийн “АУДИ”-г хөдөлгөөнгүй шахам болсон хотын гол замаар хурдлуулж явлаа. Гэвч товлосон цагт нь арайхийн амжиж ирлээ.

Савицкийн гудамж хотын захын нэгэн нойрмог дүүрэгт байдаг ажээ. Капустины байр байдаг есөн давхар тоосгон байшин тэг дөрвөлжин байдлаар баригдсан байх бөгөөд дунд нь

хүүхдийн тоглоомын талбай, машины зогсоол байна.

Лобников цэнхэр өнгийн “Мерседес” өмнө нь зогсож байгаа орц чиглэн машинаа залан хүрч очлоо. Тэрээр тэр машиныг хармагц Капустиных гэж таниад санаа нь амран тайвшрав. Лобников Капустин түүнийг хүлээн авч ярилцах юм гэж нэг их найдахгүй байсан юм.

Энэ өглөө толгойдоо хар торон баг углаж тусгай хувцас өмссөн автомат буу барьсан залуусыг дагуулсан энгийн хувцастай хүмүүс Лобниковын пүүсний албан газар хүрч ирснээс хойш Валерий Капустин руу угасдсаар байсан юм. Тэр энгийн хувцастай хүмүүс өөрсдийгөө прокурорын газрын ажилтнууд гэж танилцуулжээ. Тэд Лобниковын пүүстэй шууд харьцаатай байсан “Аркада” гэгч газрын тосны компанийн үйл ажиллагааны талаар эрүү үүсгэн шалгаж байгаа хэргийн хүрээнд энэ пүүсийн ажиллагааг шалгах зорилготой юм гэж тайлбарлаж байв.

Тэр комиссын бүрэлдэхүүнд зөвхөн прокурорын ажилтнуудаас гадна ФСБ-ийнхэн (Холбооны Аюулгүйн алба), МВД-ийнхэн (Дотоод хэргийн яам) оролцож явсан болохыг Лобников удалгүй мэдсэн юм. Энэ нь тэдний болон ажил төрлийн холбоотой түншүүдийн нь талаар тун ноцтой бөгөөд нухацтай хандаж эхэлснийг гэрчилж байв.

Энэ шалгалтын цаана Москва хотын тун өндөр албаны ноёд зогсож байгаа гэдэгт ч Лобников эргэлзэхгүй байлаа. Капустин болон түүний боссууд тийм хүчирхэг бүрэлдэхүүнтэй комисс гэнэтхэн хүрч ирнэ гэдгийг яагаад урьдчилан мэдэж чадсангүй вэ? Тэдний ард хэн зогсож байна вэ? Энэ шалгалт Лобниковын цаашдын хувь заяанд хэрхэн нөлөөлөх вэ? Эдгээр асуултад Капустин хариу өгөх ёстой.

...Лобников хөдөлгүүрийг унтрааж машинаас гарахыг завдаж байтал Андрей Капустин өөрөө орцноос гарч ирлээ. Тэрээр саарал өнгийн урт цув өмссөн байх агаад нэг гарт нь багавтар арьсан цүнх нөгөө гарт нь машины түлхүүр бариастай харагдана. Тэрээр эргэн тойрноо тэвдэнгүй хараад авснаа довжооны шатаар яаран буугаад машиндаа хүрч очлоо. Лобников машинаасаа гарч түүнийг дуудахыг завдтал гэнэтхэн Капустины “Мерседес”-ийн зүг ухасхийн хөдөлж байгаа саарал өнгийн “БМВ”-г харчих нь тэр. Валерий өөрийн машины дэргэд зогтусан зогсоод тэдний араас харж байв. “БМВ” хориод метр хэртэй яваад Капустины машинтай зэрэгцэн очиж огцом тоормозлов. Дараагийн агшинд Лобниковын сонсгол дөнгөж дуулдах төдий алгадах мэт чимээг хүлээж авсан юм.

Валерийн байгаа газраас машин руу нь нуруугаа харуулан зогсож байсан Капустин агдасхийснээ машины хаалганаас салганан шүүрч аваад аажмаар гэдэргээ саван ойчих нь сайн харагдаж байлаа. Дараачийн мөчид саарал өнгийн нэхмэл ноосон малгайтай савхин цамц өмссөн, намхавтар нуруутай нэгэн эр “БМВ”-ээс гарч ирэв. Лобников тэр хөлсний алуурчнаас арваад метрээс холгүй байсан боловч түүний царайг тогтоож амжсангүй. Зөвхөн утаан өнгөтэй том нүдний шил, нямбай янзалсан буурал сахал үсийг нь тогтоож авчээ.

Алуурчин өөрийн золионы үхдэлд хүрч очсоноо түүний цогцос руу дахин хяналтын сум тавьж орхилоо. Тэгснээ хурдан бөхийж үхдэлийн хажууд хэвгэж байгаа арьсан цүнхийг шүүрэн аваад гар буугаа таримал бут руу чулуудаж орхиод машиндаа яаран орж суув. Тэгснээ огцом ухасхийн Лобниковын дэргэдүүр асар өндөр хурдтай давхин өнгөрч байшингийн

хөндий рүү орж алга боллоо. Энэ явдал нэг минут хүрэхгүй хугацаанд болж өнгөрчээ.

Ямар нэгэн хэмжээгээр өөрийгөө буруутгах дотоод хүчинд захирагдан балмагдал айдсаа арайхийн дарж Лобников Капустины цогцос руу хүрч очив. Капустин цусан балчигт хутгалдан хэвтэнэ. Түүний баруун хөмсгөн дээрх хар нүх байгаагүйсэн бол Андрейн царай амгалан бөгөөд бүр баясгалантай мэт харагдах байлаа. Энэ үхлийн жижигхэн тэмдэг зөвхөн “Эндээс зугт. Маш түргэн зугт” гэх мэдрэмжийг Лобниковт төрүүлж байв.

Тэрээр машиндаа гүйж хүрээд хэдхэн мөчийн дараа гол гудамжинд гарч хаашаа явж байгаагаа ч мэдэх сөхөөгүй галзуурсан мэт давхиж явлаа. Аллага үйлдэгдсэн газраас хүрэлцэхүйц холдож зайлсныхаа дараа тэрээр хурдаа хасаж хотын нэгэн чимээгүй гудамжинд хүрч зогслоо. Лобников балмагдал нь бүрэн намжаагүй байсан боловч өнгөрсөн ойрын хэд хоногт болсон үйл явдлыг эргэцүүлж бодохыг оролдов. Яагаад түүнийг хөнөөх болов гэсэн гол асуулт түүнийг зовооно. Түүний балмагдал түгшүүр намжих явцад энэ бол “Аркада” хэмээх газрын тосны компанийн ерөнхийлөгч Олег Сатаровын ойрын хамсаатнуудын дэс дараатай хэрэгжүүлж байгаа ажлын нэг хэмээн улам тод томруун дүгнэлт гаргахад хүргэж байсан юм.

Андрей Капустин, Алексей Петров, өөрөө Лобников нар Сатаровын санхүүгийн бүлэг гэгчид харьяалагдаж байв. Өөрөөр хэлбэл мөнгөний нь урсгалыг хангаж байдаг онцгой ойр хүмүүсийн нь эгнээнд ордог байсан юм. Чухам тэд “Аркада” компанийн мөнгө дамжин эргэх үйлдвэрийн чухал газруудын холбоог зохицуулж өгдөг байлаа. Тэрээр Алексей Петров алагдсан гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байсан бөгөөд дараачийнх нь өөрөө гэдэгт ч мэдээж эргэлзээ байсангүй. Энэ аллагууд ганцхан Сатаровт хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой. “Байдал үнэхээр ноцтой болж байна” хэмээн Лобников тамхиа шуналтай сормогцоо түгшүүрлэн “Олег хөндлөнгийн гэрчүүдээсээ салахыг боджээ. Олег, Олег минь дээ. Чи дээрэмчин байсан. Дээрэмчин хэвээр үлджээ. Ямар ч өндөр албан тушаал чамайг өөрчилж чадсангүй. Чамайг бүр ийм алхам хийхэд хүргэсэн нь чам руу онц ноцтой мөрдлөг шалгалт ирж дээ. Бурхны аварлаар би өөрийн болон гэр бүлийнхээ аюулгүй байдалд санаа тавих цаг хугацаа одоохондоо надад байна” гэж бодож суулаа.

Валерий гар утсаа гарган залгаж эхнэрийнхээ дууг сонсмогц:

-Оленька, би байна аа! Намайг сонсож байна уу? хэмээн хашгирлаа.

-Сайн сонсож байна, хонгор минь. Ингэхэд чи хэзээ гэртээ ирэх хүн юм бэ? гэж эхнэр нь асуув.

-Өнөөдөр би гэртээ харихгүй нь гэж Лобников шийдмэг хариулав.

-Юу гэнэ ээ? Ойлгосонгүй. Бас л үйлдвэрлэлийн шаардлага гараа юу? гэж эхнэр нь дурамжхан дуугаар асуув.

-Намайг тун анхааралтай сонсож бай! Одоохон чи ойр зуурын шаардлагатай юмаа болон гэрт байгаа бүх мөнгө, үнэт эдлэлээ аваад Машкатайгаа тэндээс тун хурдан зайлж яв! хэмээн Лобников хатуу тушаав.

-Энэ чинь бас юун сонин хэрэг вэ? гэж эхнэр нь асуугаад, би тэгээд ямар учраас хаашаа явах болж байна? Бас Машаг чирээд шүү. Охин чинь аль хэдийнэ унтахаар орондоо орчихоод байна гэлээ.

-Олон юм асуулгүй тун хурдан миний хэлснээр хий! хэмээн Лобников зандран хашгирснаа бага зэрэг тайвшран, дөнгөж саяхан миний нүдэн дээр Андрей Капустиныг алчихлаа. Леха Петров ч алуулсан бололтой гэлээ.

-Бурхан минь! гэж цочирдож балмагдсан эхнэр нь хариу хэлэхийн завдал өгөлгүй Лобников:

-Би дараачийнх нь болохыг хүсэхгүй байна. Ийм учраас энэ хотоос маш хурдан зайлж явах хэрэгтэй гэв.

-Би тэгээд хаашаа явах юм бэ?

-Машиндаа дүүрэн бензин аваад Кировск дахь хадам ээждээ оч. Зам муу ч гэсэн чи өглөө гэхэд тэнд хүрсэн байна гэж бодож байна. Тэгээд үд хүртэл намайг хүлээж амарч ав. Хэрэв үд гэхэд намайг очихгүй бол Москва руу яв. Чи миний хуучин найз зураач Леша Хворостенког санаж байна уу? Бид хоёр жилийн өмнө тэднийд зочилж очсон шүү дээ...

-Тийм ээ! Санаж байна. Гэвч би гэрийн нь хаягийг мартаж орхиж...

-Миний тэмдэглэлийн дэвтэрт утасны нь дугаар байгаа. Түүн рүү ярьж хэд хоног гэртээ байлгахыг гуй. Тэр татгалзахгүй. байх гэж бодож байна. Энэ хугацаанд би өөрөө хүрч очих юм уу эсвэл өөрийнхөө тухай мэдэгдэнэ. Чи бүгдийг сайн ойлгов уу?

-Ойлголоо гэж Ольга хариулаад, харин чи хаана байх юм бэ? Би чиний төлөө их санаа зовж байна гэж асуулаа.

-Бүү санаа зов гэж Лобников инээн хариулаад би аюулгүй газар байгаа. Хамгийн гол нь та нарт муу юм бүү тохиолдоосой гэж санаа зовж байна гэлээ.

-Би бүгдийг чиний хэлснээр хийе гэж Ольга хариулав.

-За тэгвэл баяртай хонгор минь. Удахгүй уулзана гэдэгт би итгэж байна гээд Валерий үгээ дуусгав.

Тэрээр янжуураа сорсноо машины цонхоор хаяж орхиод “За яах вэ. Одоо би зарим нэгэн данс бүртгэлийн хадгалалт хамгаалалтад анхаарах хэрэгтэй болж байх шив дээ. Чухам тэр данс бүртгэлүүдээс болж Петров, Капустин нар амиа алдсан нь гарцаагүй. Тэгэхлээр чухам тэр данс бүртгэлүүд миний аюулгүй байдлын бамбай болж харин Сатаров болон түүний алуурчдад зориулсан жад хутга болох ёстой” гэж өөрөө өөртөө шүд зуун дуугарлаа. Тэгснээ машинаа асаан хотын өөр нэгэн дүүрэг рүү хөдлөв.

Лобников сарын өмнө Мясницкийн гудамжинд байх есөн давхар тоосгон байшинд хоёр өрөө байр хөлслөн авсан байжээ. Бас тэрээр өөрийн найз хүүхнүүдтэй уулзаж байх гэж янз бүрийн газар өрөө хөлслөн авдаг байсан юм. Дурлалын наадам дуусмагц тэр өрөөний

хөлсийг хэдэн сараар урьдчилан төлөөд зугаалуулсан хүүхнээ эндээ амьдарч болно гэж орхиод зайлж явдаг байв. Өөр хүүхэнтэй танилцмагц түүнд дахиад л өөр газар байр хөлслөн авахад хүрдэг байлаа. Гэвч Валерийн Мясницк дахь байр нь өөр зориулалттай юм. Энэ байрандаа тэрээр анх удаа мөнгөний эргэлтийн талаархи данс бүртгэлээ авчирчээ. Энэ данс бүртгэлүүдийг Капустины зөвлөсөн ёсоор шалгалтынхны гарт оруулахгүйн тулд энд авчирсан байв. Харин одоо эдгээрийг Сатароваас өөрөөс нь нуух хэрэг гарлаа. Гэвч түүний олон булхайн хэргүүдийн нууцыг хадгалагч нь Лобников биеэрээ байсан хэрэг.

Лобников арын суудал дээрээс арьсан “дипломат” шүүрэн аваад байшингийн орц руу яаран алхлаа. Энэ байшин бол дээдчүүлд зориулагдан шинэхэн баригдсан учир орцны хаалга нь тоон түлхүүртэй цоожтойгоос гадна дуут дохиоллоор тоногдсон ажээ. Лобников түлхүүр тоог дарж орцонд ороод хэдэн хормын дараа цахилгаан шатаар долоон давхарт гарсан байв. Тэрээр давхрын хүнгүй урт хонгилоор явсаар байрныхаа төмөр хаалганд хүрч очоод тусгай түлхүүрээр яаран онгойлгож орлоо. Энэ хөлсний байр нь тавилга муутай бөгөөд хоосон шахам хоёр том өрөөний нэгэнд том гэгчийн бичгийн ширээ, намхан урт сервант, жижиг буйдан, сандал зэрэг тавиастай байна. Энэ нь Лобниковын ажлын өрөө юм. Нөгөө өрөө нь унтлагынх бөгөөд хувцасны шүүгээ, хоёр хүний өргөн ор тавиастай ажээ.

Лобников ажлынхаа өрөөнд ормогц сервантын доод шургуулганы нэгийг татан данс бичиг баримт мэтийн цаас дүүрэн чихээстэй кардон хайрцаг гаргаж ирлээ. Дараа нь цуваа тайлж буйдан дээр чулуудаж орхиод зөөлөн сандал дээр тухлан суугаад тамхиа гарган асаалаа. Түүний мэдэлд бүтэн шөнийн хугацаа байгаа тул данс бүртгэлүүдийг ангилан ялгаж элбэг амжина. Өөртөө авч явах энд нь үлдээх гэж ялгах ёстой юм.

Маргааш өглөө эрт түүний бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бас нэгэн дүүрэн бичиг баримт хадгалагдаж байгаа Губерскийн худалдаа хөгжлийн банк орох ёстой байв. Энэ бол аль хэдийнэ устгавал зохих онц ноцтой данс бүртгэлүүд байсан боловч Лобников тэгээгүй юм. Лобников өөрийн нь өндөр ашигтай бизнесийн талаар хууль хяналтын байгууллагууд эрт орой хэзээ нэгэн цагт сонирхох болно гэдгийг сайн мэдэж байжээ. Ийм нөхцөл байдалд Сатаров мэтийн хүмүүс өөрийг нь илчилж өгч элбэг дөнгөнө гэдгийг ч мөн адил үгүйсгэхгүй байлаа. Чухам ийм учраас Валерий ямар нэгэн хэмжээгээр өөрийн нь аюулгүй байдлын баталгаа болж чадах данс бүртгэлүүдийг хадгалсаар байжээ.

Чинээлэг гэрт өсч өндийсөн тэрээр ямар нэгэн юмаар дутагдаж гачигдахыг мэддэггүй байв. Эцэг нь нэгэн цэрэг зэвсгийн томоохон үйлдвэрт ерөнхий инженерээр ажиллаж, эх нь бүх насаараа багшилж байгаад тэтгэвэртээ гарсан боловч сургуульдаа үлдэж сургалт хариуцсан эрхлэгчийн ажлыг хийж байжээ. Валерий өөрөө бүрэн дунд сургуулийг алтан медальтай төгсгөөд их сургуулийн тоо-физикийн ангид амархан элсэж орсон боловч бүр оюутан байхдаа ирээдүйд энэ мэргэжлээр ажиллаж чадахгүй гэдгээ ойлгожээ. Тэгээд сургуулийнхаа хэсэг оюутан нөхдийнхөө хамт бизнест хөдөлж эхэлсэн байна. Овсгоо самбаатай Лобников энэ ажилдаа хурдан амжилт олж эхэлсэн нь эцгийн танил талын холбоо их тус болсон нь мэдээж. Орос оронд шинэ тутам үүсэж байгаа бизнесийн ажиллагаанд хувийн жингээрээ тун их хэрэгтэй зуучлалын асуудлыг эрхлэх болжээ. Гүйлгээ ухаан сайтай тэрээр нилээд хөрөнгөжиж, үйлдвэр худалдааны хүрээнд зарим талаар нэр нөлөөтэй нэгэн болсон байна. Чухам энэ үед Лобников хотын нилээд нэртэй залуу бизнесмен Олег Сатаровын хараанд

өртсөн ажээ. Ухаалаг бөгөөд болгоомжтой Сатаров Лобников руу бүдүүлгээр халдахыг бодсонгүй.

Лобников болон түүний бизнесийг гарч болох эрсдэлээс хамгаалах үүрэг хүлээж хариуд нь хамтран ажиллахыг санал болгожээ. Лобников түүнтэй хамтран ажилласан өнгөрсөн он жилүүдэд залуу бизнесмены эрүүгийн үйл ажиллагаа зөвхөн сарнай цэцгээр бус бас цус нулимсаар чимэгдсэн байдгийг ажиглаж мэдсэн байна. Энэ үйл ажиллагаанд Лобников шууд хамааралгүй байсан бөгөөд энэ талаар бодож санаагаа зовоолгүй зөвхөн өөрийн бизнест анхаардаг байсан юм. Сатаровын амжилт нь түүний ажил хэрэгт эергээр нөлөөлдөг учир Лобниковын ажил бүтэмжтэй болдог байлаа. Магадгүй чухам ийм учраас Сатаров өөрт нь заналхийлэх хэрэг гарвал Валерийг шууд устгах юм гэж урьд нь санадаггүй байсан байж болно.

Лобников түгшүүртэй бодлоосоо арайхийн салж ширээн дээр тавиастай байх эхнэр охин хоёрынхоо жаазтай зураг руу хараагаа шилжүүлэв. Үнэн хэрэгтээ Лобников хэзээ ч тийм сайн өрхийн тэргүүн байгаагүй юм. Тэрээр залуу бизнесменүүдийн бүрэн эрхт нэгэн гишүүний хувьд тэдэнтэй хамт нэг бус удаа хөнгөн явдалтай охидтой цагийг зугаатай өнгөрөөдөг байлаа. Түүнээс гадна Лобниковоор ивээн тэтгүүлдэг нууц амрагууд ямагт байдаг ажээ. Тэрээр барууны орнуудад явж байсан өөрийн олон бизнесмен нөхдийн жишээгээр өөрийгөө журамтай бөгөөд нийгмийн зөв хүмүүжилтэй хүн мэт харагдуулахын тулд ингэж гэр бүлийнхээ жаазтай зургийг ажлынхаа ширээн дээр ил тавьдаг байсан юм. Саяхан таван нас хүрч байгаа охиныхоо өсөх бүрийд түүний аавыгаа хөгжилтэй ширтэх харц нь өөрт нь халуун бүлээн халамжийг бэлэглэж байх болсныг мэдрэх нь таатай санагдах болжээ. Лобников охиныхоо гэрэл зургийг хагас жил тутамд шинэчилж сольдог байв. Охин нь түүний ажлын ачааллын ядаргааг нь намжааж тайвшруулдаг ганц хүн нь, сэтгэл зүрхийг нь бүлээцүүлж өгдөг бяцхан үр нь байсан юм. Магадгүй зөвхөн энэ шалтгаанаар эхнэр Ольгатайгаа одоо хүртэл эвтэй найрсаг амьдарсаар байгаа ч юм бил үү. Ялангуяа сүүлийн жилүүдэд Валерий цагийг гэр орондоо өнгөрөөх нь улам ч цөөрөх болсон байлаа. Хэдийнээ эвдэрч нурсан мэт болсон гэр бүлийн амьдралын бат бөхийн шалгалтыг Валерий ямар ч гэсэн давж чадсан юм.

Харин одоо амьдралын хамгийн хүнд гэж хэлмээр хямралыг давж гарах болсон энэ үед гэр бүл нь хамгийн хэрэгтэй түшиг тулгуур болохыг Валерий өөрийн эрхгүй ухаарч байлаа. “Энэ хараал идсэн бизнесийг чөтгөр аваг! Ямар нэгэн амралт сувиллын нам гүмхэн хотод даруухан амьдрахад хүрэлцэх мөнгө байна. Эндхийн энэ байдал намжсаны дараа эргээд ирж болох юм. Одоо хамгийн гол нь эндээс аль болох хурдан тонилох нь чухал” гэж бодож сууснаа Валерий янжуураа үнсний саванд нухаж унтраагаад кардон хайрцагнаас эхний нэг хавтсыг гарган нээж үзэхээр завдаж байтал гар утас нь жингэнэлээ. “Утсаа салгаж орхих нь зөв байх” гэж юуны түүрүүнд санаанд нь орлоо. Гэвч Ольга ч байж болох тул тэгсэнгүй. Тэгээд ч Сатаровын хүмүүс байвал гар утсаар ярихад түүний хаана байгааг мэдэж чадахгүй.

-Таныг сонсож байна...

-Оройн мэнд Валерий гэх эрэгтэй хүний намуун жигд дуу сонсогдов. Дуу нь танил биш юм шиг сонсогдоход Валерий:

-Та хэн бэ? гэж асуулаа.

-Хэн байх нь чухал биш хэмээн тэр хүн хариулаад, Олегийн даалгавраар ярьж байна гэв.

-Сатаровын уу? гэж Валерий өөрийн эрхгүй асууж орхилоо.

-Тийм ээ. Сатаровын гэж хэлэх нь сонсогдоод Олег таныг өөрийнхөө пүүсний үйл ажиллагааны тухай бүх данс бүртгэлээ өөрт нь өгөхийг шаардаж байна гэж дамжуулаарай гэсэн юм. Тэр данс бүртгэлүүдээсээ аль болох хурдан салахыг танд урьдчилан сануулж байна гэв.

-Тийм ээ. Би яг түүний хэлснээр хийж байгаа хэмээн Лобников батлан хэлээд бүх юм хэлснээр нь болно гэж Олегт дамжуулаарай гэж хариуллаа.

-Яаж хэлснээр нь гэж? Та хэзээ тэр новшийн цааснуудаа бидэнд өгөх гэж байна? гэж тэр этгээд ширүүхэн асуугаад, бид тэр цааснуудыг чинь аваад өөрсдөө устгах болно гэв.

-Би тэр данс бүртгэлүүдээ маргааш өглөө та нарт дамжуулж өгнө гэж Лобников аль болох тайвнаар дугарахыг хичээн хариу хэллээ.

-Тэр цааснууд чинь яг одоо маш яаралтай хэрэгтэй байна гэх шаардангуй дуу сонсогдов.

-Одоо бүр шөнө болчихоод байна шүү дээ.

-Тэр хамаагүй. Та өөрөө хаана байгаагаа хэлчих. Бид өөрсдөө очиж авья гэж хэлэх нь тэр.

Байдал тодорхой. Тэр хүнд зөвхөн данс бүртгэл сонирхогдсонгүй. Тэр хүнд Лобниковын одоо байгаа газар илүү сонирхогдож байгаа нь тодорхой боллоо. Түүний одоо байгаа газар данс бүртгэл нь заавал хамт байх албагүй шүү дээ. Тэгэхлээр тэд яах зорилготой байгаа нь ойлгомжтой.

-Сайн байна гэж Лобников зөвшөөрөөд “Зангууны гинж” гэдэг шөнийн цэнгээний клубт хүрээд ир. Би таныг тэнд хүлээж байя. Үүдний жижүүрт өөрийгөө ирснийг мэдэгдэхэд чинь тэр миний байгаа өрөөнд хүргэж өгнө гэлээ. Нөгөө этгээд хариу хэлсэнгүй. Яриа дууссаныг Валерийд ойлгуулах мэт нилээд удаан байсны эцэст дахин гайхмаар хилэнтэй дуу гарч:

-Сонсож бай новш минь! Надтай чи муур хулгана болж тоглохыг бүү оролд. Чи миний ямар дэгээнд ороод байгаагаа мэдэж байна уу? Чи хар дарсан зүүдэндээ ч үзэхгүй гэж зандарлаа.

-Та юуны тухай ярьж байна вэ? хэмээн балмагдаж түгшсэн Лобников лавлан асуув.

-Энэний тухай ярьж байна. Одоо чи ойлгох болно гэж хорсолтой дуу сонсогдлоо. Гэтэл хэдэн хором чимээгүй болсноо Олегагийн сандруу дуу сонсогдох нь тэр.

-Валера минь... Биднийг гэрээс гармагц барьж авсан... Би эдний нэгийг нь ч мэдэхгүй. Тэдэнд чи хэрэгтэй гэнэ. Чи тэдэнд ямар нэгэн юм өгөх ёстой гэж байна гэж Ольга ярьснаа цөхөрсөн дуугаар:

-Валера минь. Тэдний хүссэн бүхнийг өгч орхи! Бид хоёрыг дарамтлан тамлахаар сүрдүүлж байна гэж гуйлаа.

Лобников айн сандарч:

-Машка хаана байна? Чамтай хамт байна уу? Охин яаж байна? гэж хашгиран асуув.

-Надтай хамт энд байна гэж Ольга хариулаад энэ хүмүүс чамайг өгөх ёстой юмаа өгөхгүй бол чинь бид хоёрыг ... гэж хэлээд үгээ дуусгалгүй уйлж орхих нь сонсогдов.

Энэ мөчид хүүхнээс утсыг нь авсан бололтой дахин үл таних жигд заналхийлэх дуу сонсогдлоо. Дөнгөж саяхан хилэгнэн хашгирч байсан тэр хүн ийм хурдан хэрхэн тайвширсан нь Лобниковын гайхлыг бага зэрэг төрүүлж байв.

-Чи намайг анхааралтай сонсож бай, Валерий минь гэж тэрээр анхааруулаад чи одоо байгаа газрынхаа хаягийг хэл. Тэгээд тэндээ бидний очтол хүлээж бай. Бүх данс бүртгэлийг бидэнд өгсний чинь дараа эхнэр хүүхдийг чинь тавьж явуулна. Тэгээд ч тэднээ аваад энэ хотоос холдож далд орж үз. Сатаров ингэхийг чинь хүсэж байна. Хэрэв чи зальдаж бултахыг оролдвол өөрт чинь болон эхнэр хүүхдэд чинь тун эвгүй юм болно гэдгийг санаж ав. Бид тэднийг чинь хэсэг хэсгээр нь тасчаад, төрөл төрөгсдөд чинь илгээх болно гэж сүрдүүллээ. Тэгээд дахин хэдэн мөч чимээгүй болсноо:

-Валера, хэрэв чи миний хэлсэн үгэнд эргэлзэж байгаа бол одоохон би үнэн юм ярьж байгаагаа батлаад өгье ... Гриня тэр охиныг нааш нь чирээд авчир гэх дуу сонсогдох нь тэр. Лобников утсанд хүүхдийн зүрх зүсэм чарлах дуу сонсогдоход тэрээр галзуурсан мэт чанга дуугаар:

-Үгүй ээ! Сонсож бай! Хүүхдээр бүү оролд! Би хаашаа ч зайлахгүй. Та нарыг хүлээж байя! гэж хашгирлаа.

Дахин дээрэмчин хүний дээрэнгүй жигд дуу гарч:

-За тэр дээ. Яг одоо байгаа газрынхаа хаягийг хэлээд орхи. Бидэнд чиний тэр уулзахаар санал болгосон оромж чинь хэрэггүй гэлээ. Лобников өөрийнхөө энэ байрны хаягийг өөрийн эрхгүй хэлж өглөө.

-Маш сайн. Бид цагийн дараа гэхэд очсон байна гэж тэр хүн хэлээд утсаа салгалаа.

Утсанд нь хэсэг хугацаанд дохионы тасархай дуу гарсаар байсан боловч Валерийд түүнийг сонсох тэнхээ байсангүй. Энэ мөчид тэрээр өөрийгөө нэгэнт үхдэл болсон гэж ухааран бодлоо. Энэ бол хачирхалтай мэдрэмж байсан юм. Одоо тэрээр амьсгалж, явж, тамхилж тэр ч бүү хэл эндээс зайлж чадах боловч тэгж болохгүй, Андрей Капустины хойноос явах боллоо гэдгийг дотоод мэдрэмж нь ойлгуулсаар байв. Бүр тавхан минутын өмнө Андрей Капустины үхэл түүнд айсуй аюулыг эмгэнэлт байдлаар урьдчилан сануулснаар аз боллоо гэж Лобников бодож байсан билээ. Гэвч бүх юм эсрэгээр эргэлээ.

Сатаровын алуурчид өөрөөс нь өрсөн хөдөлж Лобниковын төлөвлөгөөг урьдчилан мэдсэнээр ийнхүү сүйрэлд хүргэлээ. Валерий салганан хөдөлж найган явсаар зөөлөн сандал дээр очиж шигдэн суув. “Амьд байх хугацаа минь нэг цаг үлдлээ”. Энэ бодол толгойд нь эргэлдсээр гарцаагүй үхлийн айдас тархи толгойд нь улам хүчтэй нэвчсээр байлаа. Тэрээр эхнэр охин хоёрынхоо зургийг өрөвдөн гашуудаж ширтэнэ. Эхнэрийн нь нүдэнд ямар нэгэн үл ойлгогдох хэдэр өнгө ажиглагдах боловч охин нь урьдын адил гэнэн цайлганаар аавыгаа ширтэнэ. Лобников охиныхоо энэ өхөөрдөм царайг хараад өөрийгөө эндээс хаашаа ч явж чадахгүй, зөвхөн алуурчдыг хүлээж байх болно гэдгээ сайн ойлгож байсан юм. Энэ шийдэл нь Лобниковоос багагүй эр зориг, сэтгэлийн хүч тэнхээг шаардаж байсан боловч түүний сэтгэл мэдрэл тэсвэрлэж чадахгүйд хүрч байлаа. Тэрээр агдасхийн хуруунуудынхаа үеийг шажигнатал сандлын хажуу түшлэгийг атган базсанаа нүдээ аньж бараг ямар ч чимээ гаргалгүй нүднийхээ нулимсыг унагаж байв.

* * *

Утасны дуудлагын чимээ түүнийг цочроон энэхүү хямралын байдлаас дахин эргүүлж гаргав. Тэрээр нүдээ нээж гар утас руугаа ширтлээ. “За ингээд гүйцээ. Тэд ирэв бололтой” хэмээн Валерий өөрийн эрхгүй бодоод утсыг яаралгүй авч мөн адил яаралгүй чихэндээ ойртуулан:

-Би сонсож байна хэмээн бувтнав.

-Сайн уу, Валерий? гэх дуу утасны нөгөө үзүүрт сонсогдоод чи тэндээ байсаар л байна уу? Үнэнээ хэлэхэд би чамайг зайлж зугтсан байх гэж бодож байсан юм гэх нь Лобниковт тэр хүний дуу танил юм шиг санагдлаа.

-Та хэн бэ?

-Танихгүй байна уу? гэж нөгөө хүн асуугаад, гэвч энэ чинь чиний энэ байдалд байж болох л зүйл. За тэр яах вэ. Чи наанаа сууж бай. Би одоо дээшээ гарч чам дээр очно. Бид хоёрт ярих юм байна. Харин чи ямар нэгэн илбийн номер үзүүлэх гэж оролдож миний болон өөрийнхөө байдлыг бүү хүндрүүлээрэй гэж тохирье гэлээ.

Яриа дуусаж Лобников энэ бага зэрэг паргиа бүдүүн дуу хэнийх байдаг билээ гэдгийг санаж ядсаар суулаа. Цаг явсаар Лобниковт бараг арваад минут өнгөрөх мэт санагдана. Үнэн хэрэгтээ цахилгаан шатны бүхээгийн хаалга онгойх чимээ дуулдах хүртэл ганц минут ч болоогүй байсан юм. Хэдэн хормын дараа түгжээтэй байсан хаалганы цоож тожигнох чимээ гарснаа богино хонгилоор яаралгүй алхах хөлийн чимээ гарч орцны тасалгаанд хар жийнсэн өмдтэй хар савхин цамц өмссөн нэгэн хүний дүрс үзэгдлээ. Энэ бол дунд зэргийн нуруутай өргөн булиа цээжтэй шөрмөслөг байрын эр байлаа. Ирсэн зочин харанхуй хонгилоор алхалсаар бүдэг гэрэлтэй өрөөнд нь орж ирэв.

-Владимир? Полунин? хэмээн Лобников гайхан дуу алдав. Эндүүрсэнгүй гэдэгтээ итгэж болно гэж тэрээр инээд алдан хэлээд ширээнд нь дөхөж ирлээ.

Лобников буруу таниагүй байсан бөгөөд тэр хүнд ямар нэгэн өөрчлөлт гарсныг мэдэхийг хүсэх мэт нүүрийг нь дуугүй ширтэж суулаа. Хамгийн сүүлд уулзсанаас хойшхи хоёр жилийн

хугацаанд тэр хүн гаднах төрхөөрөө өөрчлөгдсөнгүй бололтой. “Буурал” хэмээх нэр авахад хүргэсэн буурал халимагаа богинохон тайрч янзалсан тэрээр зөвхөн нүүрэн дээрх хүнхэр хар нүдээрээ анхааралтай бөгөөд бага зэрэг инээвхийлэн сонжин ширтэх ажээ. Гэвч нүүрний нь ерөнхий байдал бага зэрэг өөрчлөгдөн ядарч суларсны шинжтэйгээс гадна чухал бөгөөд хүнд хүчир том ажлыг төгс хэрэгжүүлэхээр зориг шулуудаж яваа шийдмэг төрхийг илэрхийлж байлаа.

-Чи ийшээ яаж орж ирэв? Хаалга түгжээтэй байгаагүй бил үү? гэж Лобников асуув.

Владимир инээд алдаад:

-Тийм ээ. Хаалга чинь цоожоороо түгжээтэй байсан. Харин чи хэнтэй ярьж байгаагаа ойлгосонгүй эсвэл мартсан бололтой. Би чинь хулгайч, эрүүгийн хэрэгтэн биш бил үү. Бусдын цоожтой хаалгыг онгойлгох нь миний үндсэн мэргэжлийн нэг юм. Чиний хаалганд ямар түгжээ суулгах нь надад хамаагүй. Тэр цоож хийсэн хүн чинь найдвартай түгжээтэй болсон гэж чамайг хуурсан хэрэг гэж хэллээ.

-Чи олон зүйлийг үйлдэж чадах учир би заримыг нь мартаж орхижээ хэмээн Лобников зөрүүдлэн хэлээд, чи хоригдол байсан. Дараа нь бизнес эрхлэх болсон. Тодруулбал автомашин засварлаж бас борлуулдаг байсан. Тэдгээрийг чи амархан шиг хулгайлж махлан зардаг байсан гэх яриа ч гардаг байв. Харин дараа нь чи хотын нэгэн том үйлдвэрийн эзэн болж их нэр хүнд олж байснаа сүүлд нь зүгээр л нэг тэнэмэл амьтан болсныг чинь би мэднэ гэж ярилаа. Тэгснээ Лобников үргэлжлүүлэн:

-Олон хүн чамайг аль хэдийнэ үхсэнд тооцож байхад харин чи манай хязгаар нутагт дахин гарч ирлээ... Бүр хөлсний алуурчны шинэ мэргэжил эзэмшээд шүү гэж ярив. Валерий өмнө нь зогсож байгаа Полунинг духуйн ширтэж байснаа гэнэтхэн түүн рүү дөхөж очоод:

-Намайг алуулахаар Сатаров чамайг явуулаа биз? гэж хилэгнэн асуулаа. Лобниковын огцом хөдөлгөөнөөс болж Полунин хоромхон зуур нурууныхаа ар руу гараа явуулж тэлээнийхээ цаана нуусан “ТТ”-г гарган нүүр рүү нь онилоод:

-Суу, бүү хөдөл! Илбэ үзүүлсний хэрэггүй гэж би сануулсан гэж зандрав. Онилоостой гар бууг хармагц Лобников өөрийн мэдэлгүй ухарсан боловч алуурчинг үзэн ядах харцаар ширтсээр байлаа. Лобниковын номхорсон байдлыг хараад Полунин буугаа далд хийж

-Валера чи намайг муу мэдэж байна. Учир нь гэвэл намайг аль хэдийнээ хэн ч хаашаа ч явуулахгүй болсон. Олон жилийн өмнө хамгийн сүүлд шүүхээс надад модны ажилд цөлөх ял оноосноос хойш би хаашаа явж юу хийхээ өөрөө мэддэг болсон юм гэлээ.

-Худал бүү ярь! Гөлөг минь хэмээн Лобников шүд зуун дуугараад, та нар Сатаровын даалгавраар эхнэр хүүхдийг минь барьцаанд авсан. Чи миний эмзэг талыг бүгдээс илүү мэднэ. Чи өөрөө нэгэн үед гэр бүлээсээ хагацаж байсан хүн. Одоо бусдыг өөр шигээ болгохыг хүсээ юу гэж асуулаа.

-Амаа хамхи, тэнэг амьтан! гэж Полунин бүдүүлгээр зандраад, энэ байдлаасаа болж ухаан

мэдрэл чинь самуурч байна. Тэгээд чи намайг Сатаровын даалгавраар хүрч ирлээ гэж бодож байна гэлээ.

-Тэгээд? Чи тэгвэл тэгээгүй юм уу? гэж Лобников хорсолтой инээмсэглэн асуулаа.

-Валера чи надаар ямар нэгэн чөтгөр хийх гэж бүү оролд гээд Полунин ширээний буланд хажуулдан сууснаа, нэгд би хэнд ч хөлслөгдөж байгаагүй. Хойшид ч хөлслөгдөхгүй. Хоёрт би чиний эхнэр болон балчир охиныг чинь барьцаанд авна гэж төсөөлж ч чадахгүй. Намайг Сатаровт хөлслөгдөн ажиллаж байна гэж санасан хүн бол жинхэнэ шувтарсан новш байж таарна. Чиний болон миний хүзүүнд чулуу дүүжлээд усанд хаях хүнд Сатаров чамгүй хөлс төлнө гэдэгт би эргэлзэхгүй байна гэлээ.

-Тэгвэл миний гэр бүлийг олзолж барьцаалсан нь чиний ажил биш гэж үү? хэмээн түүний хэлсэн үгэнд мэл гайхсан Лобников дуу алдан асуув.

-Биш гэдгийг би чамд дахин хэлье гэж Полунин цөхөрсөн дуугаар хариу хэллээ. Валерий хэлсэн үгийг нь цэгнэн хэдэн хором дуугүй сууснаа:

-Тэгвэл миний гэр бүлийг барьцаанд авсан болон би энд юу хүлээж байгааг минь чи яаж мэдээ вэ? гэж асуулаа. Полунин Лобниковын гайхсан царайг харж дахин инээд алдаад:

-Заримыг нь чи өөрөө надад хэлж өгсөн. Эхнэр хүүхдэд чинь юу тохиолдсон болон чи өөрөө ямар нэгэн хүмүүсийг хүлээж ухаан алдталаа айж суугааг чинь би хараад мэдсэн. Харин энд байгааг чинь... гээд Полунин хэдэн хором дуугүй бодлогоширч байснаа, ер нь чамайг ингэж зовоогоод яахав гэлээ. Тэгснээ Лобниковын хувьд санаандгүй юм болж Полунин зүүн гараараа ширээний чийдэн авч суурийг нь хазайлган түүнд харуулав. Чийдэнгийн сууринд цамцны жирийн товчноос томгүй хэмжээний микрофон бэхлээтэй байх нь тэр.

-Би чамайг мөрдөж байсан юм гэж Полунин үүнийгээ тайлбарлав.

-Мөрдөж байсан гэж Лобников түүний үгийг өөрийн мэдэлгүй давтаад чийдэнгийн суурийг гайхан ширтсэнээ яагаад тэр билээ? Чи надаар яах гэсэн юм бэ? гэж асуулаа.

-Чиний энэ асуултад хариулах нь тийм ч амар биш гэж Полунин хэлээд чийдэнг байранд нь эргүүлж тавимагц:

-Хамгийн товчоор хэлэхэд энэ данс бүртгэл чинь надад хэрэгтэй. Тун удахгүй энэ цааснуудын чинь төлөө хот даяар жинхэнэ ангуучлал болно гэдэгт би эргэлзэхгүй байна гээд хавгаснууд байгаа кардон хайрцаг руу толгой дохилоо.

Полунин хайрцагнаас нэг хавтсыг авч онгойлгоод чанга дуугаар:

-”Ромакс” пүүсний тавдугаар сарын төлбөрийн данс гэж уншлаа. Тэгснээ хуудсуудыг нь эргүүлж үзэв.

Тийм ээ. Овоо юм энд байх чинь. Үнэн байдлыг эргэцүүлэн бодоход чухам энэ мөнгө хилийн чанад дахь хуурамч тооцоонд төлөгдөж дараагаар нь татваргүй зоонд замхран жинхэнэ

дансанд орж ирдэг. Тодорхой хүний нэрийн дансанд шүү дээ гэж Полунин хэллээ.

-Чи тэгэхлээр хэний төлөө ажиллаж байгаа юм бэ? гэж Лобников түүнийг зэвүүнээр ширтэн асуув.

-Чиний энэ асуултын хариу тун олон хүнд сонирхогдох байх гэж Полунин инээмсэглэн хариулаад, би чамд нуулгүй үнэнээ хэлье. Би зөвхөн өөрийнхөө төлөө ажиллаж байна. Энэ данс бүртгэлүүд юуны өмнө надад өөрт минь хэрэгтэй гэлээ.

Валера түүнийг духуйн ширтэж дуугүй сонсож суулаа. Тэр хүн яриагаа дуусгасны дараа Лобников шийдмэгээр:

-Би чамд энэ данс бүртгэлүүдээс нэгийг нь ч өгөхгүй гэлээ.

Полунин инээд алдан халааснаасаа хайрцаг тамхи, асаагуур гаргаж янжуураа асаан сороод утааг нь Лобниковын нүүр рүү үлээн гаргаад:

-Харамсалтай нь энэ асуудлыг одоо чи шийдэхгүй. Бүх данс бүртгэлийг би өөртөө авна. Тэр чамд хойшид хэрэг болохгүй гэв.

-Би өгөхгүй гэж хэлж байна шүү дээ хэмээн Лобников хашгираад одоохон энэ цааснуудыг авахаар хүмүүс ирнэ. Чи тэдэнд саад хийж чадахгүй гэлээ. Ингэж хэлээд Лобников түүний эсрэг хажуугаараа хараад сууж байгаа Полунин руу дайрч савхин цамцны нь энгэрээс шүүрэн барьж шалан дээр унагахыг оролдлоо. Гэвч түүнийг ингэнэ гэдгийг Полунин тааварлаж байсан бололтой гарыг нь сурамгай гэгчээр шүүрэн авч ард нь эргүүлээд нүүрээр нь ширээн дээр дарж орхилоо.

-Чөтгөр гэж! хэмээн Полунин инээд алдсанаа, өөрийг нь алахаар завдаж буй хүнийг хамгаалах гэж ингэж улайран тэмцэж байгаа хүнтэй би анх удаа тааралдаж байна гэлээ. Дараа нь Полунин гарыг нь тавьж цувны энгэр тэлээ хоёроос нь атган барьж ширээнээс ховх татан өргөөд эсэргүүцэхээр оролдож ядан тийчигнэж байгаа мань эрийг өрөөн дотуур чирэн буйдан дээр аваачин чулуудаж орхилоо.

-Тэнэг минь! Чи дахин дүрсгүйтвэл чинь би хүлж орхино гэж Полунин зандран сануулаад Лобниковын зүг янжуур хавчуулсан хоёр хуруугаараа чичлээ. Тэрээр түүнийг ширээн дээр дарж байхдаа хүртэл янжуураа амандаа зуусан хэвээр байсан юм.

-Намайг одоо алчих хэмээн Лобников арга тасарсан дорой дуугаар хэлээд яагаад гэвэл одоо хүрээд ирэх гэж байгаа хүмүүс тэр данс бүртгэлүүд алга болсныг мэдмэгц тэртээ тэргүй эхнэр хүүхдийг минь тарчлаан устгах болно гээд Полунинг үзэн ядаж ширтлээ. Тэгснээ:

-Үнэн хэрэгтээ энэ цааснууд чамд огт хэрэггүй. Чи дээр үед өөртөө болон гэр бүлдээ тохиолдсон тэр явдал бусад хүнд тухайлбал надад тохиолдоосой гэсэндээ ингэж байна гэлээ.

Полунингийн нүүрэн дээрх мэдэгдэм төдий баясгалан арчсан мэт алга болж нүүрний нь булчингууд татганан нүдэнд нь хилэнгийн туяа татаад явчихлаа.

-Чи үнэхээр мунхаг амьтан юм Валера! Чи тэдгээр хөлдүүснүүдэд данс бүртгэлүүдээ өгснөөрөө эхнэр хүүхдээ аварна гэж үнэхээр бодоогүй биз! гэж ширүүн зандраад, тэд чинь гэрчүүдийг зүгээр нэг орхичихдоггүй юм гэлээ. Тэрээр янжуураа хүчтэй сорж хэсэг дуугүй болсноо эргэж тайван дуугаар:

-Чи хэнтэй учирч ямар байдалд ороод байгаагаа гүйцэд ойлгоогүй юм шиг байна. Үхлийн торонд орчхоод байгаа хүмүүс энэрэнгүй сэтгэл гаргаж хүнийг өрөвдөнө гэж бүү бод. Энэ торноос мултарч гарахын тулд тэд хэнийг ч хайрлахгүй гэж тайлбарлав.

-Чи тэгээд юу хэлэх гээд байгаа юм бэ?

-Тийм хэмжээний мөнгөний хэрэгт тоглоом огт өөрөөр өрнөх болно гэдгийг би хэлэх гээд байгаа юм гэж Полунин дахин бухимдан хэлээд, амьд үлдсэн нь ялагч болдог. Ийм нөхцөлд ямар ч хүмүүнлиг зан хэрэггүй гэв.

-Тэгвэл би яах ёстой юм бэ? хэмээн Лобников бачимдан сандарч асуув. Тэрээр гэнэтхэн Полунингийн нүүрэнд дайсны бус холбоотны өнгө тодорч байгааг ажиглах шиг боллоо. Полунингийн энэ байдал тэр урилгагүй зочид ирэх үед өөрийн ойр дотнын хүмүүсээ аварч болох боломж гарна гэдгийг хэлж өгч байгаа мэт Лобниковт санагдлаа.

-Яах ёстой вэ гэвэл үү? гэж Полунин мөрөө хавчин өөрөө өөртөө мэт дуугараад, тэднийг чинь хүлээнэ гэв.

-Яаж хүлээх гэж?

-Юу яаж гэж? хэмээн Полунин ойлгож ядан асуув.

-Миний яах гэж хүлээх нь тодорхой. Харин чи яагаад тэднийг хүлээх гээ вэ? гэж Лобников асуулаа.

Полунин хариу хэлэлгүй эргэж ширээ рүү очоод Лобниковын сууж байсан зөөлөн сандалд шигдэн суугаад гар буу гарган ширээн дээр торхийтэл тавих нь тэр.

-Би тэдэнтэй жич яриатай гэж тэрээр сандлын түшлэгийг налан дуугарлаа. Лобников буу руу сэжиглэн харснаа Полунин руу хараагаа шилжүүлэн:

-Чиний тэдэнтэй ярих ярианд чинь буу хэрэгтэй юм уу? гэж бага зэрэг инээмсэглэх аядан асуув.

-Би тэдний мэдэх хэлээр ярилцана. Эс тэгвэл ярианы маань үр дүн бидний эсрэг гарах болно хэмээн Полунин хөмсөг зангидан хариу хэллээ.

Лобников бухимдан гүн амьсгаа авснаа бугуйн цагаа хараад тамхиа гарган чичирхийлсэн гараар асааж сорлоо. Полунин түүнийг ширтсээр суух ажээ.

-Чамд өнөөдөр хүндхэн өдөр боллоо хэмээн тэрээр хэлээд, ийм өдрийг насан туршид мартдаггүй юм гэлээ.

-Надад тэгэх хувь заяа байхгүй биз гэж Лобников уруу царайлан ядрангуй дуугарав.

-Харин надад тийм өдрүүд бишгүй л тохиолдож байлаа гэж Полунин түүний хэлснийг үл ойшоон хэлээд, хагас жилийн өмнө тийм нэгэн өдөр миний амьдралыг орвонгоор нь эргүүлсэн явдал болсон юм. Тэр хүртэл надад хань бүл, гэр орон, эрхлэх ажил, хөрөнгө мөнгө цөм байсан юм. Гэвч тэр бүгд маань хоромхон зуур алга болсон. Тэгээд би бүхнээсээ хагацаж бусдын нэрээр амь зуух хөөгдмөл тэнүүлчин болж хувирсан билээ гэж ярилаа. Тэгснээ чимээгүй болж өмнө нь ширээн дээр тавиастай байгаа данс бүртгэлийн кардон хайрцгийг ширтсээр байв. Тэрээр цааш нь:

-Чи ойлгож байна уу?. Би чухам хаана юун дээр алдаж ийм байдалд хүрэв гэж заримдаа боддог юм. Магадгүй миний хувьд хүршгүй тэр хараал идсэн “Нефть-оргсинтез” хэмээх үйлдвэрийн ашгийг хуваалцах гэж оролдсоноос болов уу. Бас магадгүй бизнесийн найдваргүй түншүүдтээ хэт их итгэл хүлээлгэсний уршиг юм болов уу. Энэ бол өөрийн алдаанд хамгийн өндөр хөлс төлдөг орос хүний хувь заяа намайг тойрч гараагүй хэрэг байх л даа гэж яриад дахин дуугаа хураалаа.

Тэр хүний бодлогоширсон харц өөрийг нь ийм эмгэнэлт байдалд хүргэсэн тэр нүгэлт алдааг цаг хугацааны зузаан давхрааг нэвт харан эрэх мэт бага зэрэг цөхөрөнгө бөгөөд гунигтай харагдах ажээ.

Нэгдүгээр бүлэг

Полунин өөрийн найз, бизнесийн түнш “Самбист” хэмээх хочтой Антон Сеницыны гэрт нь хүрч ирсэн тэр нэгэн амралтын өдрийг байн байн эргэж санадаг байсан юм. Антон бол хотын рэкетир-дарамтлагчдын томхон бүлгийн нэгэн толгойлогч байсан юм. Полунин түүний эрүүгийн бизнестэй шууд харьцаагүй байсан боловч зарим нэгэн хуулиар зөвшөөрөгдсөн төсөл хэрэгжүүлэх талаар хамтран ажилладаг байв.

Полунингийн сүүлийн арван жил эрхэлж ирсэн бизнес бол автомашиныг хулгайлан худалдах ажил байлаа. Үүнийг тэрээр өөрийн зөвшөөрөгдсөн бизнесийн халхавчин доор хийдэг байв. Учир нь тэрээр автомашины техникийн үйлчилгээний томоохон станцаас гадна шинэ болон сэргээн засварласан автомашины үзэсгэлэн худалдааны захыг албан ёсоор эзэмшдэг байв.

Полунин Сеницын хоёрыг хуулийн ижилхэн асуудал холбож байснаас гадна Полунин “Самбист”-ын сайн нөхөр, ерөнхий зөвлөх байсан ажээ. Полунин зөвлөгөөг авалгүйгээр Сеницын бараг нэг ч томоохон асуудлыг бие даан шийдвэрлэдэггүй байсан юм. Полунин Сеницынээс бараг арваад насны ах бөгөөд амьдралын туршлага илүүтэй хүн байлаа. Тэрээр шорон гянданд ч чамлахааргүй хугацаатай сууж хашир сууж юм үзсэн толгой ажээ. Мөн Полунин хотын захиргаа, хууль хяналтын байгууллагатай муугүй харьцаатай байсан юм. Иймээс тэр хоёрын түншлэл хэн хэндээ ашигтай байв.

Полунин хотын эрүүгийн ертөнцийн этгээдүүдтэй ямар нэгэн шөргөлцөөнгүй байдаг байв. Түүний ар талд Самбистын хүчирхэг бүлэглэл байдгийг тэд цөм мэддэг байв. Сеницын ч гэсэн өөрийн ухаалаг бөгөөд нэр хүндтэй зөвлөгч - түншийнхээ ачаар хот дахь нэр нөлөөллөө аажмаар нилээд дээшлүүлж чаджээ. Полунин өөрийн нэр хүндээс гадна аливаа хэцүү сөргөлдөөн маргаантай асуудлыг зөв шийдвэрлэж чаддагаараа бусдаасаа ялгагдана. Эрүүгийнхэн өөрсдийн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд түүнийг маргаан таслагч шүүгч маягаар нэг бус удаа урьж ирүүлдэг ажээ.

Энэ бүхнээс гадна Полунин Сеницын хоёр нэг байшингийн зэрэгцээ орцонд хөршлөн амьдардаг байсан бөгөөд Антон Сеницын Полунингийн байнга ирж дэмий хөөрөлдөж цаг нөхцөөдөг жирийн сайн найзууд байсан юм.

...Долоодугаар сарын тэр нэгэн орой зургаан цагийн орчимд Антон нийлэг уутанд хөнгөн зууш, хэдэн лааз шар айраг хийгээд Полунингийн зочилж ирсэн юм. Хоёр найз шар айрагнаас хатуу ундааг хэрэглэдэггүй байсан юм. Полунин олон жил ходоодны эмгэгээр шаналж явсан тул согтууруулах ундааг үл хэрэглэнэ. Антон Сеницын бол самбо барилдааны спортын мастер цолтой хүн бөгөөд үүгээрээ ч Самбист гэдэг хочтой болж спиртийн төрлийн ундаанаас зайлсхийж явдаг байлаа. Тиймээс ч тэрээр өөрийн багт хатуу сахилга журам тогтоож согтууруулах ундаанд ойртуулдаггүй байв.

-Мэнд үү, Иваныч хэмээн Сеницын хаалга онгойлгож өгсөн Полунинд хандан хөгжилтэйгөөр мэндлээд:

-Алив бага зэрэг шар айргаар зугаацаж хажуугаар нь зарим нэгэн ажил ярья гэлээ.

-Гал тогоонд орё гэж Полунин уриад би гэртээ ганцаараа байгаа, Анна хүүтэйгээ хамт салхинд гарсан гэв.

-Чи өөрөө яагаад тэдэнтэйгээ хамт гараагүй юм бэ? гэж Антон өрөөнд орох зуураа асуугаад авчирсан юмаа ширээн дээр гаргаж тавилаа.

-Залхуу хүрээд гэж Полунин гараа савчин хариулаад сүүлийн саруудад зугаалахаар гарахаа бараг больсон доо. Үүндээ ч дасчихаж гэв.

-Өөрөө л мэд, Иваныч залхурсаар байгаад гэрийн манаач болчихов доо гэж Самбист инээд алдан сануулаад шүүгээнээс шилэн аяга гаргаж тавив.

-Антоша минь. Би энэ насандаа бишгүй л нэг тэнүүчиллээ хэмээн Полунин гунигтайгаар инээмсэглээд, гэртээ суух цаг минь болж дээ. Эхнэр маань ч тэгэхийг минь хүсдэг бололтой гэв.

-Зөв дөө хэмээн Самбист хэлээд, өнгөрсөн жил чамайг идэр насаа дурсаж бага насанд чинь гомдоож байсан зарим нэгэнтэйгээ уулзахаар төрсөн нутгаа явахад чинь эхнэр чинь эргэж ирэхгүй болов уу гэж бодож байсан. Чамайг Шакирыг хагалгаанд орсон гэж мэдэгдэхэд нь би ч гэсэн чамайг амьд буцаж ирнэ гэдэгт эргэлзэж байсан. Би тэгэхэд нэг бус удаа чамд туслая гэж санал тавьж байсан. Цуглуулсан мөнгөө чамд тэр Тарасов гэгч газар руу чинь явуулья гэсэн боловч эхнэр чинь татгалзсан юм. Тэр хотыг чинь мэдэхгүй, өөрөө мэдэг, би энд оролцоод байхгүй гэсэн. Танай хүн ч чанга зантай хүүхэн дээ гэж ярилаа.

-Миний хаана юу хийж явааг тэрээр үнэхээр мэдээгүй байсан юм гэж Полунин хэлээд ширээний ард суулаа. Тэрээр өвчний дараа нилээд турсан боловч шөрмөслөг биенд нь чөлөөтэй таарсан биеийн тамирын хөнгөн хувцас өмсчээ. Синицын лаазтай “Хольстен” гэдэг шар айргийг аягалан Полунингийн дэргэд суув. Энэ үед хаалганы түгжээ дуугаран ээж хүү хоёр орж ирлээ. Зургаан настай жаал хүү гал тогооны өрөөнд түрүүлж орж ирмэгцээ шууд Синицыны зүг гүйж ирлээ. Тэрээр:

-Сайн уу, Антон өвөө? гээд жижигхэн гараа шууд өглөө.

-Нэг нэртхэн минь сайн уу? гэж Синицын паравгар том гараа түүнд өгөөд шууд өвөр дээрээ авч суулгав.

-Чи ер нь нэг л олигтой том болж өгөхгүй юм гэж Синицын инээмсэглэн хэлээд, тийм учраас чамд тус болж магадгүй юм гэж авчирсан гээд уутнаас том хавтгай шоколад гарган бяцхан Антонд өгөв.

-Май идэж орхи. Энэ бол уураг, нүүрс ус элбэгтэй эд байгаа юм. Тийм учраас чи удахгүй над шиг булиа том эр болно гэж Синицын нэмж хэллээ. Синицын өөрөө үнэхээр хоёр метр орчим өндөр нуруутай, зуугаас багагүй жинтэй эр байлаа. Тэгж байтал гал тогооны өрөөнд намхан бөгөөд гоолиг нуруутай, хар үстэй Анна орж ирлээ. Полунингийн эхнэр Синицынтэй насаар чацуу бөгөөд саяхан хорин зургаа хүрчээ.

-Сайн байна уу? Антон! гэж Анна Сеницынд инээмсэглэн хандаж мэндлээд тэр орцны дэргэд байгаа никельдсэн “хуягт танк” чинийх биш биз дээ? гэж асуув.

Сеницын тааламжтай байдлаар маасайн инээмсэглээд:

-Тийм ээ, минийх гэж мөрөө хөдөлгөн хариулаад Полунин руу хараагаа шилжүүлэн:

-Би уржигдар шинэ жийп худалдаж авсан юм гэв.

-Юу гэнээ? хэмээн Полунин гайхан асуугаад чи ч саяхан шинэхэн “Вольво” хөлөглөж явсан биш бил үү? гэж асуув.

-Чи мэдэж байна уу, Иваныч. Машин бол миний сул тал юм даа. Би жийптэй болохсон гэж аль түрүүнээс мөрөөдөж байсан юм. Гэтэл саяхан дээд зэрэглэлийн жийпүүдийг хотод оруулж ирсэн юм. Тэгээд л энэ ягаан өнгийн “Мицубици-Паджеро”-г худалдаж авлаа гэж Сеницын нүүр дүүрэн баясаж тайлбарлав.

-Одоо байгаа нүүр шиг чинь өнгөтэй байх нь ээ гэж Полунин хошигнон инээгээд энэ хэргийг угаах нь зүйтэй юү? гэж асуулаа.

-Болох л юм гээд Сеницын аягатайгаа өргөлөө. Полунин түүнийг дэмжин

-За тэгвэл Антон Сеницыны машины тав дахь цуглуулгын нь төлөө тулгачихъя гэлээ. Тэд аягатай шар айрагнаасаа нилээд том балгацгаалаа. Тэгтэл Полунингийн хүү:

-Ааваа чи яагаад тийм том жийп худалдаж авахгүй байгаа юм бэ? гэж асуув.

-Аавын чинь нуруу болон жин нь Антон өвөөгөөс чинь хамаагүй бага юм. Тийм учраас өөрийнхөө жижигхэн “БМВ”-д чөлөөтэй багтдаг юм гэж аав нь инээмсэглэн хариулав.

-Зүгээрээ, Антошка. Би өөрийнхөө жийпд чамайг суулгаж зугаалуулна гэж Сеницын хүүг аргадаад чамайг өвөр дээрээ суулган өөрөөр чинь жолоо бариулна гэлээ.

-Хүү бид хоёр хажууд чинь байж болох уу? Эсвэл ажил төрлийн тусгай яриатай юу гэж Анна эрчүүдээс асуулаа.

-Ажлын тухай ярьж амжина хэмээн Сеницын хөгжилтэйгөөр хариулаад тийм учраас та хоёр бидэнтэй хамт сууж л бай. Уух юм хүрэлцээтэй байгаа гэлээ. Тэд бүр орой болтол элдэв юм хөөрөлдөн суужээ.

Энэ үед голдуу Анна хөгжилтэй юм ярьж инээлдэж байсан ажээ. Гэрийн эзэн тийм ч их нийтэч хүн биш учир Полунингийн зочид ховор орж ирдэг байсан юм. Ихэвчлэн Владимерын тун ойрын хүмүүс л хааяа орж гарна. Тэдний орж ирэхэд Анна ихэд баяртай хүлээж авна. Полунин өөрийн зожигдуу зан болон цаг зав муутай байдгаас болж залуу эхнэрт нь хөгжилдөх найз нөхөд хэрэгтэй гэдгийг ойлгодог байсан юм. “Самбистын” энэхүү айлчлал нь зөвхөн өөрт нь төдийгүй бас эхнэрт нь хэрэгтэй юм гэдгийг тэрээр мэдэж байв. Бүр орой болж айлчин явахаар завдаж байтал Полунин:

-Чи надтай ярилцах гэсэн хэрэг чинь юу юм бэ? гэж сануулан асуулаа.

-Өө, тийм ээ хэмээн Сеницын гэнэт санасан мэт дуу алдаад, ер нь тэр асуудлыг маргааш ярилцъя гэж бодож байсан юм. Гэвч одоо хэлчихье. Маргааш орой зургаан цагт манай спортын зааланд би нэгэн хүнтэй уулзахаар тохирсон юм. Энэ уулзалтад чамайг байгаасай гэж би гуйх гэсэн юм гэлээ.

-Тэр хүн чинь тэгээд хэн юм бэ? Би байх ямар хэрэгтэй юм?

-Нэг том хэргийг барьж авах хэрэгтэй байна гэж Антон тайлбарлаад, чи бол сэргэлэн ухаантай хүн учир бидэнд хэрэгтэй юм хэлж чадна гэж бодсон юм гэлээ.

-Бүү дүлж ядаад бай хэмээн Полунин үрчийн хэлээд тодорхой ярь! гэж шаардав.

-Товчдоо “Нефтьоргсинтез” үйлдвэр дээр нэг боломж гараад байгаа юм аа. Энийг мөнгө олоход ашиглах хэрэгтэй байна. Олон хувилбар байгаа л даа. Гэвч тохитой сууж тархиа ажиллуулан сайтар бодох хэрэгтэй.

-Тэр хүнд чинь хувилбар байгаа юу?

-Тийм ээ хэмээн Сеницын толгой дохиод, чи зөв тааж байна. Тэр эр чинь муугүй тархитай хүн. Маргааш чамайг танилцуулъя. Чи ирэх үү? гэж асуув.

-Ирэлгүй яах вэ? хэмээн Полунин мөрөө хавчин дуугараад ухаалаг хүмүүстэй хөөрөлдөх нь таагай байдаг юм. Ямар нэгэн ашигтай юмны сэжүүр олдож ч юу магад гэв.

-За тэгвэл маргааш оройн зургаан цагт Динамовскийн гудамжинд байгаа “Савлуур” дээр хүрээд ир гэж хэлээд Самбист салах ёс гүйцэтгэн гар барилаа.

* * *

Маргааш нь Полунин Динамовскийн гудамжны таван давхар байшингийн нэгдүгээр давхарт байдаг жирийн хүмүүс яагаад ч юм “Савлуур” гэж нэр өгсөн тэр спорт клуб “Зенит” рүү хүрч ирлээ. Клубийн танхимыг Антон Сеницын Полунины зөвлөснөөр худалдаж авсан ажээ. Энд бас доод хонгилд нь саун, амрах өрөө, биллиардны танхим байдаг.

“Зенит” клуб нь албан ёсны уулзалт хийдэг Сеницыны нэгэн салбар газар юм. Полунинтай хамт намхавтар нуруу, цайвар үстэ, нүүрийн баясгалантай залуу Болдин машины жолоо барьж ирлээ. Вячислав Болдин бол Полунины гарын туслах бөгөөд автомашины үзэсгэлэн худалдааны газрын захирлын үүрэг гүйцэтгэдэг байлаа. Тэрээр өөрийн шөфийн тонгоруу дүртэй хүн юм. Гучин таван нас хүрч ээдрээтэй амьдралаас нэгэнт залхаж эхэлсэн тайван бөгөөд бодлогоширсон Полунингаас дөнгөж хорин хоёр нас шүүрч яваа залуу Славка ирээдүйдээ итгэлтэй, шантаршгүй зүтгэлтэй боловч түргэн хөнгөн зантайгаараа ялгаатай хүн байлаа. Гэвч энэ нь Полунинг тэр залууг итгэлтэй бөгөөд өөрт нь үнэнч гэж дүгнэхэд саад болдоггүй байв. Славка ч нэг бус удаа үүнийгээ баталж чадсан ажээ. Славка “Спорт клуб Зенит” гэсэн цагаан дэвсгэр дээр тод хөхөөр бичсэн хаягтай спортын заалны орцны үүдэнд

машинаа зогсоолоо.

-Магадгүй энэ бол манай Антонийн хамгийн хайртай газар байх гэж Болдин дуугараад:

-Тэрээр бусад албан контороосоо илүү энд цагаа өнгөрөөх дуртай хүн юм гэв.

-Яах вэ дээ хэмээн Полунин инээмсэглээд хэн маань ч гэсэн арай тохилог газар руу тэмүүлдэг хойно доо. Славик минь би хүмүүс өөрчлөгддөггүйг аль эртнээс мэддэг болсон юм. Энэ Самбист юу ч хийлээ гэсэн бага залуугаасаа хичээллэж байсан спортын заал, түүнтэй адилхан хичээллэж байгаа залуус түүний сэтгэл зүрхэнд ойр дөт санагдаж байдаг биз. Тэр хүн “Самбист” хэвээрээ л үлдэнэ гэж тайлбарлав.

-Харин чи Иваныч ямар хүн болж төлөвшсөн хүн бэ? гэж Болдин Полунинг залирхаг ширтэж асуулаа.

-Хүнд итгэдэггүй хүн болж төлөвшсөн гэж Полунин товчхон хариулаад машинаас гарав. Араас нь Болдин дагаж довжооны шатаар өгсөн тэд клубийн байшинд орлоо. Жижигхэн ширээний цаана байх лангууны ард булчинлаг биеийг нь барьсан биеийн тамирын трустик майктай жижүүр залуу сууж байв. Залуу тэр хоёрыг хармагц хүндэтгэн босож мэндлэв.

-Сайна уу, Иваныч

-Сайн, сайн, Коля. Антон байгаа юу?

-Байгаа. Тэр заалны цаад буланд хэвтээгээрээ гарын булчингийн дасгал хийж байна гээд Николай тэр зүг рүү зааж өглөө. Хоёр зочин зааланд ороод цаад буланд байгаа Сеницыны дасгал хийж байгаа урт сандлын зүг явлаа.

Антоноос гадна зааланд бас арваад хүн хичээллэж байлаа. Полунин тэд “Самбистын” бүлгийн хүмүүс байсан тул бараг цөмийг нь нүүрээр нь болон нэрээр нь таних байв. Тэд Полунинг хармагцаа эелдэгээр дохин мэндэллээ. Самбист бүрээстэй урт сандал дээр өөдөө харан хэвтээд штанг дээш нь аажмаар түлхээд мөн аажмаар доош нь буулгах дасгал хийж байгаа нь харагдана. Тэр штанг нь Полунины багцаагаар 120 кг-аас багагүй жинтэй мэт бөгөөд Самбистын хөдөлгөөн бүрийн нь дараа улам хүнд болж байгаа бололтой. Эцэст нь Антон бүх хүчээ шавхан мэнчийж улайтлаа штангийг өргөөд толгойнхоо ард тавин тулгуур руу түлхэж сая нэг юм саллаа. Тэрээр өндийн суугаад өмнө зогсож байгаа зочдоо харлаа. Болдин урдаа гараа зөрүүлж бариад мөрөөрөө хана түшин зогсоод түүний тэр мэриймтгий үйлдлийг хачирхан ширтэж байв. Түүний штангатай тэмцэлдэх дасгалаа дуусмагц Славка даажигнах маягаар:

-Антон минь энэ чинь чамд тийм чухал хэрэгтэй эд үү? гэж штанганы зүг дохин асуув. Самбист нөхөрсөгөөр инээмсэглээд:

-Славик минь. Би үнэндээ тэрний чинь доор эхлэн хэвтэх бүрийдээ энэ асуултыг чинь өөртөө тавьдаг юм гэлээ.

-Энэ төмрийнхөө оронд хүүхний доор хааяа ч гэсэн хэвтэх чинь илүү дээр байх гэж Болдин ёжлон хэлээд мөн л ашигтай дасгал болно. Ямар ч ядаргаа бэрхшээл байхгүй гэлээ.

-Далиманд хэлэхэд хүүхний тухайд гэвэл гэж Самбист хөгжин дуугараад харин чи штанг хүүхэн хоёрын үндсэн ялгааг мэдэх үү? гэж асуув.

-Төсөөлж байна гэж Болдин инээд алдаж хариулаад, чи штангатай хамт байхдаа ямагт түүнийхээ доор, харин хүүхэнтэй бол дээр нь хэвтдэг гэж хэллээ.

-Биш ээ гэж Сеницын инээмсэглээд, өөр юмаар. Чи эхлээд штанган доор хэвтэхдээ энэ нь хэнд хэрэгтэй юм бэ гэж бодно. Харин дасгал хийсний дараа ядарсан ч гэсэн сэтгэл чинь дүүрэн ханамжтай босож ирдэг юм. Харин эмэгтэй хүнтэй бол эсрэг байдаг. Түүнтэй оронд орох үедээ үүнийг чи заавал үйлдэх ёстой гэж бодно. Харин дараа нь гээд Самбист уйтгартай санаа алдаад, дараа нь чиний бүх бие суларчихсан, энэ явдал хэнд хэрэгтэй юм бэ гэж дургүй чинь хүрэн хэвтэх болно гэлээ.

Полунин тэр хоёр найзынхаа хөгжилтэй яриаг инээмсэглэн чагнаж байснаа:

-Дээр нь нэмж хэлэхэд хэрэв чамд ийм явдал учирвал аль алины нь тохиолдолд хэцүүхэн л байх болно гэлээ.

-Чи бас гүн ухаантан юмаа даа, Антоша минь гэж Славка инээмсэглэн хэлээд би өмнө нь мэддэггүй байжээ гэв.

-Би хөгширч байна даа, Славка минь. Амьдралын тухай эргэцүүлэн бодох боллоо... Славка Антоны зүг дохисноо:

-Иваныч чи түүнийг хараач. Эргэцүүлэл хүн болгонд ч тэгж их нөлөөлдөггүй бололтой. Жишээ нь энүүнд л гэхэд тэр штанг хүүхэн хүнээс илүү санагдсаар байх шиг байна гэв.

-Чиний энэ чалчаа үгийг сонсоод чамайг би өөрийн хиамны үйлдвэрт консеровны махны оронд явуулмаар санагдаж байна гэж Антон үргэлжлүүлэн довтолж хэллээ.

-Одоо энэ балай яриагаа боль гэж Полунин яриаг нь таслаад , ажлаа ярих цаг боллоо. Үйлдвэрээс ирэх тэр танил чинь хаана байна гэж асуув.

-Тэр өөрийнхөө гүзээтэй байлдаж байгаа хүнийг харж байна уу? гэж Антон асуугаад эсрэг талын хана руу зааж, харин ашгүй амжиж ийшээ ирсэн юм. Тэгээгүйсэн бол түүнийг тун удахгүй хэзээ мөдгүй амаржих гэж байгаа жирэмсэн эмэгтэй гэж харах болно гэв.

Полунин Болдин хоёр түүний заасан зүг эргэж хармагцаа хананд бэхэлсэн швед сараалжны дээд хөндлөвчнөөс хоёр гараараа барин дүүжлээстэй байгаа трусик майк өмссөн, нүдний шилтэй, их гэдэстэй эрийг олж харлаа. Дүүжлээстэй бүдүүн эр сүүлчийн хүчээ шавхан байж хөлөө өргөн, шалтай зэрэгцээ байдалд хүргэхийг оролдож байв. Энэ үед түүний удахгүй “амаржих” бие цогцос тэр аяараа чичирхийлэн амнаас нь шахмал хий исгэрэн гарах сонсогдоно.

-Тийм ээ хэмээн Антон шведийн хана руу харан сунжруулан дуугараад тэр хана түүнд хэтэрхий эгц байгаа бололтой... Эй Гриша наадхаа орхи. Хурдан буугаад нааш ир гэж хашгирлаа. Гриша аажимхнаар алгаа тэнийлгэж хөндлөвчийг тавьж нүсэр чимээ гарган шалан дээр газардав. Тэгээд тэрээр ойр ойрхон хөлөө солбин алхсаар хүрч ирлээ. Тэр бол их бүдүүн агаад намхан нуруутай эр байв. Түүний шингэн бужгар үс толгойн халцарч яваа хөлстэй гялаанд наалдаж орхижээ. Мань эрийн зузаавтар уруул махлаг хамар, зах нь дээшээ сэртгийсэн нарийхан хөмсөг царайг нь гэмгүй ааштайн шинжийг илтгэнэ. Дээд уруул нь доодхоосоо ялимгүй богино ажээ. Энэ нь түүний бөх эрүүл шүднүүдийг ил гарган царайг инээмтгий шинжтэй болгож байх мэт харагдуулна. Тэр хүний урт сормуустай том хар нүднээс нь анхаарал болон сайн санааны дулаан гэрэл гарах мэт ажээ.

-Танилц. Энэ бол Гриша Соловейчик. “Нефтьоргсинтез” заводын ерөнхий инженер. Миний эртний сайн найз гэж Антон бүдүүн эрийг тэдэнд танилцуулав.

-Магадгүй. Бас л урьд нь тамирчин хүн байсан биз? хэмээн Славка тэсэлгүй асууж орхилоо.

Гэвч Григорий гомдсонгүйгээр үл барам хөгжилтэйгөөр инээд алдаад:

-Яг тийм. Тааж орхилоо. Би шатрын спортын дэд мастер хүн гэлээ.

-Уран гулгалтын спортын мастер биш гэдгийг чинь би мэдэж байна хэмээн сонгомол барилдааны спортын зэрэгтэй Славка ингэж хэлэх бүрэн эрхтэй мэт хорон үг чулуудав.

-Чи дэмий ингэж ярьж байна. Уран гулгалтын хувьд Гриша спортын мастер байх бүрэн боломжтой хүн гэж Антон “Уран” гэдэг үгний “а” үсгийг зориуд өргөлттэй дуудан инээмсэглэн дуугарлаа.

Полунин Соловейчикийг дахин дуугүй ширтэв. “Монтана” гэж хөх өнгийн бичигтэй цагаан майка нь түүнд хэтэрхий багадсан агаад зах нь унжиж гэдсэн доогуур нь татсан хар трустик нь спортын гэхээсээ гэрийн гэлтэй харагдана. Хөлдөө элэгдэж хуучирсан шаахай өмсчээ. Том үйлдвэрийн ерөнхий инженер гэхэд арай л доожоогүй харагдана.

-За яах вэ? хэмээн Полунин хэлээд явж ярилцъя. Харин хаана дээр вэ? гэж Антонд хандан асуулаа.

-Мэдээж доошоо амрах өрөөнд оръё. Тэнд бидэнд хэн ч саад болохгүй гэж Антон хэлэв.

Тэр дөрөв доод хонгил руу орох модон довжоо руу чиглэн алхацгаалаа. Тэр хонгил зэрэгцээ хоёр уужим танхимтай бөгөөд цаана нь шүршүүрийн өрөө, саун болон багавтар усан сан байх ажээ. Эрчүүд арьсан бүрээстэй тавилга бүхий наад талын хамгийн уужим танхимд орж тухалцгаалаа. Тэднийг дөнгөж жижиг ширээг тойрон суумагц хажуугийн хаалга онгойн зөвхөн усны хөнгөн хувцас өмссөн хоёр гоолиг бүсгүй орж ирлээ.

-Бидний хэрэг байна уу? гэж урт хөлтэй шар үстэй нэг нь асуув.

-Үгүй дээ. Бүсгүйчүүд минь. Бид чухал юм ярих гэж байна. Хажуу өрөөнд ороод хүлээж байж

болно хэмээн Антон хариулав. Хүүхнүүд ялдам инээмсэглээд бушуухан гарч явлаа.

-Мөөн! гэж Славка хөгжилтэйгөөр дуу алдаад энэ дасгал хийх “төхөөрөмжүүд” чинь тэр дээр байгаагаас чинь надад илүү таалагдаж байна гэлээ.

-Ямар сайхан охид вэ? хэмээн Гриша Соловейчик бахдан дуу алдлаа.

-Эд бол манай иллэг хийдэг бүсгүйчүүд юм гэж Антон гайхуулах маягаар тайлбарлаад түүний хажуугаар саун, халуун усны ажлыг хариуцдаг. За тэр яах вэ? Ажилдаа орьё. Гриша, миний найз Владимир Ивановичид өөрийн санаагаа тайлбарлаж өг. Бид түншилдэг хүмүүс учир түүний шийдвэрээс энэ ажиллагаанд миний оролцох эсэх минь олон талаар хамаарах болно гэлээ.

Гриша хөлстэй майкныхаа хормойгоор нүүрээ шудран арчсанаа Полунин руу бага зэрэг бөхийн хандаж яриагаа эхэллээ.

-Та мэдэж байгаа байх л даа. Манай үйлдвэр хувийн өмчийн хувьцаат компани болсон. Заводын үнэт цаасыг манай компанийн ерөнхий захирал Веселовскаас эхлээд энгийн цэвэрлэгч хүртэлх бүх ажилчид албан хаагчиддаа хувааж өгсөн юм. Веселовскийн хувь цэвэрлэгчийнхээс мэдээжээр илүү ноогдсон боловч үнэт цаасны ихэнхийг жирийн ажилчид авсан. Тэднээс тэр цаасыг хямдхан худалдаж авч болох цаг яг одоо болоод байна. Хэрэв амжвал шүү дээ. Надад мөнгө байхгүй боловч үйлдвэрийн ажиллагаанд би ямар нэгэн хэмжээгээр нөлөөтэй байдаг учраас бид тохирч би тус болж чадах байх гэж бодож байна гэж тэрээр яриад Полунин руу анхааралтай ширтлээ.

Полунин толгой дохиод, тамхиа асаан сорсноо:

-Тийм хэрэг байж... Асуудал тун ойлгомжтой. Гэвч зарим зүйлийг тодруулах нь зүйтэй байх. Өнөөдөр гэхэд “Нефтьоргсинтез” бол тийм ч их орлоготой үйлдвэр биш гэж би мэдэж байгаа. Тэгэхлээр ямар зорилгоор бид үнэт цаасыг нь худалдаж авах болж байна гэж асуулаа.

Хариуд нь Соловейчик зөвхөн инээд алдаад, үргэлжлүүлэн:

-Би танд нуулгүй илэн далангүй хэлье. Өнөөдрийн хувьд завод бүрмөсөн дампуурлын ирмэгт хүрээд байгааг нуух юун. Үйлдвэрлэл бараг зогсчихсон, түүхий эд байхгүй, тоног төхөөрөмжүүд нь хуучирчихсан, хөрөнгө оруулалт юу ч байхгүй. Гэвч энэ байдал удаан үргэлжлэхгүй гэдгийг би багтай хэлж чадна гэлээ.

Полунин түүний яриаг сонсож байхдаа тэр хүн хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглахгүй байж чадсангүй. Эхлээд гадна төрхөөрөө ч тэр, дотор сэтгэлээрээ ч ялгаагүй энгийн бөгөөд зөөлөн мэт санагдсан тэр хүн тун ухаалаг бөгөөд цэгц сэтгэдэг эрчимтэй шийдмэг бизнесмен болон хувирч байлаа. Нүд нь одоо болохоор хурц ширүүн бөгөөд хүйтэн жаврыг Полунины нүүр өөд үлээх мэт харагдаж байв. Полунинд Соловейчик бол ойрын ирээдүйг сайн ойлгож, түүнээс хэрхэн ашиг гаргаж авахаа мэддэг хүн мэт сэтгэгдэл төрүүлж байлаа. Энэ нь ч батлагдаж байсан юм.

-Тэр бол сайн ирээдүйтэй үйлдвэр хэмээн Григорий үргэлжлүүлэн хэлээд, одоо бол ашигтай бөгөөд зах зээл сайтай болоод байгаа цаг. Тэгэхлээр манай үйлдвэр ойрын ирээдүйд ашиг орлого сайтай болох магадлал өндөр байна. Харин энд хүрэхийн тулд заводад технологийн бага зэрэг шинэчлэл хийх шаардлага байгаа юм. Үүнийг Москвагийн чадварлаг бизнесменүүд ойлгож байгаа. Манайд хэдийнээ янз бүрийн компаниас хэд хэдэн мэргэжилтнүүд ирж Веселовскийтэй зөвлөлдөн мэдээлэл цуглуулж аваад явсан. Манай үйлдвэрийн тухай сонирхол хойшид улам ихсэнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байна гэж ярилаа.

-Тэгээд энүүнд чинь ямар дүгнэлт хийж болох вэ? гэж Полунин асуулаа.

-Хэрэв бид одоо хямд байгаа хувьцааны тасалбаруудыг ажилчдаас худалдан аваад багц болгон дээрх Москвагийн бизнесменүүдэд дамлан багагүй үнээр худалдаж болох юм. Үүнийг ганцхан би мэдэж байгаа юм биш. Завод дээр энэ талаар аль хэдийнэ яриа гараад байна. Энэ хотын зарим нэгэн хоршоо түншүүд хамтран тэр үнэт цаасыг худалдан авах ажиллагаандаа орж эхэлж байна. Үйлдвэрт ч хяналт тогтоож эхэлсэн гэж Григорий тайлбарлав.

-Тэгэхлээр бид хойшид хэрхэхээ шийдэх болж байна уу. Ярианаас чинь үзвэл чи өөрийн ерөнхий захирал Веселовскийтэй таагүй харьцаатай хүн юмаа даа хэмээн Полунин дүгнэн хэллээ.

Гриша инээмсэглэх аядсанаа дургүйцсэн байдлаар:

-Бүх юмыг өөртөө хаман авахыг оролдож байгаа хүнтэй ямар таатай харьцаа байх вэ дээ гэж гомдоллон дуугараад тэр чинь өөрийгөө үйлдвэрийн эзэн мэтээр сэтгэж надтай ч ямар нэгэн санаагаа зөвлөдөггүй юм. Тэр ч бүү хэл мөнгө байхгүй гэх нэрийдлээр сүүлийн хэдэн сар цалингийн маань ч тавьж өгсөнгүй. Үйлдвэрт орж байгаа бүх мөнгийг тэр зүүн гарын дансаар оруулан өөрийн болгож байна гэж хэллээ.

Полунин түүний хуучирсан трустик, майкийг хараад Гриша Соловейчик өөрийн гадаад байдалдаа санаа тавьдаггүйгээс гадна мөнгөөр гачигдаж байдаг хүн юм гэж бодож байлаа. Тэгтэл гэнэтхэн Антон дуугарч:

-Веселовский бол хамгийн гол асуудал ч биш юм. Тэр новшид бид хазаар олж бариад хоншоорыг нь тэмтрэн үзэхэд эрвээхий мэт хатаж орхино. Хамгийн гол нь түүний ар талд Сатар байгаад л хамаг учир байна гэлээ.

-Чи Олег Сатаровыг хэлж байна уу? гэж Полунин асуулаа.

-Тийм ээ. Өөр хэн байхав хэмээн Антон ярвайн хариулаад тэр үсчүүр чинь хаяагүй амжиж, хотын Зеленогорск дүүргийн бүх газрыг уландаа гишгэлээд байна. Хотын хуучин шинэ казино, үйлчилгээний газрын зарим хэсэг нь түүний гарт ороод байна гэж хэллээ.

Энэ Сатаров гэгч нэрийг Полунин мэддэг байсан юм. Тэрээр Сатаровтай биечлэн уулзаж байгаагүй боловч Антоны хэлснээр Олег Сатаров бол хот дахь рэкетерүүдийн шинэ урсгалаар гарч ирсэн эрүүгийн хүчтэй этгээд байсан юм. Зарчмын хувьд Сатаров Синицын хоёр нэг замаар явж байлаа. Хоёулаа тамирчин байсан бөгөөд Сатаров нь каратегийн аварга, спортын

дэд мастер хүн ажээ. Дунд сургуулиа төгсгөмөгц шууд ажил хийж эхэлсэн Сеницынээс ялгаатай нь гэвэл Сатаров Политехникийн дээд сургуулийг дүүргэж амжсан байв. Гэвч тэрээр эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаагүй бөгөөд наймааны ажилд шуурхайлан орсон юм. Гэвч тэгтлээ амжилт олохгүй байлаа. Тэгснээ удалгүй тэрээр наймаачидтай тэргэнд адилхан хөллөгдөж явснаас тэднийг хөллөж явах нь илүү ашигтай юм гэдгийг ойлгожээ. Ингэхийн тулд ажилладаг уураг тархинаас гадна ажиллаж чадах хүч чадал хэрэгтэй. Тэр хүч нь түүний хамт хичээллэж байсан нөхдүүд нь байв. Сатаров Сеницыны нэгэн адил тэднээсээ төмөр мэт сахилга батыг шаардаж ямар ч архидалт, илүү зугаа цэнгэлийг тэвчдэггүй байсан юм. Харин хүлээцтэй бөгөөд нэг их хагуу биш Сеницынээс түүний бүлэг харгис хагуу, шийдмэг байдлаараа ялгаатай байв. Бүх хяналтын хүрээ хуваагдсан үед энэ нь ашигтай гэдгээ харуулж чаджээ. Тэрээр хотын Зеленогорскийн дүүргийн нутаг дэвсгэрт өөрийн эрүүгийн үйл ажиллагааг эхлэн энэ өргөн уудам нутагт дураараа аашилж байсан дээрэмчдийн бүлгүүдтэй хайр найргүй тэмцэж дараа дараагаар нь даран устгаж байсан ажээ. Ингэж тэрээр энэ хотын тэнгэрт хамгийн тод гэрэлтэх эрүүгийн од болон хувирсан юм. Харин тэрээр Самбистын бүлэгтэй шөргөөцөлдөхийг хүссэнгүй. Учир нь тэдний сонирхол нэг ч удаа зөрчилдөөгүй байсан бөгөөд Старовынхантай харьцуулбал Сеницыны бүлэг аль эрт бүрэлдэн хүчээ нэгэнт авсан сайн зохион байгуулалттай байлаа. Гэвч тэрээр хэрхэн хүчээ авч зогсолтгүй түргэн дээшилж байгааг нэр хүнд бүхий хотын олон эрүүгийн бүлгийн толгойлогчид ажиглан харж эмээн болгоомжилж байсан юм.

-Хэрэв бид энэ хэргийг барьж авбал өөр бас хэнтэй тулгарах асуудал гарах вэ? гэж Полунин тамхиа соронгоо асуув.

-Бидний нөхөр огт биш бас нэг хүн байгаа гэж Антон инээд алдан хэлээд Решетов нэртэй, Коля-Решето гэдэг хочтой түүнийг завод дээр байхыг би нэг бус удаа харсан. Бидний энэ ярьж байгаа асуудлыг тэр этгээд бас сонирхож байсан гэж ярьцгааж байна билээ гэв.

-Сонин хэрэг байна гэж Полунин инээмсэглэн дуугараад хэрэв хоёр дээр хоёрыг нэмж чадахгүй тэр хүн заводын хувьцааг сонирхож яваа бол тэр үйлдвэр ирээдүйд үнэхээр ашигтай болох ёстой байна. Учир нь тэр Решетов чинь хиамыг үнэрлэж олох нохой мэт мөнгийг маш сайн үнэрлэж чадах хүн гэлээ.

-Тэр чинь дархлагдсан хулгайч гэдэг нь үнэн үү? хэмээн Григорий сэрэмжлэн асуув.

-Үнэн гэж Полунин батлан хариулаад тэр Коля гэгч арван таван жил торонд хашигдаж байгаад таван жилийн өмнө суллагдан ирэхэд нь хянагчаар тавьсан юм. Гэвч хотод хулгайчдаас дээрэмчид нь олон учир тэр этгээд хянагчийн албандаа удаан байж чадаагүй юм гэж хэлээд Сеницыныг инээмсэглэн ширтсэнээ:

-Түүнээс гадна Коля жинхэнэ толгойлогч болж чадсангүй учир сайн нэр хүндийг ч олсонгүй. Гэвч түүнийг шоронгоос суллагдсан хуучин эрүүгийн хэрэгтнүүд илүү сонирхдог учир тэрээр ямар нэг хэмжээгээр нөлөөтэй газар түүнд бий хэмээн Полунин Гришад тайлбарлаж ярилаа.

-Та мөн адил биз дээ Владимир Иванович? гэж Соловейчик Полунингаас асуугаад би таныг бас тэдний нэг нь гэж ойлгодог гэлээ.

Полунин хариу хэлсэнгүй, янжуураа шуналтай сорж суулаа. Гэтэл гэнэт Антон дуугарч:

-Иваныч бол ямагт Иваныч хэвээрээ байдаг хүн. Тэрээр бусдын нурууг хэзээ ч нугалахыг боддоггүй. Бусдыг ч тэгүүлэхийг хүсдэггүй хүн. Тийм учраас хотод Иванычийн нэр хүнд сайн байдаг юм гэж хэллээ. Полунин:

-Би журамтай хүмүүстэй харьцах дуртай хүн Гриша минь хэмээн сая нэг юм ам нээгээд энэ сэдвийн яриаг нэгмөсөн цэглэхийг хүсэх мэт,

-Тийм хүмүүс хааяагүй эрүүгийнхний дунд ч, шинэ тутам гарч ирж байгаа залуучуудын дунд ч, тэр ч бүү хэл цагдаа нарын дунд ч байдаг юм гэж Самбист, Соловейчик нарт хандан хэллээ.

Полунин Соловейчикийг гэмшингүйгээр инээмсэглэх аядан толгой дохихыг хараад өөрийн нь өгсөн санааг ойлгов гэж мэдээд дэмий ч ингэж юм ойлгодог хүн шиг жүжиглэсэнгүй гэж бодлоо.

-Одоо би Гриша минь чиний санааг тодорхой мэдэхийг хүсэж байна гэж Владимир асуув.

-Би хоёр асуудлыг шийдмэг барьж авах хэрэгтэй байна гэж Григорий хэлээд, нэгд би өөрийн хувьцааны бичгийг зузаатгамаар байна. Би энэ үйлдвэрийн төлөө багагүй хүч болон цагаа зарж ирсэн учир авах ёстой хувиа авах ёстой юм. Би тэр үйлдвэрт бараг долоон жилийн тэртээ анх ирээд мастераас ерөнхий инженер болтлоо хүчин зүтгэсэн хүн. Ийм учраас одоо надад ноогдож байгаа ашгаас хувь илүү ашиг ноогдох ёстой юм гэлээ.

-Харин хоёр дахь шалтгаан чинь?

-Тэр хоёр дахь асуудал нэг дэхтэйгээ холбоотой хэмээн Григорий хариулаад, би өөрөө үйлдвэрийн ажиллагааг бодитойгоор бие даан шийдэл гаргаж удирдмаар байна. Миний энэ ажилд тэр бүр зэвсэглэчихсэн залуусын хүчинд түшиглэсэн Веселовскийн нусгай жаалууд саад хийх ёсгүй гэв.

-Чи тэгвэл Самбистын зэвсгийг түших гээ юу? хэмээн түүний цаад санааг мэдэх гэсэн юм шиг Полунин инээмсэглэн асуулаа.

-Яагаад болохгүй гэж хэмээн Соловейчик зальжин инээмсэглэж хэлээд, бий болсон ямар нэгэн хүчний эсрэг түүнээс илүү хүч гарч ирдэг жамтай гэж хариулав. Тэгснээ Самбистын хүчирхэг мөрийг бахархан ширтээд авлаа. Гэвч дараачийн агшинд түүний инээмсэглэл хийсэн арчигдаж дахин Полунин руу төлөв байдлаар ширтэн:

-Энэ чинь бас танд хэрэгтэй шүү дээ. Та ойлгож байна уу? гэж асуулаа.

-Гриша минь. Энэ чинь хэрэгтэйгээс гадна надад бүү хэл чамд ч тун осолтой зүйл хэмээн Полунин хариулаад:

-Сатаров ч тэр, мөн чиний дургүйг чинь хүргэж байгаа тэр Веселовский чинь ч тэр энэ бантангийн чинь төлөө чамайг хэзээ ч уучлахгүй гэлээ.

-Би тэднээс гарч болох хэргийн эсрэг сорил амсахад хэзээ ч бэлэн байгаа гэж Григорий мэдэгдээд, би тэр Веселовский гэгч новшид чинь байвал зохих газрыг нь баталгаатай зааж өгч чадна. Түүний зэрэгцээгээр Григорий Самбист, Полунин хоёрыг итгэлтэй ширтсэнээ, та нар намайг гарч болзошгүй аюулаас хамгаална гэдэгт итгэж байна гэлээ. Гэнэтхэн аяндаа бий болсон эвгүй мэт нам гүмийг Самбист эвдэн Григорийн зүг талархалтайгаар гараа өгч мөрийг нь нөхөрсөгөөр алгадаад:

-Гришка минь, айсны хэрэггүй. Тэр новш чамайг бидэнтэй хамт гэдгийг мэдмэгц чамаар оролдохгүй болно гээд тэрээр Полунин руу хандан, харин чи энэ талаар юу бодож байна, Иваныч? гэж асуулаа. Полунин шууд хариулсангүй, янжуурынхаа үлдсэн цогийг хичээнгүйлэн нухаж унтраагаад:

-За яахав, сонин санаа байна. Харин нухацтайгаар тал бүрээс нь авч бодож үзэх хэрэгтэй юм гэж хариу хэлэв.

-За тэгэхлээр сайн байна гэж дуугүй сууж байсан Славка гэнэт ярианд оролцон, та Иванычтай тодорхой ярилц л даа. Эцсийн эцэст тэр мөнгө та хоёрт л хэрэгтэй шүү дээ. Харин би явж саунд орж иллэгчин хүүхнүүдтэй дэмий ярья гээд босож явдал дундаа цамцныхаа энгэрийн товчийг тайлсаар сауны өрөө рүү чиглэв.

Соловейчик Славкийг тэд хоёулхнаа ярилцаг гэж бодоод ингэж байна гэдгийг ойлгоод бас босож:

-Би ч гэсэн түүнтэй хамт саунд орох минь. Та хоёрт саад болоод яахав... Харин тэр хүүхнүүдийг чинь нэрийг мэдэж болох уу? гэж Антоноос асуув.

-Татьяна нөгөөг нь Ксения гэдэг хэмээн Антон яаран хариулав.

-Шаргал үстэйг нь хэн гэдэг юм? гэж Григорий үргэлжлүүлэн шалж, би гоолиг биетэй хүүхнүүдэд дуртай гэлээ.

-Ксения нь тэр. Алив. Бушуу явж үз.Хоцрох чинь! гэж Антон ундууцан хариулав. Полунин Синицын хоёр хоёулхнаа үлдсэний дараа хэдэн мөч дуугүй сууцгаалаа. Полунин бодлогошрон янжуур гарган нухаж байв. Самбист түүний юу гэж хэлэхийг нь хүлээж суув.

-За тэгээд Иваныч ярь л даа. Чи биднийг бодвол ажилтай тархитай хүн шүү дээ?

-Юу ярих билээ дээ. Чамайг тэр заводыг өөрийн гарт оруулахад хэдийнээ бэлэн байгаа гэж би ойлгож байна...

-Тэгээд юу гэж? Ашиг өгөх хэрэг шүү дээ. Харин Гриша биднийг бүү мунхруулчихаасай билээ. Би түүнийг эртнээс мэднэ. Тэр бол гүйлгээ ухаан сайнтай хүн бөгөөд бусдын болон өөрийн ашиг хонжоог ялгаж сайн харж чаддаг хүн юм гэж Антон хариулав.

Полунин Самбистын яарч байгааг нэг их анхааралгүй Соловейчикийн саналыг эргэцүүлэн бодож тамхиа сорон сууж байлаа. Тэрээр энэ хэрэгт Антон зөвхөн санхүүгийн ашгийг

тооцоолоогүй гэдгийг сайн мэдэж байсан юм. Самбист бас энэ хот дахь өөрийн нөлөөг бэхжүүлэн Сатаров болон түүний өрсөлдөгч Коля Решетов нарыг доошлуулах зорилготой байв. Тэр Решетов гэгч нь амжилтгүй боловч хотын гол овгорын төлөө тэмцлээ үргэлжлүүлсээр байсан юм.

Полунин тэдний саналыг хүлээж авснаар аюултай тоглоомтой орооцолдох болно гэж болгоомжлон ямар хариу хэлэхээ эргэлзэж суусан ажээ. Гэвч тэдний саналыг хүлээж авах нь зүйтэй гэж бодож байв. Учир нь нэгд Соловейчикийн үгэнд итгэх юм бол (түүнд итгэж болно гэж боддог байв) түүнд багагүй юм унах ёстой юм. Хоёрт, зөвхөн ажил төрлийн бус амин хувийн эртний найзууд учир Полунин Антон Самбистын саналыг дэмжихээс өөр аргагүй ажээ. Гуравдахь дээрх хоёроос дутуугүй бодолцож үзэх шалтгаан бол одоо Владимир өөрийн амьдралын эрс өөрчлөлтийн шатандаа байгаа явдал юм. Тэрээр урьдын цэвэр эрүүгийн асуудлаас бүрмөсөн холдож цоо шинээр хуулиар зөвшөөрөгдсөн бизнес эрхэлж амьдрахаар шийдсэн байжээ. Тэр утгаар нь авч үзвэл Соловейчикийн одоохондоо алдагдалд ороод байгаа боловч ирээдүй сайтай том үйлдвэрийн хувьцаа эзэмшигч болгох санал нь түүнд зүгээр юм шиг санагдаж байлаа.

-За тэгвэл туршаад үзье гэж Полунин Антоныг баярлуулан хэлээд, харин эхлээд сайтар бодох хэрэгтэй. Маргааш чи над дээр хүрээд ир. Тэгээд хоёул яаж хөдлөхөө нарийвчлан ярилцъя гэлээ.

-Сайн байна. Тэгье гэж Самбист баяртай хэлээд, харин санал нийлж байгаагаа тэмдэглэх юм биш үү? гэж хэлээд нүд ирмэлээ.

-Одоогоор тэмдэглээд байх юм байхгүй, хэмээн Полунин инээмсэглэн хариулаад, бодит ажил байхгүй байна. Зөвхөн санаа л байна. Тэрнээс гадна өнөөдөр би гэртээ эрт харих ёстой. Эхнэр маань хүлээж байгаа гэв. Антон түүний хэлснийг ойлгон:

-Тэгвэл Аннад мэнд дамжуулаарай. Маргааш уулзъя. Эсвэл одоо бидэнтэй үлдэх юм биш үү. Би чамд иллэгний хоёр бүсгүйг олж өгье гээд түүнийг ширтэв.

-Үгүй дээ. Баярлалаа хэмээн Полунин инээд алдан хэлээд, та нар минь надгүйгээр хөгжилдөцгөө. Гэрт байгаа чавганц минь намайг загнаж магадгүй гэлээ.

-Чавганц байхдаа ч юу билээ, хэмээн Сеницын хөгжилтэй дуугараад, хэрэв миний гэрт тийм чавганц сууж байдагсан бол би оройн цагаар энүүгээр хэсүүчилж явахгүйсэн гэв.

-Тиймсэн бол өдийд чи тэр чавганцтайгаа миний чавганцтай нийлэн энд биш манайд сууж байхсан гэж Полунин ёжлон хэлээд гараараа дохиж салах ёс гүйцэтгээд өөрийн машин руу зүглэн алхлаа.

Самбист түүний араас удаан ширтэн бодлогоцрон сууж байсан юм.

* * *

Дараа өдөр нь хүлээгдэж байгаа ажлын талаар Полунин Сеницын хоёр дэлгэрэнгүй зөвлөн

ярилцаад хэрхэн хөдлөх тухай төлөвлөгөө гарган ажилдаа шуурхайлан оржээ. Хэдхэн хоногт багтаан өөрсдийн нэрэн дээр пүүс бүртгүүлж чаджээ. Энэ пүүс нь албан ёсоор хувьцааны тасалбар эзэмшигч жирийн хүмүүст боломжийн гэж бодогдмоор үнээр “Нефтьоргсинтез” үйлдвэрийн хувьцааг худалдан авах ажлыг эрхэлнэ. Үүний зэрэгцээ Соловейчик Полунин Самбист хоёроос их хэмжээний мөнгө бэлнээр авч шууд үйлдвэр дээр ажилчид ажилтнуудаас хувьцааны тасалбар худалдан авах ажлыг хийж байлаа. Соловейчикийн тасалбар худалдан авах үнэ бусад худалдан авагчдаас дээгүүр байсан учир ажил нь эхнээсээ бүтэмжтэй болж байв. Хэдэн сараар тавьж өгдөггүй цалингийн цөөхөн мөнгөөр арайхийн хоног өнгөрөөж байнга гачигдан амьдарч байсан үйлдвэрийн ажилчид энэ заводад он удаан жил ажилласны нь шагнал болгон өгсөн хэнд ч хэрэггүй тэр цаасыг дуртайяа худалдаж байв. Гэвч энэ бүтэмжтэй эхлэл нь бас өөрийн сөрөг үр дагавартай байсан юм.

Полунин үнэт цаас худалдаж авсан эхний өдрөөс эхлэн өрсөлдөгчийн зүгээс ирэх хариу үйлдлийг өдөр болгон хүлээж байсан боловч өдөр хоног өнгөрсөөр энэ талаар ямар ч мэдээлэл ирэхгүй байв. Өдөр бүр Гриша Соловейчик түүн рүү утасдаж өнгөрсөн өдрийн арилжааны үр дүнг мэдээлэхийн зэрэгцээ ямар ч хүндрэл бэрхшээл одоохондоо гарахгүй байна гэж илтгэдэг байлаа. Полунинд мөн адил мэдээллийг Самбист орой нь тэднийд орохдоо өгдөг байсан юм. Гэвч тэдний хэн хэнд нь хариу үйлдэл гарахгүй байгаа нь сэжиг төрүүлэхгүй байлаа. Ийм байдлаар үнэт цаасны арилжаа хийснээс хойш бүтэн долоо хоног өнгөрөв. Полунин өглөө эрт өөрийн техникийн үйлчилгээний станцад хүрч ирлээ. Энэ бол Полунины худалдаж авсан тусдаа хашаатай зэрэгцээ тоосгон гарашууд байв. Энд бас автомашины засвар үйлчилгээний тасалгаанууд байна. Түүнээс гадна гараш дээрээ дахин нэг давхар нэмж бариад өөрийн болон нягтлан бодохынхоо өрөөг байрлуулжээ. Бас тэнд машины эд ангийн тохируулга хэмжилтийн өрөө ч бас байна.

Полунин гарашийн хашаанд ороод машинаас гарч контортоо орохоор явлаа. Тэгтэл өндөр нуруутай булиа махлаг ахимаг насны тос болсон ажлын хувцас өмссөн нэгэн эр угтан хүрч ирлээ. Тэрээр зуны энэ халууныг үл мэдрэх мэт ноосон малгай өмссөн байх агаад түүний хажуу захнаас буурал үс цухуйж аманд нь унтарч байгаа “Беломор” зуулттай харагдана.

-Өглөөний мэнд, Шакирыч гэж Полунин засварчин өвгөнтэй мэндлээд, ажил ямар байна? Бүх юм хэвийн биз дээ? гэж асуув.

-Чи ойрын үед ажил чинь хэвийн үү гэж байн байн сонирхох боллоо. Яагаад тэр билээ хэмээн өвгөжөөр эр ундууцан бувтнаад, бараг байнга тос масло болсон том гэгчийн алгатай гараа түүнд өгөөд, Славка та хоёр миний ажлыг хэвийн бус болгох ямар нэгэн юм сэдээгүй биз дээ гэж асуулаа. Шакирыч Славка Болдины нэгэн адил Полунины зөвшөөрөгдсөн, зөвшөөрөгдөөгүй бизнесийн хоёрдахь ойрын нь туслах байв. Урьд нь нэг үе тэд гурвуулаа нийлж автомашин хулгайлан худалддаг байсан ажээ. Одоо Славка нь эндээс холгүй орших автомашины үзэсгэлэн худалдааны газрыг хариуцаж, Шакирыч Полуниныг орлож техникийн үйлчилгээний энэ станцыг хариуцна. Түүнээс гадна тэр хүн чадварлаг автомеханикч тул засварын ажил түүнд ойрхон байдаг ажээ.

-Славка өнөөдөр энд ирээгүй юу? гэж Полунин дотогшоо харан асуув.

Шакарычийн шинэхэн улаан өнгийн “Нива”, Полунины “БМВ”-ээс өөр машин тэнд

байсангүй.

-Одоохон өнхрөөд ирнэ дээ, хийх юмаа олж ядсан амьтан гэж Шакирыч үглэтэл хашаанд цагаан өнгийн “Тоёота” орж ирлээ. Машинаас Славка Болдин инээмсэглэсээр гарч ирээд тэдэнд дөхөж ирэн:

-Сайн уу, эрчүүд минь хэмээн мэндлэв.

-За тэр, чи түүнийг хараач гэж Шакирыч Владимирт хандан хэлээд, би гурав дахь өдрөө энүүний хоншоорыг ажиглаж байна. Өглөө болгон бэлцийтлээ хөөчихсөн байх юм. Өчигдөр орой зэгсэн наргисан байх гэв.

-Би түүнийг хаана ингэтлээ наргисныг нь тааварлаж байна гэж Полунин инээд алдан хэлээд Славкад хандан: -Самбистын саун чамд таалагдав уу? гэж асуув.

-Антоха чамд ховлоо биз? гэж Славка асуулаа.

-Үгүй ээ. Би өөрөө тааж байна. Түүнээс гадна үс чинь өнгөлөг бөгөөд одоо хүртэл эвкалиптын үнэр гарч байна гэж Полунин хариулав.

-Тэр Самбист чинь халуун ус ууранд орох тун дуртай хүн юм гэж Болдин хэлээд, тэр бас валеранка болон эвкалиптыг халуун чулуун дээгүүр цацан тансаг үнэр гаргаад биеийг нь мөчрөөр ороолгож шавшихыг шаарддаг. Харин Гришка бид хоёрт тэр халуун усны дон зохихгүй гэлээ.

-Өөр ямар Гришкаг чи яриад орхив хэмээн Полунин сэрэмжлэн асуулаа.

-Яагаав дээ. Самбист та хоёртой хэд хоногийн өмнө ажил ярилцаж байсан тэр Гришка Соловейчикийг хэлж байна гэж Болдин хариулав.

-Тэр чинь халуун ус саунд дуртай хүн юм уу? гэж Полунин хөмсөг зангидан асуув.

-Үгүй дээ хэмээн Славка хариулаад, тэр чинь хүүхнүүдэд илүү дуртай хүн. Харахад тийм унжгар мөртлөө сексдэхдээ ямар гээч. Шуурга гэсэн үг. Чи тэр өндөр шар үст иллэгчин Ксюхаг санаж байна уу? Гриша тэр хүүхэнтэй өчигдөр орой таван удаа улаан буланд орсон. Шакирыч чи төсөөлж байна уу. Түүний гүзээ бүхэл бүтэн чамаас том мөртлөө өмдөн дотор нь ямар их хүч байна гээч гэж хэллээ.

-Атаархаж байна уу? хэмээн Шакирыч мушийн инээмсэглэн асуув.

-Хэнтэй. Чамтай юу эсвэл Гришкатай юу? гэж Славка ойлгоогүй мэт асуув.

-Шар үст хүүхэнтэй гэж Шакирыч тайлбарлаад унтарсан “Беломороо” нулимж хаялаа.

-Тонил цаашаа хэмээн гомдсон Славка гараа савчин дуугарав.

-Би Соловейчикийн оронд байсан бол хамраа цухуйлгалгүй гэртээ сууж байхсан гэж Полунин

хөмсөг зангидан дуугараад, харин тэр тэнэг халуун ус, саунаар хэсүүчилж, өөрийн хошноготоо адал явдал хайж явах юм. Чөтгөр аваг гэж хэлэв.

-Зүгээр ээ Иванов минь. Санаа бүү зов хэмээн Славка түүнийг тайвшруулах гэж хэлээд, харин тэр Самбистын дэргэд бүрэн аюулгүй байдалд байх болно. Спортын клуб нь хамгаалалттайгаас гадна түүний дайчин найзууд байнга тийшээ ирдэг юм гэлээ.

Полунин уужран санаа алдаад:

-Би яагаад Гришаг дутуу үнэлэв? Тэрээр ашигтай зүйлийг таатай зүйлтэй хослуулдаг хүн шүү гэв.

-Та хоёр ингэж сэрэмжлэх болсон ямар үйл хийж байгаагаа эцсийн эцэст надад ярьж өгөх юм биш үү? гэж Шакирыч тэвчээр алдан асуув.

-Явъя. Би чамд цөмийг нь тайлбарлаж өгье. Шакирыч минь гээд Полунин өвгөний мөрийг нөхөрсөгөөр алгандан хэлээд Болдин руу эргэж харж, харин чи явж ажлаа хий. Чи сүүлийн үед хэтэрхий их амрах болоод байна гэлээ.

Полунины яриаг Шакирыч сонсоод дургүйцэх маягтай үрчийн урагш хойшоо алхаж байв.

-Энэ бүхэн чинь надад огтхон ч таалагдахгүй байна гэж тэрээр баргил сөөнгөдүү дуугаар хэллээ. Полунин хариуд нь зөвхөн инээмсэглэх аядав.

-Чамайг ингэж хэлнэ байх гэж би бодож байсан юм гэж тэрээр хэлээд, чи миний саналыг шууд сайшааж байсан удааг би санахгүй байна гэв.

-Энэ бол онцгой асуудал. Би тэр цааснуудад чинь итгэхгүй байна. Ер нь ч манай энэ Орос оронд түүний заавраар ажиллахад би итгэдэггүй. Тэр зааврууд чинь заавал биднийг чадаж байдаг гэж Шакирыч хэллээ.

-Аюул эрсдэлд чи бид хоёр дасах гэж зовохгүй, Шакирыч минь. Бид машин хулгайлж байхдаа бага биш эрсдэлтэй зүйл үйлдэж байсан шүү дээ.

-Тэр бол өөр хэрэг гэж Шакирыч цөхрөн хариулаад, тэгэхэд тэр заавруудыг чинь бид өөрсдөө боловсруулж мөрддөг байсан. Үнэндээ би тийм амьдралаас залхаж гүйлцлээ. Амьдралдаа л нэг үзлээ. Би одоо хөгшин болсон. Тайван суухыг хүсэж байна гэж хэллээ.

-Шакирыч минь, бүү санаа зов хэмээн Полунин батлан хэлээд, би чамайг араасаа чангаахгүй шүү дээ. Харин чамайг зүгээр мэдээсэй гэсэндээ би үүнийг ярьж байна. Харин Самбист бид хоёрын төлөвлөгөө хэрэгжвэл станц дээрх чиний ажил нэмэгдэнэ. Эндхийн аж ахуйг хэн нэгэн хариуцах ёстой биш үү гэж тайлбарлав.

Шакирыч цонх руу очоод хашаан доторхийг ширтэж байснаа Полунин руу хялайн хараад:

-Иванов чамд манай энэ аж ахуй багадаа байна уу? гэж асуув.

-Шакирыч, үнэнээ хэлэхэд багадаад байна гэж Полунин шударгаар хариулаад, ямар нэгэн том үйлийг хэрэгжүүлмээр байна. Амьдрал үргэлжилж өдөр бүр өөрчлөгдөн урагшилж байхад бид нэг газраа л дэвхцэж байна...

-За, за хэмээн Шакирыч сэтгэл дундуур байгаа бололтой үгийг нь таслаад, өндөр ашиг бол ямагт хүнд асуудлуудыг дагуулж явдаг... Ашиг гэснээс... гээд дахин цонхоор харснаа, зочид ирж байгаа бололтой. Тэд зүгээр л нэг ирээгүй байх гэж миний санаа зовж байна гэлээ.

Полунин босож цонх руу очиж Шакирычийн дэргэд зогслоо. Хашаанд том хар өнгийн жийп “Гранд-Чероки” орж ирэн зогсоод дөрвөн эрэгтэй хүн гарч ирлээ. Тэдний хоёр нь тэндээ үлдэж хоёр нь хоёрдугаар давхарт гардаг шат руу чиглэн ирэв.

-Би яах вэ? Хажууд чинь үлдэх үү явах уу? гэж Шакирыч асуулаа.

-Одоохондоо үлд гэж Полунин тайван дуугаар хариулаад бичгийн ширээнийхээ ард очиж суув. Хэдэн хормын дараа өрөөний хаалга онгойж хоёр залуу орж ирлээ. Эхнийх нь түүний шөрмөслөг туранхай биенд нь таарсан цайвар өнгийн үнэтэй костюмтай, өргөн мөртэй, өндөр нуруутай залуу ажээ. Харахад хорин тав хорин зургаа орчим насны гэмээр агаад хар үсээ нямбай засуулж арагш нь толийтол самнасан харагдана. Холоос харахад царайлаг, нүдэнд дулаан мэт нүүртэй ажээ. Харин нүдний нь харц жавар хурсан хөдөлгөөнгүй байх бөгөөд байнга хөдлөх нимгэн уруулд нь үе үе инээмсэглэл тодрох нь сэжигтэй. Тэрээр цэвэрхэн нямбай хувцаслажээ. Үнэтэй костюм өмсөж цагаан өнгийн сорочкин цамцан дээр хавчаар бүхий чамин зангиа зүүж үнэ ихтэй болов уу гэмээр арьсан шаахай өмсчээ. Араас нь бор царайтай намхан нуруутай бужгар үстэй туранхай залуу хэдэн алхам зайтай дагалдан орж ирэв. Эхний залуутайгаа нэгэн адил сайхан хувцаслажээ. Туранхай гонзгойдуу царай, хянган хамартай, нимгэн жимбэгэр уруулаа жимийсэн түүний хар нүдэнд нь анхааралтай бөгөөд болгоомжилсон өнгө мэдэгдэнэ. Эхний залуу нь Полунингийн ширээнд дөхөж ирээд сандлыг хөлөөрөө хөдөлгөн тэгшилснээ шийдмэг янзтай сууж пиджакныхаа товчийг тайллаа. Тэрээр зөөлөвтэй сандлын хажуугийн тохойвчин дээр гараа тавьж толгойгоо бага зэрэг гилжийлгэн Полунинг анхааралтай ширтэнэ. Нөгөө залуу нь хажууд нь ирж зогсоод Полунин Шакирыч хоёрыг хүйтэн нүдээр цоо ширтэх ажээ. Тэрээр инээмсэглэх үү үгүй юу гэдгээ шийдэж ядаж байгаа юм шиг уруулаа эвгүй хөдөлгөх ажээ.

-Чи Володя Седой мөн биз дээ гэж Полунины эсрэг талд сууж байсан залуу асуулаа.

-Соёлтой хүмүүс намайг Владимир Ивановыч гэж мэддэг юм хэмээн Полунин урилгагүй зочдыг урьдын адил тайван ширтсээр хариулав.

Зочин зөвхөн инээмсэглэх аядаад:

-Намайг Сатаров Олег Григорьевич гэдэг. Та ийм хүнийг сонссон биз ээ? гэж өөрийгөө танилцууллаа.

-Сонссон юм байна гэж Полунин хариулаад, харин чиний ард зогсож байгаа бие хамгаалагч чинь хэн юм? гэж асуув.

-Шооч хүн юм та гэж Сатаров мушийн инээмсэглээд, чиний энэ өвгөн нягтлантай чинь адил бие хамгаалагчтай адилгүй хүн гэж Сатаров цонхны дэргэд зогсож байсан Шакирыч руу толгой дохин хэлэв.

-Чи дэмий ярьж байна. Шакирыч бол алтан гартай мастер хүн. Энд нягтлан бодогчийн ажлыг хавсран хийдэг юм. Ямар ч байсан мөнгө даатгаж болно гэж Полунин хариуд нь хэлэв.

-Харин миний нэрийг Веселовский Александр Михайлович гэдэг хэмээн зогсож байсан залуу өөрийгөө танилцуулаад, би “Нефтьоргсинтез” гэдэг үйлдвэрийн ерөнхий захирал байна гэлээ.

-Та нар хаалга тогшилгүй орж ирээд гэртээ байгаа юм шиг миний сандал дээр зөвшөөрөлгүй суух ямар эрхтэй хүмүүс юм. Манайх тэр “Нефтьоргсинтез” гэгчийн чинь салбар биш хэмээн Полунин зэвүүцэн хэлэв.

-Чухам тийм ээ. Одоохондоо шүү хэмээн Сатаров ёжтой байдлаар инээмсэглээд таныг энэ асуудлаар ажиллаж байгаа гэж би сонссон. Ямар ч байсан өөрийн хам Антоха Самбисттай хамтран манай үйлдвэрийн үнэт цаасыг худалдан авч байгааг чинь би баттай мэдэж байна гэж ярилаа.

-Эдний хүмүүс тэр тэнэг Соловейчикийг өдөр шөнөгүй шахаж байгаа юм. Би тэр новшийг аль эрт халчихдаг байж хэмээн Веселовский нэмж хэлэв.

-Бид түүнийг түрүүний далд оруулаагүй нь харамсалтай. Тэгсэн бол энэ хот нэг ч гэсэн усан тэнэгээс салж амьсгалах агаар нь бага ч гэсэн цэвэр болохсон гэж Сатаров нэмж хэллээ.

-Мөн дөө хэмээн Полунин инээд алдаад, та нар эрт үүнийгээ хийдэг байж л дээ. Одоо бол тун хүнд болсон. Харамсалтай нь та нар хоцорчихож гэж хэллээ.

-Миний хэлэх үгийг сонсож бай Седой минь, гэж Сатаров нам дуугаар хэлээд Полунин руу бөхийн нүүрээ ойртуулаад, миний хэлснийг чи хүлээж авсан чинь өлзийтэй байх. Одоохондоо та нарыг тэндээс ар бөгс рүү чинь өшиглөн хөөчихөөгүй байгаа дээр тэр новшийн еврейгээ аваад заводаас холдож үз гэж сүрдүүлэв.

-Мөн! Алив сонсож бай бацаан минь гэж Полунины дуугарахад царай нь зэвхийрч шанааны нь булчин зангирч байсан боловч урьдын адил тайван дуугаар:

-Хэрэв чи цаашид надтай ийм дуугаар харьцах юм бол энэ еврейнхээ хамт өөрөө эндээс үсрэн гарах болно. Хэрэв чи надтай ажил хэргийн талаар ярилцахаар ирсэн бол сэтгэцийн гажигтай хүүхдүүдийн сургуулийн сурагч шиг биш эрүүл хүн шиг ярьж үз гэлээ.

Сатаровын нүүр чулуу шиг болж нүд нь гөлрөн Полунин руу чиглээд уруулаа тас жимийлээ. Нэг хоёр мөчийн дараа ярьж суугаа хоёр бие биенээ заамдан авахад бэлэн болоод байсан юм.

-Тэд хоёулхнаа ярилцсан нь дээр юм шиг байна гэж Шакирыч цонхноос холдонгоо дуугараад Сатаровын сууж байсан сандлыг тойрон явж Веселовскийд дөхөж очоод мөрнөөс нь барьж

хуванцар тоглоом шиг хөнгөхнөөр эргүүлмэгцээ:

-Хүү минь, гарья эндээс гэж эцэг нь юм шиг эелдэгээр хэлээд Веселовскийг хаалганы зүг аяархан түлхээд, том ах нар өөрсдөө ярилцаг. Хэрэгтэй гэж үзвэл юу ярьснаа дараа нь бид хоёрт хэлнэ биз гэлээ. Шакирыч түүнээс бүтэн толгой өндөр нуруутай, бараг хоёр дахин өргөн биетэй учир Веселовский юу ч хэлж чадсангүй. Тэрээр Сатаровыг асуух мэт ширтсэн боловч тэр нь түүний зүг харсан ч үгүй учир Веселовский өрөөнөөс дуугүй гарлаа. Гарах хаалга хаагдсаны дараа Полунин:

-Олег чи надад чухам юу гэж хэлэх гэсэн юм бэ? гэж Сатаровоос асуув.

-Хэлэх гэсэн үгээ би дөнгөж саяхан чамд хэлсэн хэмээн Сатаров шүд зуун хэлээд манай үйлдвэрийн хувьцааны тасалбарыг худалдаж авах ажлаа зогсоож үз. Энэ үйлдвэр миний “хавхаг” дор байдаг учир тэнд юу хийхээ зөвхөн би мэднэ. Бас тэр хувь нийлүүлэгч болохыг оролдож байгаа Коля-Решето надад хүрэлцээтэй хүндрэл учруулж байхад бас та нар гарч ирлээ. Самбист та хоёр хэр хэмжээгээ мэдвэл таарна гэв.

-Хэмжээгээ мэдэхгүй байгаа нь чи өөрөө байна хэмээн Полунин хариулаад, тэр үйлдвэр чиний “хавхаг” доор байгаа ч гэсэн одоохондоо чиний хувийн өмч биш. Чиний өөрийн чинь хувийн нутаг дэвсгэр гэж хэнтэй чи тохиролцоов? Коля Решетотай юу, эсвэл Самбисттай юу? Ер нь чи яагаад тэдэн рүү биш, над руу хүрч ирсэн юм? гэж асуув. Тэгтэл Сатаров ухасхийн босож Полунин руу бөхийгөөд:

-Седой! Чи бүү тэнэглэ. Чи тэр хүний гол зөвлөгч гэдгийг цөмөөрөө мэдэж байгаа. Тэр чинь зөвхөн чиний хэлснээр явах хүн. Би түүнтэй ярих шаардлагагүй. Тийм учраас тэр завод руу минь бүү өнгий гэж хэлэхээр би чам руу шууд хүрч ирсэн. Хэрэв энэ явдлаа даруйхан зогсоохгүй бол та нарын хохь чинь болно шүү. Ойлгов уу? гэж Полунины нүд рүү хуруугаараа чичлэн орилов.

Тэгтэл Сатаровын хувьд гэнэтхэн санаандгүй юм болж Полунин зүүн гараараа түүний чичиж байсан хурууг атган аваад баруун гараараа үснээс нь атган толгойг нь ширээн дээр хүчтэй дарж орхилоо. Сатаров өвдсөндөө болж зэвхийрэн цайрч хөдөлж ч чадсангүй.

-Май чи, зангиа зүүсэн нусгай минь! гэж Полунин түүний чихэнд зандраад, би чиний балайрахыг анхааралтай бөгөөд тэсвэртэй сонсож байсан. Одоо залхаж орхилоо. Одоо чи намайг анхааралтай бөгөөд тэсвэртэй сонсох ээлж чинь. Чи ажил хэргийн талаар надтай ярилцах гэж ирсэн бол дэмий юм бүү дүрсгүйтэн чалч гэдгийг нэгмөсөн санаж ав. Хоёрт, хэрэв чи хэн нэгэнд юмыг ойлгуулж итгүүлэх гэсэн бол эхлээд тэр хүнээ сайн мэдэж ав. Хэрэв чи миний занг урьдчилан судалж мэдсэнсэн бол надтай ингэж харьцаад огт тус болохгүй гэдгийг ойлгосон байх ёстой байсан. Би амьдралдаа их юм үзсэн толгой. Чам шиг хүн надтай бишгүй нэг тааралдаж байсан юм. Гуравт, үүнийг чи хэзээ ч мартаж болохгүй. Хэрэв чи ямар нэгэн хэргийг бүтээх гэж барьж авсан бол эхлээд энэ талаар хүмүүстэй зөвлө. Хүний үгийг сонс. Ашиггүй хэрүүлээс тус багатай найрамдал хэзээ ч илүү байдаг. Зөвхөн хөлдүү толгойтнууд тэнэгүүд юу юунаас түрүүнд байлдахаа урьтал болгодог. Ухаалаг хүмүүс асуудлыг хэлэлцэж шийддэг юм. Би энэ дүрмийг аль эртнээс баримталж ирсэн. Ингэж яваасай гэж би чамд ч зөвлөх байна. Харин одоо эхний шат өнгөрсөн бол алив дараачийн

шатыг тайван ярилцаж шийдье. Асуудлыг хойш тавилгүй одоохон шийдэх нь зүйтэй гэж зөвлөлөө. Тэгснээ түүний гарыг тавьж толгойг нь түлхэж өөрөөсөө холдуулав. Сатаров тэнцвэрээ олж ядан ганхаж байснаа түрүүний сууж байсан сандал дээрээ лагхийн шигдэн суулаа. Дараа нь өвдсөнөөсөө болж нүүрээ үрчийлгэн гэдсэн дээрээ баруун гарынхаа алгыг тавиад зүүн гараараа эрчимтэй үрж гарлаа.

-Муу нохой хэмээн Сатаров хорсон сийгүүлээд, чи харамсах болно доо гэлээ.

-Чамтай ингэж харьцсандаа би хэдийнээ харамсаж байна. Гэвч өөр арга байсангүй. За тэгээд ярилцах уу? гэж Полунин асуув.

-Чамтай ярилцах юм юу ч байхгүй хэмээн Сатаров бачимдан дуугараад, та нарт хоёрхон сонголт байна. Нэг бол сайн дураараа заводаас холд, эсвэл бид та нарыг тэндээс хэвтээ байдлаар гаргаж зайлуулах болно гэлээ.

-Харамсалтай байна хэмээн Полунин мөрөө хавчин хэлээд, чи минь санасныг бодвол сүрхий чадварлаг сурагч таарлаа. Дараа нь энэ тухай чи өөрөө надаас сөхрөн гуйх болно гайгүй гэв.

Сатаров босож юм хэлэлгүй хаалга руу чиглэн алхлаа.

-Хүлээж бай гэж Полунин араас нь хэлээд, наад үс толгойгоо янзалж үз. Ийм байдалтай болчихоод явааг чинь танай хүмүүс харчихвал эвгүй юм бодно гэж цаашлуулав.

Сатаров зогтусан зогсоод хананд бэхэлсэн жижиг толины өмнө очиж зогсоод халааснаасаа сам гарган халимагаа хичээнгүйлэн самнаад Полунин руу зэвүүнээр харц чулуудсанаа гарч явлаа.

Шакирычийн эргэж ирэхэд Полунин цонхны дэргэд зогсоод урилгагүй зочид хэрхэн хашаанаас гарч явахыг бодлогошрон харж байв.

-За яав? Яриа тохирсонгүй юу?

Полунин дуугүй толгой дохилоо.

-Өнөөдрийн хувьд тохирсонгүй хэмээн Полунин хариулаад, энэ залуу ямар хүнтэй тохиролцох гэж байгаагаа ойлгов бололтой. Гэвч яаж тохиролцохоо мэдэхгүй байна. Ямар ч гэсэн толгой нь ажилтай л юм шиг залуу байна гэлээ.

-Гэвч тэр миний ойлгосноор дээврээс дээгүүр сэхүүн залуу бололтой хэмээн Шакирыч бага зэрэг түгшүүрлэсэн өнгөөр дуугараад, эцсийн эцэст энэ явдал юунд хүргэдэг бол? гэж асуув.

Полунин ойлгомжгүйгээр мөрөө хавчаад:

-Мэдэхгүй. Бүх юм хэрхэн харьцахаас хамаарна. Ухаалгаар уу эсвэл мунхагаар уу? гэж хариулав.

Хоёрдугаар бүлэг

Нүдээ аньж сандлын түшлэгт толгойгоо тавиад жигд амьсгалж байгаа Полунин унтчихсан шиг Лобниковт санагдсан боловч түүнийг тамхиа гаргахаар халаас руугаа гараа явуулахыг мэдмэгц нүдээ нээж сэжиглэсэн мэт түүнийг харлаа.

-Ер нь чи Сатаровыг хэзээнээс мэдэх болсон юм бэ? гэж Полунин гэнэтхэн асуув. Валера мушилзан инээмсэглээд:

-Өнөөдөр хүртэл би түүнийг бараг мэдэхгүй байсан гэж хэлж болно гэж хариулав.

-Чиний хариулт хачин санагдаж байна хэмээн Полунин хорсолтой инээмсэглээд

-Манай хотод юу болж байгааг чи мэдээгүй юм гэж үү. Зөвхөн манайхныг самгардуулаад зогсоогүй төвийн сонинуудад түгшүүр зарлан гарч байгаа тэр аймшигтай аллагуудын талаар чи сонсоогүй юу? Чи үүнээс өмнө далайн дундах алс холын нэгэн хүн амьтангүй арал дээр бус харин Сатаровтой хамтран ажиллаж байсан шүү дээ. Түүний юу хийж байгааг мэдэхгүй байна гэж үү? гэж асуув.

-Тэр бүхэн надад хамаагүй байсан юм гэж Лобников ядрангуй байдлаар хариулаад, учир нь энэ бүхэн чинь өөр ертөнцөд болж байсан юм. Тэр танай хулгайч дээрэмчдийн ертөнцөд гэсэн үг. Харин би компанийн тодорхой нэг асуудлыг хариуцаж байсан. Та нарын хэрэгт оролцохыг хүсээгүй. Тодорхой ярих юм бол би хөндлөнгөөс тооцоо бүртгэлээ хийж байсан гэлээ.

-Тулалдаан болж байхад сүүлийн машин дотор сууж байхдаа үхэхгүй гэж бодож байгаа гэнэн хүний төөрөгдөл гэж Полунин хэлээд, зарим үед үндсэн хүчийг нь устгахын тулд дайсан машин техникийг нь хамгийн түрүүнд бөмбөгддөг юм. Тийм учраас чи тэр хөндлөнгийн тооцоо бүртгэлээ хийж байхдаа тулалдааны яг төв дунд сууж байсан хэрэг. Хэрэв Сатаров таныг хамгаалалтын хүч муутай хэсэг гэж үзвэл хамгийн түрүүн тань руу хөлсний алуурчныг илгээх болно гэв.

* * *

Сатаровтай хийх мөргөлдөөн тун эрчимтэй өрнөснөө мөн адил хурдан замхарчээ. Сатаровын Полунинтай уулзаж таагүй яриа өрнүүлсэн тэр өдөр “Нефтьоргсинтез” заводын ерөнхий инженер Григорий Соловейчикийн албан өрөөнд хоёр хүн орж ирлээ. Григорийн нарийн бичигч дөчөөд насны махлаг хүүхэн Анастасия Павловна хувьцааны асуудлаар түүнтэй уулзахаар хоёр хүн ирээд байна гэж дотор утсаар мэдэгдэв.

Григорий тэднийг хүлээж авахыг зөвшөөрөөд дотор нь мөнгө болон үнэт цаас хадгалсан сейфээ онгойлгохоор хэлхээтэй түлхүүрээ гаргаснаа орж ирж байгаа хүмүүсийг сэрэмжлэн харлаа. Учир нь тэр хоёр хүн жирийн ажилчидтай огт адилгүй байсан ажээ. Тэд үйлдвэрийн ажилчдын ажлын хувцастай байсан боловч бүдүүрсэн булчин, тарган нүүр нь өлөн зэлмэн явдаг ажилчидтай нь огт төсөөгүй байв. Тэд хоёулаа хоёр метр орчим өндөр нуруутай агаад

халимаг үсээ богинохон тайруулан засуулжээ.

-Залуус минь, та хоёр аль цехийнх вэ? хэмээн Гриша түлхүүрээ өмднийхөө халаасанд хийх зуураа асуув. Дараачийн агшинд түүний хамгийн эвгүй таамаглал зөв байсныг мэдлээ. Тэдний нэг нь сандал авч хаалганы бариулын цаагуур хөлийг нь шургуулан түгжиж орхих нь тэр. Гриша өөрийн эрхгүй гэдэргээ ухарч айснаасаа болж арайхийн дуугарч:

-Залуус минь, яаж байна... Би яасан юм... Арай та нар намайг... хэмээн бувтнав.

-Бид Сатаровын цехийнхэн гэж нэг дээрэмчин нь инээд алдан хариулаад, бид чамайг хэр их хувьцаа цуглуулсныг чинь шалгахаар ирлээ гэв.

Соловейчик бүдүүн богино хөлөө майжигануулан гүйж ажлын ширээнийхээ ард очоод хоёр гараа дэлгэн

-Залуус минь, залуус минь, алив ярилцъя гэлээ.

-Мэдээж ярилцах болно. Бүдүүн бөгст минь гээд нэг дээрэмчин нь ширээг нь тойрч ирснээ, харин бид өөрийн хэлээр чамтай ярилцана гэв. Дээрэмчин гараа хүргэмээр ойр ирсний нь дараа тэрээр дуугаа өндөрсгөн:

-Би Самбистын төлөө ажиллаж байна гэлээ.

-Чи тэгвэл одоо эмийн сантай харьцаж ажиллах болно гээд дээрэмчин залуу баруун гарын хүчтэй цохилтоор эрүү рүү нь явуулж орхив.

Нөгөө дээрэмчин нь гэдэс рүү нь өшиглөлөө. Тэдний хүчтэй довтолгоонд Григорий агшин зуур гэдэргээ савж унахдаа ард байсан сандлын хамт шалан дээр тэрийн ойчлоо. Түүний ойчих чимээ бүр нарийн бичигчид нь дуулдахаар чанга сонсогджээ. Шалан дээр хэвтээ Григорийг дээрэмчид нэрвэн өшиглөсөөр байлаа. Ухаантай ухаангүй болсон тэрээр өөрийн эрхгүй нэг гараараа нүүрээ нөгөө гараараа эмзэг газраа халхлахыг оролдоно. Тэгтэл хүнд гэмтэл авахаас нь Анастасия Павловна аварч чадлаа. Шефийн нь өрөөнд түжигнэх дуу сонсогдоход хүүхэн хаалганд нь үсрэн хүрсэн боловч дотроосоо түгжээтэй байсан учир улам айж хаалгыг нь хүчтэй балбаж гарав.

Энэ үед дээрэмчид үүргээ гүйцэтгэлээ одоо зайлах хэрэгтэй хэмээн ойлгоод хохирогчийнхоо гэдэс рүү дахин хүчтэй өшиглөхөд Соловейчикийн дуу заводын удирдах газрынханд цөмд нь дуулдахаар сонсогдсон юм.

-Хэрэв чи дахин нэг цаас худалдаж авбал чинь бид чиний гэдсийг чинь гаргаад хүзүүгээр чинь ороож орхино гэж нэг этгээд нь сүрдүүллээ. Өрөөний хаалга гэнэтхэн онгойж Анастасия Павловнагийн өмнө яргачин залуус зогсож байхыг тэрээр хармагц нүд нь бүлтийн балмагдаж орхилоо. Хоёр дахь залуу нь эмэгтэйн толгойг хавчин бариад хаалганаас холдуулаад:

-Дутуу саалгуулсан үнээ шиг юундаа бухимдаад байгаа юм бэ? хэмээн шүдээ сийгүүлэн

асуулаа.

-Наанаа дуугүй сууж бай. Тэгэхгүй бол чинь бид одоохон дэлэн хөхийг чинь хоослож орхино гэж түрүүчийн дээрэмчин нь хэлээд өгзөг дээр нь алгадаж орхив. Анастасия Павловна айснаасаа болж тэдний гарч явтал хөдөлж ч чадсангүй. Тэдний явмагц Соловейчикийн өрөөнд орж, нүүр ам нь нил цусанд будагдсан шефийнхээ шалан дээр хэвтэж байхыг харав.

-Ээ бурхан минь! Таныг яаж орхих нь энэ вэ? гэж эмэгтэй уулга алдан дуугараад халааснаасаа алчуур гарган мань хүн рүү бөхийлөө. Хариуд нь Григорий аяархан ёолоод тохойгоо тулан арайхийн өндийж хана түшин суулаа.

-Чөтгөр ав. Их өвдөж байна гэж Григорий хэлээд халаасаа дарж үзсэнээ, Бурхны аврал! Ашгүй сейфны түлхүүр минь байна гэв.

Анастасия Павловна цус болсон нүүрийг нь цэвэрлэж байхад Гриша ичиж зоволгүй цүндгэр гэдсээ гарган иллэг хийж байв.

-Цагдаа дуудах уу? гэж бичээч нь асуулаа.

-Хэрэггүй гэж Гриша бухимдан хэлээд, цагдаа нар тэднийг тэртээ тэргүй олохгүй. Харин хэсгийн эмнэлгээс сувилагчийг дуудчих. Алив утас аваад өг. Би хөдөлж чадахгүй байна гэв.

Бичээч эмэгтэй гарч явсны дараа тэрээр Самбист руу утсаа залгалаа.

-Антоша хэмээн Соловейчик дорой дуугаар гаслан дуудаад, над руу дөнгөж саяхан дайрч ороод нүдэж орхилоо... Тийм ээ... Би цусандаа холилдчихоод хэвтэж байна... Үгүй, үгүй. Би цааснуудыг тэдгээр новшнуудад алдаагүй. Далимд хэлэхэд өнөөдөр муугүй наймаа хийсэн гэж хэлэхдээ дуу нь илтэд сэргээд ирлээ. Гэвч удалгүй дахин түүний дуу суларч уйлагнаад:

-Тэнгэр минь! Миний бүх бие хэрхэн өвдөж байгааг чи мэддэг ч болоосой гэлээ.

* * *

Тэр өдрийн орой Полунин Самбист хоёр Григорийг эргэхээр гэрт нь очлоо. Григорий савхин бүрээстэй буйдан дээр дэр тавиад хажуулдан хэвтэж байв. Түүний нүүрний зарим хэсэгт шархны лент наалттай байх бөгөөд цагаан малгай өмсгөсөн мэт толгойг нь боолтоор боожээ. Хажууд нь түрүүчийн танил “Зенит” спорт клубийн иллэгчин Ксения хүүхэн түүнийг асарч сууна. Зочид Григорийн эсрэг талд байгаа сандал дээр суумагц:

-Яаж байгаад ингэж орхив оо? Чи юунд хамгаалалтын хүмүүсээ хашааны гадна байлгасан юм бэ? гэж Антон харамсан асуув.

-Өнөөдөр хүртэл бүх юм тайван байсан юм, Антоша минь. Иваныч өглөө надтай утсаар ярьж сэрэмжтэй байхыг сануулсан боловч хоёрхон цагийн дараа тэр дээрэмчид хүрч ирээд намайг нүдэж орхилоо гэж Гриша хэлээд том хар нүднээс нь нулимс гарч гараараа өөрийн мэдэлгүй хөндүүр газраа дарлаа.

-Зүгээр ээ. Хонгор минь. Тайвшир даа хэмээн зөөлөвчтэй сандлын тохойвчин дээр сууж байсан Ксения хэлээд өөрийн уран нарийн хуруугаараа түүний унжсан мөрийг нь илээд уруулаа боолттой духан дээр нь зөөлөн хүргэлээ.

-Хөөрхийг чинь ийм болгочих гэж дээ. Гэвч санаа бүү зов. Тайвширч үз. Хурим хүртэл зөв зүгээр болно...

Гриша урьдын адил гиншин мөрөө чичигнүүлж байгааг харж суусан Самбист бухимдан:

-Ксения минь тэр охин бяруунуудынхаа энхрийлэлтэйгээ холдож үз. Бидэнд чамгүйгээр ярилцах чухал юм байна гэлээ.

Ксения гомдолтой харц чулуудаад гал тогооны өрөө рүү явж орлоо.

-Тэд өөр юу чамд ярьсан бэ? гэж Самбист асуув.

-Өөр юу ярих ёстой юм? Тэд эрүүл энхийг ерөөх гэж над дээр ирээгүй нь лавтай хэмээн Гриша цухалдан хэлээд, хэрэв би тэр хувьцааны наймаагаа зогсоохгүй юм бол өлөн гэдсийг минь гаргаж хүзүүгээр минь орооно гэж сүрдүүлсэн гэв.

-Ойлгомжтой хэмээн Антон хүндээр санаа алдаад Полунин руу хараагаа шилжүүлснээ, Сатаров хэтэрхий огцом аашилж байна гэж чамд бодогдохгүй байна уу, Иваныч? Өглөө нь чамтай уулзаж ярилцсан, үд гэхэд Гриша руу дайрлаа. Чи түүнд ингэж хилэнгий нь хөдөлгөхөөр юу хэлсэн юм бэ? гэж асуув.

-Антоша минь, би түүнд сайн юм хэлээгүй нь мэдээж хэмээн Владимир ядрангуй дуугаар хэлээд, урьд нь бэлдэж байсан учир тэр ийм огцом хөдөлж байгаа юм. Ойрын үед тэднээс дахин санаанд оромгүй зүйл гарч мэдэх учир бид маш сэрэмжтэй байх хэрэгтэй. Хаана ч явсан хамгаалалтгүй явж болохгүй. Бүр жорлонд орохдоо ч тэр гээд Соловейчик руу харж, онц шаардлагагүй бол гэрээсээ бүү цухуй. Үл таних хүмүүст хаалгаа бүү тавьж өг. Тэр шөнийн клуб, саун зэрэг газраар шөнө орой хэсүүчилдэг явдлаа зогсоо гэж шийдмэг санууллаа.

Ингэж хэлэхэд нь Антон түүн рүү духуйн ширтээд дургүй нь хүрсэн янзтайгаар:

-За боль доо Иваныч. Спорт клуб найдвартай хамгаалалттай бүр хорин дөрвөн цагийн гэж ярьтал гар утас нь дуудлаа.

Полунин утсаа залгаж:

-Полунин сонсож байна гэж хэлэв. Тэрээр цаад хүнээ хэдэн минут анхааралтай сонсож байснаа:

-За би цөмийг ойлголоо. Одоо гэртээ хариад хамгаалалтынхан хүрч очтол сууж бай гэв.

Тэрээр утсаа салгаад Гриша Самбист нарыг доогтой инээвхийлэн ширтсэнээ:

-Танай тэр халуун усны болон сауны илээч хүүхнүүдийн хорхойтой бас нэгэн хүн Славка Болдин спорт клубээс ярьж байна. Хажуугаар нь өнгөрч явсан машин дотроос клубийн цонх руу автоматаар галласан гэнэ гэх нь тэр.

-Хүн амьд уу? гэж Самбист сандран асуув.

-Бурхны авралаар хүн өртөөгүй гэнэ. Спорт зааланд ердөө л гурван хүн байсан, бусад нь доод хонгилд саунд орж байсан юм байх. Тэгсэн учраас тэд энэ удаа амьд гарчээ гэж Полунин хариулав.

-Спорт зааланд байгсад нь зүгээр үү?

-Нэг нь хагарсан шилний хэлтэрхийд онуулж бага зэрэг зүсүүлсэн гэнэ. Славкийн ярих нь тэр буудсан хүн нь хүн алах зорилгогүй байсан бололтой гэнэ. Учир нь ихэнх сум нь цонхны дээд талаар хананд нэлээд дээгүүр тусаж байсан юм байх.

-Айлгаж байгаа нь тэр, нохойнууд гэж Антон нүсэр том нударгаа зангидан шүдээ зуун хэлээд, за яахав чамд би цусыг чинь хөртөл наадам үзүүлээд өгье л дөө гэлээ.

-Тэдэнтэй ёсорхоод байсны хэрэггүй хэмээн Григорий гэнэтхэн дуу алдан хилэгнээд биднийг цөмийг маань огтолж алаагүй байгаа дээр нь тонилгох хэрэгтэй гэж хашгирлаа.

Тэгтэл Полунин, амаа тат гэм! гэж үгийг нь таслан зандраад, чиний ажил бол хувьцааны тасалбар худалдаж авах явдал юм. Түүнийгээ л чи хий. Бас миний хэлсэн ёсоор өөрийн аюулгүй байдалд санаа тавь гэлээ.

-Тэд чинь ямар ч байсан тайван суулгахгүй гэж Соловейчик түгшүүрлэж дуугарав.

-Энэ бол чиний санаа зовох хэрэг биш. Энэ бол Антон бид хоёрын санаа зовох хэрэг. Тэр асуудлыг чинь бид хоёр шийднэ гэж Полунин хэллээ.

Тэрээр яриа дууссаныг мэдэгдэж босоход Антон мөн адил даган бослоо.

-Харин бие чинь яаж байна? Маргааш ажилдаа очиж чадах уу? гэж Полунин асуув.

-Чадна гэж Григорий сулхан хариулаад очих замд минь алчихгүй бол гэлээ.

-Бүү санаа зов гэж Самбист инээмсэглэн хэлээд эхний дугаарт Иваныч бид хоёрыг ална. Харин дараачийн дугаарт чамайг гэв.

-Энэ чинь тийм ч тайтгаруулаад байх үг биш дээ хэмээн Соловейчик хариуллаа. Полунин Сеницын хоёрыг Ксения орж ирэн гаргаж өгөөд Антон эвлэрэнгүй дуугаар:

-Чи ч гэсэн эндээ сууж бай. Спорт клуб рүү бүү оч. Осолтой болоод байна. Энэ Григорийг асарч байгаарай гэж хэллээ.

-Тэгье. Григорийг удахгүй хөл дээр нь босгоно гэж Ксения хэлэв.

Антон инээмсэглэн, тоглоом хийж:

-Гриша ингэж хэвтээ боловч чамд хэрэгтэй юм нь босоо хэвээрээ байгаа гэлээ.

-Тийм ээ. Бүү санаа зов гэж Ксения инээмсэглэн Сеницынд хандан хэлээд, би бүр та хоёрын ирэхээс өмнө шалгаж үзсэн. Аппарат хэрэгсэл огт гэмтээгүй байна билээ гэж мөчөөгөө өгөлгүй хариу хэлэв.

-Мөн дөө. Ямар амь бөхтэй эд вэ? хэмээн Самбист гайхах байдлаар хэллээ. Самбист Полунин хоёр өөрсдийн жийпд сууж саяхан спорт клубт харсан Николай гэгч залуу жолоо барилаа. Машин Соловейчикийн байшингийн дэргэдээс хөдөлсний дараа Антон Полунингаас:

-За яах вэ, Иваныч? Хариу өгөх үү? Тэгэхгүй бол удахгүй тэр новш чинь бидний шуудангийн хайрцагт бөмбөг тавих болно гэж асуулаа.

-Тийм ээ. Хэдийнээ бөмбөгөө тавьчихаагүй бол гэж хэлээд Полунин бодлогоширов.

-Яг үнэн хэмээн Антон батлан дуугараад, хариу өгөх цаг нэгэнт болсон гэлээ.

-Хотод том мөргөлдөөн гаргахыг хэн ч бидэнд зөвшөөрөхгүй, тэгээд ч тийм дайн бидэнд хэрэггүй. Бидний хувьд ялалт нь хэтэрхий үнэтэй олдож юу магад гэж Полунин хэллээ.

-Тэгээд чи яая гэж бодож байна?

Полунин янжуураа хүчтэй сорон машины өнгөт шилэн цонхоор үлээн гаргаснаа

-Сайн мэргэн буудагч хэрэгтэй гэлээ. Антон ингэж хэлэхийг нь хэдийнээ хүлээж байсан мэт:

-Надад тийм хүн бий гэв. Тэгснээ жолоо барьж яваа залуугийн мөрөн дээр гараа тавьж:

-Энэ Николай. МВД-ийн тусгай ангид алба хааж байхдаа нэг биш удаа халуун цэгийг өнгөрөөж байсан. Мэргэн буучийн цэрэгжлийн мэргэжил эзэмшсэн хүн гэлээ. Полунин тэр залуугийн нүүрийг арын толинд хараад харц мөргөлдөв. Залуу Полунингийн харцыг юу ч болоогүй юм шиг харснаа эргэж замаа харлаа.

-Санаа зовсны хэрэггүй, Иваныч. Энэ бол найдвартай хүн. Би өөртөө итгэхээс илүү энэ залууд итгэдэг гэлээ.

-Тэгвэл та хоёр тун анхааралтай сонсож бай. Надад нэгэн санаа байна...

* * *

Байлдааны үйл явц “Зенит” хэмээх спорт клубийн дэргэдэх буудалцаанаар төгссөнгүй ажээ. Өглөө эрт Антоны гаргаж өгсөн бие хамгаалагчдыг дагуулан ажилдаа ирэх үедээ Полунин урьд шөнө станцын хашааны хаалган дээр дэлбэрэлт болсныг хэдийнээ мэдэж байсан юм. Энэ тухай түүнд өглөө эрт мэдэгджээ. Цагдаагийн газраас ирсэн шинжээчид цагийн механизмаар ажилладаг гар хийцийн бөмбөг дэлбэрснийг тодорхойлсон ажээ.

Станц дээр ганцхан манаач байх үед шөнийн дөрвөн цагийн орчимд энэ дэлбэрэлт болжээ. Дэлбэрэлтээс болж төмөр хаалга сарампай болж тэсрэлтийн цохих долгионд станцын цонх болон ойролцоох байшингуудын цонхнууд хагарчээ. Полунингийн ирэх үед цагдаа нар хэдийнээ явчихсан, Шакирыч ажилчдаараа эвдэрсэн хаалгыг засуулж байв.

-Шинээр хийлгэвэл дахин дэлбэлчих биз гэж бодоод ингэж байна гэж Шакирыч бувгнав.

Полунин Шакирычид юу ч хэлэлгүй өөрийнхөө албан өрөө рүү чиглэн явлаа. Түүний хоёрдугаар давхарт дөнгөж гартал утас нь дуугарав. Соловейчик утасдаж ээлжит явуулгын талаар мэдэгдлээ. Шархны боолттой Григорий гурван бие хамгаалагчийн хамт өөрийн төрөлх үйлдвэр дээрээ хүрч иртэл гэнэтийн явдал хүлээж байжээ. Түүний хүрч очтол үйлдвэрийн санхүүгийн хүнд байдлыг харгалзан үзэж ерөнхий захирлын тушаалаар түүнд ээлжийн амралтыг нь олгосон гэх шалтгаанаар заводын цэрэгжүүлсэн харуул оруулахгүй нэлээд удаан хугацаагаар хаалган дээр саатуулжээ. Соловейчик харуул өвгөнийг хатуу арга хэмжээ авна гэж сүрдүүлэн загнасны хүчинд ямар ч гэсэн заводын хашаанд орж өөрийн өрөөнд хүрч очтол хаалгыг нь өөр төмөр хаалгаар сольсон байх нь тэр. Хаалганы түлхүүрийг мэдээж түүнд хэн ч өгсөнгүй. Түүний нарийн бичигч Анастасия Павловна шефийгээ хүлээн хонгилд сууж байлаа. Түүнд ч гэсэн Соловейчикийн нэгэн адил цалингүй ээлжийн нь амралтыг олгосон байсан учир яах учраа мэдэхгүй сууж байв. Григорий бараг хагас өдрийн туршид боловсон хүчний ажилтнуудыг ерөнхий захирлын тэр тушаал хууль бус хүчингүй хэмээн батлан зандарч байлаа. Гэвч Веселовский үйлдвэр дээр байхгүй байсан учир тэр тушаалыг нь өөрчлөх эрхтэй хүн байсангүй. Тэр тушаал бол ядаж бага хэрэг. Гол нь өрөөний нь шинэ хаалганы түлхүүрийг өгөх хүн олдохгүй байсан юм. Харин бүр орой болж байхад түүнд Василий нэртэй нэгэн засварчин өрөөндөө ороход нь туслав. Тэрээр лонх архины хөлсөнд засварын жирийн багажуудын тусламжтайгаар хаалгыг нь онгойлгож өгчээ.

Гэвч Соловейчиикоос энэ явдлын тухай сонсоод Полунин тэр үйлдвэрийн хашаан доторхи сөргөлдөөнд өөрсдийгөө ялахгүй нь бололтой гэж ойлголоо. Веселовскийн засаглалын хүч чадал Соловейчикийнхоос хамаагүй илүү байв. Полунин бүтэл нь хазайсан Соловейчикт тохиолдож байгаа явдлыг сонсоод тийм дүгнэлт хийж тэр даруй Антон Сеницын руу ярилаа.

-За тэгэхлээр Антон ингэе. Хоёр дахь хувилбартаа орох нь зүйтэй байна. Мухлаг бэлд хэмээн Полунин түүнд үүрэг өгөөд, түрээсийн зөвшөөрлийн талаархи бүх асуудлыг би захиргаатай ярьж тохирно гэлээ.

-Ойлголоо Иваныч гэж Сеницын зөвшөөрөн хариулаад, мухлаг бэлэн. Өнөөдөр орой хүмүүст харагдахуйц газар байрлуулна. Орой танайхаар очье гэж хариулав.

-Үгүй ээ. Өнөө орой хэрэггүй. Би эхнэр хүүхдээ энэ үймээнээс хол зуслан руу аваачих гэж байна гэж Полунин хэллээ.

-За, би ойлголоо хэмээн Самбист хэсэг дуугүй байснаа хэлээд, хэрэв дахиад шинэ юм гарвал утсаар ярилцъя гэлээ. Антонтой ингэж ярилцасны дараа Полунин шууд утасны өөр дугаар дарлаа.

-Сайн уу, Василий Алексеевич? Би Владимир дахин л чамд саад болж байна. Би түрүүний

ярьж байсан зүйлийнхээ талаар эргэж хэлэх гэсэн юм.

-Сайн, сайн, Иваныч гэх эрэгтэй хүний бөглүүдүү дуу сонсогдож, би цөмийг чиний хэлсэн ёсоор хийсэн. Чи өөрөө мэдэж байгаа, энэ талаар утсаар ярьсны хэрэггүй биз. Чи өнөөдөр зусландаа очих уу? гэж асуулаа.

-Очно. Одоо явахаар бэлтгэж байна.

-Сайн байна. Тэнд очоод ярилцъя.

-Орой уулзъя. Баяртай гээд Полунин утсаа салгав.

Цагдаагийн дэд хурандаа Василий Алексеевич Крикунов Мужийн замын цагдаагийн удирдах газрын орлогч дарга хүн ажээ. Василий Алексеевичийн зуслан Полунинны зуслантай хөрш зэргэлдээ оршдог байв. Тэдний зуслангийн хоёр давхар байшин хотоос холгүй байдаг Анисовка тосгонд байдаг ажээ. Энд голдуу хотын дээд ноёд түшмэлүүдийн зуслан байх бөгөөд хэдэн жилийн өмнө Полунин энд бэлэн байшинг чамгүй өндөр үнээр худалдаж авсан юм. Түүнээс хойш Полунин зуслангийн олон хөршүүдтэйгээ танилцсан бөгөөд заримтай нь ажил төрлийн ч холбоо тогтоож амжжээ. Ялангуяа Полунин Крикуновтой дотно танилцаж бизнесийн ажлаар түншлэн ажиллах болсон байлаа. Василий Алексеевич бол Полунинны эрүүгийн бизнесийн нууц түншүүдийн нэг бөгөөд хулгайн машины баримт бичгүүдийг бүрдүүлж өгдөг байлаа. Харин тэр хоёрын “нөхөрлөлийн” энэ талыг хэн ч мэддэггүй байв. Василий Иванович өөрөө Полунинтай холбоогоо бэхжүүлэх бүх талын бололцоог бүрдүүлдэг байв. Ер нь Полунинны засвар үйлчилгээний газраар өөрсдийн машиныг засварлуулдаг хотын олон дээд түшмэлүүд бий болсон ажээ.

Харин өнөөдөр Полунин Василий Алексеевичид огт өөр асуудлаар хандсан юм. Полунин оройхон хэрд очоод түүний зуслангийн хашаны явган хаалгыг онгойлгоход кавказ үүлдэрийн нохой нь хуцах чимээгээр Василий байшингаасаа гарч ирээд түүнийг хармагцаа гараа алдлан нүүр дүүрэн инээмсэглэн зочноо угтаж ирлээ.

-Чамайг ирсэнд баяртай байна Владимир Иванович хэмээн Крикунов зочноо тэврэн баяр хөөр болон хэллээ.

Тэр хүн бол нуруугаар Полунинтай бараг чацуу боловч хөндлөнгөөр хамаагүй илүү нэгэн ажээ. Василий Алексеевич дөч нас хүрэх үедээ жин нь ихэд нэмэгдэж, харин толгойн нь үс нэлээд хорогджээ. Зулайнхаа үсний хорогдлыг нөхөх зорилгоор ширвээ сахал тавьсан нь тун зохисон байв.

-Алив. Ор, ор Володя, би өчигдөр өнгөрсөн жилийн ургацаар лонх юм нэрсэн юмсан. Би тэгэхэд усан үзмийн талбайд тэгж эргүү юм шиг дэмий эргэлдэж байгаагүй юм байна гэдгийг минь чи ойлгож байна уу? Чи одоо амсаж үзээд хэл. Чи ямар тансаг дарс гаргасныг минь гайхах болно гэж баярлан хэллээ.

Крикунов Полунинны мөрөөр тэвэрч аваад гэрийн зүг алхлав.

-Би эргэлзэхгүй байна Алексеевич минь гэж Полунин хэлээд, харин усан үзмийн ундааг амсан тансаглахаас өмнө ажил хэргийн талаар бага зэрэг ярилцмаар байна гэв. Крикунов инээмсэглэж байснаа больж түүний саналыг ойлгон толгой дохиод:

-Санаа зовсны хэрэггүй, Иваныч. Би амласан ёсоороо бүх юмыг хийсэн гэлээ. Тэд зочдын уужим саруул өрөөнд ортол тэнд бас нэгэн зочин сууж байлаа. Тэр бол өндөр нуруу, хар үстэй туранхайвтар биетэй, дөч хүрээгүй насны болов уу гэмээр залуувтар эр байв. Зуны байдлаар цайвар өмд, бараан өнгийн цамц өмссөн тэр хүн Полунинг хармагцаа инээмсэглэн гараа өгч мэндлэв.

-Танилц, Иваныч. Энэ бол мужийн Дотоод хэргийн удирдах газрын (УВД) хошууч Бирюков Константин Матвеевич гэдэг хүн. Энэ хүн чамд тусална гэж бодож байна. Харин Матвеевич, хэрэв чиний тэр ямбий тэргэнд эмчилгээ хийх шаардлага гарвал Владимир Ивановичийн засварын станц түүнийг чинь хямдхан үнээр цоо эрүүл болгоод өгнө. Та хоёр ярилцана биз. Би явж ширээн дээр ямар нэг юм бэлтгэе гэж хэлээд тэр хоёрын мөрөн дээр алгадаад өрөөнөөс гарлаа. Хоёр зочин үлдэж зөөлөн сандал дээр өөд өөдөөсөө харан сууна. Түрүүлж хошууч Бирюков ам гарлаа.

-Тэгэхлээр Владимир Иванович өөрийн асуудлын талаар ярь даа. Би ямар нэгэн юмаар тусалж чадах байж юу магад гэж асуув. Полунин хайрцагтай тамхинаасаа янжуур сугалан гаргаж яаралгүй асааж сорсныхоо дараа хариу хэлэв.

-Та тийм ч оновчтой асуулт асуусангүй. Константин Матвеевич. Би зөвхөн өөрийн бус бас таны асуудлыг ярилцахаар ирсэн юм гэж Полунин хариулав.

Бирюковын зүүн нүдний хөмсөг татвасхийн гонзгойдуу нүүрэнд нь бага зэрэг гайхах шинж харагдана. Тэгснээ:

-Үнэнээ хэлэхэд юуны тухай хэлснийг тань би ойлгосонгүй гэж хошууч асуув.

-Би эндүүрээгүй бол та манай мужийн УВД-ийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны хүн гэж Полунин тодруулав.

-Яг тийм. Гэвч энэ бол ярилцах гэж байгаа асуудалд маань ямар хамаатай юм бэ? гэж Бирюков мөрөө хавчин асуулаа.

-Хэрэв энэ хотын элдэв бүлэг нөхөд дахин цус урсгаж эхэлбэл чухам танд болон танай албанд хамаатай асуудал гарна гэж би бодож байна. Энэ үед хотын иргэд зөвхөн та нарт дурамжхан байх болно гэж Полунин хошуучийн нүүрний хувирлыг ажиглан асуулаа.

-Та юун цус урсгах тухай ярьж байна? гэж Бирюков хөмсөг зангидан асуугаад, та тэр “Нефтьоргсинтез” дахь Самбист Сагаров хоёрын бүлгүүдийн хоорон дахь тэмцлийн тухай ярьж байна уу? гэв.

-Та өөдрөг үзэлтэй хүн юм, нөхөр хошууч хэмээн Полунин инээмсэглэн хэлээд, одоо хотод автомат тачигнан, бөмбөг дэлбэрч, хүмүүсийг ажил дээрээ байхад нь гэмттэл зодож байна.

Азаар хүний амь сүйдчихээгүй байна. Одоохондоо шүү дээ. Харин та үүнийг тэмцэл төдийд нэрлэж байх шив гэлээ.

-Ямар шалтгаанаар тийм юм болж байна? Аль эрт дампуурч балгас болох дөхсөн тэр үйлдвэрээс болж яагаад тийм хурц тэмцэл болж байна вэ? Тэд тэр үйлдвэрээс юу олж авах гэж ингэх болов? гэж хошууч асуув.

Полунин дахин инээмсэглээд:

-Константин Матвеевич би хэн нэгнийг ховлох гэж ирээгүй. Хов жив ярих нь миний зан биш. Намайг цагдаагийн мэдээлэгч байж чадахгүй гэдгийг надад амьдрал хэлж өгсөн юм гэв.

-Өршөөгөөрэй, Владимир Иванович минь хэмээн Бирюков ундууцан хэлээд, асуулт асууж хариулт сонсох нь бидний цэвэр мэргэжлийн заншил юм. Түүнээс биш би таныг гомдоох гээгүй. Гэвч би танд туслах гэвэл тэр асуудлаар чинь аль болох ихийг мэдэх шаардлагатай юм гэлээ.

-Би нэг асуудлаар санал болгох гэж ирсэн юм гэж Полунин хариулаад, таны асуултын хувьд гэвэл дараахь зүйлийг хэлье. Тэр бүлгийн залуус орчин үеийн соёлтой өрсөлдөөн гэгчийг мэддэггүй зөвхөн хүчээр асуудлыг шийдэж болно гэж ойлгодгоос болж тэр буудалцаан болж байгаа юм. Тэр залуус чинь зөвхөн сайн буудаж чаддагаас бус хэлэлцэн тохирч буулт хийх гэдгийг огт мэддэггүй гэдгийг та мэднэ гэж ярилаа. Полунин янжуураа гүнзгий сорон байж ярих бөгөөд Бирюков түүний яриаг нэг их анхаарсан шинжгүй сууна.

-Заводын хувьд гэвэл, гэж Владимир яриагаа үргэлжлүүлэн, цаг цагаараа байдаггүй, өнөөдөр балгас болох дөхөөд байгаа боловч маргааш цэцэглэн хөгжиж болно. Тэр үйлдвэрийн ирээдүй бидний гарт байна. Өөрөөр хэлбэл хувьцаа эзэмшигч нараас хамаарна гэсэн үг гэлээ.

-Энэ бүхнийг та яагаад надад ярьж байна вэ? Владимир Иванович гэж Бирюков гэнэтхэн асуугаад, тэдний хэнийг нь алах, хэнийг нь шоронд хийх нь эцсийн эцэст надад хамаагүй. Хотод зөвхөн хянаж болох дэг журам байгаасай гэж би хүсдэг гэлээ. Тэгснээ Бирюков инээд алдаад үргэлжлүүлэн:

-Ний нуугүй ярьж байгааг минь өршөөгөөрэй, би хориглолтын хананы нөгөө талд нь байгаа хүн шүү дээ гэв. Полунин мөрөө хавчин инээмсэглээд:

-Зүгээр ээ. Би таны үзэл бодлоос болж ямар ч бүтэлгүй юм бодоогүй байна. Гэвч та нөгөө талд байгаа ч гэсэн бид хоёр нэг гудамжаар нэг зүг явж байгаа учир нэг зорилготой байгаа юм. Танд манай хотод хавтгайрсан цуст мөргөлдөөн хэрэггүй. Би ч бас тайван сууж бизнесийн ажлаа үргэлжлүүлэн хиймээр байна. Хөлсний алуурчнаас айж нуугдаж ажиллах нь надад хэцүү байх болно гэж учирлав. Хошууч:

-Тэгэхлээр та ямар саналтай байна? гэж тодорхой юм сонсохыг хүсэж асуув.

-Тэдний зэвсгийг нь далд хийлгэх хэрэгтэй гэж Полунин товчхон хариу хэлэв.

-За яахав, сайхан л санаа байна гэж Бирюсов зөвшөөрөөд, эцсийн эцэст танаас өөрөөс чинь их юм хамаарна. Самбистын бүлэгт таны нөлөө хүрэлцэхүйц их биз дээ. Тийм учраас та өөрийн найзаас ил тулалдаанд эхэлж орохгүй байхыг хүсэх хэрэгтэй гэж зөвлөв.

-Би түүнийг ятгаж чадна гэж бодож байна хэмээн Полунин хариулаад, гэвч тулааныг тэр илүү биеэ тоосон түрэмгий авиртай бүлгийн толгойлогч Сатаров эхэлсэн. Түүний энэ түрэмгийллийг зогсоох нь тийм амар биш. Үүнийг өөрийн эрхгүй хэлэлцээрийн ширээний ард суулгах тийм шалтгаан гаргах хэрэгтэй гэж хэллээ.

Бирюсов сандлынхаа түшлэгийг налан эрүүгээ атган хэдэн минут хэртэй бодлогоширон суулаа. Тэгтэл Полунин цагдаагийн хошуучийг анхааралтай сонжин харж байснаа:

-Нэмж хэлэхэд эв найрамдал бидэнд чухал хэрэгтэй. Тийм учраас би түүний төлөө төлбөр гаргахад бэлэн байна гэв. Бирюковын нүүрэнд бага зэрэг ханамжтай инээмсэглэл тодрох нь мэдэгдэж байв.

-За яахав. Тэгвэл энэ асуудлыг хэрхэн шийдэхээ нарийвчлан ярилцахыг оролдоё гэж тэрээр хэллээ.

* * *

Дараачийн өдрийн өглөө “Нефтьоргсинтез”-ийн ажилчид явган хүний зам дээр орох хаалганаас холгүй цагаан өнгөөр будсан сонин зардаг газар шиг жижгэвтэр мухлаг бий болсныг харжээ. Харин мухлагны нэгэн жижигхэн шагайвчнаас бусад бүх цонхнууд сөхөгддөг төмөр хөшгөөр хаалттай байх бөгөөд хэн нэгэн сонирхож шагайвч руу шагайвал царайлаг байрын эмэгтэйн нүүрийг харж болох ажээ. Мухлагны дээврийн доорхон нь хэн бүхэнд харагдахуйц газар “Нефтьоргсинтез” заводын хувьцааны тасалбар худалдан авна гэж том үсгээр бичсэн хаяг харагдана. Эхний үед заводын хүмүүс энэ хачин мухлаг гэнэт бий болсныг хараад бага зэрэг гайхаж байв. Гэвч удалгүй ерөнхий захирлын тушаалаар заводаас хөөгдсөн Соловейчикийн мухлаг гэсэн яриа таржээ.

Ерөнхий инженер Соловейчик заводын захиралтай харьцуулбал ажилчдын дунд нэр хүнд сайтай, ойр дотно харьцаатай хүн байлаа. Тэр ч бүү хэл захиргааны зүгээс түүнийг бага зэрэг хавчдаг гэдгийг ч жирийн ажилчид мэддэг байсан юм. Өөрийн албан өрөөндөө Соловейчикийн зодуулсан тэр явдал түүний нэр хүндийг улам нэмэгдүүлснээс гадна түүнд хувьцаагаа худалдах нь ашигтай байсны зэрэгцээ энэ нь түүний нүдүүлсний өшөөг авах бас нэгэн хэлбэр юм гэж хүмүүс үзэж байв. Өөрөөр хэлбэр тэд ерөнхий инженерийнхээ шударга явдлыг ойлгож байсан юм. Тийм учраас тэр мухлагт хувьцаагаа худалдаалах нь эрс нэмэгджээ. Гэвч мэдээжээр энэ мухлаг заводын хаалганы ойролцоо бий болсон явдал урьдчилан тооцоолж байсан шиг бүх хүнийг баярлуулсангүй.

Нэг их удалгүй мухлагны өмнө нэгэн “БМВ” ирж түүнээс биеийн тамирын хувцастай шөрмөслөг залуу гарч ирлээ. Тэрээр мухлагт хүрч ирээд цонхыг нь нүдэн шагайвч руу шагайгаад бүдүүлгээр,

-Чи хэний охин бэ? гэж асуулаа.

-Яах гээ вэ? хэмээн охин ойлгож ядан хариулав.

Охины хариулт залуугийн дургүйг хүргэсэн нь илт.

-Би чамаас ямар пүүснээс ирээд хувьцааны наймаа хийж байна вэ гэж асууж байна, тэнэг минь? гэж залуу зандран асуув.

-Би “Солокомоос” гэж охин гомдонгуй хариулаад, чи өөрөө тэнэг! хэмээн хэлмэгцээ залуугийн хамрыг нь хавчих дөхөн шагайвчаа тас хийтэл хааж орхив.

-”Солоком”... тэгэхлээр... хэмээн залуу бодлогоширон дуугараад, ойлгомжтой... гэв.

Залуу эргэж машин руугаа яаран алхлав. Машинадаа орсныхоо дараа гар утсаа залган:

-Вован уу? Би Леха байна. Заводын хажууд бий болсон мухлаг Седой, Самбист хоёрынх гэж Олегт хэл. Тэнд хувьцааны наймаа хийж байгаа охин бол “Солоком” пүүснийх гэдгээ хэлсэн. “Солоком” гэж тэдний албан газрын нэр... Одоо яах вэ гэж асуу. Тэр янзагатай нь хамт шатааж орхих уу?.. За ойлголоо, одоо очъё... гэж ярилцлаа.

Тэр өдөр үдийн дараа мухлаг руу машины бүхэл бүтэн цуваа хүрч ирлээ. Эхнийх нь түрүүний ирдэг тамирчин залуугийн “БМВ” байсан бөгөөд нөгөө залуутай хамт бас дөрвөн булиа “бух” машинаас гарч ирэв. Араас нь ачааны “Камаз”-тай хамт автокран “Зил” хүрч ирлээ. Дөрвөн зэрлэг “бух” мухлаг руу хүрч ирмэгцээ мухлагийг кардоноор хийсэн мэт түлхэж ганжуулан инээлдэж байснаа:

-За яаж байна, өлөгчин минь? хэмээн нэг нь цонхоор шагайн хэлснээ, чи өөрөө сайн дураараа гарч ирэх үү, эсвэл бид чамайг хайрцагтай чинь хамт хог хаягдлын газар аваачиж хаях уу? гэж доогтой нь аргагүй асуух нь тэр.

Цонхоор тэр даруй айсан охины нүүр харагдаад тэрээр гадаа нь зогсож байгаа дээрэмчид болон машинуудыг гайхан хараад:

-Хүүе ээ. Ингэж болохгүй. Та нарыг шийтгэх болно! гэж хашгирлаа. Тэр охины балмагдаж сандарсан дууг сонсоод дээрэмчид улам хөөрөн баясаж, ахлагч нь бололтой Леха гэгч нь кран руу эргэн хараад:

-Эй жолооч оо! Энэ хайрцагийг бушуухан өргөж “Камаз” дээр тавь. Дотор нь байгаа тэр бяцхан амьтан хайрцагтайгаа хамт хот дотуур зугаалаг гэж хашгирлаа.

-Үгүй, үгүй! Одоо эндээс гаръя гэж охин хашгираад мухлагныхаа хаалгыг онгойлгов. Тэгтэл тэндээс гартаа богино голтой автомат “Калаш” барьсан, гудамжны халууныг үл хайхран сум үл нэвтрэх хуяг бүхий хүрэм өмссөн шаргал үстэй, намхан нуруутай цагдаа үсрэн гарч ирэх нь тэр. Түүний мөрөнд бага оврын холбооны аппарат бэхлээстэй байх агаад балмагдаж гайхсан дээрэмчдийн чихэнд цагдаагийн диспетчерийн:

-Дөрөв байна уу? Дөрөв байна уу? Наана чинь юу болоод байна вэ? Жижүүрт мэдэгдье! гэх дуу сонсогдлоо.

Шар үст цагдаа “тугал” болтлоо айж гайхсан “бухнууд” руу хараад өөрийн хуучин найз нартаа хандаж байгаа мэт тайвнаар:

-Хүүхдүүд минь энд юу хийж дүрсгүйтэж байгаа чинь энэ вэ? гээд “Камаз”, кран руу дохин, ямар хүчтэй техникүүдийг авчраа вэ? Болж байна уу? гэж асуулаа.

Гялаан толгойтой дээрэмчид дэслэгч рүү нүдээ бүлтийлгэн амаа ангайн харж байв.

-Бид зүгээр... Бид мухлагийг гэж юу болж байгааг сая ойлгосон Леха түгдрэн хэлж байтал:

-Мухлагийг ачиж авах гэсэн юм хэмээн дэслэгч Лехагийн хэлэх гэсэн үгийг хэлж өглөө.

-Тийм ээ... Мухлагийг... хэмээн Леха сэргэн толгой дохин давтаж хэлэв.

-Үгүй ээ, хүүхдүүд минь. Мухлагийг эндээс авч болохгүй. Энэ үнэт цаасны худалдаа хийдэг чухал газар байгаа юм гэж дэслэгч тун хүндэтгэлтэй бөгөөд нухацтай хэллээ.

-Энд харин... гэж Леха түгдрэн дуугараад, энд харин үнэт цаасны наймаа хийж болохгүй гэв.

-Бидэнд болно гэж дэслэгч чанга дуугаар хариу хэлээд, бидэнд болно гэсэн захиргааны зөвшөөрөл байгаа. Энд наалттай байна гэж мухлагийн цонхны дотор талд наалттай хуудас цаас руу автоматаараа зааж хэлэв.

-Харин танд зөвшөөрөл байна уу? гэж Леха хүндээр санаа алдан асуув.

-Байлгүй яахав гэж дэслэгч давтан хэлээд, бас хамгаалалт ч байна гэж автоматынхаа оосрыг зориуд тэгшлэн хариулав.

-Тийм учраас залуус минь та нар дэмий авто кран зэргийг авч ирж дээ гэж дэслэгч үргэлжлүүлэн хэллээ. Тэгтэл нам гүм байдлыг краны жолооч эвдэн:

-Хүүе, эрчүүл минь яах болж байна? Энэ мухлагийг чинь оосорлох уу, үгүй юу? гэж хашгиран асуув. Тэгтэл богино долгионы холбоо дахин дуудаж кранчны асуултад хариу өгөх мэт цагдаагийн жижүүрийн дуу,

-Дөрөв байна уу... Наана чинь юу болж байгааг илтгэ! Эсвэл тусламж хэрэгтэй юу? гэлээ. Энэ үгийг сонсоод Леха бушуухан эргэж кранчин руу хандан:

-Юугаа хийж зогсоод байгаа юм бэ? Харахгүй байна уу? Эдэнд чинь мухлаг энд ажиллуулах зөвшөөрөл байна шүү дээ. Эндээс бушуухан явж үз гэж орилов.

Кранчин зарим нэгэнтэй адил дахин хэлүүлэхийг хүсдэггүй хүн учир тэр даруй хөдөлгүүрээ асаав. Нэг минутын дараа гэхэд мухлагийн дэргэд кран ч, “Камаз” ч байхгүй болсон байлаа. Гялаан толгойтой “бухнууд” ч гэсэн мөн адил машин руугаа яаравчилцгаав. Араас нь алхангаа Леха:

-Алив, арилцгаая гэж дуугарлаа.

Дэслэгч тэдний “БМВ” явж далд ортол араас нь харж зогслоо.

-Би дөрөв байна. Жижүүрт хандаж байна. Бүх юм тайван болж өнгөрлөө. “Зочид” дөнгөж сая эндээс явцгаалаа гэж хэлснээ бухимдуу дуугаар, нөхөр хошуучаа жорлонгийн асуудлыг хэзээ шийдэх гэж байна вэ? Эцсийн эцэст. Заводын хашаанд оруулахгүй байна. Гурван хорооллын цаадахь үйлчилгээний төв хүртэл шээх гэж гүйх нь хэтэрхий хол байна гэж асуув.

-Санаа бүү зов дэслэгч минь. Наадах мухлагийг чинь нэлээд удаан хугацаагаар ажиллуулах учир бүх асуудлыг өнөөдөр нэгмөсөн шийдчихгүй боловч харуул тавихыг хүсэгчид тэр асуудлыг чинь тун удахгүй шийдчихнэ гэж хошууч хариулав.

* * *

Тэр өдрийн орой “Оливер” нэртэй рестораны тусгай өрөөнд бүлгийн ахлагч Леха Олег Сатаровын өмнө болсон явдлыг тайлагнаж суув.

-Би яах ёстой байсан юм? Хуягласан хүрэм өмсөж автомат буу барьсан цагдааг би яаж чадах юм? Бас цаана нь бүхэл бүлэг дайчид нь над руу буугаа онилоостой байгаа...

-Чи үүнийг яаж мэдсэн юм? Айснаасаа болж далдыг харагч болчихоо юу? хэмээн Сатаров бухимдан асуув.

-Тийм ээ. Тэр цагдаад богино холбооны аппарат байсан. Тэр нь чанга дуулдаж цагдаагийн газрын жижүүр наана чинь юу болоод байна, тусламж хэрэгтэй юу гэж асууж байсан. Би мэдэж байна, Олег. Тэд урьдчилан мэдээд биднийг хүлээж байжээ. Ийм байдлаар тэднийг бид дийлэхгүй. Бүх зөвшөөрөл зэрэг бичиг цаас нь захиргаанаас өгсөн албан ёсных байна билээ.. гэж Леха илтгээд Сатаровын ууртай царайг хэсэг зуур ширтэж байснаа үргэлжлүүлэн:

-Олег чи ойлгож байна уу? Гэгээн цагаан өдрөөр цагдаа нартай байлдаж тэр хараал идсэн мухлагийг авч болохгүй шүү дээ. Тэглээ ч гэсэн удахгүй биднийг цөмийг маань баривчлах болно гэлээ.

-За яахав. Амаа тат! гэж Сатаров зандраад, чи үнэнээ хэл. Зэвсэгтэй нэг муу цагдааг хараад өмдөндөө тавьчихаа биз гэж асуув.

-Олег, яах билээ?... гэж Леха гомдоллон орилтол Олег үгийг нь огцом таслан ширээ доргитол шааж:

-Амаа тат гэж чамд би хэлж байна. Бид цагдаа дүрстэй хүн болгоныг хараад тэгж шээс алдаад байвал үнэхээр биднийг цөмийг маань барьж аваад торны цаана чихчихнэ гэж хашгираад хилэгнэснээсээ болж үсрэн босож өрөөн дотуураа урагш хойшоо алхаж гарлаа. Лехагаас гадна ширээний ард Веселовский бас нэгэн хүний хамт сууж байсан юм. Тэр хүн нь өндөр нуруутай шар үстэй чийрэг байрын эр байв. Тэрээр Сатаровын нэгэн адил цэвэрхэн хувцаслажээ. Нарийн ширхэгтэй сайн чанарын даавуун костюм, цайвар өнгийн цамц өмссөн ажээ. Сатароваас бага зэрэг ахимаг насны гучин тавгай болов уу гэж хармаар тэр хүн үсээ богинохон тайруулж янзалсан агаад хамар нь бага зэрэг шантгар нь Сатаровтай төсгүй

харагдана. Гэвч гүн суусан хар нүд нь анхааралтай бөгөөд бодлогоширсон шинжтэй нь жирийн бус дотоод төрхийг илэрхийлнэ. Энэ бол Сатаровын баруун гарын хүн Романыч хочтой Сергей Романенков байсан юм. Тэр хүн Сатаровын бүлгийн үндсэн гишүүд шиг тамирчин биш байв. Тэрээр шефийнхээ нэгэн адил дээд боловсролтой хүн бөгөөд цэргийн улс төрийн сургууль дүүргээд орон тооны цомхотголоор халагдах хүртлээ цэргийн газар алба хаажээ. Тэгээд хэд хэдэн албан газар түр зуур ажиллаж байгаад эцэст нь бизнест хүчээ сорихоор шийдсэн байна. Тэгж яваад энэ Сатаровтай танилцжээ. Тэр хоёр ямар нэг хугацаагаар бизнесийн түнш болж явав. Гэвч Сатаров залуу дарамтлагч-рәкетүүдийг бүрдүүлж бүлэг зохион байгуулсныхаа дараа түүнийг өөртөө татан авсан нь Романычид таалагдсан ажээ. Цэргийн газрын хуучин офицер тэрээр муугүй стратегич, сайн зохион байгуулагч байсан бөгөөд Сатаровын урдуур оролгүй түүний ар сүүдэрт үлдэж чаддаг нь бас нэг чухал чанар нь байсан юм. Энэ бүхний хажуугаар Романыч өөрийн бүлэгт хуучин “халуун цэгт” алба хааж байсан хэд хэдэн цэргийн албан хаагчдыг элсүүлж авсан нь хүчийг нь мэдээж нэмэгдүүлсэн ажээ.

... Хэсэг хугацаанд Олег баргар царайлан уруугаа харж хойш урагшаа алхаж байснаа гэнэтхэн зогсож пиджакаа тайлж сандлын түшлэгэнд нямбай хөдөлгөөнөөр өлгөв. Харин дотор хүрмээ тайлалгүй зөөлөн сандал дээр суугаад Лехаг хүйтнээр ширтэн:

-Чи юундаа энд суугаад байгаа юм бэ? Эндээс зайл! Чи өөрийн ажлаа нэгэнт хийчхээд байна гэж шүд зуун хэлэв. Бүлгийн ахлагч Леха босож уруу царайлан өрөөнөөс гарч явлаа.

-Чи дэмий ингэж байна, Олег, үнэндээ түүний зөв гэж Веселовский болгоомжтой дуугараад, цагдаа нартай зууралдах тэр бүү хэл заводын хаалган дээр шүү, утгагүй явдал болно. Тэгэх юм бол бидний асуудал улам хүндрэх болно гэв.

-Больж үз хэмээн Сатаров түүнийг ууртайгаар ширвэн хараад, чи өөрийнхөө арьснаас айж байна уу? Тэр цааснуудыг чи хэн нэгэн тавганд хийж авчраад өмнө чинь бөхийн барьж чи зөвхөн тоолж үзээд хүлээж авч байхыг хүсээгүй биз. Чи тэр өөрийн туслах Соловейчиикоос үлгэр аваач. Тэр хүн өөрийн толгойгоо гогцоонд углахаас айхгүй байна гэлээ.

-Бодлогогүй жирийн хэрэг хэмээн Веселовский гүн ухаантны өнгөөр дуугараад бухимдсанаасаа болж үзгээ гартаа эргүүлж суув. Сатаров түүн рүү гараа савчиж орхиод Романенков руу хандлаа.

-Харин чи юу гэж хэлмээр байна, Серега? гэж асуув. Нөгөөдөх хүн нь яаралгүй мөрөө хавчсанаа:

-Чи өөрөө ойлгож байгаа биз ээ. Энэ удаа бид Седой, Самбист нарт ялагдсан байна. Тэд цагдаагийн газар хандах юм гэж хэн маань ч санасангүй. Энэ бол Седой нэртийн ажил гэж бодож байна. Түүнийг хуучин хулгайч хоригдол байсан учир юуны өмнө өөрийн найз Коля-Решетод хандаж хоёул нэгдэн бидний эсрэг босох байх гэж би бодож байсан юм. Хэрэв тэгвэл тэдний хүч биднийхээс илүү болох юм. Гэвч Полунин ухаалаг хандаж цагдаа нараас тусламж авснаараа асуудлыг цус урсгалгүй шийдэх гэсэн хэрэг гэж ярилаа.

-Тийм болж байна хэмээн Сатаров ядрангүй дуугаар хэлээд, түүнээс сурах юм бидэнд бас

байгаа бололтой гэлээ.

-Бид тэдэнтэй гарцаагүй мөргөлдөх болно, харин хохирол бага гараасай гэж хүсэж байсан боловч Полунин уламжлалт бус тун үр ашигтай нүүдлээр нүүсэн байна. Хулгайч цагдаа хоёр үгээ ололцоно гэж хэн санах билээ гэж Романенков үглэв.

-Энд цагдаа хулгайч нар ямар хамаа байна? Ухаалаг хүмүүс хааяагүй байна. Полунин ухаалаг хүн учраас цагдаа нарыг итгүүлж туслалцаа авч чадсан байна. Тэдэнд юм ч амласан байж болно гэж Сатаров урьдын адил бухимдан дуугараад, гэвч бид хариу цохилт өгөх болно гэлээ.

-Тэр мухлаг манай үйлдвэрийн нутаг дэвсгэрт байгаа учир би түүнийг зайлуулж өгөхийг хотын захиргаанаас албан ёсоор шаардана гэж Веселовский саналаа хэлэв.

-Тэр хамаагүй хэмээн Романыч толгой сэгсрээд, тэглээ ч гэсэн тэд энэ мухлагаа зүгээр л гудамжны нөгөө талд аваачаад тавьж орхино. Тэгснээрээ тэд юу ч алдахгүй гэлээ. Сатаров Романыч руу ширтэн:

-Чи тэгээд ямар саналтай байна? гэж асуулаа.

-Хамгийн түрүүн Седой, Самбист нар цагдаагийн газартай ямар холбоо тогтоосныг мэдэх нь чухал. Би тэдний заримтай нь танил юм. Ойрын үед би үүнийг мэдэж авахыг оролдоно. Хоёрт, цагдаа нар цөмөөрөө нэг хэвэнд цутгаагүй байдаг учир бид тэдний дундаас холбоотон болох хүнийг олох хэрэгтэй. Хурдан тусмаа сайн гэж Романыч саналаа хэллээ.

Сатаров түүний саналыг зөвшөөрөн толгой дохиод дахин хөмсөг зангидан:

-Намайг сонсож бай... Седой үр ашигтай ажиллагаа хийсэн байна гэж чи зөв ярьж байна. Тэр их цус урсгахаас татгалзаж байгаа нь бага цус урсгахаас татгалзаж байгаа хэрэг огт биш. Энэ тохиолдолд өрсөлдөгчдийн толгойлогчийг устгах нь хамгийн оновчтой арга мөн. Тэр цагдаа нарын халхавчин доор үүнийг хийх нь тийм ч хэцүү биш гэх нь тэр.

* * *

Самбист саарал өнгийн “9”-гээ Коммунарный гэдэг гудамжны таван давхар байшингийн өмнөх зогсоолд залан аваачиж тавилаа. Тэгээд арын суудалд суугаа Николай руу эргэн харж:

-За тэгэхлээр Коля өөр асуулт байна уу? гэж асуув.

-Байхгүй гэж Коля товч хариулаад, асуудал ойлгомжтой юм шиг байна гэж нэмж хэллээ.

-Сайн байна. Тэгвэл чи тамхиа татаж бай. Би байдлыг дахин нэг тодорхой лавлаад орхиё. Самбист халааснаасаа гар утсаа гарган тэр даруй дугаар дарж өөрийн үл үзэгдэгч хүнтэй холбоо барив.

-Антон ярьж байна. Бүх юм хэвийн үү?

-Нөгөө хүн маань ресторанд бэлэн хүлээж байна гэж утасны нөгөө үзүүрт сонсогдоод, хэдий

болтол хүлээх нь тодорхойгүй. Машинаа гадаа бэлэн байлгасныг нь бодвол энд хонохгүй бололтой гэлээ.

-Ойлголоо гээд Антон утсаа салгав. Тэрээр дахин Николай руу эргэж хараад:

-Алив Николай хөдлөх цаг болсон. Тэр хүн байрандаа байна. Хэзээ гарах нь тодорхойгүй учир чи хүлээх болно гэв. Тэгснээ дахин:

-Хөлсний алуурчны хамгийн үнэтэй чанар юундаа байдгийг чи мэднэ биз? гэж инээмсэглэн асуулаа.

-Мэднэ хэмээн Николай мөн адил инээмсэглэн хариулаад, хүлээж чаддаг чанар нь. Энэ талаар надад санаа зовсны хэрэггүй гэлээ.

-Юмыг яаж мэдэхэв гэж сануулж байна гэж Самбист нухацтай өнгөөр дуугараад, хуучин зурагт самбарын доор буу байгаа. Бас тэнд хувцанцар сав дүүрэн сум байгаа. Цагаан “5” булангийн цаана байгаа түлхүүр нь жолооны дор байхыг олоорой. Шуугиан гармагц байгаа газраасаа даруй зайлж яв гэлээ. Николай түүний санамжийг анхааралтай сонсоод:

-Бүгдийг ойлголоо, Антон. Чи үүнийгээ гурав дахь удаагаа давтан хэлж байна. Би сургуулийн сурагч биш шүү дээ. Ямар нэгэн хэмжээгээр энэ талын туршлагатай хүн гэж хэлэв.

-Нэг удаа алдсанаас тав дахин давтсан нь дээр хэмээн Самбист сануулав.

Николай үнгэгдэн үрчийсэн ноосон малгай өмсөж нүдний шил зүүгээд хүнсний зүйл хийсэн цүнх авч машинаас гарлаа.

-Амжилт хүсье гэж Самбист ерөөв.

-Болно биз гэж хэлээд Николай холдон явсаар гудамж хөндлөн гараад таван давхрын нэгэн орц руу орж явчихлаа. Тэрээр хөндлөнгөөс харвал гэртээ ирж яваа жирийн нэгэн ажилчин мэт байв. Дээр үед баригдсан тэр байшин өндөр тааз бүхий гаднаас шууд орох орцтой байжээ. Николай гаднаас шууд очиж орсон тул хэн ч түүнийг ажигласангүй. Тэрээр гүйх шахам явсаар таван давхарт гарч бас нэгэн төмөр шатаар авиран дээврийн хонгилын төмөр хаалганд тулж очив. Николай хүнсний зүйл хийсэн цүнхээ тавцан дээр тавиад халааснаасаа урьдчилан хийсэн түлхүүр гарган хаалгыг онгойлгов. Дээврийн хонгилд барилгын модон хашлаганы хөндлөвч, хэмхэрхий буйдан сандал зэрэг элдэв новшоор дүүрсэн ажээ. Нэг буланд нь дээр үед баяр ёслолоор хэрэглэж байсан хуучны зурагт самбар, лоозон зэрэг овоолоостой байна.

Николай овоолоостой байгаа самбаруудын хамгийн захын нэгийг өргөтөл доор нь шуудайн материалаар боосон гонзгой зүйл хажууд нь хуванцар хайрцагтай юм байв. Тэрээр резин бээлий гаргаж өмсөөд тэр зүйлийн боолтыг хурдан эргүүлэн задалтал дотроос нь “СВД” системийн мэргэн буучийн цэргийн винтов гарч ирлээ. Винтовт тав дахин өсгөдөг дуран хараа суурилуулж, голонд нь дуу намжаагч эрэгдэж суулгасан байх нь шууд буудахад бэлэн болгосон ажээ.

Харин хүхээгт нь сумтай төмөр дайз хийгээгүй байв. Николай сумны хуванцар дайзыг буунд холбоод замгийг түлхэн сойв. Дараа нь буугаа хана түшүүлэн шалан дээр тавиад хонгилын цонхоор гадагш ажиглан харлаа. Николай байршлыг нягтлан шалгаж үзээд галын цэгийг тун оновчтой сонгож авсныг ойлгов.

Воробьевын гудамжны зэрэгцээ хоёр таван давхар байшингийн хооронд ямар нэгэн барилгын ажил хийх зорилгоор гүнзгий нүх ухаж түүнийг тойруулан хашаа барьсан байв. Энэ нь коммунарын гудамжтай зэрэгцээ орших Воробьевын гудамжны орчин болон хаалган дээр нь “Ресторан Оливер” гэсэн гэрлэн хаягтай дөнгөж саяхан сэргээн засварласан хоёр давхар байшингийн орц орчмыг сайн харагдуулах боломжтой болгожээ. Рестораны орцноос холгүй арваад метрийн зайд “Гранд-Чероки” жийп машин зогсож байлаа. Энэ бол орох хаалганд ойрхон тавьсан ганцхан машин байв. Бусад машинууд тэндээс хол зайд эсвэл бүгд гудамжны нөгөө талд тавиастай харагдана.

Николай буугаа авч цонхоор амыг нь бага зэрэг цухуйлган рестораны орц руу дуран хараагаар нь онилон шагайж үзэв. Тэгэхэд “Оливер”-ын орц орчим болон жийп машин алган дээр нь байгаа юм шиг тод харагдлаа. Жийпний жолооч хорин тав орчим насны залуу машиныхаа суудлыг налан яарсан шинжгүй тамхи татаж суулаа. Ресторанаас гарч ирж яваа хоёр хосыг Николай бууныхаа дуран харааны хэрээсэнд тааруулж үзлээ. Тэр хоёр залуу хосууд тэврэлдэн үнсэлдээд холдож явав. Тэр үед нь Николай тэднийг дуран хараанаас алдалгүй харж жийп машин хүртэлх зайг тодорхойлохыг хичээв. Тэд рестораны хаалган дээрээс жийп машин байгаа газар хүртэл арван алхам явсан байв. Тэрээр хурдан хөдөлж дээврийн хонгилын нэгэн булангаас гурван хөлтэй эвдэрхий сандал олж галын байрандаа авчрав. Тэр сандал дээрээ болгоомжтой суугаад цагаа харвал найман цаг арван таван минутыг зааж байлаа. Тэгээд унжирсан удаан бөгөөд түгшүүртэй хүлээлт үргэлжиллээ. Николай буугаа өвөр дээрээ тавиад чулуун баримал мэт хөдөлгөөнгүй сууна. Зөвхөн хааяа нэг лонхтой рашаанаас балгах бөгөөд энэ үедээ тэрээр байныхаа газраас хараагаа агшин зуур ч салгахгүй байсан юм. Хөлсний алуурчны бугуйн цаг хэдийнээ арван нэг болсныг дохиолов. Николай хөдөлгөөнгүй удаан сууснаас болж хөшсөн мөрөө хөдөлгөөд саванд үлдсэн рашааныг ууж дуусган савыг нь буцааж үүргэвчиндээ хийлээ. Энэ үед хотод зуны шөнийн сэрүүн орж байв. Воробьевын гудамжны чийдэнгүүд бүх чадлаараа гэрэлтэн хурц өнгөөрөө рестораны “Оливер” гэсэн хаягийг тов тодхон харагдуулна.

Энэ хурц гэрлийг удаан хугацаагаар тасралтгүй ширтсэний улмаас Николай нүд бага зэрэг ядрах шинжтэй болж байсан юм. Тэрээр зүүн гарынхаа хоёр хуруугаар нүднийхээ зовхийг болгоомжтой арчиж хүзүүгээ эргүүлж хөдөлгөж чилээг нь гаргаж байхдаа баруун гарынхаа заах хурууг винтовны гохноос салгахгүй байв. Тэгж байтлаа хөлсний алуурчин гэнэтхэн энэ дасгалаа зогсоож маш хурдан хөдлөн бууны амыг цонхоор гарган цухуйлгаад дуран хараагаар шагайв. Энэ үед ресторанаас дөрвөн хүн гарч түүний дотор саарал костюмтай, хар халимагтай өндөр хүн байгааг Николай дуран хараагаараа харан Олег Сатаров байхыг танилаа. Тэдний нэг өндөр биш нуруутай, бужгар үстэй залуу тэдэнтэйгээ салах ёс гүйцэтгээд хурдан алхалсаар гудамжны нөгөө талд зогсож байсан цагаан өнгийн “Волга” руу чиглэн явлаа. Тэр хүн машинд суумагц ухасхийн хөдөлж хажуугийн булан тойрч алга болов. Сатаров цэнхэр костюмтай, үсээ богиноор тайруулж зассан нэгэн хүний хамт жийп машин руу зүглэн явлаа. Араас нь саарал өмдтэй, цамцныхаа энгэрийг задгай тавьсан мангар булиа

бие хамгаалагч нь дагана. Николай баруун гарын эрхий хуруугаараа бууны замагны түгжээг мултлан заах хуруугаа гохон дээр тавилаа. Тэд ойролцоогоор машин хаалга хоёрын хоорондох зайн талд нь хүрч явахад мэргэн бууч Сатаровын толгойг бууны дуран харааны хэрэгсэлд тааруулж авлаа. Сатаров машиндаа хүрэхэд хэдхэн алхам зайтай байхад Николай бууныхаа дуран харааны хэрээсийг түүний явах зүгийн дагуу машины арын салхины шил рүү шилжүүлэн бууныхаа гохыг зөөлөн дарчихлаа. Дуу намжаагч винтовын богинохон дууг зөвхөн буудагч өөрөө л сонссон ажээ. Бууны сум машины арын болон хажуугийн шилийг нэвт гаран цаад байшингийн хананд тусчээ. Харин шилний бутарсан хагархайн хэсгүүд тал тал тийш цацагдан нэг хэлтэрхий нь Сатаровын хүзүүний маханд гүн биш зоогдож орхилоо.

-Яанаа! хэмээн Сатаров шархатсан хүзүүгээ сандран дарж машиныхаа цоо үсэрсэн салхины шилийг харан чанга дуугаар ориллоо. Араас нь дагалдагсад байрандаа хөшиж орхиод машины шилний цоорхойгоос тал тал тийшээ цацарсан мэт гарсан зураасуудыг гөлрөн ширтэнэ. Алгадах мэт сэжигтэй чимээг сонссон жолооч залуу эргэн хараад мөн адил балмагдан хөшчихлөө. Тэдний балмагдал хэдхэн агшинд болж өнгөртөл Романенко дуу алдан,

-Хүүе ээ, мэргэн бууч гэж орилов. Тэд бүгдээрээ бууны сумнаас хамгаалж болох ганцхан нуувч нь энэ гэж санасан мэт нэг зэрэг үсрэн машиндаа орчихлоо. Энэ үед Николай дахин сум тавьж орхилоо. Энэ удаагийн сум жийпний арын дугуйг зад татжээ. Дараа нь мэргэн бууч дахин хэд хэд буудав. Машины арын болон хажуугийн салхины шилүүд бут үсрэн нэг сум машины урд дугуйн резинийг цөмлөн орж тогтжээ. Машинаасаа хоромхон зуур үсрэн гарсан жолооч зугтах гэснээ больж шеф болон бусад нөхдийн нь нэгэн адил машины эсрэг талд гарч толгойгоо мөр рүүгээ шигтгэн машиндаа наалдан хар зам дээр сууцгаалаа. Бие хамгаалагч нь тэлээндээ зүүсэн гар буу “ТТ”-г шүүрэн авч хаанаас сум ирж байгааг мэдэхийг оролдоно. Гэвч түүний мөлчийтөл хуссан толгой машины бүхээгнээс дөнгөж цухуймагц сум дахин шунгинан ирж машины салхины урд шилийг цоо цохив. Бие хамгаалагч машины цаанаас гараа цухуйлган баригдах гэж байгаа барилгын хашаа руу хоёр дахин буудаад буцаж суумагцаа:

-Тэр нохой тэр барилгын талбай хавиас винтовоор буудаж байгаа бололтой. Тийм учраас эндээс бүү цухуй. Тэгвэл биднийг тэр новш цөмийг маань буудаж орхино нохойн гөлөг! хэмээн орилов.

Газарт наалдсан Сатаров хажууд нь байгаа Романенко руу нүдээ бүлтийлгэн харж

-Одоо яах вэ? гэж асуув.

-Буу байна уу? гэж нөгөө нь асуув.

-Буу хаана байна? гэж Олег газар хэвтэж байгаа жолоочоо хөлөөрөө түлхэн асуув.

-Урд суудал доорхи нууц хайрцагт автомат, хоёр гар буу байгаа.

-Үгүй тэгээд аваад ирээч.Юугаа хийж өнөө хүртэл газар наалдаж суугаа юм бэ? гэж Сатаров зандарлаа.

Айж сандарсан жолооч үг дуугүй машины хаалгыг онгойлгон суудал доогуур гараа шургуулан мөрөвчгүй автомат “Калаш” хоёр гар буу “Макаров”-ыг гаргаж ирлээ.

-Тэд хаанаас буудаж байгааг чи мэдэж байна уу? гэж Романенко автоматын замгийг сойх зуураа бие хамгаалагчаас асуув.

Баригдах гэж байгаа барилгын хашаа руу дөнгөж саяхан хоёр удаа буудсан бие хамгаалагч Романыч, Сатаров хоёрыг сандарснаас болж бүлт үсрэх шахсан нүдээр ширтэн:

-Сайн мэдэхгүй байна. Гэвч тэр барилгын нүхний хашаанд нуугдаад байгаа байх гэж бодож байна гэв.

-Үгүй байх аа, хэмээн Романыч толгой сэгсрээд, гэвч ямар ч гэсэн тэр зүг цөмөөрөө нэг зэрэг галлаад үзье гэлээ.

Сатаров бие хамгаалагчид Романенковын хамт машины цаанаас ухасхийн өндийж барилгын модон хашааны зүг зэрэг галлалаа. Зад шүршүүлж байгаа хашааны модноос зомгол тал тал тийш үсэрч байв. Гэвч машины бүхээг дээрээс цөмрөн орсон мэргэн буучийн бас нэг сум тэдний галыг хоромхон зуур зогсоож тэднийг урьдын адил машиныхаа цаана нуугдахад хүргэлээ.

-Чөтгөрийн чинь барилгын хашаа! Тэр чинь бүр холоос буудаж байна. Дуран хараатай мэргэн буучийн винтовтой байгаа бололтой, хэмээн Сатаров хилэгнэн хашгирав.

-Тэр нохой биднийг онож чадахгүй байгаа биш зориуд энд маань барьж байхын тулд ингэж буудаж байна гэж Романыч нэмж хэллээ.

-Энэ нь юунд хэрэгтэй юм бэ? гэж Сатаров гайхан асуув. Тэгтэл Сатаровт өгөх хариу үгний оронд цагдаагийн машины дохионы дуу сонсогдох нь тэр. Жийпийн хоёр талаар дохионы гэрлээ гялалзуулан дуут дохиогоо орилуулсаар хоёр хөх шар машин зэрэгцэн ирж тоормозлов. Машинаас хоромхон зуур бүрэн зэвсэглэсэн ОМОН-чууд (цагдаагийн онц хэргийг мөрдөх бүлэг) үсрэн гарч ирлээ.

-Буугаа хаяцгаа, газар хэвт! гэж нэг цагдаа тэдний зүг автоматаа онилон тушаав.

-Яагаад ингэснийг нь одоо ойлголоо хэмээн Романыч автоматаа газар тавингаа дуугарав.

-Түй чөтгөр ав! гэж Сатаров харамсан нулимж хэлээд гар буугаа хажуу тийш нь чулуудаж орхилоо.

-Цөмөөрөө уруугаа хараад хэвт гэж байна! гэж түрүүчийн цагдаа зандраад автоматаа онилсоор тэдэн рүү дөхөж ирлээ.

Сатаров нэгэнт шавар шороо болсон үнэтэй костюмаа харамсан санаа алдан хараад дуртай дургүй гүзээгээ газар наан уруу харан хэвтэхээс өөр аргагүй болов. Хэдэн секундын дараа дөрвүүлэнгий нь гарыг ард нь мушгин бариад гавлаж орхилоо. Тэгтэл,

-За Олег Григорьевич минь тайвширч чадахгүй л байна уу? Хотын төв дунд буудалцаан зохион байгуулж байдаг. Болж байгаа юм уу? гэх танил дуу Сатаровт сонсогдов.

Сатаров тэр зүг хялайн харвал тэдний дунд ганцаараа энгийн хувцас өмссөн нэгэн эр зогсож байхыг харав. Тэр хүн бол цагдаагийн газрын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн ажилтан хошууч Бирюков байхыг Сатаров танилаа.

-Харин чи харахгүй байна уу? Биднийг арай л алчихсангүй. Тэр хашааны цаана алуурчин нуугдаж байна.

-Зүгээр ээ. Бид учрыг нь олно гээд Бирюков эргэж харан, бүх зэвсгүүдийг гялгар уутанд бээлийтэй гараараа барин хурааж хий. Эд мөрийн баримт болно хэмээн тушаалаа.

* * *

Цагдаа нарын хүч иртэл арван сумтай хүхээгээ дуустал буудсан Николай бууны амыг цонхноос сугалан авч хананы дэргэд тавилаа. Тэрээр гэрлэн дохиогоо гялалзуулан зогсож байгаа машинууд руу сүүлчийн удаа харснаа хүнсний зүйлтэй үүргэвчээ авч хонгилын хаалганд очиж онгойлгон гарч бариулыг нь алчуураар арчив. Дараа нь яаралгүй алхалсаар шатаар уруудах зуураа гарнаасаа резин бээлийгээ мултлан авлаа. Орцноос гарч мөн адил яаралгүй алхалсаар ойрхон байгаа буланг тойрч ард нь “сүүл” байхгүйг сэмхэн эргэж хараад резин бээлийгээ хогийн саванд хийж хаяад Сеницыны хэлсэн цагаан өнгийн “5” булан тойртол өмнө нь зогсож байв. Хаалга нь түгжээгүй байсан учир Николай шууд орж үүргэвчээ хажуугийн суудал дээр тавиад жолооны доор нуусан түлхүүрийг олж машиныг асаав. Түүний замын уулзварт дөхөж очих үед хотын оройн нам гүмийг цочроосон дохионыхоо дууг орилуулсаар цагдаагийн хоёр машин “Оливер”-ийн зүгээс өндөр хурдтай давхин өнгөрөв.

* * *

Мөрдөнгийн хорих өрөөнд өнгөрөөсөн тэр шөнийг Сатаров удтал мартдаггүй байсан юм. Тэрээр цагдаа нар яах бол гэж айгаагүй юм. Харин түүнийг ихэмсэг зангийн нь хор шар дарамталж цаашдын ойлгомжгүй хувь заяа санааг нь зовоож байсан юм. Тэрээр мэргэн буучийн сумны тусгалаас үсэрсэн шилний хэлтэрхий хүзүүг нь бага зэрэг шархлуулснаас өөр юмгүй нэг ч дусал цус урсгаагүй энэ дайнд зальтай бөгөөд ухаалаг Полунинд ялагдал хүлээснээ сайн ойлгож байлаа. Одоо түүнд зөвхөн Полунингийн цагдаа нартай хамтран хийх цаашдын ажиллагаанд ямар хэмжээгээр оролцож болох тухай эвгүй бодол эргэлдсээр байв. Гэвч түүний олз болох байсан завод одоо Седой Самбист нарын бүрэн хяналтад орж байгаа явдал Сатаровын санааг хамгийн ихээр зовоож байлаа. Сэтгэлийн шаналгаанаас болж тэрээр бараг үүр цайж байхад түр зуур дуг хийж байтал шоронгийн харуул орж ирлээ. Цаг долоо ч болоогүй байв. Харуул:

-Сатаров бос! Байцаалтад гэж зандрав. Шаланд нь эрэгдэж тогтоосон хоёр урт сандал, модон ширээ бүхий байцаах өрөөнд Сатаровыг оруулж ирэв. Нэг сандал дээр ширээ тохойлдон хошууч Бирюков сууж байв. Тэрээр:

-Суугтун, ноён Сатаров хэмээн сул байгаа сандал руу заан уриад, ийм эрт сэрээсэн явдлыг

минь уучлаарай гэв.

-Өнөөдөр та ихэд эелдэг байх чинь гэж Сатаров сандалд суунгаа инээд алдан дуугараад, очигдөр таны залуус биднийг баллаж байхад арай өөр байсан гэлээ.

-Тийм ээ, Олег Григорьевич. Та болон таны нөхдүүд тэр рестораны дэргэд буу зэвсэгтэй гүйлдэж жинхэнэ байлдаан хийж байсан. Харин хэн ч хэлмэгдээгүй нь гайхалтай. Тэр барилга барих гэж байгаа газрын модон хашаан доторхи шовгорт байгаа манаач хуучин цэрэг хашир хүн байсан учир буун дуу сонсмогц газар хэвтэж амиа аварчээ. Харин манааны шовгорт сум орсон арваад нүх гарсан байсан юм гэж хошууч хэллээ.

-Та буруу хэлж байна. Бид зэвсэг барин гүйлдээгүй. Харин бид мэргэн буучийн сумнаас хамгаалж машиныхаа цаана нуугдаж суусан юм. Үүнийг та сайн мэдэж байгаа гэж Сатаров хэлэв.

-Тийм ээ. Хаанаас та нарыг буудаж байсныг бид мэдсэн. Та нарыг Коммунарный гудамжны таван давхар байшингийн дээврийн хонгилоос Драгунов системийн винтовоор буудсаныг бид тогтоосон. Тэр мэргэн бууч болон буу хаанаас гарч тэр хүнд очсон зэрэг хэргийг бид мөрдөж байна гэж хошууч ярилаа.

Сатаров Бирюковын нүд рүү ширтэн инээмсэглээд:

-Харин тэр алуурчны захиалагчийг та нар сайн мэдэж байгаа гэж бодож байна. Учир нь мэргэн буучийн буудаж байсан байдал та нарын гэнэтхэн цагаа олж хүрч ирсэн явдал зэрэг сэжигтэй байна гэж ярьтал, Бирюков үгийг нь таслан:

-За ийм байна, Олег Григорьевич минь гэж хөмсөг зангидан түүнийг цоо ширтэн хэлээд, гэмт хэргийг судлан дүгнэлт гаргах нь бидний ажил. Үүний төлөө бидэнд цалин өгдөг гэв.

-Бас бус өөр юмны төлөө ч мөнгө авдаг гэж Сатаров зориуд үг чулуудав.

Бирюков түүний энэ үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөн тайван дуугаар үргэлжлүүлж,

-Өөрийн дүгнэлт хийх нь таны эрх. Гэвч би танд энэ талын үг дахин бүү дуугараасай гэж зөвлөж байна... Өөрийн аюулгүйн байдлыг хангахын тулд ч энэ нь танд хэрэгтэй болов уу гэж бодож байна гэлээ.

Энэ удаа Сатаров юм хэлсэнгүй. Бирюков бүр тайван дуугаар үргэлжлүүлж:

-Мэргэн бууч та нарыг буудсанаас биеэ хамгаалах гэж та нар түүний эсрэг галт зэвсэг хэрэглэсэн байлаа ч гэсэн галт зэвсэг хууль бусаар хадгалж байсан, санаатайгаар бус ч гэсэн аллага үйлдэхийг оролдсон зэрэг хэргээр таныг хэд хэдэн зүйл ангиар яллах үндэс бидэнд байна. Тэр манаач та нарыг шүүхэд өгөх гэж байгааг далиманд нь хэлье гэж бодож байна гэж сануулав.

Түүний хэлсэн үг албан ёсны байсан боловч өнгө нь Сатаровыг ямар нэгэн байдлаар болгоомжлохыг сануулах мэт байлаа. Хошууч түүнд зөвхөн болсон явдлыг сануулж ял

тулгахаар авчраагүй, бас цаана нь өөр ноцтой санаа нуугдаж байгаа юм биш биз.

Сатаров инээмсэглэн ярианы хооронд үг хавчуулан:

-Саяхан би нөхөд нь Седой гэж дууддаг Полунинтай ярьж байхдаа түүнд эвгүй үг дуугарсан юм. Магадгүй бас тэр намайг шүүхэд өгсөн байж болох юм. Эсвэл би буруу ойлгосон уу? гэж асуув.

-Надад таны талаар олон хүн гомдол гаргасан хэмээн Бирюков тайван хариулаад, таныг хотод олон хүн мэднэ. Та ажлаа идэвхтэй явуулж, үйлдвэр худалдааны газрын олон хүнтэй уулзаж байсан хүн. Харамсалтай нь зарим үед ийм уулзалтын дараа зарим нь эмнэлэгт хүргэгдэж, зарим нь бүр сураггүй алга болдог ч явдал бий. Амьд үлдсэн зарим нь таны талаар гомдол мэдүүлж ирдэг юм. Харин та энэ бүхнийг гүтгэлэг гэж эрс үгүйсгэдэг нь мэдээж. Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэд будилж буруу юм хийж гомдол мэдүүлсэн байна гэж мэдэгдлээ буцааж авдаг юм гэж ярилаа.

-Та дэмий юм бүү чалч, хэмээн Сатаров гэнэтхэн хилэгнээд, та намайг аль эртнээс дэгээдэж унагаахыг хүсэж байсан боловч бүтэхгүй явсаар өнөө хүрсэн. Харин одоо танд Полунин тусалсан байна. Би ганцхан юмыг ойлгохгүй юм. Яахлаараа тэр Полунин та нарын ард суух болов. Эсвэл та нарыг өөрийн ажилд аваа юу гэж асуув.

Тэрээр чинээндээ хүртэл бухимдаж байгаа нь илт харагдана. Гэвч Бирюков түүний энэ тэсрэлтийг үл анзааран яриагаа үргэлжлүүлэн:

-Олег Григорьевич та чадварлаг хүн. Гэвч залуу бөгөөд гэнэн байна. Полунин бид хоёр шиг эрс тэс ялгаатай хүн хамтарч ажиллах юм гэж та үнэхээр бодож байна гэж үү? хэмээн асуулаа.

-Гэвч ажиллаж л байна биш үү гэж Сатаров зөрүүдлэв.

-Харин энд та огт буруу ярьж байна гэж Бирюков сануулаад, тэр бид хоёр хэтэрхий өөр хүмүүс. Би эрүүгийн цагдаа хүн. Харин тэр чинь хулгайч. Тийм учраас бид хоёр юм болгонд тохирч чадах тийм дотно харьцаа байхгүй. Харин бие биендээ хүндэтгэлтэй хандаж тэр ч бүү хэл бидний эцсийн зорилго ижил байх тохиолдолд бид харилцан тохирч болохыг үгүйсгэхгүй гэлээ.

Бирюков хэсэг дуугүй байснаа дахин Сатаровын нүд рүү ширтэн:

-Дээрэмчид хулгайчдын ямар бүлэг юуны төлөө тэмцэлдэж байгаа, худалдааны мухлагийн төлөө юу, том үйлдвэрийн төлөө юу гэдэг нь бидэнд хамаагүй, харин тэдний хооронд зэвсэгт мөргөлдөөн гаргуулахгүй байх нь бидний үүрэг гэлээ.

-Бид гэж та чухам хэнийг хэлж байна? Цагдаа нарыг уу? гэж Сатаров асуув.

-Зөвхөн цагдаа нарыг ч бус хотын захиргааны удирдах хүмүүсийг хэлж байна гэж Бирюков товч хариулав.

-Харин Полунин ямар хамаатай юм бэ?

-Ямар ч хамаагүй гэж Бирюков мөрөө хавчин хариулаад, тэр бидэнд хийх ёстой юмаа хий гэж зөвлөсөн юм. Тэр хүн бидний нэгэн адил аливаа асуудлыг цус урсгалгүй хэлэлцэн шийдэхийг хүсэж байдаг хүн. Тэгэхлээр та Олег Григорьевич тэр хүнийг дэмжих хэрэгтэй гэж зөвлөв.

Сатаров эргэцүүлэн бодож байгаа мэт баргар царайлан сууна. Хошууч яриагаа дахин эхэлж:

-Энэ хот бидний тогтоосон хууль дүрмийг мөрдөн амьдрах ёстой Олег Григорьевич. Та ч гэсэн үүнийг хүлээн зөвшөөрвөл зохино. Хэрэв бидний энэ тогтоосон хууль дүрмийг та зөвшөөрөхгүй байгаа бол та өөрөө ихэд харамсах болно. Хэрэв зөвшөөрч байгаа бол бидний хамтын ажиллагаа үр дүнтэй байх болно. Таныг өнөөдөр эндээс суллаж явуулна. Харин энэ хотоос гарч явахгүй гэсэн гарын үсэгтэй баталгаа танаас авна гэлээ.

-Харин миний хүмүүсийг? гэж Сатаров асуув.

-Мэдээж суллана гэж Бирюков амлаад, та харин бид зэвсэг олсон цагдаагийн газар аваачиж хураалгах гэж байна гэсэн утгатай өргөдөл бичээд өнгөрсөн цагаар сар өдрөө тавьчих. Хэрэв энэ алхмыг шүүх үл зөвшөөрвөл таны зургаан хүний нэг нь бүх бурууг өөртөө авч зургаан сарын тэнсэн авна гэдгийг би баталгаатай хэлж байна гэж хэллээ.

Бирюков хуруугаараа ширээний тавцанг бухимдан тогшиж баргар царайлан суугаа Сатаровыг ноцтой ширтсэнээ

-За тэгвэл тохиролцов уу? гэж тулган асуув. Нөгөө хүн нь түүн рүү харалгүй бодлогоширон сууж байснаа:

-Тамхи байна уу? гэж асуулаа.

-Та тамхи татдаггүйсэн биш бил үү гэж Бирюков гайхан асуулаа.

-Татдаггүй. Гэвч одоо татмаар байна гэж Сатаров хариулав.

* * *

Полунин асаагуур часхийлгэн янжуураа асаагаад яаралгүй сороод:

-Харав уу. Зочид ирлээ гэж дуугарлаа. Самбист тэр хоёр зоогийн ширээнүүдийн дундуур өөрсөд рүү нь чиглэн ирж яваа Сатаров, Романенко хоёрыг зэрэг эргэн харлаа. Тэднийг урьдчилан хорихоос суллаж тавьсны хоёр хоногийн дараа оройн долоон цагт энэ “Каскад” гэдэг ресторанд уулзахаар тохиролцсон байлаа. Тэд ресторанд тусдаа өрөө захиалсан байв. Тэр ресторан нь хотын төвд орших бөгөөд хэд хэдэн бүлэглэлийн ивээлд байдаг нэг ёсны төвийг сахисан газар учир янз бүрийн өрсөлдөгч талууд уулзаж ярилцахад тохиромжтой ажээ. Сатаров Романенко нар ширээнд хүрч ирээд суумагцаа тэр хоёрт юу ч хэлэлгүй хөмсөг зангидан ширтэнэ.

Тэр өрөөнд түгшүүртэй нам гүм хэсэг зуур үргэлжилж байтал Полунин “Мальборо” янжуур

гарган Сатаровыг дайдж:

-Тамхилна уу? Олег Григорьевич гэлээ.

-Би тамхи татдаггүй хэмээн Сатаров ууртай дуугарч татгалзахад Романенко халааснаасаа өөрийн янжуурыг гаргав.

-За алив, юу ярих гэсэн юм? гэж Сатаров үл мэдэг хайнгадуу өнгөөр асуугаад, бид анхааралтай сонсоё л доо гэлээ. Полунин Сеницын хоёр бие бие рүүгээ ёжтой харц чулуудаад Полунин бага зэрэг инээмсэглэн:

-Залуус минь та нарт юу тохиолдоов? Өнөөдөр тавгүй шинжтэй харагдах чинь. Та нарын нааран дээр сууж байхад чинь тэр цагдаа нар юу зөвлөө вэ? гэж асуув. Тэгж хэлэхэд нь Самбист инээд алдаж орхилоо. Харин Сатаровын нүүрэнд бухимдал хилэнгийн хүйтэн өнгө илэрч урагшаа огцом бөхөсхийн заналхийлэх дуугаар

-Седой чи сонс! Чи одоо өөрийгөө ялагч мэтээр ойлгож байна. Чи бүү онгирч бидний зэвүүг хүргээд бай гэж чамд зөвлөө. Би үзүүлээд өгнө, гайгүй... гэж зандчив. Тэгснээ хүзүүгээ болгоомжгүй хөдөлгөснөөс болж шархны тууз наасан шархыг хөндөж орхилоо. Тэрээр нүүрээ эвгүй үрчийлгэснээ шархаа гараараа дарж нуруугаа цэхлэв.

-Чи дэмий ингэж тарчилж байна гэж түүнийг тайван ширтсээр суусан Полунин инээмсэглэн хэлээд, би ялагчийн байрнаас чамтай яриагүй байна. Ялагдагчтай ярилцдаггүй харин түүнийг устгадаг юм. Учир нь шарх авсан чоно заавал эргээд дайрдаг гэж хэлээд дуугүй болж Сатаровын юу гэж хариулахыг хүлээж суув. Гэвч Сатаров юм хэлсэнгүй.

-Би чамаас хамтарч ажиллахыг хүсэх гэсэн юм гэж Полунин хэллээ.

-Тодорхой ярь хэмээн Сатаров болгоомжлон хэлээд, ямар ажлаар яаж хамтарч ажиллах юм бэ? гэж асуув.

-Ямар ажлаар гэдэг нь тодорхой хэмээн Полунин мөрөө хавчин хэлээд, та бид хоёр “Нефтьоргсинтез”-ийн төлөө өрсөлдөж байна. Тэгэхлээр заавал ингэж тэмцээд байхын хэрэг юун. Адилхан тэгш эрхтэй эзэмшигчид болохгүй нь юу байна гэв.

-Тэгш эрхтэй гэв үү? гэж Сатаров асуугаад, чи надад үнэт цаасны тавин хувийг санал болгож байгаа хэрэг үү? гэж асуув.

-Үгүй ээ. Дөчин таван хувийг гэж Полунин хариуллаа.

-Мөн дөө. Надаар тоглож байна уу? гэж дахин Сатаров хилэгнэн үүнийгээ чи тэгш эрх гэж нэрлэж байгаа юм уу? гэж асуув.

-Тийм ээ, манай бүлэгт мөн адил дөчин таван хувь нь ноогдоно гэж Полунин хариулав.

Сатаров улам ихээр бухимдан:

-Тэгвэл үлдсэн арван хувийг хэн авах юм гэж асуув.

Полунин хариу хэлэхийн оронд өрөөний хаалганы завсраар харагдах, танхим руу толгой дохив. Сатаров түүний харсан зүг рүү эргэж харлаа. Танхим дотор хар костюм, саарал өнгийн цамц өмссөн хижээл насны эр яаралгүй алхан ирж яваа нь харагдлаа.

-Коля Решето? гэж Сатаров гайхан асуув.

-Яг тэр хэмээн Николай Решетов өрөөнд орох зуураа батлан хэлээд Олег минь надтай энд уулзана гэж санаагүй биз? Би ч гэсэн энэ нөхөрсөг хамуудтай энд уулзана гэж бодсонгүй гээд сул байгаа зөөлөн сандал дээр суулаа.

-Тэгэхлээр чи түүнийг урьсан байх нь уу? гэж Сатаров Полунингаас асуув.

-Тийм ээ би гэж Полунин тайван хариулав.

-Ямар чөтгөрөө хийж тэр энд хэрэгтэй юм бэ? Чи хувьцаагаа энүүнтэй хуваалцах гээгүй биз дээ? гэж Сатаров бухимдав.

-Тийм ээ. Хуваалцах гэсэн юм хэмээн Полунин хариулаад, Коля мөн бидний нэгэн адил тэр үйлдвэрийн хувьцааг сонирхож худалдан авч эхлээд байгаа юм. Гэвч тэрээр бидэнтэй адил том шуугиан гаргаагүй. Нэг их ч хувьцаа худалдаж аваагүй байгаа боловч нэгэнт ямар нэгэн хэмжээгээр цуглуулж амжаад байгаа хүн гэв.

-Би өөрийн хууль ёсоор олсон хувьцааг энэ тарган гахайтай хуваалцахыг огт хүсэхгүй байна гэж Сатаров бухимдан хэлээд, өөрсдийн мөнгөө өгсөн тэр үйлдвэрийнхээ хувьцааг түүнд яагаад өгөх ёстой юм? гэж асуув.

-Үнэндээ би ч гэсэн ойлгохгүй байна гэж Антон Синицын гайхширан дуугараад, бид Сатаровтай тэр хувьцааны чинь төлөө байлдаж байхад энэ хүн зүгээр л хэн хэнийгээ нухах нь вэ гэж хараад сууж байсан. Одоо болоход хувь авна гэж байдаг гэж асуулаа.

Коля Решет залуу дээрэмчдийн яриаг сонсоод дургүйцсэнээс болж нүүр нь улайж суулаа. Тэрээр халааснаасаа том гэгчийн алчуур гарган бүдүүн хүзүү, махлаг дугуй нүүрээ арчаад сая нэг юм ам нээж:

-За тэгэхлээр Иваныч гэж бага зэрэг сөөнгөдүү бөгөөд тальтраадуу дуугаар хэлээд, би ажил хэргийн талаар ярилцах гэж ийшээ ирсэн болохоос биш энэ нусгайчуудын чалчихыг сонсох гэж ирээгүй. Чамд надад ярих юм байвал хэлээд орхи. Эс бол би эндээс явах минь. Дараа нь өөр байдлаар ярилцах болно гэлээ.

-Аяд, Коля минь хэмээн Полунин тайван хэлээд, чухал юм ярих гэж байна. Энэ туршлагагүй залуус юу гэж сагсуурах нь хамаагүй гэв.

Решетовын жижигхэн хар нүд бяцхан зураас болтлоо улам онийж:

-Надад юу өгөх өгөхгүй асуудлыг ямар нэгэн хөхнөөсөө гараагүй жаалуудаар би

шийдүүлэхгүй. Би бол дархлагдсан хулгайч. Би энэ хотын эзэн учраас юуг авах, юуг эс авахаа өөрөө шийднэ. Харин эд нар надад хувь төлөх нь гарцаагүй гэж нударгаа зангидан шүд зуун сануулав.

-Мөн дөө. Солиорч байх чинь хэмээн Сатаров инээд алдаад, хувь авна гэх нь үү. Чиний тэр хулгайчийн титэм дээр чинь би шээж орхино. Тэр цол чинь өөрсдийнхөнд чинь хэрэгтэй болохоос биш надад хамаагүй. Миний хувьд чи юу ч биш гэж хэллээ.

-Сатаровын зөв гэж гэнэтхэн Олегийг Антон дэмжин хэлээд, бид зүгээр суугаа хэн нэгнийг тэжээх шаардлагагүй. Мөнгө ажиллаж олохоос биш хэвтэж олдоггүй гэв.

-Одоо больцгоо! гэж Полунин гэнэтхэн ширээ шаан зандраад, ингэж яриад байвал эцэст нь улаан хоолойгоо тас химлэлдэх болно гэлээ.

Ямагт тайван байдаг Полунингийн гэнэтийн хилэгнэл тэдэнд нөлөөлөв бололтой цөм чимээгүй болон Владимерын юу гэхийг хүлээлээ. Тэгснээ Полунин Сатаров руу хараагаа шилжүүлэн:

-Олег сонсож бай! Энэ бүхэн чамд юунд хэрэгтэй юм бэ? гэж асуув.

-Ойлгосонгүй. Чи юуны тухай? гэж Сатаров гайхан хариулав.

-Чи тэр хувьцааны тасалбаруудаар яах гэсэн юм? Үйлдвэрийн эзэн болохыг хүсээ юу? гэж Полунин асуув.

Яриа ингэж огцом эргэхийг санаагүй байсан Сатаров мөрөө хавчин үнэнээ хэллээ.

-Би бүх насаараа гудамжны хүүхэд мэт мухлаг сахиж суух юм уу? Би том хүн том хэргийг барьж авмаар байна гэж Сатаров хэлэв. Полунин Сатаровыг анхааралтай сонсоод

-Би чамайг ингэж хэлнэ гэж санасангүй Олег. Би чамайг зөвхөн захирлын хувцас өмссөн хүн гэж бодож байтал харин чи үнэн хэрэгтээ тэр албан тушаалыг санаархаж явдаг хүн бололтой. Би ч гэсэн том бөгөөд чухал бизнес эрхлэхийг хүсэж байна. Би чамтай нэгэн адил тэр үйлдвэрт их хэмжээний хөрөнгө оруулалт хийж энэ байдлаас нь гаргаж босгохыг хүсэж байна. Ингэснээрээ би өөрийн гараар нэр хүндтэй үр бүтээлтэй ажиллаж бусдад ч гэсэн тус болохыг чармайж байна гэв.

Сатаров дуугүй сууж байх бөгөөд түүний харцны байдлыг ажиглавал ямар нэгэн хэмжээгээр түүний хэлсэн үг нь нөлөөлсөн бололтой ажээ.

-Гэвч би нэг зарчмыг баримтлах болно Олег минь хэмээн Полунин яриагаа үргэлжлүүлэн, би их мөнгө оруулж тайван ажиллахыг хүсэж байна. Их мөнгө оруулж цаг ямагт ямар нэг юмнаас сэргэмжилж байхыг би хүсэхгүй байна. Чухам тийм учраас надад ямар нэгэн асуудалгүй тайван ажиллахад боломж олгох хэлэлцээр хэн нэгэнтэй хийх шаардлагатай юм. Чухам ийм учраас Коля Решето тэр үйлдвэрийн үнэт цаасны арван хувийг авах эрхтэй юм гэлээ. Полунин үгээ дуусгахад дахин нам гүм болов.

Сатаров Синицын хоёр толгойгоо унжуулан Полунины хэлсэн үгийг эргэцүүлэн бодож суутал гэнэтхэн Коля Решето ам нээж:

-Арван хувь гэж дурамжхан байдлаар дуугараад, ердөө л аравхан хувь уу? Та нарын ухаан эрүүл байна уу? Надаас зоос унагах гээ юу? Гучин хувиас доош би зөвшөөрөхгүй гэж хэллээ.

-Зөвшөөрөх үү, үгүй юу гэж чамаас хэн ч асуугаагүй байна гэж Самбист дургүйцэн хэлэв.

-Хувь өгч байгаад маань баярлалаа гэж хэл хэмээн Сатаров нэмж дуугарав.

-За тэгвэл бидний яриа тохирсонгүй гэж Решетов дүгнэн хариуллаа.

Полунин энэ ярианы дараа бүрмөсөн тэвчээр алдан өөрт нь бусдаас хамгийн ойрхон сууж байгаа Решетов руу хандан нүд рүү нь цоо ширтэн нам бөгөөд хорсолтой дуугаар:

-Коля минь чи дайтахыг хүсээ юу? Өөрийн цүдгэр гэдсээ бууны суманд тавьж өгөхийг хүсээ юу. Тэгвэл эхэл л дээ. Харин энэ дайнд чи ганцаараа бидний бүлгүүдтэй тулалдах болно. Чиний хүч хүрнэ гэдэгт би эргэлзэж байна гэж хэллээ. Решетов хүндээр амьсгаалан байн байн хөлстэй духаа арчиж сууна.

Владимир цааш нь:

-Би чамайг ухаалаг хандана гэж бодож байсан юм, Николай гэж нэмж хэллээ.

Тэгтэл арай хийж нэг юм Решето зузаан уруулаа нээж:

-За яахав. Надад хорин хувийг л өгчих. Тэгээд гар барья гэв.

-Энд Коля минь хэн хэнд ч юу ч өгөхгүй. Харин юм худалдаж авна гэж Полунин үгийг нь таслан хэлээд чи арван хувийг илүү ч үгүй худалдан авч болно. Энэ арван хувь бол чамд биднээс сайн санааны үүднээс гарган өгч байгаа үнэт цаас юм. Өөрийн зэрэг дэвийг хүндэлж байгаа бол чи ойлгох ёстой. Хэрэв зөвшөөрөхгүй байгаа бол дахин чамтай ярих юм байхгүй гэж тулгалаа.

Решетов үзэн ядах харцнаасаа болж ярвайн инээж:

-За яахав чи, Иваныч, миний эсрэг байх шив дээ? Чи өөрөө хулгайчдаас гаралтай шиг санаж байна. Гэтэл чи дээрэмчидтэй хутгалдан өөрийн хамуудын эсрэг босож байх чинь. Намайг энэ хотынхон хамгаалагчаа болгосон. Москвагийн томчуул хүртэл миний талд байдгийг бүү мартаарай гэв.

Полунин түүнийг дэмжиж байдаг тэр томчуулыг мэддэг байсан юм. Тэдний нэг нь нэрд гарсан хулгайч Мирон хочтой овгор байв. Чухам тэр этгээд Решетог дэмжиж энэ хотын дархалсан хулгайч болгожээ. Бас түүний сонирхолыг Решето энэ хотод дэмждэг байсан юм.

-Чиний тэр загалмайлсан эцэг Мироновтой би ч танил хэмээн Полунин мэдэгдээд, тэр чамайг энэ хот руу хянагчаар явуулах гэж байсан тэр үед би түүнд чамаас олигтой юм

гарахгүй гэж хэлж байсан маань зөв байжээ. Хэрэв чи хэвийн байдлаар энэ хотыг харж байсан бол энэ залуус чамд өөрсдийн болзлоо тулгахгүй байхсан гэлээ.

-Тэгвэл чи өөрөө энэ хотыг хяналтандаа авахыг хүсэж байгаа юм биш биз? Миний суудалд санаархаж дархлагдсан хулгайч болохыг хүсэж байна уу? гэж Решето мушийн инээмсэглэв.

-Би хэзээ ч тэгэхгүй хэмээн Полунин хариулаад, миний нэр хүнд чиний хийж байгаа ажлаас огтхон ч хамааралгүй. Ухаан чинь бүрмөсөн муудчихаагүй бол би өөрийн хэрэгт чамайг оролцуулснаар би чиний нэр хүндийг өргөж байна гэдгийг чи ойлгох ёстой. Магадгүй чи ингүүлэх гавьяагүй ч байж болно гэж ярив. Тэгснээ Полунин Решетогийн нүдийг цоо ширтэн ширүүнээр:

-За тэгээд бидний тавьсан болзлыг зөвшөөрч байна уу? Үгүй юу? гэж асуув.

Коля Решето уруулаа эвгүй хөдөлгөснөө хүзүүгээ алчуураар арчин гараа савчин:

-За яахав. Чөтгөр аваг та нарыг! Би зөвшөөрөхөөс дөө. Та нар ятгаж чадлаа гэж хэлэв.

Тэрээр энэ үгээ ямар нэгэн бэлэг өгөхөөр ятгаад байхад нь татгалзсан мэт дуугаар хэлсэн ажээ. Дараа нь тэрээр баргар царайлан босож:

-Бусад асуудлаа надгүйгээр ярьцгааж шийднэ биз. Надад өнөөдөр бас өөр ажил байна. Миний хэрэг болвол миний байгаа газрыг та нар мэднэ гээд гараа дохин салах ёс гүйцэтгээд өрөөнөөс гарлаа.

Өрөөнд үлдсэн дөрөв бас хэсэг хугацаанд ажил хэргийн талаар нарийвчлан ярилцав. Тэд хамтран үнэт цаас худалдан авах пүүс байгуулахаар тогтов. Худалдаж авсан үнэт цаасыг өнөөдөр ярилцсан ёсоор хувааж авах бөгөөд үйлдвэрийн удирдлагын хувьд өөрчлөлтгүй ерөнхий захирлаар Веселовский, дэд захирлаар нь Соловейчик хэвээр үлдэх нь зүйтэй гэж үзэв. Түүнээс гадна бүх сонирхогч талын төлөөлөгчид оролцсон захирлуудын зөвлөл байгуулж даргаар нь Полунинг томилжээ.

Ингэж заводын гүйцэтгэх захиргааг Сатаров толгойлж Полунин ерөнхийд нь хяналт тавьж байхаар болов. Энэ асуудлыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчлан хэлэлцсэний дараа Сатаров Романенков нар явахыг завдаж байх үед гэнэтхэн Олег Полунинд гараа өгч уулзсанаас хойш анх удаагаа инээмсэглэн:

-Чи мэдэж байна уу? Ингэж хамтрах нь зүйтэй санаа байжээ. Бид хамтдаа муугүй хүч болох учир их зүйлийг хийж чадна. Та бидний эсрэг босож ирэх хүн гарах нь юу л бол. Тан шиг хашир туршлагатай хүнтэй хамтарч ажиллах болсондоо би баяртай байна гэж хэллээ.

-За яахав. Би ч гэсэн чамайг ярианыхаа төгсгөлд гомдоочихоогүй дээ мөн адил баяртай байна хэмээн Полунин инээмсэглээд, чиний төлөвлөгөө чинь бодитой хэрэгжих юм бол миний төлөвлөгөө ч хэрэгжих боломжтой учир бид гар нийлж чадна. Хамгийн гол нь энэ тохиролцооноосоо буцаж болохгүй гэж санууллаа.

Гуравдугаар бүлэг

Полунин бодож байсан дурсамжаасаа гэнэтхэн салж суудлаасаа үсрэх шахам босоод өрөөн дотуураа холхин алхаллаа. Лобников бага зэрэг гайхан Владимирыг ажиглаж байсныг анзаарсангүй тэрээр сэтгэл ханамжтай байдлаар:

-Валерий чи мэдэж байна уу. Хэрэв хэн нэгэн гэнэтхэн шинэ Орос орны бизнесийн түүхийг өөрчлөн байгуулалтаас эхлэн өнөөгийн үе хүртэл бичихээр шийдвэл тэр нь нэгдүгээр нь “Их завшилт”, хоёрдугаар нь “Их устгал” гэсэн үндсэн хоёр бүлэгтэй ном болох байх. Хоёр бүлэг нь хоёулаа цус урсгасан эмгэнэлт явдлаар дүүрэн байх болно. Хамгийн сонирхолтой нь нэгдүгээр бүлэгт бичигдэх түүх нь хэдийнээ болоод өнгөрсөн байхад харин хоёр дахь бүлгийн түүхийг бичиж хэн ч чадахгүй юм. Би энэ бүлгийг хэзээ ч бичиж дуусахгүй гэж бодож байна гэж ярилаа.

-Би өнөөдрийн явдалд тохирох нэг зүйлийг нэмж хэлмээр байна гэж Лобников гашуунаар инээмсэглэн хэлээд, тэр номын чинь төгсгөлийн бүлэг болгон энэ хоёр үе шатны хугацаанд алуулсан хүмүүсийн нэрсийг он оноор нь жагсааж гаргахсан. Энэ нэрсийн жагсаалтад Андрей Капустины нэр орно. Мөн цаашид ч хэн нэгний нэр энэ хар дэвгэрт орох нь дамжиггүй болоод байна гэлээ. Тэгснээ Лобников Полунин руу таагүй харцаар ширтээд:

-Чи хаа нэгтээ нам тайван газар шигдэн сууж тэр номоо бичвэл таарна. Тэгвэл чамаар хэн ч оролдохгүй, бид ч санаа зовохгүй байх болно гэв. Хариуд нь Полунин инээд алдаад:

-Чиний гэнэн зан гайхал төрүүлж байна. Тэртэй тэргүй хэн ч чамайг тайван суулгахгүй. Яагаад гэдгийг мэдэх үү? гэж асуув.

-Яагаад?

-Яагаад гэвэл заводын одоогийн удирдлага болон хотын зарим түшмэдүүд тэр номын хоёр дахь бүлгийн бизнесийн түүхэнд маргаангүй хамрагдах баатрууд юм хэмээн Полунин харамсан өгүүлээд, тэд ганцхан над руу бус бусад олон хүмүүс рүү дайрч байна. Эрт орой хэзээ нэгэн цагт бид гарцаагүй хариуцлага хүлээхээс өөр аргагүй гээд ширээ рүүгээ дөхөж очоод сандал дээр ядарсан байдалтай суулаа.

-Бүх юм их мөнгөнөөс болж байна хэмээн тэрээр үргэлжлүүлэн ярьж, их мөнгө бол их засаглал юм. Их засаглал нь хэзээд ч итгэлгүйдэл болон сэжиглэлийг төдий чинээ хэмжээгээр төрүүлж байдаг юм. Ийм нөхцөлд уух усыг нь булингартуулж орхих нь хүрэлцээтэй. Тэр булингартай уснаас их хэмжээний загасыг удаан хугацаагаар барьж болдог гэж ярилаа.

* * *

“Каскад” ресторанд уулзалт хийсэн тэр орой Полунин ядарсан боловч сэтгэл ханамжтай гэртээ харьж ирлээ. Сүүлийн хоногуудыг тэрээр их ачаалалтай бөгөөд түгшүүртэй өнгөрөөжээ. “Нефтьоргсинтез”-ийн эргэн тойрон асуудал улам хурцдаж байсан юм. Гэвч бий

болсон байдлыг өөрийн сонирхолыг хэвээр үлдээн намжааж чадсан явдал түүний санааг амрааж түүний зэрэгцээ хэрхэн ядарч байгаагаа мэдрэхэд хүргэжээ. Энэ бол тааламжтай ядаргаа байв. Тэр орой тэрээр гал тогооны өрөөндөө тухлан сууж өнгөрсөн олон жилийн хугацаанд бараг анх удаагаа идэр насны баяр баясгалангаар өөрийн ирээдүйн төлөвийг төсөөлөн бодож байсан билээ. Оройн хоолоо бэлтгэж байсан Анна дуугүй сууж тамхиа татаж байгаа эр нөхрөө гайхан ажиглаж байснаа тэсгэлгүй:

-За юу болов? Маргаанаа намжааж чадсан шиг байна гэж асуув.

-Тэглээ. Харин чи яаж мэдэв? гэж Полунин гайхан асуув.

-Өнөөдөр чи тайвширч нүдний чинь түгшүүр алга болсон юм шиг харагдаж байна. Чи ховорхон ийм амгалан байдаг шүү дээ гэж Анна хариуллаа.

Полунин эхнэртээ хийсэн хэлэлцээрийнхээ талаар, цаашид энэ бизнест ямар асуудал эрхлэн ажиллах болсон тухайгаа ярьж өглөө.

-За ямар байна, миний төлөө баярлаж байна уу? гэж Полунин асуув. Гэвч эхнэрийн нь хариулт түүнийг бага зэрэг гайхахад хүргэлээ.

-Үүнээс хойш би гэрээс гарах болгондоо яах бол гэж айж явахгүй болсондоо бүхнээс илүү баярлаж байна гэж Анна үнэнээ хэлээд, та нарын их азаар эвлэрч хамтрахаас өмнө би цаг ямагт сэтгэл зовж гэрээс гарахдаа Антон эсвэл түүний хүмүүсийг дагуулан явдаг байсан. Чиний тэр албан тушаалын чинь хувьд гэвэл чи хагалгаа хийлгэснийхээ дараа бүрэн эдгэртлээ гэртээ сууж байх чинь дээр гэж хэлж бага зэрэг урмыг чинь хугалмаар байлаа. Чам шиг ийм хүнийг даашинзнаасаа уяж тогтоож чадахгүй гэдгээ би мэдэж л байна. Гэвч энэ байдалдаа аль хэдийнээ би дасаж орхиж л дээ гэлээ.

Анна нөхрийнхөө цайгаа уухыг дуугүй харан сууж байснаа шаардах мэт өнгөөр:

-Чи амралтаа аваад хамтдаа гадаад явъя гэж амласан биш бил үү. Би Франц очиж үзэх юмсан гэж бүх насаараа мөрөөдөж явах юм гэв.

-Тийм ээ, тэгнэ хэмээн Полунин толгой дохиод, бага зэрэг хүлээх хэрэгтэй. Одоо надад ажил маш их байна гэлээ.

-Одоо гэдэг чинь хэдий болтол үргэлжлэх юм бэ? Нэг сар уу? Эсвэл хагас жил, бүр бүтэн жил үү? Би хэдий болтол хүлээх юм бэ? гэж Анна асуув.

Полунин эхнэрээ инээмсэглэн ширтээд:

-Чи хүлээж болохоор залуу хүн шүү дээ. Хүмүүс чиний насан дээр дөнгөж амьдралаа эхэлж байна гэв.

-Энэ чинь цэвэр эр хүний сэтгэлгээ гэж Анна дуугараад, би хэдэн настайгаасаа хамааралгүй юмыг хойш тавихыг хүсэхгүй байна. Бид хэзээ Париж явахыг би яг таг мэдмээр байна? гэж асуув.

Полунин мөрөө хавчин:

-Нэг жилээс багагүй хугацаа өнгөрсний дараа гэж бодож байна. Харин одоо сайн ажиллах хэрэгтэй гэж хариулжээ.

* * *

Хүлээгдэж байгаа жил бол үйлдвэрийн ажиллагаа болон түүнтэй хувь заяагаа холбосон хүмүүсийн хувьд маш их ачаалалтай бөгөөд хариуцлагатай жил байх болно гэж Полунин төсөөлж байсан нь зөв байлаа. Үнэт цаасны гүйлгээний бүх төрлийн ёс төдий зөвшөөрөл бичиг хэргийн ажил дууссаны дараа үйлдвэрийн хувьцаа бодит хүмүүсийн хооронд хуваарилагдсан ажээ. Полунин Самбист нарт тус бүр хорь хорин хувь, Соловейчик, Веселовский нарт тав таван хувь, Романенков, Решетов нарт арав арван хувь, харин Сатаровт гучин хувь хувьцаа ноогджээ. Решетов өөрийн хувьцааг өөрийн санхүүгийн асуудлыг хариуцсан Серегинь нэрэн дээр авахаар баримт бичгээ бүрдүүлсэн ажээ. Ингэж ямар нэгэн далд санаагүйгээр үйлдвэрийн бүх хувьцааг ил тохиролцсоны үндсэн дээр хувааж авчээ. Үйлдвэрийн дотоод асуудлыг шуурхай бөгөөд үр ашигтай шийдвэрлэх болсноор үйлдвэрийн байдал хурдан сайжирч байлаа.

Мөн заводын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл ч энүүнд сайнаар нөлөөлсөн юмсанжээ. Хувь нийлүүлэгчид үйлдвэрийн хувьцааг зөвхөн худалдаж аваад зогссонгүй дүрмийн санг нэмэгдүүлэх арга хэмжээг авч байлаа. Үүний үр дүнд багагүй хөрөнгө оруулалт хийгдэж байв.

Найдваргүй бөгөөд осолтой байдлаас болж сул зогсож байсан өндөр шаталтын бензин нэрэх шугамыг богино хугацаанд өөрчлөн засварлажээ. Нийлэг эдийн үйлдвэрлэлийн шугамыг шинэчлэх ажлыг аажмаар гүйцэтгэж байв. Бензиний гүйлгээ эрс сайжран үйлдвэрийн ашиг хурдан нэмэгдэж байлаа. Үйлдвэр хагас жилийн дотор улсын байгууллага болон хувийн үйлдвэрүүдэд төлөх өрөө бүрэн төлж чадсан байна. Үйлдвэрийг удирдан хянаж байгаа ийм хүчирхэг бүлэглэл Сатаров, Самбис нартай тусгай холбоотой байдаг зарим нэгэн идэвхтэй зээл олгогч нарыг болгоомжлоход хүргэж байлаа.

Сатаров, Полдуин нар бэлэн газрын тосны компанийг худалдаж авахад илүү их зардал гаргахгүйн тулд Веселовский, Соловейчик хоёрын зөвлөснөөр газрын тос олзворлох зөвшөөрөл авчээ. Үүний үр дүнд оны эцэст гэхэд ажиллаж байсан болон ажиллахад бэлэн болоод байгаа газрын тосны хэд хэдэн цамхаг тэр хоёрын мэдэлд шилжлээ. Ингэхийн тулд тэд мужийн болон бүр Москвагийн том түшмэдүүдийн гарыг цайлгаж Москвагийн газрын тосны том пүүсүүдтэй өрсөлдөх хэрэг гарчээ. Гэвч мөнгө өөрийн шидийг үзүүлж тэр ч бүү хэл Москвагийн бизнесийн мундагчуул хүртэл тэдний хүчирхэг бүлэглэлтэй тэрсэлдэхийг хүссэнгүй. Ингэж “Нефтьоргсинтез” нэртэй тэр завод ирээдүй сайтай эрчимтэй цэцэглэж байгаа үйлдвэр болон хөгжиж бас нэг жилийн дараа газрын тос олзворлон боловсруулах “Аркада” нэртэй хүчирхэг компани болон хувирчээ. Энэ хугацаанд боловсон хүчний тогтворгүй байдал бүрмөсөн зогсож ажиллах шинэ шинэ хүчээр нэмэгдэж байв.

Полунин шинэ албан тушаал авснаас хойш хагас жилийн дараа түүний ажлын өрөөнд Сатаров гурван залууг дагуулан орж ирсэн юм.

-Танилц Владимир Иванович. Эд бол манай шинэ түншүүд юм. Бид нэгэн удаа санхүү бол манай эмзэг газар юм гэж ярьж байсныг чи санаж байна уу. Энэ залуус энэ талаар бидэнд тусалж чадна гэдэгт бат итгэж болно. Би эдэнтэй өмнө нь хамт ажиллаж байсан учир сайн мэднэ. Эд залуу бөгөөд боловсролтой, бизнесийн ажлыг сайн мэдэх хүмүүс гэлээ. Полунин орж ирэгсэдтэй эелдэгээр мэндлэв. Тэдний хамгийн ахмад нь гуч орчим насных болов уу гэмээр өндөр нуруутай жавхаалаг залуу байв. Нэрийг нь Андрей Капустин гэнэ. Нөгөө хоёр нь түүнээс залуу хүмүүс ажээ. Өндөр нуруутай, туранхай биетэй, үсээ нямбай самнасан нэгийг нь Валерий Лобников, нөгөө намхан бөгөөд булчинлаг биетэйг нь Алексей Петров гэдэг ажээ.

-Энэ залуус ялангуяа хилийн чанад дахь наймааны татвараас хэрхэн зайлах аргыг чи бид хоёроос илүү мэднэ. Эдгээр залуус гадаад хэлийг сайн мэдэх учир бидний гадаад орнуудтай хийсэн гэрээ хэлэлцээрийг сайн ойлгох болно гэлээ.

Татварын дарамтнаас аль болохоор зайлсхийхийн чухлыг Сатаров Полунин хоёр нэг бус удаа ярилцаж байсан юм. Тэгэхгүй бол компаний ирээдүйн хөгжлийн тухай ярихын ч хэрэггүй нөхцөлд тэд ажиллаж байжээ. Полунин үйлдвэрийн бүх ажиллагаанд тал бүрийн дүн шинжилгээ хийж, түүний санхүүгийн нарийн асуудлуудыг мэдсэний үндсэн дээр Капустины бүлэгтэй идэвхтэй хамтран ажиллах болжээ. Өөрийн ажлын тухай илтгэх гэж түүнтэй уулзахаар Лобников бусдаас илүү олон хүрч ирдэг байлаа.

Нэгэн удаа ирэхдээ Валерий Полунингийн шинэ юмыг ихэд шохоорхон судалж хэрэгжүүлдэг зан чанар, овсгоо самбаа, идэвх санаачилгыг үнэлж тэсгэлгүй:

-Владимир Иванович таныг ийм хүн гэж огт санасангүй гэж бахархан хэлэв.

-Ийм гэж ямар гэсэн үг вэ? хэмээн Полунин гайхан асуув.

-Тантай танилцахын өмнө би таныг зөвхөн шоронд цөөнгүй жил суусан, өөрсдийн хулгайн бүлгийнхний дунд нэр хүнд олсон хүн л гэж мэддэг байсан гэж Валерий хариулав.

-Гэтэл? гэж Полунин инээд алдан асуув.

-Гэтэл та бүрэн орчин үеийн сэтгэлгээтэй бөгөөд боловсролтой бизнесмен байсан юм байна. Танай байгууллагын удирдлагуудын дундаас тантай харьцаж ажиллах нь надад нэн таатай байдаг гэж Валерий хэллээ.

-Яагаад надтай гэж?

-Яагаад гэвэл та Веселовский, Соловейчик хоёроос дутуугүй боловсролтой, мэдлэгтэй ажилтан. Түүнээс гадна та бол ямар ч асуудлыг бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй учир асуудлыг тантай хамт шуудхан шийдчихэж болдог гэж Валерий тайлбарлав.

-За яахав. Дотно үгэнд чинь баярлалаа гэж Полунин инээмсэглэн хэлээд, тэгвэл би энэ өрөөнд дэмий сууж цаг үрдэггүй юм байна. Зөвхөн энд ч биш хэмээн уйтгартай царайлан дуугарав.

Хөл дээрээ бат зогсож эхэлсэн завод зөвхөн ажил төрлийн талаар түншлэн ажиллах хүсэлтэй пүүс, газруудын сонирхлыг татаад зогссонгүй. Санхүүгийн чадвар нь өсөхийн зэрэгцээ энэ бялуунаас хувь хүртэхийг хүсэгчид цөөнгүй гарч ирлээ. Полунинг мужийн захиргаанаас уригчид олширсоор байв. Түүнтэй үйлдвэрлэл – худалдааны ажил хариуцсан мужийн дэд захирагч Симонов Евгений Петрович олон цагаар сууж зөвлөлдөв. Тэрээр эхлээд үйлдвэрийн ажиллагаа болон тулгарч байгаа асуудлуудыг ихэд сонирхож байснаа аажмаар үйлдвэрийн санхүүгийн байдал сайжрахын хэрээр хүртэх хувь хишгээ нэмэгдүүлэхийг хүсэж байгаа нь илт боллоо. Түүний сануулга нь улам тодорхой болж байв. Мөн энэ хугацаанд дэд хурандаа цолтой болж мужийн УВД-ийн орлогчоор дэвшсэн Бирюков түүнтэй нэг бус удаа уулзаж байлаа. Бирюков мөн адил нэг бус удаа цагдаагийн ажилтнуудын тарчиг амьдрал, хуучирч хоцрогдсон техник хэрэгслийнхээ талаар үг цухуйлгаж байсан юм.

Цагдаагийн байгууллагад туслахаар хотод тусгай сан байгуулсан бөгөөд тэр санд олон бизнесменүүд багагүй мөнгө оруулдаг байлаа. Бирюковтой холбоогоо холдуулахыг хүсээгүй Полунин тэр санд хэд хэдэн удаа мөнгө шилжүүлсэн ажээ. Гэвч хөл дээрээ босоод удаагүй байсан үйлдвэр хэн нэгний ивээн тэтгэхээр их мөнгө гаргаж чадахгүй байсан юм. Эхний тэр жил Решетовын төлөөний хүмүүсээс бусад хувь нийлүүлэгчид үйлдвэрээ хөгжүүлэх зорилгоор ноогдол ашгаа хувьдаа авахаас татгалзаж байсан ажээ. Тийм учраас захирлуудын зөвлөлөөс ямар нэгэн байгууллагыг ивээн тэтгэх мөнгө гаргахгүй байхаар тогтжээ. Тийм шийдвэр нь хотын захиргааг гайхашруулж дургүйцэхэд хүргэсэн юм.

Жил өнгөрөхөд “Нефтьоргсинтез” завод томрон газрын тосны “Аркада” хувьцаат компани болсны дараа зах зээлд бензин түлшний үнэ буурснаас болж санхүүгийн хүндрэлтэй тулгарах боллоо. Зээлдэгч газрууд бүр тодруулбал Москвагийн худалдааны томоохон компани “Томотекс” гэнэтхэн “Аркада” руу довтолж эхлэв. “Томотекс” бол бүр түрүүчийн удирдлагын үед газрын тосны бүтээгдэхүүнийг наймаалдаг зээлдүүлэгч компани байв.

Полунин үйлдвэрийн захиргааны удирдлагад орсныхоо дараахан тэр компанийн ерөнхий захирал Томашевский Альберт Николаевичтай биечлэн уулзаж жилийн дотор өрөө төлөхийн зэрэгцээгээр хугацааг сунгасны хөлсөнд тодорхой хэмжээний хүү төлөхөөр тохиролцсон байжээ. Энэ хэлэлцээгээ хоёр тал бараг жилийн туршид мөрдөж байсан юм. Гэвч “Аркада” ХК-ийн захирлуудын нэгэн зөвлөлгөөний өмнөхөн захирлаараа толгойлуулсан “Томотекс” компанийн бие төлөөлөгчид хүрч ирлээ.

Тэр хоёр захирал хуучин нөхөд мэт дотно уулзсан боловч Полунинг зөвхөн тэдний гэнэтхэн хүрч ирсэн явдал бус бас тэдний мэдэгдэл самгардуулж орхив. Тэр өдрийн өглөө эрт Томашевский хотод ирснийг Полунин мэдсэн байв. Полунингийн нарийн бичигч хүүхэн Томашевскийн ирснийг шөфдээ мэдэгдмэгц өрөөнд нь өндөр нуруутай, буурал үстэй, тавь орчим насны туранхай эр орж ирлээ.

Тэр анхааралтай хүрэн өнгийн нүдтэй, гонзгойдуу зөв хэлбэрийн царайтай хүн ажээ. Гадна төрхөөрөө олон ангит нэгэн киноны баатар-нууц амрагийг санагдуулна. Гэвч түүний гаднахь сүр жавхлантай байдал нь хатуу чанга зантай нь хослон байгаа нь мэдрэгдэнэ. Тэрээр өөрийн зорилгодоо хүрэхийн тулд юу ч хийхэд бэлэн хүн юм. Хуучин яамны ажилтан байсан

Томашевский засгийн газар болон бүс нутгуудын засаг захиргааны байгууллагуудтай холбоотой байдгаа ашиглан газрын тос боловсруулах болон олзворлох улсын олон үйлдвэрийг хувьчлах ажилд оролцож байжээ. Чухам тэр үед өөрийн “Томотекс” хувьцаат компанийг үүсгэн байгуулжээ.

“Нефтьоргсинтез” завод Томашевскийн сонирхолыг аль эртнээс татаж байсан юм. Гэвч тэр үйлдвэр дампуурлын ирмэгт тулж очсон байдал түүнийг худалдан авахыг яаруулаагүй бөгөөд тэрээр энэ чиглэлийн бусад ашигтай үйлдвэрт санаагаа чиглүүлж байжээ. Гэтэл үйлдвэрийг дараа нь захирлуудын зөвлөлийн дарга нь болсон Полунин тэргүүтэй орон нутгийн бизнесменүүд хамтран худалдаж авсныг мэдээд бага зэрэг хачирхсан боловч тэр үйлдвэрийн өр төлөх хугацааг нь сунгасан байна. “Нефтьоргсинтез”-ийн бүтэц болон санхүүгийн байдалд зарим нэгэн судалгаа хийсний үндсэн дээр тэрээр тэр завод өөрсдийгөө болон компаниа хамгаалж чадах чадварлаг хүмүүсийн гарт орсныг ойлгожээ.

Тэгээд Томашевский компанийн шинэ удирдлага тэр үйлдвэрийн ажил хэргийг цаашид хэрхэн удирдан өрнүүлэхийг ажиглан харж хүлээнэхээр шийдсэн ажээ. Гэвч тэрээр зөвхөн хүлээж байсангүй бөгөөд харин тэр завод руу шийдвэрлэх дайралт хийхээр зэхэж наад зах нь хувь нийлүүлэгчийн нь нэгэн болохоор төлөвлөж байжээ. Ингэхийн тулд тэр хүн “Нефтьоргсинтез”-ийн тавьсан өрийг хувьдаа нууцаар худалдан авсан байна. Ингээд “хүндэт” зочид юу ярихаар хүрэлцэн ирсэн нь Полунингийн гайхлыг өөрийн эрхгүй төрүүлжээ.

-Тэгэхлээр Владимир Иванович. Асуудал тодорхой. Бид яаж тохирох нь зөвхөн танаас хамаарна. Үүнд хоёр зам байна. Эсвэл бид багагүй хугацаагаар шүүхийн үүдээр эргэлдэх, энэ нь мэдээжээр манай талд ашигтайгаар шийдэгдэж танай үйлдвэрийг гарцаагүй дампуурахад хүргэнэ. Эсвэл бид ухаалаг хандаж хэлэлцэн тохиролцож цаашид хамтран ажиллахад оршино гэж “Томотексийн” захирал тулгалаа. Полунин Томашевскийн хэлсэн үгийг сонсоод тэр даруй нарийн бичигч рүүгээ утасдан:

-Алив Лена Сатаровыг олоод над руу оруулчих гэлээ.

-Сатаров гэгч чинь хэн бэ? Бидний ярианд ямар хэрэгтэй юм? гэж Томашевский гайхан асуув.

-Тэр бол манай бас нэгэн томхон хувь нийлүүлэгч байгаа юм хэмээн Полунин тайлбарлаад, миний болон тэр хүний хүмүүс энэ үйлдвэрийн хувьцааны ерэн хувийг эзэмшдэг юм гэлээ. Хэдэн минут өнгөрсний дараа өрөөнд Сатаров орж ирэв.

Полунин түүнд байдлыг товч тайлбарлаж өглөө.

-Тиймээс ноён Томашевский бол манай томоохон зээл олгогч бөгөөд ойрын үед шүүхэд зарга мэдүүлснээр биднийг дампууруулж болохыг сануулж байгаа юм. Хэрэв... гээд Полунин энэ яриаг хайхрамжгүй сонсож суугаа Томашевскийн зүг хандаж:

-Хэрэв бид түүний хоёр дахь саналыг хүлээж авахгүй бол, ноён Томашевский та өөрөө тайлбарлаж өгнө үү? гэж хүсэв. “Томотексийн” захирал инээмсэглэн хүлцэнгүй дуугаар:

-Би танай үйлдвэрийн өрийг дарах журмаар хувьцааны гучаас доошгүй хувийг эзэмших санал гаргаж байна гэх нь тэр.

Балмагдсан Сатаров эхлээд Полунинг дараа нь Томашевскийг нүдээ цавчилгүй ширтсэнээ.

-Өвөө минь та юу ярьж байна? Чи ямар шавар болох гэж байгаагаа өөрөө ойлгож байна уу? Чи ингэж ярьж байхдаа биднийг гудамны нусгайчууд гэж бодоогүй биз? гэж бухимдан асуулаа. Сатаровын энэ сүрхий хилэнтэй үгийг Томашевский сонсоод улам эелдэг дуугаар:

-Энэ хувьцаа эзэмшигч гэгчийг та дэмий нааш нь урьж авчирсан байна гэж танд бодогдохгүй байна уу Владимир Иванович минь? Миний бодоход энэ хүн өөрийн хөгжлөөр тээр дор гудамжны жижиг дээрэмчдийн хэмжээнд байгаа хүн бололтой. Тэр газраасаа энд хүрч ирээд сууж байгаа амьтан байх гэлээ.

Полунин хүйтнээр инээд алдсанаа:

-Та дэмий ингэж ярьж байна, Альберт Николаевич та Олег Григорьевичийг муу мэдэх учир ингэж дутуу үнэлж байгаа бололтой. Шударгаар хэлэхэд таны саналын хувьд надад Олегтой нэгэн адил бодол төрж байна. Би өөрийн энэ залуу түншээсээ насаар ахимаг учир огцом ааш гаргахгүй байна гэж тайлбарлав.

Томашевскийн нүүрэн дэх эелдэг инээмсэглэл хорсол хилэнгээр өөрчлөгдөн:

-За яахав. Энэ гайхаад байх юм юу ч алга. Би хэнтэй харьцаж байгаагаа мэдэж байна. Энэ үйлдвэрийн ихэнх эзэд нь хуучин эрүүгийн хэрэгтнүүд эсвэл дээрэмчдийн шинэ хүрээний хүмүүс байдаг гэж би сонссон юм. Гэвч би энэ насыг туулах хугацаанд янз бүрийн хүмүүстэй уулзаж учирч байсан. Тийм учраас миний саналыг хэлэлцэх гэж байгаа бол би туслахад бэлэн. Авч хэлэлцэхгүй гэж байгаа бол би бизнесийн асуудалтай анх удаагаа тулгарч байгаа биш дараачийн алхмаа хийх болно гэж ярилаа.

Өрөөнд хэсэг зуур түгшүүртэй нам гүм үргэлжилж байсныг Полунин эвдэн

-Альберт Николаевич нэг асуулт байна гэв.

-Асуу, асуу гэж Томашевский таагүй дуугаар зөвшөөрөв.

-Би нэг жилийн өмнө зээлийн хугацаагаа сунгахыг хүсэж тантай уулзахад та зөвшөөрсөн шүү дээ гэж Полунин санууллаа.

-Яг үнэн хэмээн Томашевский хүлээгээд, одоо миний саналыг хүлээж авах таны ээлж. Хамтдаа бид энэ үйлдвэрийг цэцэглэж байгаа үйлдвэр болгож чадна гэж бодож байна гэлээ.

-Тэр үед та яагаад хувь нийлүүлэгч болох саналаа хэлээгүй юм бэ? Тэгэхэд энэ үйлдвэрт хөрөнгө оруулалт тун хэрэгтэй болоод байсан юм. Таны тусламж их тус болох байлаа гэж Полунин асуув. Тэгтэл Сатаров дахин дэлбэрэн хилэглэж:

-Миний бодоход хэлэх хариу нь ойлгомжтой. Энэ өвөө цөмийг нь хямд үнээр нэгмөсөн

худалдан авахыг хүсэж байна. Энэ хүн бид мөнгөө оруулан бүх л хүнд хар ажлаа дуусгасны дараа бэлэн юм авахаар ирж байна. Үйлдвэрийг цэцэглэн хөгжүүлэх нэрэн дор биднийг шулах гэж байна гэж зандчилаа.

Харин түүний энэ хэлснийг Томашевский үл тоомсорлон сууна. Тэгтэл Полунин Томашевскийн нүд рүү цоо ширтэн:

-Миний бодоход энэ чинь жинхэнэ дээрмийн хэрэг болж байна, Альберт Николаевич. Гудамжны нэгэн жирийн рэкетээс ялгаа юу байна? гэж хэлэв. Хариу хэлэхийн оронд Томашевский дуугүй босож гарах хаалга чиглэн алхав. Хаалганд хүрч очмогцоо эргэж хараад:

-Та нар гомдлынхоо нулимсыг арчиж тайвширсныхаа дараа зөв юм санал болгосныг минь ойлгох болно. Владимир Иванович таны энэ хэлсэн болгон зүгээр л уянгалаг сонсогдох худал үг. Гэтэл бодит байдал биднээс огт өөр юм шаардаж байна. Одоогийн таны байдал надад томорхох, тэр ч бүү хэл сүрдүүлэх түвшинд хүрч очоогүй байна. Би маргааш өглөө хүртэл танай хотод байх ажилтай. Хэрэв ярих юм гарч ирвэл зочид буудал руу утасдана биз гэлээ.

Томашевскийн гарсны дараа Сатаров хилэгнэн үсрэн босоод өрөөн дотуур холхисноо чанга дуугаар:

-Муу нохойн гөлөг, өмхий луйварчин гучин хувьд санаархана гэнэ үү? Мөн горьдов оо? Чи яг л авч таарна даа! Тэр новш байсан газар руугаа тонилог! Дахин наашаа бүү зүглэг гэж хашгирлаа.

-Тэр тэгэхгүй байх хэмээн Полунин ядрангуй дуугаар хэлэв.

-Бид түүний ар талыг нь галаар гэсгээж өгнө, гайгүй. Тэгэхэд тэр эндээс арилахгүй хаа очдог юм. Энэ бол манай хот, манай үйлдвэр, бид эзэд нь!

-Чи дэмий бухимдаж байна даа хэмээн Полунин түүнийг аргадан дуугараад, чиний энэ сэтгэлийн хямрал ажил хэрэгт тус болохгүй, хор болно гэв.

-Чи тэгээд яая гэж бодож байна? хэмээн Сатаров бухимдан асуугаад, гэртээ байгаа юм шиг аашилж бас сүрдүүлж байгаа энэ муу увайгүй новштой ёсорхож байх хэрэгтэй гэж үү? гэж асуув.

Полунин бодолхийлж байснаа өөртөө хэлж байгаа мэтээр:

-Гэвч нэг зүйлд түүний зөв, бидэнд үнэхээр дайн бус харин мөнгө хэрэгтэй. Харин тэрээр цагийг тун зөв тооцоолж ирсэн байна. Эсвэл одоо бид түүнээс хөрөнгө оруулалт авах эсвэл бидний өнгөрсөн хугацааны хөдөлмөр үрэн таран болно гэлээ.

-Ойлгосонгүй хэмээн Сатаров хөмсөг зангидан хэлээд, чи түүнтэй тохирох гээ юу? Үнэт цаасаа түүнд худалдах гэж үү? гэж асуув.

-Ямар ч байсан тохиролцох нь зөв.

-Яаж тохиролцох гэж? хэмээн Сатаров хашгиран бухимдаад, түүнд өөрсдийн суудлаа тавьж өгөх юм гэж үү? Өмнө нь өвдөг сөхрөн мөлхөх юм гэж үү дээ? Ухаан чинь эрүүл байна уу? гэж асуулаа.

-Бүү хашгир! хэмээн Полунин зандраад

-Энэ бол дайн биш бизнес гэдгийг чи ойлгохгүй байна гэж үү? Энд ухаалаг хандах хэрэгтэй. Зодолдож эхэлбэл бид бүхнээ алдах болно. Бид хамгийн бага хэмжээгээр зөвшөөрөөд дараа нь эргүүлж авна гэв.

Сатаров дуу гаралгүй Полунинг ширтэж сууснаа санаандгүй тайвнаар:

-Чи дотроо нэг юм төлөвлөж байгаа бололтой. Түүнийгээ надад ярихгүй байна. Магадгүй бүхнийг алдсан ч хамаагүй энэ зөөлөн сандал дээрээ сууж үлдэхийг хүсэж байна уу? гэж асуулаа.

-Чи тэнэг хүн юм даа, залуу минь. Харин энэ зан чинь залуу настай чинь хамт үлдэх нь сайн хэрэг. Гэвч тэр болтол чи багагүй хэрэг тарих шинжтэй гэж Полунин хариулав.

Сатаров шүдээ зуун юу ч хэлэлгүй шефийнхээ өрөөнөөс гарч явлаа. Энэ бол тэр хоёр энэ үйлдвэрт хамтран ажиллах болсноос хойш гарсан анхны маргаан байсан юм. Энэ явдлаас хойш тэр хоёрын хоорондуур нь хар муур гүйж өнгөрсөн мэт бага зэрэг хүйтэвгэр харьцаатай болжээ. Тэр үйлдвэрийнхээ ирээдүйн хувь заяаны талаар уулзаж ярилцах нь улам цөөрч, уулзах болгондоо маргаж зөрөлгүй тарах нь ховор болжээ.

* * *

Хувь нийлүүлэгчдийн жилийн эцсийн зөвлөлгөөн дахин шинэ түгшүүр нэмж үүсгэлээ. Полунин өөрийн илтгэлдээ бий болсон нөхцөл байдалд дахин хөрөнгө оруулалт хэрэгтэй бөгөөд үйлдвэрийн тайван ажиллагааг юу юунаас чухал гэдгийг цохон тэмдэглэв. Тэрээр үйлдвэрийн үнэт цаасыг зарим шинээр хувь нийлүүлэхийг хүсэгчдэд арилжаалж хөрөнгө оруулах санал гаргалаа. Учир нь үйлдвэрт нэгэнт хувь нийлүүлсэн хүмүүс санхүүгийн нөөцөө шавхаж дуусгасан байлаа. Түүнээс гадна “Томотекс”-тэй тогтоосон харьцаа буруу тийшээ эргэвэл энэ үйлдвэрт дампуурах хүртэл аюул нүүрлэж байгааг Полунин тэмдэглэж байв.

Владимирын тааварлаж байсан шиг түүний дараа үг хэлсэн Сатаров түүний гаргасан бүх саналын эсрэг байр суурь баримталж байв. Тэрээр түүнийг үйлдвэр болон хувь нийлүүлэгчийн эрх ашгаас урвасан санаа гаргаж байнаа гэж шүүмжлэв. Гэвч Коля Решето, Сатаров, Полунин хоёрын хоёулангийн саналыг эрс эсэргүүцсэн үг хэлсэн юм.

-Та нарыг тэр хогийн цааснуудын чинь хамт чөтгөр аваасай хэмээн Коля галзуурсан юм шиг нүдээ эргэлдүүлэн дуу алдаад, та нар дур дураараа үр гэж би өөрийн зоосыг гаргаж өгөө юу? Би яагаад өнөө хүртэл энэ хараал идсэн газраас сохор улаан зоос ч авахгүй байгаа юм бэ? гэлээ.

-Яагаад гэвэл өнгөрсөн жилийн зөвлөгөөн дээр ирэх жилийн ноогдол ашгаа цөмийг нь үйлдвэрээ хөгжүүлэхэд зориулна гэж тохирсон. Мөнгө өгөх цаг болоогүй байна Коля минь гэж Полунин тайван дуугаар хариу хэлэв.

-Нэгэнт ашиг өгөхгүй байгаа юм чинь энэ бүхэн надад ямар хэрэгтэй юм! гэж Коля бухимдаад, энэ бол зөв ажиллагаа огт биш намайг гаргуунд нь хаяж байгаа хэрэг мөн. Надтай хэн ч өнөө хүртэл ингэж харьцаагүй юм шүү нөхөд минь гэж сүрдүүлэх байдлаар зандалаа.

-Чамайг хэн ч хааш нь ч хаяагүй байна, Коля минь! хэмээн Полунин түүнийг тайвшруулахыг оролдон дуугараад, жилийн өмнө оруулсан мөнгөнөөс чинь илүү үнэ хүрэх хувьцааны багц тасалбар чамд хэдийнээ бий болоод байна гэж хэлэв.

-Энэ хувьцаа гэгчийн чинь үнийг би нулимж хаяна. Надад бодит мөнгө хэрэгтэй. Би тэр мөнгийг тогтмол авч байхыг хүсэж байна. Та нараас бусад түншүүд минь надад зохих ёсоор нь бүгдийг өгч байгаа гэж Решето хэлээд бухимдсаар суув.

Итгэл үнэмшлээрээ өөрөөс нь тэс ондоо Решетовыг Сатаров үзэн яддаг байсан юм. Тэрээр Решетовыг хорсолтойгоор ширтэн:

-Чамайг төмсөгнөөс чинь барьж аваад хэн ч нааш нь чирч авчраагүй. Хэрэв чамд ямар нэгэн юм таалагдахгүй байгаа бол эндээс тонилж үз. Тэгээд өөрийнхөө тэр мухлаг лангуу болон янхны газруудтайгаа зууралд. Тэр чинь чамд таарах ажил. Чамд юм өгөх эсэхийг бид шийдээгүй цагт чи сохор зоос ч бүү горьд гэж зандалаа.

Решетов галзуурсан мэт үсрэн босож Полунин, Сатаров хоёрыг ээлжлэн хорсолтойгоор харж шүд зуун:

-Тэгвэл та нар намайг хаяхаар шийдэв үү? Муу нохойнууд! Зоосыг минь хоослоод эргүүлж юу ч өгөхгүй байх нь уу? гэж орилов.

-Суу, Коля гэж Полунин хүйтэн дуугаар зандраад, одоогоор ихэнх хувьцаа эзэмшигчдийн саналын дагуу ноогдол ашгийг бидний хэн нь ч гэсэн авахгүй байна гэж би чамд зуу дахин тайлбарлаж байна. Хэрэв чи үүнийг зөвшөөрөхгүй байгаа бол чамд хоёр зам байна. Эсвэл үүнийг хүлээн зөвшөөр, эсвэл өөрийн цаасыг худалдаад хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнээс гар гэж зөвлөлөө.

Полунин Решетовын зэрэгцээ сууж байгаа нэг ч хялгасгүй хав халзан толгойтой алтадсан хүрээ бүхий гоёмсог том нүдний шилнээс өөр тогтоож авах онцгой шинжгүй царайтай жижигхэн бөөрөнхий биетэй Серегин рүү хараагаа шилжүүлэн:

-Ядахнаа өөрийн хувьцааны зөрүү үнийн талаар хэрхэн буруу ойлгож байгааг нь өөрийнхөө шөфд тайлбарлаж өгөөч гэж хүслээ.

Серегин Решетов руу бөхийн ямар нэг юм шивнэн хэлтэл тэрээр түүнийг өөрөөсөө холдуулан түлхэж орхиод урьдын адил хилэгнэн:

-Залуус минь! Би та нарыг энд бүх хорыг найруулж зоос цуглуулан залгиж байхыг харан бүтэн жил хүлээлээ. Би ингэж дэмий цагаа үрж суусан байжээ. Та нар миний уураг тархийг булингартуулж бүх мөнгийг өөртөө авах гэсэн байна. Энэ булхай чинь бүтэхгүй. Та нар ямар хүнтэй ингэж харьцаж байгаагаа мартсан бололтой. Товчоор хэлбэл би эндээс явлаа. Мөнгө байхгүй бол та нартай ярих юм надад алга гэж сүрдүүлэв.

Ингэж энэ цуглаан хувьцаа эзэмшигч талуудын хоорон дахь үр ашиггүй маргаанаас өөр шийдсэн юмгүй болж өнгөрчээ.

Нэмэлт хөрөнгө оруулахын тулд мөнгөтэй хүмүүст зориулж дахин хувьцаа гаргах санал гаргасан Полунинг Сатаров эрс эсэргүүцэв. Решетов уурлаж бухимдан зөвлөлгөөний танхимыг орхиж явлаа. Романенков Сатаровын саналыг бүх талаар бүрэн дэмжжээ. Харин үйлдвэрийг санхүүжүүлэх шинэ эх үүсвэрийг эрэлхийлэх нь зарчмын хувьд зөв гэж Веселовский Полунинг дэмжлээ. Соловейчик мөн адил Полунины саналыг дэмжин “Томотекс” бол засгийн газарт багагүй нөлөөтэй санхүүгийн том компани бөгөөд түүнтэй сөргөлдөх нь дөнгөж хөл дээрээ босон дэнжигнэж байгаа “Аркадад” том цохилт болно гэж ярилаа.

Гэвч Сатаров Веселовскийг дахин юм хэлэх сонирхолгүй болтол бүдүүлгээр загнаж орхилоо.

Соловейчик Полунинд дахин үг хэлэх боломж олгохыг хичээсэн боловч бүтсэнгүй бөгөөд тэд бие биендээ уурласаар тарж явлаа.

Ийм байдлаар ажил хэрэг цаашид бүтэмжтэй явахгүй гэдгийг ойлгосон Полунин эвийг олох оновчтой арга эрэлхийлэх боллоо. Тэрээр орой нь Сатаров, Решетов нар руу утасдаж долоо хоногийн дараа дахин уулзаж ярилцахыг санал болгов. Тэр уулзалтад Полунин компанийг хөгжүүлэх талаар зарим нэгэн буулт хийсэн саналаа боловсруулж авч очно гэж амласан юм. Түүний саналыг бид мөн адил зарим нэгэн буулт хийх нь зүйтэй байх гэж тэд хэлээд хүлээж авсан нь Полунинг баярлуулжээ.

* * *

Полунин Сатаров, Решетов хоёртой ярилцсан даруйдаа Гриша Соловейчик руу утасдлаа.

-За тэгэхлээр Гриша өнөөдөр чи бид хоёрын ярилцаж байсан тэр буулт хийж тохиролцох санаагаа бичгээр үйлдээд маргааш надад авчирч үзүүлээч. Долоо хоногийн дараа хувь нийлүүлэгчдийн цуглааныг дахин хийнэ. Тэнд бид өөрсдийн энэ санаагаа хэлэх болно. Тэр хүртэл энэ саналын маань тухай чи бид хоёроос өөр хэн ч мэдэх ёсгүй гэж Полунин түүнд үүрэг өглөө.

-Таныг ойлголоо, Владимир Иванович хэмээн Григорий хариулаад, гэвч бүгдийн санаанд нийцэхээр санал гаргах нь тун хүнд асуудал. Хэн нэгэн нь гарцаагүй сэтгэл дундуур үлдэнэ гэлээ.

-Тэгээд юу гэж? Чамд өөр санал байна уу?

-Мэдэхгүй гэж Григорий тодорхой бус хариу хэлэв.

-Шийдвэрлэх өөр зам байдаг байх гэж Полунин санаа алдан дуугараад гэвч чи миний сануулснаас өөр тийшээ хазайж болохгүйг чамд би хатуу сануулж байна. Бид ямар нэг хэмжээгээр үнэт цаас шинээр гаргаж мөнгө олох хэрэгтэй байна. Ингэснээрээ Москвачуудаас бид бага хамааралтай болох юм гэлээ.

-Би бүгдийг санаж байна, Владимир Иванович гэж Соловейчик хэлээд, би цөмийг нь ярьсан ёсоороо бэлтгэе гэлээ.

Полунин дутуу орхисон аягатай кофегоо уух гэж авмагцаа өмнө нь түүний яриаг сонирхдоггүй байсан Анна ширээний эсрэг талд суугаад саяны яриаг нь тун анхааралтай сонсож байхыг хараад бага зэрэг гайхлаа.

-Ямар нэг юм болов уу? гэж тэрээр эхнэрээсээ асуулаа.

Анна нөхрийгөө анхааралтай ширтэн:

-Үүнийг би өөрөөс чинь асуумаар байна. Та нар дахин л ямар нэгэн хэцүү асуудалтай тулгарч дээ гэлээ. Полунин мөрөө хавчин:

-Том хэрэгт том асуудал тулгардаг. Энд гайхах юм юу байх вэ дээ? гэж хайш хэрэг хариуллаа. Тэгснээ эхнэрээ инээмсэглэн харж:

-Том хүний яриаг хөндлөнгөөс чагнаж болохгүй гэж аав, ээж чинь чамд хэлдэггүй байсан юм уу? гэж асуув.

-Би аль хэдийнэ жижигхэн охин биш болсон гэж Анна хүйтнээр хариулаад, тэгээд ч чиний асуудал бас надад ч хамаатай гэв.

-Яагаад чамд хамаатай гэж? хэмээн Полунин бага зэрэг гайхан асуув.

-Танай үйлдвэрт ямар нэгэн хэцүү асуудал тулгарах бүрт миний амьдрал өөрчлөгдөж байдаг. Жилийн өмнө та нар энэ чөтгөрийн үйлдвэрийн төлөө тэмцэлдэж байх үед би айгаад гадагшаа ч цухуйж чадахгүй байсан. Би хотоор явах болвол нэг бол Антоныг эсвэл түүний хүмүүсээс дагуулж явдаг байв. Тэгэхэд чиний төлөө үргэлжийн санаа зовж байдаг байсан. Одоо нэмээд өөрийн болон хүүгийнхээ төлөө айж явах боллоо. Чиний огцом өсөлт хэтэрхий их үнэд хүрэх вий гэж сэтгэл минь шаналж байна гэж Анна ярилаа.

-Энэ бол зөвхөн минийх бус бас чиний өсөлт юм гэж Полунин хэлээд, хэрэв ажил маань бүтэмжтэй болвол бид гурав их баяжих болно. Тэгээд хилийн чанадад хувийн байшин худалдан авч бүх насаараа юугаар ч гачигдахгүй амьдарч, Антон гадаадын алдартай их сургуульд суралцах болно гэлээ.

-Харин чи юунд зөвхөн Антон бид хоёрыг ярина вэ? Чи өөрөө бид хоёртой хамт байхгүй юм уу? гэж Анна асуулаа.

-Би өөрийнхөө тухай ч ярьж байна гэж Полунин бага зэрэг дургүйцэн хариулаад, би ингэхийн төлөө л ажиллаж, зүтгэж байна шүү дээ гэлээ.

-Тийм ээ. Чи үнэхээр ингэхийн төлөө ажиллаж байна хэмээн Анна зөвшөөрөөд үүнийг чинь би мэдэхгүй бол хэн мэдэх юм бэ? Чи өглөө эрт, орой нь бүр шөнө л нэг үзэгддэг шүү дээ. Энэ чинь бараг жил үргэлжилж байна. Одоо дахин асуудал гарч хүмүүс чинь хэл амаа ололцохгүй болоод байна. Өөрөөр хэлбэл удахгүй би дахин л нэг бол Антоныг эсвэл түүний хүмүүсээс дагуулж хотоор явах болж байна. Полунин эхнэр рүүгээ таагүй харц чулуудаад:

-Антон үүнээс болж нэг их хохирохгүй биз. Тэртэй тэргүй тэр чинь чиний хажууд багагүй цагаа бардаг гэдгийг би мэднэ гэлээ. Анна нөхрөө цоо ширтэн харж байснаа:

-Чи намайг Синицынтэй хардаж байгаа юм биш биз? хэмээн асуув.

-Үгүй дээ хэмээн Полунин хариулаад зүгээр Антон надад бизнесийн ажлаар туслахаас илүү чиний дэлгүүр хоршоогоор явах болон салхинд гарахад чинь дагалдан явах дуртай хүн шүү дээ гэлээ.

-Антон надтай илэн далангүй ярилцдаг ганцхан хүн юм гэж Анна хэлээд, тэрээр албан ажил нь гэр орон эхнэр хүүхдээс нь илүү санагддаг нөхөртэй эмэгтэй хүнд хичнээн хэцүү байдгийг ойлгодог хүн гэлээ.

-За болоо! хэмээн Полунин үгийг нь огцом таслан, чи анх ямар хүнтэй суух гэж байгаагаа мэдэж л байсан. Өнгөрсөн он жилүүдэд болоод л байсан. Харин одоо миний хувьд ажил маань хүндрээд ачаалал их болоод байхад заавал үүнийг ярьж надад бүх бурууг тохсоны хэрэг юун гэж бухимдан хэллээ.

-Яагаад гэвэл чухам одоо би энэ байдлыг цаашид тэвчиж чадахгүй болоод байна. Би ганцаардлаас болж ухаан санаа минь муудах нь. Чиний энэ алба ажилтай чинь өрсөлдөж чадахгүйгээ бодохоос дургүй минь хүрч байна гэж Анна яриад шуудхан босож унтлагынхаа өрөөнд гүйж ороод дотроос нь түгжив.

Полунин ядарсан байдалтай тамхиа татан “Тийм ээ. Хүнд асуудал цуварч ирдэггүй байсан. Өнөөдөр бүр ч цөмөөрөө нэгэн зэрэг бууж ирлээ. Бизнесийн хүндрэлээс гадна гэр бүлийн тохигүй байдал бас гарч ирлээ” хэмээн гуниглан бодож суув.

* * *

Цагаан өнгийн “Волга” машинд дөрвөн эр сууж явна. Ард нь гурван зуугаад метрийн зайтай яваа “Газель” фургонд ганцхан жолооч нь явах бөгөөд бүхээгэнд нь голдуу банан болон бусад жимстэй хайрцагуудыг пиг дүүрэн чихжээ. Тэд богино долгионы холбооны аппаратаар харилцаж хоорондын зай хурд болон зогсох газраа тохиролцож байлаа. “Волга” машины бүхээгэнд сонгодог хөгжмийн ая эгшиглэх агаад түүнийг ганцхан жолоочийн хажуу дахь суудалд суугаа эр шимтэн сонсож явлаа. Энэ бол өндөр нуруу, махлаг биетэй дөч орчим насны хүн ажээ. Өтгөн үсээ нямбай тайрч янзалсан эрүүнд нь цэвэрхэн тавьсан ооч сахал харагдана. Тэрээр зөв хэлбэрийн нүүртэй боловч царай нь тийм ч том биш агаад жижигхэн

хар нүд нь байнга онийж эргэн тойронд нь олон янзын үрчлээ тодорч байх нь энэ хүн инээж байгаа эсвэл ямар нэгэн юмыг хүчлэн харж байгаа нь үл ялгагдана. Гэвч энэ хүн зөвхөн онцгой шаардлагатай үед л инээмсэглэж чаддаг байв.

ГАИ (Авто шалган байцаах)-ийн дэслэгч “Волга” машиныг шүгэлдэн зогсоох үед тэр инээмсэглэх шаардлага нь гарах нь тэр. Өмнө нь тэрээр холбоогоо яаран залгаж:

-Саша биднийг цагдаа зогсоох гэж байна. Тэр биднийг шалгаж байх хооронд чи хурдаа сайн нэмээд хажуугаар нь хурдан өнгөрч яв гэлээ. Тэгснээ холбоогоо таслан нууж орхиод хөгжмөө зогсоож жолоочдоо хандан:

-Хайран сайхан хөгжмийг минь тасалдуулж орхилоо! Замд явахдаа би Шопеныг сонсох дуртай... Гриня зогс... Цагдаатай хууч хөөрөлдөө гэлээ.

Жолооч хажуу тийш нь жолоогоо залж замын хажууд зогсож байсан дэслэгчийн ойролцоо машинаа огцом тоормозлон зогсоов. Дэслэгч ёслон хүндэтгэл үзүүлээд машины цонхоор бичиг баримтуудыг нь авч шалгалаа.

-Аль хүрэх нь вэ? гэж тэрээр ооч сахалтай эрээс асуугаад:

-Томилолтоор танай хот орж явна гэсэн хариу сонсов.

Дэслэгч түүний паспортыг нээж үзсэнээ:

-Малеев Константин Петрович... хэмээн тод дуугаар уншлаа.

-Яг тийм гэж сахалтай эр хариулаад, энэ бол би. Паспортан дотор пүүсийн захирал миний гарын үсэгтэй томилолт минь байгаа гэлээ.

Дэслэгч дахин тэр хүн рүү харав. Түүний буурьтай төрх, сайн костюм, үнэтэй бугуйн цаг зэрэг нь дэслэгчид үнэхээр захирал гэдгийг баталж байв. Дэслэгч бүхээгийн дотогш шагайснаа:

-Тантай хамт ямар хүмүүс явна? гэж асуув.

-Ажлын маань хүмүүс гэж Малеев хариулав.

Түүний “ажлын хүмүүс” болох хорин таваас гуч орчим насны сонгож бүрдүүлсэн мэт шөрмөслөг залуус бичиг баримтыг шалгаж байгаа дэслэгчийг тоосон шинжгүй тайван харж сууна.

-Тэдний бичиг баримтыг үзүүлэх үү? гэж Малеев асуув.

-Хэрэггүй гээд дэслэгч паспортыг буцааж өгөөд наашаагаа өндөр хурдтай ирж яваа “Газель”-ийг олж харлаа.

-Явж болно гэж тэрээр бувтнаад “Волгыг” тойрон гарч “Газельд” зогсох дохио өглөө.

-Новшийн цагдаанцар муу нохой гэж Гриня шүд зуун дуугараад машинаа хөдөлгөв.

-Гурван зуугаад метр яваад зогсоорой. Шурик ямар дохио өгөхийг нь хүлээе гэж Малеев тушаагаад машины арын толинд “Газель”-аас өндөр нуруутай залуу гарч дэслэгч рүү очиж явахыг харж байв.

“Волга” шалгалтын цэгнээс холдож яваад зогсов. Тэд дөрвүүлээ юу болохыг түгшүүрлэн хүлээх бөгөөд Малеев бухимдан тамхиа шуналтай нь аргагүй сорох ажээ. Гэвч арав хүрэхгүй минутын дараа Малеевын гарт байгаа аппарат шажигнан:

-Малей, та нар хаана байна? Бүх юм хэвийн. Цагдаа машиныг минь шалгаж үзээд явууллаа гэх Шурикийн дуу сонсогдов.

-За болж , хонгор минь гэж Малеев тайвшран дуу алдаад жолоочдоо хөдлөхийг тушаамагц холбоогоо залган: тохирсон ёсоороо зочид буудалд уулзъя. Машинаа Сухомлинскийн гудамжны зогсоолд тавиарай гэж хэллээ.

-Ойлголоо. Малей гэх хариу сонсогдов. Малеев сэтгэл ханамжтай инээмсэглээд Шопены хөгжмийг дахин залгалаа.

* * *

Тэдний “Волга” өндөр хурдтай явсаар дөнгөж сэрж байгаа хот руу орж ирлээ. Харин Гриня хотын төв хэсэг рүү оролгүй “Летняя” хэмээх нам гүм гудамжинд байх “Колос” нэртэй зочид буудлын таван давхар байшингийн дэргэдэх зогсоолд машинаа тавив. “Волга”-ийн зорчигчид хоёр хоёроороо цувран, эхлээд арын суудалд сууж ирсэн хоёр залуу арваад минутын дараа Гриня, Малеев хоёр машинаас гарч явлаа.

Малеев буудлын жижүүрт паспортаа үзүүлэн түүнд хоёр хүний өрөө урьдчилан захиалсан байх ёстойг хэлэв.

Арван минутын дараа Малеев Гринягийн хамт гурван давхарт гарч захиалсан өрөөндөө ороод цүнхээ орон дээр чулуудаж орхиод ширээн дээр байх утасны аппаратанд дугаар эргүүлэн:

-Өдрийн мэнд. Би Константин байна. Би дөнгөж сая хүрч ирээд зочид буудлаас ярьж байна. Бид саадгүй явж ирсэн гэж хэлээд хариуг нь сонсож утсаа тавилаа.

-За яав? гэж Гриня асуув.

-Тухалж аваад хүлээж бай. Орой ирнэ гэсэн.

-Тэгвэл явж гуанзанд орьё. Өчигдрөөс хойш хачиртай хатсан талхнаас өөр юм хэлэн дээрээ тавьсангүй гэж Гриня санал гаргав.

Хоёр цагийн дараа фургоны жолооч Александрын хамт тэд тавуулаа болж зочид буудлаас холгүй орших рестораны тусгай өрөөнд хооллож суулаа. Гриня үмх тугалын мах амандаа хийж яаран зажлах зуураа Малеев руу харан:

-Чи мэдэж байна уу? Тэд яагаад ингэж унжраад байна? Бид аль өглөө эрт ирчихээд байхад тэд бүр орой уулзъя гэж байх нь юу вэ? гэж асуув.

-Нэгд, бид замын алжаалаа тайлах хэрэгтэй, хэмээн Малеев тайвнаар хариу хэлээд, хоёрт том хэргийг яаран шийддэггүй. Бид тун чухал асуудлаар ярилцах гэж байна гэлээ.

Малей аягатай жүржийн ундаанаас яаралгүй балгах зуураа үргэлжлүүлэн:

-Алив одоо энд биеэ хэрхэн авч байх талаар ярилцаж тохирёе. Ингэж нэг дор бид цөмөөрөө дахиж цугларахгүй гэж хэлээд “Волга” машины арын суудалд сууж ирсэн хоёр залууд хандан, Костыль Гаврик та хоёр буудалдаа буцаж очоод орой болтол хаашаа ч бүү гар. Саша чи тэдэнтэй буудалд оч, эсвэл машин дотроо сууж бай. Гриня бид хоёр гадуур бага зэрэг явж байгаад өрөөндөө буцаж очно. Оройн зургаан цагт бид цөмөөрөө нэг дор байх үед захиалагч маань утасдах ёстой. Тэр юу гэхээс шалтгаалан бид маргаашийнхаа ажлыг төлөвлөнө. Гүйцээ. Одоо салж явцгаая гэж тушаалаа.

Малей салфеткаар амаа даран арчаад тавган дээр чулуудаад тэднээс түрүүлж гарч явахыг сануулан Гриня руу толгой дохив.

Тэдний араас Костыль, Гаврик хоёр гарч явлаа. Харин жолооч захиалсан тахианы шарсан махаа идэж дуусгангаа рестораны зааланд дэмий хөлхөх залуухан үйлчлэгч хүүхнүүд болон хооллож суугаа цөөн хүмүүсийн зүг уйтгарлан ширтэж сууна. Дараа нь тэрээр тооцоогоо хийж ресторанаас гараад гудамжаар яаралгүй алхав. Гэтэл хажуугийн ширээний араас саарал жийнсэн цамцтай нэгэн залуу босож араас нь дагаж гарсныг ажигласангүй.

Александр ресторанаас гараад ойрхон байгаа мухлагнаас хоёр лааз шар айраг аваад нэгийг нь онгойлгон яаралгүй сорж явлаа. Үдийн халуун эхлээгүй гадаа нэлээд сэрүүн байсан учир одоо бага зэрэг дотроо халааж орой болтол сайн унтаж авах хэрэгтэй. Орой залуус нь цуглаж тэрээр жолооны ард суух хүртэл энэ мансууруулах ундааны үйлчилгээ аль хэдийнэ гарсан байх болно.

Түүний шар айрагны лаазыг хоослон савыг нь хогийн сав руу хаяад зогсоолд байгаа машинд хүрч очих үед нэгэн санаандгүй явдал Александрын сэтгэлийг түгшүүрлэхэд хүргэв. Авто зогсоолд орох хаалганы эсрэг талд “Жигули” машин дотор саарал жийнсэн цамцтай нэгэн залуу сууж байгаа нь харагдлаа. Тэдний харц тулгармагц тэр залуу даруй нүүр буруулан ямар нэг юм оролдож байгаа мэт дүр үзүүлнэ. Энд гайхаж сэжиглээд байх юм үнэндээ алга. Гэвч Александр гярхай бөгөөд туршлагатай хүн байсан юм. Ресторанд байсан саарал жийнсэн цамцтай тэр залуу одоо энд ирчихсэн хэн нэгнийг хүлээж байгаа бололтой байх нь нэг л сэжигтэй санагдаад байв. Александрын соргог нүдэнд цаана дэлгүүрийн үзмэрийн цонх руу хараад зогсож байгаа биеийн тамирын хувцастай бас хоёр залуу харагдав. Энэ бүхэн нэг л биш. Тэр хоёр залуугийн сонирхож байгаа дэлгүүр бол эмэгтэй хүний хувцасны дэлгүүр байв.

Александр лаазтай шар айрагнаасаа дахин нэг балгаад сандарсан шинжгүй аажим зугаалах мэт явсаар зогсоолыг өнгөрөн ойр байгаа байшингийн хаалганд хүрч очлоо. Ингэх үедээ тэрээр саарал жинсэн цамцтай залуугийн сууж байсан машин хөдөлж араас нь их биш хурдтай дагаж ирэхийг нүднийхээ булангаар ажиглалаа.

Александр байшингийн хаалганд тулж очмогц лаазтай шар айргаа чулуудаж орхиод тийшээ орж явчихав.

-Бариад ав! гэж хашгирах сонсогдон ард нь хүмүүсийн гүйлдэх хөлийн чимээ дуулах нь тэр. Александр байшингийн орцны хаалгаар ормогц цаана нөгөө гудам руу гарах хөндий байхыг олж хараад хүн хөдөлгөөнтэй гудам руу үсрэн гарлаа. Гэвч энд санаанд оромгүй явдал бас хүлээж байжээ.

Тэрээр хэдэн метр гүйж явган хүний замд хажуугаараа тулан зогсож байсан шар өнгийн “БМВ”-тэй зэрэгцэн иртэл гэнэтхэн машины хаалга огцом онгойж Александр байдаг хүчээрээ мөргөлдөж асфальтан зам дээр тэрийж орхилоо. Энэ үед машинаас нэгэн эр гарч ирээд түүнийг өвдгөөрөө дараад толгойд нь буу тулган

-Бүү хөдөл! Цагдаа байна! гэж зандрав.

* * *

Оройн яг зургаан цагт Малеев, Гриня хоёрын өрөөний хаалгыг тогших чимээ гарахад орон дээрээ хэвтэж байсан Гриня хаалганд хүрч очоод хэн байгааг асуулаа.

-Би Гаврик байна. Гриня хаалгаа тайлж өгөхөд Гаврик, Кастыль хоёр орж ирлээ.

Түшлэгтэй зөөлөн сандал дээр сонин гарчиглаад сууж байсан Малеев тэдний зүг нэг их анхаарлаа хандуулсангүй. Тэдний суусны дараа Гриня сандлын түшлэгэнд тохоостой байсан хүрэмнийхээ халааснаас хөзөр гаргаж ирээд:

-Сашаг иртэл. Алив нэг үзээд орхиё, эрчүүд минь. Малей чи тоглохгүй юм уу? гэж Шефдээ хандан асуув.

Малеев дуугүй толгой сэгсэрлээ. Гриня хөзрөө дөнгөж хувааж дуусмагц өрөөний нь утас дуугарав.

Малей тэр даруй утсыг шүүрэн авав.

-Сонсож байна... Хаана тэр вэ? гэж лавлан асуугаад, таныг ойлголоо хэмээн хариулаад утсаа тавьж

-Захиалагч ярьж байна. Гриня бид хоёр явъя. Та хоёр Сашкаг иртэл хүлээж бай гэлээ.

Малеев пиджакаа мөрөндөө углан гарахаар завдаж байтал дахин хаалга тогшив. Гриня хаалга руу очоод:

-Сашка чи юу? гэж асуув.

-Би, би гэж хаалганы цаанаас сонсогдлоо. Гриня хаалга онгойлгож өгмөгцөө цохиулсан юм шиг балмагдаж орхилоо.

Өрөөнд саарал өнгийн тусгай хувцастай хуягласан хантааз өмссөн хэсэг хүмүүс дайран орж ирэх нь тэр. Нүүрэндээ хар баг углаж гар буу, богино голтой автоматаар зэвсэглэжээ.

-Цагдаа нар байна! Цөмөөрөө шалан дээр хэвт. Гараа ардаа барь! гэж түрүүлж орж ирсэн нэг нь зандарлаа.

Байдал гэнэтхэн ингэж эргэхийг огт санаагүй байсан намбалаг төрхтэй Малеев тэргүүтэй хүндтэй зочид хэдэн хормын турш шалан дээр уруугаа харан дуулгавартай нь аргагүй хэвтэхэд хүрчээ. Тэдний гарыг нь ард нь мушгин гавлаж орхилоо. Гринягийн гар бууны бариулаар цохиулж авсан шалбархайнаас цус шүүрэх ажээ. Тэдний ширүүн эсэргүүцэлтэй тулгарч магадгүй гэж бодсон бололтой цагдаа нар нэг их ёсорхоод байсангүй. Энэ үед хэвтэж байсан буурьтай Малеев ч хувь хүртчихлээ. ОМОН-чуудын нэг нь хажуу хавирга руу нь өшиглөж орхилоо. Буудлын зорчигчдыг гавласны дараа өрөөнд дэд хурандаа Бирюков орж ирлээ.

-Та нарын хэн нь Малеев вэ? гэж тэрээр асуув.

-Энэ хүн гэж нэг цагдаа Малеевыг зааж хэлээд бичиг баримт нь энэ байна гэв.

Хэдэн мөчийн дараа мөн цагдаа Малееваас хурааж авсан паспортыг Бирюковт өглөө.

-Энэ хүнийг хажуугийн өрөөнд оруул. Эд нь хэвтэж л байг гэж дэд хурандаа тушаав.

Малеевыг хажуугийн өрөөнд аваачаад дэд хурандаагийн өмнө суулгав.

-За алив. Константин Петрович Малеев эсвэл Малей, бүр Костя Малый ч гэж нэрлэж болно. Бас өөр нэр бий юу? гэж дэд хурандаа асуулаа.

Малей хавиргаа хугарчихаагүй байгаа гэж шалгахын тулд гүнзгий амьсгалж үзээд зүгээр байсанд санаа нь уужиран инээмсэглээд:

-Таныг харахад мэдээлэл сүрхий сайтай боловсон байрын шувуухай мэт боловч хүмүүстэй хэтэрхий бүдүүлэг бөгөөд тэнэг харьцаж байна. Тухайлбал та нар биднийг юуны учир ингэж гэнэтхэн баривчлах болсныг би огт ойлгохгүй байна гэж хариулав.

-За тэгэхлээр Константин Петрович, өөрөөр хэн ч гэдэг билээ. Тэр хамаагүй. Та арай буруу ойлгож байна. Юуны учир та нарыг гавлаж байгаа нь ойлгомжтой. Харин яагаад гэдэг бол огт өөр асуудал.

-Тэгж асуу хамаагүй гэж Малеев мөрөө хавчин хэлээд, харин би та нарт ингэж бүдүүлэг аашлуулах хүн огт биш. Би жирийн бизнесмен. Танай хотын үйлдвэрүүдтэй ажил төрлийн тухай тохиролцох гэж би Рязань хотоос хүрч ирсэн гэлээ.

-Ямар наймаатай яваа вэ? Магадгүй далайн чанадаас оруулж ирсэн жимс ногоо биш биз гэж Бирюков асуув.

-Бурхан юу явуулна авахаас яахав хэмээн Малеев мөрөө хавчин хариулав.

-Дүүрэн зэвсэг хийсэн хоёр гадил жимсний хайрцагийг бас тэр бурхан чинь явуулсан юм биш биз? гэж Бирюков инээд алдан асуув.

-Юун хоёр хайрцаг зэвсгийн тухай ярьж байна? хэмээн Малеев гайхан асуув.

-Таны буусан зочид буудлаас холгүй зогсоолд тавиастай байгаа “Газель” дотор тэр хайрцгууд чинь байсан.

-Таны юу ярьж байгааг би огт ойлгохгүй байна хэмээн Малеев үнэхээр гайхсан дүр үзүүлж хариулаад би ямар ч гадил тэр байтугай буу зэвсгийн талаар юу ч мэдэхгүй гэлээ.

-Худал маяглахаа больж үз, Малеев минь гэж Бирюков ширүүнээр дуугараад тэр “Газель” өнөө өглөө тантай нэгэн зэрэг Рязаниас энэ хотод орж ирсэн гэв.

-Тэгээд яагаав? Зүгээр л тохиолдлоор тэгж таараа биз.

-”Газелийн” жолоочтой хамт ресторанд хооллосон чинь бас тохиолдол уу?

-Түүнтэй чинь би нэг нутгийнх. Ширээнээсээ хөөх эвгүй биш үү.

-Тэнэглэхээ боль Малей минь. Журам дүрэмтэй бизнесмен болж бүү жүжиглэ. Би өнөөдөр Рязань дахь нөхдүүдтэй ярилаа. Таны талаар тэд тийм ч сэтгэгдэл өндөртэй байдаггүй юм байна гэж дэд хурандаа хэлэв.

-Урьд нь хоригдож байсан хүний талаар цагдаа нар хэзээ сайн сэтгэгдэлтэй байлаа даа.

-Та дээрмийн хэргээр хоригдож байсан. Нэлээд эрт шүү дээ. Харин одоо та тэр цагаас хойш мэргэшлээ өөрчлөн энэ талаараа нэлээд өндөр авсан бололтой гээд Бирюков Малеевын онийж байгаа нүдийг харлаа. Тэгснээ, таны хөлсний алуурчдын бүлэг хамгийн чадварлагуудын нэгэнд ордог гэлээ.

Малеев юу ч хариу хэлэлгүй нүд нь анилдах мэт онийж байснаа нүүрэнд нь түгшүүрлэх байдал мэдэгдсэнээ

-Та намайг хэт өргөмжилж байна дарга минь гэж дуугараад, би ердийн дунд зэргийн бизнесмен. Хүнд хүчир уйгагүй шударга хөдөлмөрөөрөө амьдралаа залгуулж явдаг нэгэн гэв.

-Таны тэр шударга хөдөлмөр гэсэн үг дээр чинь бас хоёрын зэрэг аюултай цуст гэсэн чимэг үг оруулах хэрэгтэй юм гэж Бирюков нэмж хэлээд, би тэнэглэж тоглохоо болиорой гэж танд сүүлчийн удаа сануулж байна. Та гарцаагүй юманд ороод байна. Цахалж чирэгдсэний хэрэггүй. Энд бид хоёулхнаа байна гэдгээ ойлго гэв.

Дэд хурандаагийн хэлсэн сүүлчийн өгүүлбэр Малеевт түрүүний хэлсэн үгнүүдийг бодвол нэгийг санагдуулахад хүргэлээ.

-Уучлаарай, таны нэрийг мэдэж болохсон болов уу? гэж Малеев асуув.

-Константин Матвеевич гэж Бирюков хариулав.

-Мөөн. Бид хоёр чинь амьдай юм байна шүү дээ гэж Малеев инээд алдан хэлээд, тэгэхлээр та бид хоёрын хооронд санаа нийлэх юм бас байгаа гэж би найдаж байна. Бид тийм ч мунхаг хүмүүс биш гэж хэлэх гэсэн юм. Тийм учраас би нууж цэрвэлгүй шуудхан хэлчихье. Би үнэхээр таны бодож байсан хүн байж, тэр “Газелийн” ачаа миний ажилд зориулагдаж ирсэн байлаа ч гэсэн таны энэ үйлдэл чинь учир утгагүй тэр ч бүү хэл мэргэжлийн гэж хэлмээргүй болж байна. Би болон миний хүмүүс тэр зэвсгүүдийг гартаа авч хэрэглэж байх үед үйлдэл дээр нь баривчилсан бол өөр хэрэг байхсан гэв. Тэгснээ чимээгүй болж Бирюковийг доогтой инээмсэглэн ажиглаж суув.

-Гэвч би таныг муу мэргэжилтэн гэж огт бодохгүй байна хэмээн Малеев үргэлжлүүлэн хэрэв та ингэхээр шийдсэн бол танд өөр алхам хийх аргагүй байжээ. Тэгвэл “Газелийн” тэр жолооч ямар ч буруу хүлээгээгүй, надтай ямар ч холбоогүй гэдгээ баталж байгаа хэрэг. Хэрэв надтай тэр хүн холбоотой гэж улайвал үүнийг батлах нь тун амаргүй асуудал болно гэж ярилаа.

Бирюков хариуд нь түүнийг ноцтойгоор сонжин ширтээд:

-Хэрэв та нарын хувцасны халааснаас тэр машинд байсан буунуудын сум гарч ирвэл үүнийг тун амархан баталж болно гэв.

Бирюковын ингэж хэлэхэд Малеевын нүдэнд бага зэрэг түгшүүрийн өнгө илрэх нь мэдэгдлээ.

-Та намайг гайхахад хүргэж байна. Таны хийхээр төлөвлөж байгаа энэ бохир арга чинь хэрээс хэтрэх юм биш үү гэж Малеев асуув.

-Тэгээд? Та юу гэж хэлэх гэсэн юм бэ? гэж Бирюков ширүүхэн асуугаад, манай хотод аллага үйлдэхээр ирсэн хөлсний алуурчдыг зүгээр л тавиад явуулчихна гэж та бодоогүй биз? Би энэ хотод эмх журам сахиулахын төлөө юу ч хийхээс буцахгүй. Тэр ч бүү хэл шийдчихсэн новшийн алуурчдын халаасанд сум хийсэн ч миний дур гэв.

-Гэлээ ч гэсэн хэмээн Малеев дуу гараад, таны хэлсэн үгэнд тохиролцооны нуугдмал өнгө ая цухуйж байх шиг байна. Хэрэв би эндүүрээгүй бол таны үгийг сонсьё гэх нь тэр.

Бирюков Малеев руу бөхийн нүд рүү нь ширтээд шуудхан:

-Та нарын бэлтгэж байгаа аллагын захиалагч болон хохирогч нь хэн болохыг би сонирхож байна? Мөн хэн энэ зэвсгүүдийг чинь нийлүүлсэн юм бэ гэдгийг ч мэдэхийг хүсэж байна гэлээ.

-Энэ бол маш үнэтэй мэдээлэл хэмээн Малеев хэлээд мэдээллийн хариуд та яах юм бэ? гэж асуугаад инээмсэглэв.

-Таныг эрх чөлөө, болон бас аюулгүй байдлаар хангах болно гэж дэд хурандаа хариулаад, би таныг энэ мужийн нутаг дэвсгэрээс гаргана. Харин зэвсгүүдийг чинь хурааж авах болно гэлээ.

Малеев ганц хоёр минут хэртэй бодлогоширч байснаа:

-Зэвсгийг Кавказаас ирсэн хүмүүсээс авсан. Би тэднийг хэлж болохгүй. Аминд минь аюултай. Та нарт ч хэрэггүй.Тэд чинь танай хот, мужийн хүмүүс ч биш. Харин захиалагч болон хохирогчийн тухай би ямар ч мэдээлэлгүй гэж Малеев тайлбар хэлэв.

-Захиалагчийнхаа тухай мэдэхгүй гэж та бүү ярь. Би итгэхгүй гэж дэд хурандаа хэлтэл

-Танд үзэг, хуудас цаас байна уу? гэж байцаагдагч гэнэтхэн асуув.

Бирюков дуугүй толгой дохиод өмнө нь үзэг, цаас гаргаж тавилаа.

Малеевын гар урдаа гавлаастай байсан учир тэрээр баруун гараараа үзэг авч цаасан дээр утасны дугаарын тоонуудыг бичлээ.

-За гүйцээ. Би үүнээс өөр юм танд өгч чадахгүй гэж хэлээд тэрээр үзгээ тавилаа.

Бирюков цаасыг авч үзвэл бичсэн дугаарын тоонууд мэдээж түүнд танил бус байв. Бирюков тэр даруй цагдаагийн газар руу утасдан энэ дугаарыг лавлахаас асуув. Хэдэн минутын дараа энэ дугаар шөнийн клуб “Арлекино”-гийнх болохыг цагдаагийн газраас түүнд мэдэгдлээ.

Дөрөвдүгээр бүлэг

-Таны хэлсний дагуу нэг юм бичлээ. Владимир Иванович хэмээн Соловейчик хэлээд түүнд хэдэн хуудас цаас өгөв. Полунин хавчаараар хавчсан нэг хувийг нь өөртөө аваад нөгөөг нь өөрт нь үлдээв. Тэр бичгийг “Аркада” компанийн нэртэй хуудсан дээр үйлдсэн байлаа. Бичсэн зүйлийг Полунин гүйлгэн уншаад:

-Хэд хоногийн дараа бид дахин цугларч ярилцана. Тийм учраас хүн болгонд нэг нэг хувь хүртэхээр олшруулах хэрэгтэй гэлээ.

Соловейчик инээмсэглээд:

-Би уг нь гурван хувь цохиулсан. Нэг хувь нь алга болсон байна билээ. Тэдний нэг нь авсан биз гэв.

-Яаж авсан гэж? хэмээн Полунин гайхан асуув.

-Хальсанд бичүүлэх гэж нэг хувийг нь нарийн бичигчид би өгсөн байсан гэж Соловейчик тайлбарлаад олон орж гарч байсан хүмүүсийн хэн нэг нь авчихсан байх. Та бидний энэ төсөл хувь нийлүүлэгчдийг нэлээдгүй хөдөлгөж эхлэх нь бололтой гэж хариулав. Тэр цаасыг

-Тэр тийм! Хэн нэгэн нь хэлэлгүй суйлчихсан бол тэгж л таарах нь гэж Полунин хэлэв.

Тэрээр шилээ маажиж байснаа гараа савчин:

-За яахав. Чөтгөр аваг тэднийг. Бидний тэр төслийг тэд өнөөдөр мэднэ үү эсвэл цуглаан дээр мэднэ үү ялгаагүй гэв.

-Би ч гэсэн тэгж бодож байна гэж Соловейчик зөвшөөрөөд, хамгийн гол нь бидний энэ төлөвлөгөө зөв гэдгийг тэдэнд итгүүлэх нь чухал. Энэ бол тийм ч амархан юм биш гэлээ.

-За яахав гэж Полунин гараа дохиод, би ч тэгж бодож байна. Явж ажлаа хий. Би өнөөдөр мужийн захиргаа орж дэд захирагчтай уулзах ажилтай гэлээ.

-Мужийн захиргаанаас туслуулах гэж үү?

-Тэдний дэмжлэг илүүдэхгүй

...Гучин минутын дараа Симоновын нарийн бичигч хүүхэн Полунинг мужийн дэд захирагчийн өрөөнд орохыг урив.

Полунин өрөөнд ороод тэнд бас “Томотекс” компанийн захирал сууж байхыг хараад гайхаж орхилоо. Тэр хоёр зөвлөлгөөний дугуй ширээний ард сууж байв. Нүүрний ихэнхийг нүдний утаат өнгөтэй нүдний шил халхалсан улаан царайтай, махлаг биетэй, ахимаг насны мужийн дэд захирагч Полунинг Томашевский болон өөрийн эсрэг талд суухыг урилаа.

-Владимир Иванович та сууна уу гэж Симонов түүнийг найрсагаар уриад, бас бидэнтэй нөхөр Томашевский байгаа явдалд бүү гайхаарай. Энэ хүн өнөөдөр манай хотод дөнгөж ирээд надад бараалхаж байгаа юм гэж дэд захирагч тайлбарлав.

-Гайхах юм юу байх вэ? гэж Полунин тайвнаар хариулаад, бид хоёр тантай нэг асуудлын сэдвээр зөвлөлдөхөөр ирсэн гэж бодож байна гэлээ.

-Гэвч ноён Полунин та бид хоорондоо хамтран ажиллаж харилцан туслалцаж байя гэж миний хэлэхийг сонсоод ямар ч гэсэн гайхах л байх даа хэмээн Томашевский яриа үүсгэлээ.

-Энэ чинь гайхаад байх юу байх вэ? хэмээн Полунин мөрөө хавчин хэлээд, хамтын нөхөрлөл бол хэнд ч гэсэн ашигтай зүйл. Гэвч таны сэтгэл санаа гэнэтхэн ингэж огцом өөрчлөгдсөнд би бага зэрэг гайхаж байгааг нуух юун. Та бараг барьцааны шинжтэй санал тулгаж байснаас чинь хойш нэг их хугацаа өнгөрөөгүй байна гэлээ.

Мужийн дэд захирал бага зэрэг санаа нь зовж:

-Миний дэргэд тийм юм бүү дурсаасай гэж би хүсэж байна. Би энд чинь зарга таслагч биш зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байна. Би өөрийн мужийн ашиг сонирхлыг хамгаалахын төлөө байдаг хүн учир таны үйлдвэр шиг газар бусадтай бүү сөргөлдөөсэй ашигтай хамтран ажиллаасай гэж хүсдэг, Владимир Иванович. Мөн адил Альберт Николаевичийн компани орон нутгийн үйлдвэрүүдийг дампууруулах бус хөгжүүлж бэхжүүлэхийн төлөө ажиллаасай гэж хүсэж байна. Тухайлбал таны компанид Владимир Иванович, томоохон хөрөнгө оруулбал сайнсан гэж ярилаа.

-Чухам ийм учраас Владимир Иванович би тантай хамтран ажиллахыг санал болгож байна. Таны тэр хөлдүү толгойт дээрэмчдээс бүрдсэн түншүүдтэй биш шүү. Дахин хэлэхэд чухам тантай өөртэй чинь. Та бол тэдний дотор энэ үйлдвэрийг авч явж чадах цорын ганц хүн. Бид хоршин ажиллавал цаашид их зүйлийг хийж чадна гэж Томашевский ярив. Түүний яриаг тайван сонсож суусан Полунин:

-Их хэргийг бага боловч хуншгүй явдалгүйгээр эхэлдэггүй. Гэвч жил гаруй хамтран ажиллаж байгаа нөхдүүдээ би орхихыг хүсэхгүй байна гэв.-Та буянтан болж жүжиглэх хэрэггүй хэмээн Томашевский харамсан хэлээд, тэр хүмүүс чинь үр бүтээлтэй ажиллаж чадахгүй гэдгийг та сайн мэдэж байгаа. Та нарын сүүлчийн зөвлөлгөөн ямар үр дүнтэй болсныг би мэдэж байна. Тийм түншүүдтэй та хэзээ ч хамтран ажиллаж чадахгүй гэлээ.

-Би тэгж жүжиглээгүй байна гэж Полунин хариу хэлээд, тэр бол миний зан биш. Хувьцаа эзэмшигч бидний хооронд зарим нэгэн үл ялих зөрөлдөөн байсан боловч үндсэн асуудлаар нэг саналтай байдаг учир манай компани хөл дээрээ босон хөгжиж ирсэн юм. Бид ингэж санаа нийлэн ажиллаж ирсний үр дүнд гарч байсан зарим нэгэн хүндрэлийг давж чадаж байсан. Хойшид ч бид энэ зарчмаараа ажиллах болно. Өөрөөр байж болохгүй, тэгэх юм бол эрт орой хэзээ нэгэн цагт сөргөлдөөн нь мөргөлдөөн болох аюултай гэлээ.

-Тэр мөргөлдөөн чинь нэгэнт эхэлчихээд байна гэж Томашевский дуугараад, таны эсрэг Сатаров хагуу байр суурь баримталж байна. Тэр Решетов гэгч аюултай гэмт хэрэгтнийг чинь

Сатаров бүр ч илүү үзэн ядаж байгаа. Тэгэхлээр танд Решетовой хамтран бусадтайгаа нэгдэж Сатаровыг компаниасаа зайлуулах ганцхан зам байна гэж хэлтэл Полунин өлгөж аваад,

-Тэгээд цус урсгасан тулалдаан эхлэх. Тийм үү? гэж асуув.

-Хэрэв та намайг компанийн удирдах бүрэлдэхүүнд оруулах юм бол бид ямар ч эсэргүүцлийг няцааж чадах хүчтэй болно. Сатаровыг ч амархан няцааж чадна гэж Томашевский Полунинг ширтэж яаран хэлээд, энэ нь танд болон надад бас мужийн захиргаанд ашигтай алхам болох юм гэж тайлбарлав. Тэгснээ хажуудаа сууж байсан Симонов руу учиртай хараад авлаа.

Полунин хэдэн мөч Томашевскийн саналыг эргэцүүлж бодож сууснаа юм хэлэхгүй бичгийн хавгас гарган дотроос нь Соловейчиктай хамтран үйлдсэн төслөө гарган түүнд өгөв.

-Энэ бол таны саяны хэлсэн саналыг тусгаж сөргөлдөөнийг арилгах бидний үйлдсэн төлөвлөгөө юм. Энэ төсөл та бид болон манай нутаг бүсийн эрх ашигт нийцэх болов уу гэж бодож байна. Би энэ төлөвлөгөөнөөсөө алхам ч ухрахгүй. Хэрэв энэ нь танд таалагдвал бид холбоотон болж чадна. Эс таалагдвал та бид хоёрын зам нийлэхгүй гэж Полунин хэлэв.

Томашевский түүний өгсөн төлөвлөгөөний төслийг гүйлгэн уншсанаа хөмсөг зангидан

-Та надаар тоглоом хийж байна уу? Энэ чинь надад огт таалагдахгүй байна. Та нар надад ердөө л хорин хувийн хувьцаа ноогдуулж байна. Энэ хорин хувийг чинь авахын тулд би бүх авлагаа хааж бас дээр нь багагүй хөрөнгө оруулалт хийх болж байна! гэж бухимдан дуу алдав.

-Таны энэ хөрөнгө оруулалт болон өр хаасны чинь зардлыг манай үйлдвэрийн цаашдын ашигтай ажиллагаа бүрэн нөхөж өгөх болно гэж Полунин босох зуураа тайлбарлаад, бидний энэ саналыг та сайн бодож үз. Тэгээд өөрийн саналыг удахгүй болох захирлуудын зөвлөлгөөн дээр хэлнэ биз гэлээ.

Полунин тэдэнтэй салах ёс гүйцэтгээд дэд захирлын өрөөнөөс гарч явав. Ингэсний дараа Томашевский Полунингийн төлөвлөгөөний төслийг анхааралтай судлан уншлаа. Тэгтэл Полунин өрөөнөөс гарч хонгилоор явж байтлаа дэд хурандаа Бирюковтой санамсаргүй тааралдаж орхилоо.

-Өдрийн мэнд, Владимир Иванович! хэмээн Бирюков мэндлээд, таагүй царайтай харагдаж байх чинь. Ажил чинь бүтэмжгүй байгаа юм биш биз гэж асуув.

-Ажил санасан ёсоор хэзээ ч бүтэмжтэй байдаггүй гэж Полунин хариулаад цаашаа явах гэтэл Бирюков саатуулан:

-Хүлээж бай, Владимир Иванович надад танд ярих юм байна. Үнэндээ танд таалагдах юм биш гэдгийг нуугаад яах вэ? гэлээ.

Полунин дэд хурандааг анхааралтай ширтсэнээ:

-Юу юм бол? гэж асуув.

-Хотод дахин түгшүүртэй байдал үүсэж, агаарт хярвас хиншүү ханхлах нь...

-Тодорхой яриач Константин Матвеевич гэж Полунин хөмсөг зангидаж асуугаад, би хувьдаа ямар ч хярвас хиншүү гаргаагүй гэв.

-Та хувьдаа тэгээгүй боловч таны өрсөлдөгч нөхөд чинь хэвийн бус явдал гаргаж эхэлж байна. Хотод тайван байх нь надад хичнээн чухал гэдгийг та мэдэж байгаа, гэж Бирюков ярьж байтал Полунин үгийг нь таслан:

-Та тэгээд ямар тодорхой хиншүү үнэртсэн мэдээлэл надад хэлэх гээ вэ? гэж асуув.

-Өнгөрсөн өдрүүдэд манай шуурхайнхан Рязань хотоос ирсэн хэсэг хөлсний алуурчдыг баривчлаад байгаа. Тавуулаа яваа тэд манай хотод онц ноцтой хэрэг үйлдэхээр ирсэн бололтой.

-Хэний захиалгаар хэнийг цааш нь харуулах гэсэн юм бол?

-Хэнийг гэдгийг бид мэдэж чадаагүй байна...

Байнга хэнэггүй харагддаг дэд хурандаагийн царайд үл ялиг бухимдал тодорч,

-Харамсалтай нь баривчилгаа маань цагаа олсонгүй бололтой. Зэвсэг тээж ирсэн жолоочоос нь бусдад бид хэрэг тулгах үндэслэл олохгүй байна гэлээ.

Полунин Бирюковын нүдийг өрөмдөх мэт ширтэн:

-Тэр алуурчид чухам хэний захиалгаар явааг та мэдээгүй байна гэдэгт чинь би итгэхгүй байна гэж хэлэв.

-Тэд захиалагчтайгаа нүүр учирч ярилцаж амжаагүй байсан юм гэж Бирюков хэлээд, гэвч тэднээс сонссон зарим мэдээллээр бол тэднийг таны найз Коля Решето урьж авчирсан бололтой гэх нь тэр.

Решетовын талаар түүний хэлснийг Полунин сонсоод балмагдан хөмсөг зангидлаа. Тэрээр Решетовын талаар базаахгүй юм дуулдана байх гэж бодож явсан боловч дотроо бүү тэгээсэй хэмээн залбирч явсан юм.

-Тэдний талаар өөр юу мэдэгдэв?

-Өөр мэдэгдсэн юм одоогоор байхгүй.

-Тэд одоо хаана байна вэ?

-Одоохондоо хоригдож байгаа гэж Бирюков хариулаад, гэвч удахгүй суллана байх. Хуулийн дагуу тэдэнд ял тулгах үндэслэлгүй байгаа юм гэлээ.

-Тэгвэл тэднийг бидэнд өгчих гэж Полунин хүсээд, тэд бидэнд арай илүү юм хэлж өгөх байх

гэж бодож байна гэлээ.

Бирюковын нүүрэнд хөнгөн инээмсэглэл тодрон:

-Энэ бол малыг нядалгаанд хөөж оруулахтай адил хэрэг болно. Үнэндээ тэд тэртэй тэргүй өөр юу ч мэдэхгүй байгаа юм гэлээ.

-Тэгвэл тэднийг одоо суллах хэрэг үү? гэж Полунин хөмсөг зангидан асуулаа.

-Би танд урьдчилан санууллаа. Сатаровг ч сануулах болно. Би тэр хөлсний алуурчдыг энэ хотоос зайлуулна гэж Бирюков хариулав.

-Тэгж болохгүй гэж Полунин мэдэгдээд учир нь энэ чинь урьдчилан тааварлахын аргагүй уршиг тарьж мэднэ. Олег бол хатуу догшин зантай хүн. Би өөрөө учрыг нь олохыг оролдъё гэлээ.

-Тийм ээ. Би ойлгож байна гэж Бирюков бага зэрэг итгэлгүй өнгөөр дуугараад, гэвч одоохондоо таны оролдлого амжилтад хүрэхгүй байна. Хотын байдал сүүлийн өдрүүдэд эрс хурцадлаа. Таны бодлого Владимир Иванович минь таалагдахгүй байгаа бололтой. Би тэдний хоорондын өрсөлдөөний тухай яриагүй байна шүү! Тэр хөлсний алуурчид бол зөвхөн эхний хараацайнууд гэж ярьтал,

-Алив, тэгвэл тэд сүүлчийн хараацай болохын тулд бид өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийе гэж Полунин Бирюковын үгийг шийдмэг таслав.

Тэрээр салах ёс хурдан гүйцэтгээд цахилгаан шатны зүг яаран алхаллаа. Бирюков түүний араас бодлогошрон харж байснаа эсрэг талын хаалга чиглэн яаралгүй алхав.

* * *

Полунин мужийн захиргаан дээр хүмүүстэй уулзаж ярилцсаны дараа гэртээ сэтгэл нь тун дундуур хүрч ирлээ. Хөлсний алуурчдын ирснийг Бирюков мэдээлсэн нь түүний түгшүүрийг төрүүлэхгүй байхын аргагүй байсан юм. Түүний хэрэгжүүлж эхэлсэн үйлдвэрийг тайван байдлаар хөгжүүлэх төлөвлөгөө хувь нийлүүлэгчдийн дургүйг хүргэж байна гэж Бирюков мэдэгдсэн нь улам ч ихээр бухимдуулж байлаа. Тэр алуурчид хотод орж ирсэн явдал түүний хэлэлцээрийн журмаар асуудлыг зохицуулах оролдлого түншүүдэд нь таалагдахгүй байгааг гэрчилж байв.

“Чөтгөр аваг цаашаа. Тэдний энэ болчимгүй алхамыг би хэдий болтол хориглох гэж зүтгэнэ вэ. Одоо ямар нэгэн юм бодож олох хэрэгтэй” хэмээн тэрээр бодлоо.

Владимир өөрийн “БМВ”-г хашаандаа залан оруулаад Самбистын ягаан өнгийн том жийп “Мицубиши-Пажеро”-ийн хажууд аваачиж тавив.

Полунин гэртээ ороход түүний тааварласан шиг Самбист хэзээний л ирчихсэн Аннатай хамт урдаа лаазтай шар айраг зууш зэргийг тавьчихсан суух ажээ. Самбист орж ирж яваа Полунинг эргэж хараад нүүр дүүрэн инээмсэглэн баярлан мэндэллээ.

-Хүүе Иваныч наашаа суу, бидэнтэй цуг шар айраг уу. Чи харин өнөөдөр ашгүй нэг гэрийн хүн шиг эрт ирэв шив дээ гэлээ.

-Та нарт нэг их саад болоогүй гэж би найдаж байна гэж Полунин баргар царайлан дуугараад өөрийнхөө сандалд очиж суув. Полунин ямар нэгэн зүйлд санаа нь зовж таагүй байгааг харсан Самбист юм бодсонгүй лаазтай шар айраг онгойлгон урд нь тавилаа. Харин Анна энэ үед нөхрөө анхааралтай ажиглаж суув.

-За тэгээд манай үйлдвэрийн ажил хэрэг ямаршуухан байна даа? Эцсийн эцэст чи муугүй мэдээ дуулгана биз дээ гэж Антон асуув. Полунин

-Миний хувьд чи үйлдвэрийн талаар сонирхож байгаа чинь сайхан хэрэг байна. Сүүлийн үед чи ингэж анхааран сонирхож байгаагүй шиг санагдана гэж хариулав.

-Чи сүүлийн үед хэтэрхий их ажиллаж байна. Магадгүй гэр орноороо үйлдвэр дээр нүүж очоод тэндээсээ гаралгүй суух гэж байгаа байх гэж Сеницын хэлээд инээд алдав.

-Тэгвэл харин чи үйлдвэр рүү очих чинь олширно биз гэж Полунин ёжлон дуугарав.

-Тэр үйлдвэрээ орхи цааш нь гэж Самбист гараа савчин хэлээд надад тэр чинь хамаагүй. Дэмий цаас эрээчиж бас тэр хөлдүү хувьцааны эзэдтэй хэл амаа ололцох гэж зүдэрнэ. Чи яаж ингэж тэвчиж чадаж байна вэ? Би байсан бол өдийд цөмийнх нь нармайг нээчихээд байхсан гэв.

-Тэд ч гэсэн бас тэгж бодож байгаа байх гэж Полунин аяархан дуугарав.

-Чи хэний тухай? гэж Самбист гайхан асуув. Тэгтэл гэнэтхэн Полунин тэвчээр алдан сандлынхаа тохойвчийг алгадан:

-Бүгдийн чинь тухай ярьж байна. Чамд бол тэдгээр мунхагуудтай нударга буюу буу шийдмээр ярих чинь амар мэт санагдаж байгаа биз гэж Сеницын рүү хашгирлаа.

-Чи юу болоо вэ? Ямар шумуулд хатгуулж орхиов. Иваныч?

-Арай ч хатгуулчихсангүй гэж Полунин бувтнаад арван граммын жинтэй тугалган шумуулд гэлээ.

Сеницын урьдын адил түүнийг гайхсаар ширтэн сууна.

-Чи хэзээ ажиллаж эхлэх гэж байна? хэмээн Полунин Самбист руу ширүүнээр харж, чи эцсийн эцэст нэг юм хийж эхлэх юм уу, эсвэл бүх насаараар манай эхнэртэй шар айраг гүзээлж сууж дэлгүүр хоршоогоор хэсүүчилж явах гээ юу? гэж асуух нь тэр.

Сеницын гэнэтхэн дургүйцэж:

-Тийм ээ, би ... Бид ... хэмээн өөрийгөө зөвтгөх үг хэлэх гэсэн боловч биеэ эзэмдэн, бүү хашгир. Иваныч. Юу болсныг хэлээд орхи? гэлээ.

Полунингийн бухимдал эхэлсэн шигээ гэнэтхэн намжиж сандлынхаа түшлэгийг ядарсан байдалтай түшээд урьд нь байгаа лаазтай пивыг авч том балгаад:

-Том үйл бүтээх гэж бидний нэгэн түнш маань тэр дээрэмчдийг дуудсан тухай мэдээлэл би өнөөдөр аваад байна гэлээ.

-Юу гэнээ? Хэн маань дуудсан хэрэг вэ? гэж Сеницыны царай хувирч хөмсөг зангидан, одоо тэр жүжигчид чинь хаана байна гэж асуулаа.

-Үүнийг чинь би чамаас асуумаар байна хэмээн Полунин ядарсан дуугаар хэлээд, чамд ямар нэгэн хэмжээгээр сөрөх тагнуулын ажиллагаа байна уу? Хотод хөлсний алуурчид чөлөөтэй орж ирээд байхад бид юу ч мэдэхгүй сууж байна. Энэ чинь болж байна уу? гэж асуув.

-Чи үүнийг хэнээс мэдээ вэ?

-Бирюковоос. Тэр алуурчдыг саатуулаад байгаа гэж тэр надад хэлсэн гэж Полунин хариулав.

-Хэн хэнийг хөнөөхөөр тэднийг захиалаа вэ?

-Хэнийг гэдгийг мэдэхгүй байна. Харин тэднийг Коля Решетов захиалжээ.

-Муу новш хэмээн Сеницын нударга зангидан, тэр хэнийг цааш нь хийх гэсэн юм бол? Биднийг үү? Эсвэл Сатаровыг уу? гэж асуув.

-Харин л дээ. Тааварлахад хэцүү асуудал. Гэвч бидний нэг түнш маань зэвсэг барьж эхлээд байгаа нь яавч сайн хэрэг биш гэж Полунин хэллээ.

Самбистын нүүр барайж,

-За тэр дээ. Би чамд хэлээгүй юу хэмээн хилэгнэн дуу алдаад, тэгэхэд чи тэднийг ятгаж ойлгуулах гэж мунгинах юм. Тэр чөтгөрүүдийг тонилговол таарна гэлээ. Тэгснээ дуугүй сууж байгаа Аннаг ширэв татаад авлаа. Гэвч Анна түүний үгийг нэг их тоосонгүй Владимирыг санааширан ширтэж сууна.

-Ярьж тохирох л болно доо гэж Полунин шийдмэг дуугараад, бид улаан хоолойгоо нэгмөсөн тасчиж дуусахыг Томашевский зөвхөн хүлээж байгаа юм. Хэрэв бид өөр хоорондоо дайтаж эхэлбэл юу ч үгүй хоцорно. Энэ бол яалт ч үгүй үнэн. Би өнөөдөр Решето руу ярьж “Каскад” ресторанд уулзахаар тохирье. Би өөрөө тэр мунхаг амьтны уураг тархийг цэвэрлэх болно гэлээ. Сеницын гараа савчин:

-Ашиггүй дээ, тэр чинь. Одоо хэдийнээ оройтсон гэв.

-Оройтоогүй байгаа гэж Полунин зөрөөд, бас боломж байна. Тэгэхгүй бол бидний сүүлийн нэг жилд олсон бүх юм маань нурам болно гэлээ. Анна тэдний үгийг таслан Владимир руу эгц ширтэн:

-Хүү бид хоёр яах вэ? Эндээс зайлж явах уу? гэж асуулаа.

-Тийм ээ. Эхлээд та хоёр хотоос гарч зуслан руугаа очно. Тэндхийн тосгон хамгаалалтай байдаг учир харьцангуй тайван байх болно. Долоо юм уу сайндаа хоёр долоо хоногийн дотор би бүх бичиг баримт, зөвшөөрөл зэргийг бүрдүүлнэ. Тэгээд та хоёр гадаад гарч явах болно. Антон чи маргааш өглөө эхнэр хүү хоёрыг минь зусланд хүргэж өгөөрэй. Бас найдвартай залуусаа дагуулж яваарай гэж Полунин ярилаа.

-Тэгье. Би өөрөө хүргэж өгнө. Харин чамд бие хамгаалагч хэрэгтэй юу? гэж Синицын асуув.

-Одоохондоо хэрэггүй гэж бодож байна. Дараа нь хэрэгтэй болж болох юм гэж Полунин хариулав.

-Хүү бид хоёр хоёулхнаа гадаад явах юм гэж үү хэмээн Анна асуулаа.

Полунин хариуд нь инээмсэглээд

-Хэрэв хүсвэл Самбистыг дагуулаад яв л даа. Тэр сүүлийн үед зав ихтэй байгаа учир нэг сүрхий дургүйцээд байхгүй биз гэлээ.

-Боль доо, Иванов гэж Самбист гомдонгуй дуугараад, чи надаар тоглох гээд л байна уу даа гэлээ.

-Бүү гомдчихоорой хэмээн Полунин эвтэйхэн хэлээд санаа алдан, ийм байдалд орчихоод байх үед юу ч хэлчихэд бэлэн байх юм даа гэв.

Хэдэн хором тэд чив чимээгүй болж өөр өөрийнхөө бодолд хөтлөгдөн суув. Эцэст нь Самбист босоод:

-За яая гэх вэ дээ. Би явах уу даа. Маргааш өглөө орж ирье гэв.

-Чи өөрөө бид хоёрыг зусланд хүргээд өгч чадахгүй юм уу? гэж Анна нөхрөө ширтэн асуулаа.

-Маргааш өглөө надад хотын захиргаанд очих чухал ажил байна.

-Өөрийн эхнэр хүүхдээ өөр хүнд даалгахад хүргэх тийм чухал ажил байдаг юм уу? гэж Анна асуув.

-Яагаад өөр хүнд гэж? хэмээн Полунин инээд алдан асуугаад Антон бараг манай хүн биш гэж үү? Тэр ажил дээрээ байхаасаа илүү манай гэрт ихэнх цагаа өнгөрөөдөг хүн гэлээ. Ингэж хэлээд Полунин Самбистыг доогтой хараад авлаа. Самбист амандаа нэг юм үглээд дуугүй гарч явлаа. Анна араас нь очиж хаалга хаагаад гал тогооныхоо өрөөнд орж:

-Чи өөрийн ажлын бүтэмжгүйд бухимдахдаа заавал дэмий юм ярьж хүний дургүйг хүргэх ямар хэрэг байна? Антоныг чи дэмий доромжлох юм гэлээ.

-Бид хоёрын ажил нэг л бүтэмж муутай болоод байна гэж Полунин төлөв байдлаар хэлээд би тэгэхэд ганцаараа л санаа маань зовж байх юм. Тэгээд ч би дэмий юм яриагүй. Үнэн байдлыг л ярьж байна. Та хоёр хамтдаа цаг нөхцөөж байхдаа дуртай байдаг биш үү? гэж асуув. Тэгснээ

Аннагийн нүд рүү сонжин ширтлээ. Анна юм хэлсэнгүй эргэж унтлагынхаа өрөө рүү явж орлоо.

Полунин лаазтай шар айраг яаралгүй шимэн нэлээд удаан ганцаараа сууж байснаа гар утсаа залган,

-Би Полунин байна. Би Николайтай ярих гэсэн юм гэлээ.

-За одоохон гэж хэлэх сонсогдоод хэдэн хормын дараа Коля Решето утсаа авлаа.

-Би байна гэсэн түүний таржигнуур дуу гарав.

-Сайн байна гэж Полунин хэлээд, намайг анхааралтай сонс. Бид хоёр яаралтай уулзах чухал хэрэг байна гэв.

-Тэгье. Уулзъя гэж Коля гайхсан шинжгүй дуртай зөвшөөрөөд, чи юу ярих гээ вэ? гэж асуув.

-Бидний санал зөрөлдөөний талаар ярих гэсэн юм.

-Тэгвэл уулзаж ярилцъя гэж тэрээр тайван хариулав.

-Маргааш оройн долоон цагт “Каскад” ресторанд уулзъя.

-Тэгж тохиръё.

-Бас чамд сануулах юм байна. Би зөвхөн чамтай ярилцах гэж очно. Харин чи илбийн номер үзүүлэх гэж бүү оролдоорой. Намайг ойлгож байна уу? гэж Полунин түүнд сануулав.

Решетов хариу хэлсэнгүй утсаа салгалаа. Дараа нь Полунин бас Сатаров руу залгалаа. Гэвч тэр утсаа авсангүй. Тэрээр “За яахав. Маргааш л ярихаас даа” гэж бодлоо. Владимир сандалныхаа түшлэгийг налж нүдээ анив. Энэ мөчид тэрээр гэнэтхэн ихэд ядарч байгаагаа мэдрэн өөрийн эрхгүй нойрондоо дийлджээ.

* * *

Полунин хэн нэгэн мөрөнд нь хүрэхэд сэрвэл өмнө нь Анна зогсож байлаа. Тэрээр биеийн тамирын хувцсаа өмсчихөөд гарахаар бэлтгэсэн байхыг хараад Полунин бага зэрэг гайхан:

-Хэдэн цаг болж байна гэж асуув.

-Долоо хагас гэж Анна инээмсэглэн хариулаад, намайг уучлаарай гэв

-Юунд?

-Шөнө чамайг сэрээж оронд чинь оруулаагүй явдалд ч байж болно. Наадах сандал дээрээ тийм ч тухтай амарч чадаагүй биз дээ гэлээ.

-Зүгээр дээ гэж Полунин эхнэрээ тайвшруулаад, унтаж амрах нь ор дэвсгэрээсээ бус оюун санааны байдлаас ихэнхдээ хамаардаг гэж хэлэв.

Анна гэмшсэн байдлаар нөхрөө ширтэнэ.

-Харин чи намайг уучлаарай. Өчигдөр чи надаас арай илүү халамж хүсэж байсныг чинь би ойлгосонгүй. Чи энэ бүхнийг биднийхээ сайн сайхан ирээдүйн төлөө л гэж хийж байгаа шүү дээ гэж өглөө сэрээд би ойлгосон. Би нэгэн үе чамайг дутуу ойлгож байсан юм байна. Амьдралд бүх юм гэнэтхэн сайн сайхан болчихдоггүй алгуур аажим саад бэрхшээлийг даван зүдэрч байж бий болдог байх. Гэтэл би хэдийнээ зуу насалчихаад тун удахгүй үхэх мэтээр сэтгэж байсан юм шиг байжээ гэж Анна ярилаа.

Полунин хариуд нь инээмсэглээд босож эхнэрээ зөөлөн тэврэн:

-Чи тэгж бодож байгаад чинь би баярлаж байна.Надад энэ гэр орон та хоёроос минь илүү юм энэ хорвоод байхгүй гэж хэлэв. Энэ үед хүү Антошка нь гүйн орж ирлээ. Тэр хүү ээжтэйгээ нэгэн адил явахад бэлтгэчихээд байсан ажээ.

-Аав аа! Бид үнэхээр холын хол амрахаар явах юм уу?

-Тэгнэ.Хүү минь гэж аав нь хэлээд

-Маш сайхан газраар явж олон сонин зүйл үзэх болно. Чи өөрийгөө азтайд тооц. Олон орноор явж гоё гоё хотуудыг үзэж далайн бүлээхэн усанд сэлж, том сайхан усан онгоцоор аялах болно. Би чиний насан дээр энэ тухай мөрөөдөж ч байгаагүй юм хүү минь гэлээ.

Антон аавынхаа хэлэхийг дуугүй сонсож байснаа эцэгтэйгээ адилхан бор нүдээ эрвэлзүүлэн

-Аав та бидэнтэй хамт явна биз дээ гэж асуув.

-Явахгүй, хүү минь гэж Полунин хүндээр санаа алдаад удахгүй араас чинь очно. Одоо аавд чинь энд хийх ажил тун их байна гэлээ.

Антошка аавыгаа гунигтай харцаар ширтэн:

-Би аавтайгаа хамт энэ бүхнийг үзмээр байна гэлээ.

-Зүгээр ээ гэж Полунин хүүгээ аргадаад, чи тэр бүхнийг эхний үед ээжтэйгээ хамт явж үзэх болно. Дараа нь ааваа дагуулан явж надад үзүүлээрэй. Тэгж тохирох уу? гэж асуув.

-Тохирлоо гэж Антон дурамжхан дуугараад аавынхаа том алган дээр өөрийнхөө жижиг булбарайхан гарыг тавилаа.

-За одоо өглөөнийхөө цай ууя гэж ээж нь хэлэв.

Хориод минутын дараа тэдний цайлж дуусах үед хаалганы хонх дуугарав. Полунин хаалгаа онгойлгон Сеницыныг оруулж ирлээ. Сеницын үүдний хавьцаа бага зэрэг зовсон байдалтай

зогсож байснаа:

-За яахав? Тэгээд явцгаах уу? гэж асуув.

-Явья, явья гэж Полунин яаран хариулаад эхлээд ороод ир. Бидэнтэй хамт цай уу. Өглөөний цайгаа бас л ууж амжаагүй яваа биз гэж хэлэв.

Синицын гал тогооны өрөөнд ороод тэдний сэтгэл зүйн байдал хэвийн болсныг ажиглан мэдээд нүүр дүүрэн инээмсэглэн

-Зөв. Гэр бүлийн бүх гишүүд нэг дор цугларчээ. Маш сайн байна. Ийм л сахилга журамтай байх хэрэгтэй гэж хэлээд тайвшран санаа алдав.

Тэрээр ширээний ард суухад Анна хоол таваглаж өглөө. Хоолоо идэж дуусаад Синицын:

-Чи өөрөө өнөөдөр хаашаа явах хүн бэ? гэж асуув.

-Одоо би хотын захиргаа орно. Мужийн дэд захирагчтай ярих юм байна.

-Би танай хоёрыг хүргэж өгчихөөд үдийн дараа буцаж ирнэ. Юмыг яаж мэдэхэв, би өөрийн хоёр залууг зусланд дагуулж аваачина гэж Самбист хэлэв.

-Сайн байна. Одоо хамтдаа гарья гэж Полунин хариулав.

Тэд байшингаас гарч машинуудаа тавьсан зогсоол руу хүрч очлоо. Самбист өөрийн жийпд тэдний юмыг ачиж байхад Полунин эхнэр хүүхэдтэйгээ салах ёс гүйцэтгэлээ.

-Чи зуслан руугаа бид хоёр дээр хэзээ очих юм бэ? гэж Анна асуув.

-Зав гармагц л гэж Полунин хариулаад надад энд ганцаараа тэгээд бас сандал дээр унтаж байх нь нэг их таалагдахгүй байна гэж инээмсэглэн хэллээ.

Анна нөхрөө үнсээд машинд орж урд суудалд сууж арын суудалд жижигхэн Антон үсрэн орлоо.

-Баяртай. Дараа уулзья Ивановч гэж Самбист ажил хэрэгч байдлаар хэлэв. Полунин тамхиа асааж зогсоолоос гарч яваа машины араас харсаар хоцров.

Үнэн хэрэгтээ Полунин нэлээд эртнээс энэ хуучин машинаа жийпээр солих бодолтой байсан боловч Синицыны өмнө нэг л эвгүй санагдаад байсан юмсанжээ.

Синицын Аннад муугүй харьцаатай болохыг эрмэлзэж байсныг Владимир нэлээд түрүүний мэдэж байсан юм. Бас Анна түүнд тийм ч таатай хариу өгдөггүй зөвхөн сайн нөхөрлөлийн ёсоор харьцдаг байсныг ч мэддэг байлаа. Өнөөдөр энэ байдал нь дахин батлагдаж Самбист үүнийг өөрөө ч гэсэн ойлгохгүй байхын аргагүй учир өөрийн ойлгомжгүй мэдрэмжийг хязгаарлан Анна, бяцхан хүү хоёрт зөвхөн халамжийн хэмжээнд харьцаж байв. Бяцхан хүүг өөрийн тохилог сайхан машиндаа суулган баярлуулж явах болсондоо Синицын яагаад ч юм

дотор нь тааламжтай санагдаж байлаа. Үүнийг нь Полунин ч гэсэн тааварлаж байсан юм.

Владимир хэдийнээ унтарсан тамхиныхаа ишийг хаяж машиныхаа хаалгыг онгойлгож байтлаа хаа нэгтэйгээс өглөөний нам гүмийг зүсэх шиг үргэлжилсэн алга таших мэт огцом чимээ сонсох нь тэр. Гудамжны тэртээгээс гарсан энэ чимээг сонсоод Полунин балмагдан сандарч хөлс нь чийхран дөнгөж сая Сеницыны машин гарч явсан байшингийн хонгил руу ширтэн хөшиж орхилоо.

Гэвч тэрээр дараагийн агшинд машиныхаа хаалгыг огцом дэлгэж урд хаалганд байрлуулсан дууны баганыг угзран онгойлгоод тэнд нуусан гар буугаа авч байшингийн гарах хонгил руу байдаг хурдаараа гүйлээ.

* * *

Малеев хажуугийн суудал дээр байсан автомат “Калаш”-ийг авч замгийг нь сойгоод өвдөг дээрээ тавилаа. “Ес”-ийн урд суудалд сууж явсан Гриня шеф рүүгээ эргэж:

-Чи бүр зочдоо угтахад бэлтгэж байна уу? гэж асуув.

-Би зочдоо угтахад ямагт бэлэн байдаг хүн гэж Малеев ширүүн дуугараад орон сууцны байшингийн орц руу анхааралтай ажиглав.

-Арай эрт байгаа юм биш үү? гэж Гриня дуугараад дөнгөж долоо болж байна гэв.

-Тэр чинь нэлээд эртэч шувуухай байгаа юм гэж Малей хариулаад, тэд бүр зургаа гэхэд ажилдаа гардаг хүмүүс гэлээ.

Жолооны ард суугаа Костыль Малеев руу эргэж:

-Машинаа асаах уу? гэж асуув.

-Амжина. Энэ чинь амархан асдаг машин. Хүмүүсийн анхаарлыг яаран татаад юу хийхэв гэж Малеев хариулав. Гриня автоматаа бөгсөөр нь шалан дээр тавиад амыг нь өвдөг хоорондоо хавчуулж хурууныхаа үзүүрээр бухимдан тогших ажээ. Тэрээр

-Чөтгөр гэм, тамхи татах юмсан. Малей алив цуварч татчихъя гэхэд

-Болохгүй гэж Малей хориглоод, тэсэж үз. Ажлаа гүйцэтгэсний дараа дураараа тамхил. Би ч гэсэн одоо хөгжим тавимаар санагдаж байна. Гэвч харж байна уу, тэвчээд сууж байна гэлээ.

-Энэ бүхэн надад нэг л таалагдахгүй байна гэж Гриня гэнэтхэн ярианыхаа сэдвийг өөрчлөн хэлээд, бид ч сүрхий золиосонд гарах шиг боллоо гэв.

-Зүгээр ээ. Бүү санаа зов. Бид аль хэдийнэ золиосны амьтад болоод өнгөрсөн гэж Малеев түүнийг тайвшруулахыг оролдон хэллээ.

-Энэ хотод эвгүй юм болж эхлэх нь бололтой. Эндээс бушуухан холдох нь чухал гэж Гриня

хэлэв. Малеев зүүн гарынхаа бүдүүн хуруунуудаараа нямбай зассан сахлаа илж:

-Аллага үйлдэх нь ямагт шударга бус явдал байдаг. Журамтай хүмүүс бие биенээ хэзээ ч бууддаггүй юм. Энэ бол миний гүн итгэл үнэмшил гэлээ.

-Чиний амнаас ийм үг сонсох нь сонин байна гэж Гриня дуугараад, чи эртнээс нааш энэ үйлдлээр амьдралаа залгуулж яваа биш үү. Одоо болохоор энэ чинь өөрт чинь таалагдахгүй янзын юм ярих чинь гэв.

-Би бол хэвийн бус улс оронд амьдарч байгаа хүн гэж Малеев хариулаад, ийм учраас хэвийн бус бизнес хийх нь ердийн хэрэг. Иймд би ямагт бэлэн байдаг юм гэж тайлбарлав.

-Энэ ажлыг бид өвгөртлөө хийж явах юм гэж чи бодож байна уу? гэж Костыль асуув.

-Тийм ээ. Үхтэлээ хийж явах болно. Учир нь бидний энэ мэргэжлийн хүмүүс удаан насалдаггүй юм хэмээн Малеев хүйтнээр хариулаад харин амжиж зайлж чаддаг байх хэрэгтэй гэв. Тэгснээ тэрээр хэдэн мөч нүдээ онийлгон бодлогошрон сууж байснаа үргэжлүүлэн:

-Тэгээд хэвийн улс оронд цагаачлан гарч хэвийн байдлаар амьдарч хэвийн хүмүүстэй учрах нь чухал гэв.

-Чи тэгээд яагаад өнөө хүртэл тэр газар руугаа явахгүй байгаа юм бэ? гэж Гриня асуув.

-Би мөнгөжөөгүй байна. Одоохондоо би энд хүндтэй хүний нэгэнд тооцогдож байгаа. Учир нь би мэргэжлээрээ сайн ажиллаж байна. Би тэнд очоод энэ мэргэжлээрээ ажиллахгүй учир бусдын адил хүндлүүлж явахын тулд их мөнгөтэй байх ёстой гэлээ.

-Хэвийн улс орон гэдэг чинь хаана байна вэ? гэж Гриня асуув.

-Хаана ч байж болно. Зөвхөн Орост л байхгүй гэж Малей хариулаад жишээ нь надад Европ түүний дотор Франц улс таалагддаг. Эрт оройн хэзээ нэгэн цагт би тийшээ явах болно гэв.

-Энэ тухайгаа чи бидэнд яагаад өмнө нь ярьдаггүй байсан юм бэ?

-Би үүнийг яриад байх албагүй байсан юм. Хүн бүр өөр өөрийн бодолтой. Харин энэ чинь энд чөлөөтэй байдаг. Гэвч энэ тухай би үргэлж бодож л явсан. Харин сүүлийн үед би бүрмөсөн шийдсэн гэж Малей хариулав.

-Биднийг энд ажиллачих юм биш биз? гэж Гриня асуугаад ийш тийшээ сэрэмжлэн хараад авав.

-Бид далан хувийн урьдчилгаа авсан. Тийм болохоор тэгэхгүй байх.

-За яахав, харж л байж больё гэж Гриня хэлэв.

Хэсэг хугацаанд машин дотор чимээгүй болов. Хажуугаар нь тэдний өнгөт шилэн цонхтой

“Жигули 9”-г анзаарсан шинжгүй нэгэн хүн явж өнгөрлөө. Тэгтэл гэнэтхэн хөлсний алуурчдын хараалж байсан байшингийн орцноос Самбист, Полунин, Анна хүүтэйгээ гарч ирлээ. Тэд дөрөв орцноос холгүй орших машины зогсоол руу явцгаах нь харагдана.

-Асаа гэж Малеев нам бөгөөд тайван дуугаар хэлэв.

Хэдэн мөчийн дараа “9”-ийн хөдөлгүүр асаж машин аажим хөдөлсөөр хашаанаас холдон хонгилын цаадах гудамжны эсрэг талд очиж зогслоо.

Байшингийн хонгилоос Самбистын ягаан өнгийн жийп гарч гудамж руу аажмаар орон ойролцоох замын уулзвар руу эргэх хүртэл тэд бас минут хэртэй түгшүүрлэн хүлээв.

-Тэд байна! гэж Гриня түгшүүрлэснээсээ болж уруулаа хазан дуу алдав.

Костыль жийпний араас машинаа залан Малей, Гриня хоёр хажуугийн салхины шилийг онгойлгох товчлуурыг яаран дарлаа.

Хэдэн хормын дараа жийп замын уулзварт хүрч очоод зогстол Малей

-Костыль, улаан гэрэл! Хажууд нь зэрэгцэж оч хэмээн тушаав.

-Харж байна гэж Костыль тайван дуугараад хаазаа гишгэн хурдаа огцом нэмж зүүн гар талын эсрэг урсгалд оров. “9” жийпээс хоёр метрийн зайтай зэрэгцэн очиж зогслоо. Малей Гриня хоёр бууныхаа амыг нэгэн зэрэг машины цонхоор цухуйлган гохыг нь дарж орших нь тэр.

Чих дүлийрэм чимээ гарч автоматын нягт бөгөөд давтамж өндөртэй галын хүчинд агшин зуур Самбистын машины салхины шил бут үсрэн жийпийн урд талын хаалга шүүр болж хувирчээ.

Тэд арай л өөрсдийгөө буудчихалгүй галаа зогсоов. Дараа нь Малеев автоматаа яаралгүй хаяж орхиод гар буу “т”-г гарган бариад машинаас гарлаа. Цус болсон толгойгоороо машиныхаа жолоог дэрлэн Самбистыг хагархай цонхоор сайн харж болох тийм ойрхон зайнд хоёр машин зэрэгцэн зогсож байсан юм. Малей хохирогчдынхоо машинд бүр хүрч очоогүй байхдаа Синицыны толгой руу дахин буудлаа. Дараа нь жийпийн бүхээг рүү шагайв. Эхлээд арын суудал айснаасаа болж нүдээ бүлтэгнүүлэн хэвтэх бяцхан хүүхэд түүний нүдэнд тусав.

-Чөтгөр ав! гэж алуурчин хараал хэлээд мөчийн төдий хэвтэж буй хүүхдийн нүд рүү харж тээнэгэлзэн зогслоо.

Яг энэ үед буун дуу сонсогдов. Тэрээр буун дуу гарсан зүг рүү агшин зуур эргэж хартал өөрийн нь зүг рүү буудсаар гүйж яваа эрэгтэй хүнийг харлаа. Дараачийн агшинд тэр хүн дахин хоёр удаа буудаж Малей мөрөө шүүрэн дарж дуу тавин ориллоо.

-Малей түргэл! гэж Гриня хашгираад автоматаа чулуудан гар буугаа шүүрэн гаргалаа.

-Чи хаанаас гарч ирэв, муу өлөгчин! Хэмээн Малей өвдсөнөөсөө болж шүд зуун орилоод машин руугаа үсрэн орлоо.

Энэ үед дахин хоёр сум толгойн нь хажуугаар шунгинан өнгөрөх нь мэдэгдлээ.

Малейн дөнгөж машиндаа ормогц “9” улаан гэрлээр дайран орж замын зөрлөг өнгөрөөд өндөр хурдаар хэргийн газраас зайлан оджээ.

* * *

Полунин байшингийн хонгилоос гүйж гарсан даруйдаа юу болж байгааг шууд ойлгов. Зөрлөгийн уулзварт Самбистын буудуулж сэглүүлсэн машин зогсож байх бөгөөд бутарсан шилний хагархай энд тэндгүй хэвтэнэ. Хажууд нь саарал өнгөтэй “9” бараг шахах шахам зогсож байв. Тэгтэл тэр машин дотроос гар буу барьсан нэгэн хүн гарч ирж байлаа.

Байдлыг хоромхон зуур ойлгосон Полунин тэр мэргэжлийн хөлсний алуурчин хохирогчийг дахин хяналтын сумаар нэрвэх гэж байгааг мэдлээ. Тэрээр жийп рүү үсрэн гүйх зуураа тэр буутай алуурчингийн зүг хэдэн удаа буудаж амжлаа. Жийп хүртэл хориод метр үлдээд байхад эхний хоёр сум байгаа оносонгүй. Харин бүр ойртох үед сум нь тусаж байгаа нь мэдэгдэж Полунингийн дөрөв дэх сум алуурчны мөрөнд тусжээ. Тэр хүн муухай орилон машиндаа үсрэн ормогц агшин хүрэхгүй хугацаанд машин нь дугуйгаа хяхатнуулан ховх үсрэн хурдаа авлаа. Полунин араас нь бас хэдэн сум тавилаа. Полунин жийпийн дэргэд гүйж ирмэгцээ юу болсныг төсөөлж ядан бүх бие нь хүйт даан зогтусан зогслоо. Машины хаалгыг онгойлгохоос зүрхшээн байтал арын хаалга онгойн хүү нь үсрэн гарч ирэхийг Полунин айх гайхах баярлах зэрэгцэн харлаа. Хүүгийн нь царай зэвхий цайран эцгийгээ айж балмагдсан харцаар бүлтийн ширтээд:

-Аав аа...Тэнд...Тэнд ... -ээж хэмээн түгдрэн дуугарав.

Полунин хүүгээ тэврэн авч нүүрээ наагаад буцааж газар тавимагцаа машины хаалгыг саван онгойлголоо.

Хамгийн түрүүнд түүний нүдэнд Аннагийн нүүр тусжээ. Тэрээр тун тайван бөгөөд бүр баясгалантай мэт харагдах нь гайхмаар. Тэрээр толгойгоо Полунингийн зүг бага зэрэг хазайлган суудал дээрээ байх агаад харцанд нь ямар ч сэтгэл хөдлөлийн шинжгүй, урууд нь үл ялиг инээмсэглэл тодорчээ.

Энэхүү тайван бөгөөд инээмсэглэх аядсан царай нь Полунингийн амьдралдаа нэг бус удаа үзэж байсан үхлийн өмнөх шинжийг илтгэж байх тул тэрээр хүүхэд мэт цочрон балмагдаж орхилоо.

-Бурхан минь! гэж Полунин зөвхөн дуу алдан залбирч чадав. Тэрээр жолоогоо дэрлэн хэвтэх Синицынд ч суудал дээрээ налан суугаа Аннад ч нэгэнт ямар ч тусламж хэрэггүй болсныг ойлголоо.

-Ээж, Антон ах хоёр юу болов? гэж машин дотор шагайж харахаасаа зүрхшээн аавынхаа хажууд зогсож байсан Антон асуув.

-Зүгээр дээ. Хүү минь.. Бүү ай.. гэж аав нь хүү рүүгээ тонгойсноо явган сууж тэвэрч авлаа.

Тэрээр ар талд нь машины тоормозлох чимээ гартал хүүгээ тэврэн хэдийчинээ удаан сууснаа ч мэдсэнгүй.

Ард нь эрэгтэй хүний чанга дуу гарч:

-Хүүе чи, буугаа хая! гэх нь сонсогдов. Полунин яаралгүй босож дуу гарсан зүг рүү эргэж харлаа. Ард нь зэвсэглэсэн хоёр цагдаа зогсох бөгөөд цаад талд нь гэрлэн дохиогоо гялалзуулсан цагдаагийн “469” зогсож байх нь харагдана.

-Буугаа хая гэж хэлж байгаа шүү дээ! хэмээн цагдаагийн түрүүч зандраад өөр рүү нь бууныхаа амыг онилсон байлаа. Нөгөө цагдаа нь мөн адил богино голтой автоматынхаа амыг Полунин руу чиглүүлэн барьжээ. Полунин одоо хүртэл гартаа “беретта” буугаа барьсаар байгаагаа сая нэг юм мэдлээ. Тэгснээ буугаа хажуу тийш нь хаяад аяархан дуугаар:

-Алуурчид саарал өнгийн “9” “т” явж байгаа. Дөнгөж сая эндээс зугтаж явсан. Тэднийг барьж авах тушаал яаралтай өгөх хэрэгтэй гэлээ.

Тэгтэл цагдаагийн түрүүч:

-Хүүхдээс холд. Машин руу ойртоод хоёр гараа дээр нь тавь гэж дахин тушаав. Полунин дурамжхан байдлаар тушаалыг нь дагаж машины бүхээгэнд гараа наан хагараагүй үлдсэн салхины арын шилийг духаараа тушин зогсов.

Тэгснээ:

-Та нар дэмий цаг алдаж байна гэж дуугарав.

Цагдаа нарын нэг нь түүнд дөхөж ирээд халаасуудыг нь нэгжих зуураа:

-Алуулсан хүмүүсийг та таних уу? гэж асуув.

-Танина. Миний эхнэр, найз хоёр маань алуулчихлаа гэж Полунин харамсан хариулжээ.

* * *

Аллага үйлдэгдснээс хойш хэдийнээ таван цаг өнгөрчээ. Жийп зогсож байсан замын уулзварыг цагдаа нар бүслэн хааж эрүүгийн шинжээчид урьдчилсан дүгнэлтээ нэгэнт гаргаад байлаа.

Анна, Сеницын нарын цогцсыг хэргийн газраас авч явжээ. Мөрдөн байцаагч Полунинг хүүгий нь хамт гэрт нь хүргэж өгөхөд Шакирыч, Болдин, Самбистын туслах Николай нар гадаа нь ирээд хүлээж байв. Гэвч Полунинг тэдэнтэй яриулсангүй. Зөвхөн хамгийн ахмад Шакирычийг Полунингийн гэрт орж ярилцахыг зөвшөөрчээ. Тэрээр хүүг өвөр дээрээ аваад өөрийн нүсэр том гараараа түүнийг элгэндээ наан суух ажээ. Бяцхан хүү аажмаар юу болсныг ухааран аяархнаар гиншин уйлж байв.

Гэвч мөрдөн байцаагч Полунин хоёрын ярилцаж байх хугацаанд Шакирыч хүүгий нь

тайвшруулж амжсан нь бага зэрэг гайхмаар байв. Тэгж байтал ашгүй нэг дэд хурандаа Бирюков хүрч ирлээ. Түүнийг хүрч ирэх хүртэл Полунинг хэд хэдэн мөрдөн байцаагч бас прокурор байцааж байсан юм. Энэ бүх хугацаанд Полунинд амьд үлдсэн ганцхан бяцхан хүү нь тэдэнтэй эрүүл саруулаар ярилцах хүч чадал өгч байсан юм. Түүний энэ хүнд байдлыг ойлгож байсан Бирюков Полунинаас олон юм байцаасангүй зөвхөн:

-Тэр алуурчдыг та харж амжив уу? гэж асуулаа.

-Тийм ээ гэж Полунин хариулаад, тэр ч бүү хэл би тэдний нэгийг шархдуулж амжсан. Хүнд хөнгөнийг нь мэдэхгүй. Тэгэхлээр эмнэлгүүдтэй холбоо тогтоох нь зүйтэй болов уу. Тэр хүн эмч нарт хандаж юу магад гэв.

-Шаардлагатай бол эмч нарыг нууц байдлаар зохион байгуулж болох юм гэж Бирюков хариулаад, танд гар буу хаанаас бий болсон юм бэ? Владимир Иванович гэж Бирюков асуув.

-Замд явж байгаад олсон гэж Полунин инээмсэглэх аядан хариулав. Тэгснээ тэр даруй нүдэнд хорсол хилэн тодорч:

-Энэ асуулт чинь үнэхээр тийм чухал юм гэж үү? хэмээн нам дуугаар асуулаа.

Бирюков түүнийг тайвшруулах маягийн хөдөлгөөн хийгээд хариу юу ч хэлэлгүй,

-Уучлаарай Владимир Иванович минь. Таны байдлыг ойлгож байна. Гэвч та өнөөдөр оройхон хэрд манай удирдах газар ирж чадах уу? гэж асуув.

-Хэрэгтэй бол очье.

-Бас өөр нэг юм байна, Владимир Иванович хэмээн Бирюков бодлогошрон хэлээд, би таны уй гашуудал гарз хохирлыг чинь ойлгож байна. Гэвч танд ямар нэгэн эрсдэлтэй бөгөөд болгоомжгүй алхам хийхгүй байхыг зөвлөхгүй байхын аргагүй байна. Би энд Самбистын залуус бөөнөөрөө явж байхыг харсан. Бид энэ асуудлыг шийдвэрлэх нь хууль зүйн хувьд зөв болох юм. Би энэ хотод дахин цус урсгахыг хүсэхгүй байна гэв.

-Та энэ үгээ байнга давтаж байгаа боловч энд хүний цус нэгэнт урсчихаад байна гэж Полунин хариулав.

Бирюков юм хэлсэнгүй хэсэг зогсож байснаа өрөөнөөс гарч явлаа. Араас нь бусад нь дагалдан гарлаа. Тэгмэгц Болдин, Николай хоёр гүйлдэн орж ирлээ. Полунин Николайд хандан:

-Гал тогооны өрөөнд орьё гэв.

Николай араас нь дуугүй даган өрөөнд ороод суумагц Полунингаас:

-Одоо яах вэ Иваныч? Тэр алуурчин хэн болохыг мэдэх үү? гэж асуув.

-Одоохондоо мэдэхгүй байна. Гэвч би удахгүй заавал мэдэх болно. Өнөө орой залуусаа

“Зенитэд” цуглуулж энэ явдлын тухай мэдэгдэх нь зүйтэй гэж Полунин хариулав.

-Тэд удахгүй цөмөөрөө тэнд цугларах байх гэж би бодож байна.

-Тэгвэл сайн байна. Тэнд бүх асуудлыг ярилцаж тохиръё. Харин маш болгоомжтой байхыг сануулаарай гэж Полунин хэлэв.

Николай Полунингийн өгсөн үүргийг сонсоод хэдэн хором дуугүй сууснаа түүний нүд рүү ширтэн:

-Иваныч, тэднийг даруй олох хэрэгтэй. Чи намайг ойлгож байна уу? Заавал олох! Зөвхөн чи нэрийг нь хэлчих гэж шаардав.

-Ойлгож байна. Коля минь. Би чамайг бүр сайн ойлгож байна. Бид эрт орой хэзээ нэгэн цагт тэднийг заавал олно гэж би чамд амлаж байна. Гэвч бид одоо тэдний ард ямар хүмүүс зогсож байгааг мэдэхгүй байгаа учир дээд зэргийн сонор сэрэмжтэй байх хэрэгтэй.

-Бидний төлөө бүү санаа зов, Владимир гэж Николай хэлээд, тэд бидэнд гар хүрч чадахгүй гэв.

-Николайн гарч явсны дараа Полунин Антон, Шакирыч, Болдин нарын байгаа өрөөнд буцаж орлоо. Тэд гурвуулаа түүнээс асуух мэт ширтлээ.

-За тэгэхлээр залуус минь гэж Полунин аль болохоор тайван бөгөөд өөртөө итгэлтэйгээр дуугараад, хүнд хэцүү цаг ирж байх шиг байна. Энэ цагийг давж гарахын тулд цаашид юу хийж яаж ажиллах тухайгаа сайтар ярилцаж тогтох нь зүйтэй гэж ярилаа.

Тэгээд Шакирычийн өвөр дээр сууж байгаа хүү рүүгээ дөхөж очоод мөрөн дээр нь гараа тавиад:

-Би эхлээд чамтай ярих нь зүйтэй гэж бодож байна, хүү минь. Аав нь чамайг хэзээ ч орхихгүй. Хэрэв бид хоёрын амьдралд өөр өөр тийшээ явах хэрэг гарвал би чам руу заавал эргэж очно. Чи үүнийг ямагт санаж итгэж яваарай гэжээ.

* * *

Гриня Малеевын шархатсан мөрийг боож өглөө. Энэ үед тэрээр нэг ч удаа ёо гэсэнгүй зөвхөн их өвдөх үед нь бага зэрэг ярвайж суув. Шархыг нь боож өгсний дараа тэрээр гар утсаа залган:

-Би Малей байна. Бидний ажил зүгээр болж өнгөрлөө. Бараг зүгээр гэж хэлэх гэсэн юм. Бидний зорьсон хүнтэй хамт бас нэг хүн алагдсан гэлээ. Нөгөө ярилцагч хүн нь илт бухимдсан өнгөөр:

-Би үүнийг чинь аль хэдийнэ сонсчихоод байна. Чи юу хийчихснээ мэдэж байна уу, өөдгүй амьтан гэж асуув.

Энэ үг түүний шархыг дахин хөндөж тэрээр бага зэрэг үрчийснээ:

-Би ажлаа гүйцэтгэсэн. Ямар ч гэсэн зуун хувийн үр дүнтэй гэлээ.

-Энэ хоёр дахь хүн чинь хэн байсныг ядахнаа мэдэж байна уу, чи?

-Мэдэж байна гэж Малей тайван хариулаад хотод ээлжит захиалгат аллага үйлдсэн тухай шуурхай мэдээллийг ярьж байгаа телевиз рүү хялайн харлаа.

-Тэгж байгаа бол чи энэ үйлдлээрээ бидэнд багагүй хэрэг тарилаа гэдгээ мэдэж ав.

-Та нар сандраад байсны хэрэггүй гэж Малеев тайвнаар хариулаад, тэртэй тэргүй Полунин нэрсийн жагсаалд дараачийн хүн нь байгаа юм. Хэрэв та нарт тэр хүнтэй холбоотой ямар нэгэн асуудал гарвал бид тэрний чинь учрыг амархан олж өгье гэлээ.

-Дуугай бай. Би утсаар нэг ч хүний нэрийг бүү дурс гэж чамд сануулсан шүү дээ гэж цаад хүн нь сандран сануулаад хормын төдий чимээгүй болсноо үргэлжлүүлж,

-Седойн хувьд чамд ганцхан зүйлийг нэмж хэлье. Чи энэ бантан хутгасныхаа дараа зөвхөн бууны сум түүнээс хүлээж авахаа бүү март гэлээ.

-За больж үз. Сэтгэл мэдрэлийн тоглоом хийхээ боль. Бидний гэрээ тохироо өөрчлөгдөхгүй биз гээд Малеевын хөндүүр дахин хөдөлж ярвайлаа. Тэгснээ,

-Мэдээж. Гэвч та цаашид ажиллаж чадах эсэхийг чинь мэдэхгүй байна. Таны эрүүл мэндийн байдал базаахгүй болсон гэж би сонссон юм гэсэн хариулт сонслоо.

-Санаа бүү зов. Би цоо эрүүл байна. Ямар нэгэн ноцтой юм надад байхгүй хэмээн Малей уурлан хариулаад утсаа салгав.

Хажууд нь зогсож байсан Гриня:

-Шеф минь ямар ч гэсэн эмчид үзүүлбэл дээргүй юу? гэж асуулаа.

-Сум яс дайраагүй байна гэж Малей хариулаад, зөөлөн эд болон махан дундуур нэвт гарсан бололтой. Одоохондоо чиний энэ анхны тусламж чинь хангалттай. Шаардлага гарвал эмчид очно. Гэхдээ энд биш. Одоо бид гэрээгээ дүгнэх нь чухал гэлээ.

Гриня ойлгон толгой дохив.

Тавдугаар бүлэг

Оройхон хэрд спорт клуб “Зенитийн” дэргэд машинууд хойно хойноосоо цувран ирж зогсоход тамирчин төрхтэй шөрмөслөг залуус гарч ирээд заал руу орцгоолоо. Тэдний нас залуу бие эрүүл боловч нүүр царай нь баргардуу ямар нэгэн юманд санаа нь зовсон байдалтай харагдана. Орох хаалган дээр Николай сууж тэднийг угтан авч байв. Тэгтэл тэдний нэг нь:

-Бараг цөмөөрөө ирлээ. Эхлэх юм биш үү? гэж асуулаа.

-Болоогүй. Ивановчийг хүлээнэ. Тэр удахгүй ирэх ёстой гэж Николай хариулав.

Тэд арваас арван хоёр залуус байв. Бүгдээрээ Самбистын бүлгийн салааны ахлагчид ажээ. Салаа бүр бас хэд хэдэн хүний бүрэлдэхүүнтэй байдаг юм. Залуусыг зааланд оруулж байсан Николай заалны орцноос холгүй нэгэн “8” ирж зогсож дотроос нь гурван тамирлаг залуу гарч ирэхийг ажигласангүй. Тэд бол Малеевын алуурчдын салааны Гриня, Костыль, Гаврик гурав байв.

Гадаа зуны бүгчим халуун шатаж байсан боловч тэр гурав костюм өмсжээ. Тэд хэнэггүй царайлан алхалсаар довжооны шатаар өгсөн заалны орох хаалганы хонгилд орж ирлээ.

Николай урьд өмнө огт үзэгдэж байгаагүй үл таних залуус гэнэтхэн орж ирсэнд гайхан харж:

-Залуус, та нар юун хүмүүс вэ?

Гэтэл түрүүнд нь явсан Гриня хариу хэлэхийн оронд өмднийхөө тэлээнд хавчуулсан гар буугаа сугалан гаргаж дуу намжаагч эргэдэж суулгасан амыг нь Коля руу онилон буудаж орхих нь тэр. Николай толгойгоо шүүрэн савардсанаа сууж байсан сандалтайгаа саван унав. Энэ үед Костыль Гаврик хоёр халааснаасаа “Ф-1” маягийн гар бөмбөг гарган түгжээг нь мултлан спортын танхимын хаалгыг дэлгэн онгойлгоод гар бөмбөгөө тийш нь нэгэн зэрэг шидэж орхилоо. Тэд хаалгыг саван хаагаад хажуугийн хаалганы доголд орон гараараа чихээ даран шалан дээр суув. Танхимд нэн хүчтэй дэлбэрэлт хоёр дараалан гарч цонхнуудыг цөмийг нь яаруулаад гарах хаалгыг нугаснаас нь мулт татан онгойлголоо. Хоёр алуурчны дээрээс хана таазны шавар шохой ховхрон унаж байсан боловч тэд найдвартай “нуувчинд” орж чадсан байсан учир тэсрэлтийн долгионд огт өртсөнгүй. Хэдэн хормын дараа тэр хоёр дуу намжаагчтай гар буугаа бэлэн барьсаар босож шархадсан хүмүүсийн ёолох чимээ гарч байгаа танхим руу явж очлоо. Гриня нь хаалган дээр харуулдсан хэвээр үлдэв. Танхим дотроос гар буугаар буудах огцом бөгөөд битүү чимээ Гриняд сонсогдсоор байлаа.

Хагас минутын дараа Гаврик Костыль хоёр танхимаас гарч буунуудаа тэлээндээ зүүсэн гэрт нь хийгээд:

-Гүйцээ. Зайлъя хэмээн Гриня нь хамаандлан өөрийнхөө бууг далд хийв.

Тэд түрүүчийн нэгэн адил тайван алхалсаар заалны орцноос гарч машин руугаа явж хүрлээ.

Жолооны ард суусан Гриня машинаа яаралгүй залсаар “Зенит”-ээс бүр холдож явсны дараа

өөр гудамж руу эргэн нэлээд явснаа зогслоо.

Хөлсний алуурчид зэвсгүүдээ нямбай гэгчээр арчиж цэвэрлээд машины шалан дээр нууж тавилаа. Дараа нь мөн адил машин хаалганы бариул, жолооны хүрд, хурдны хайрцагны залгах бариул зэргийг сайтар арчив. Ингэсний эцэст тэр гурав машины хаалгыг нь түгжилгүй орхин гурван тийшээ салж явлаа. Дараа нь тэд нийтийн унаагаар явж эргэж уулзах газраа хүрч ирлээ. Тэднийг гурван өрөө байрандаа шархтай Малеев хүлээн авахад Гриня гүйцэтгэсэн ажлаа илтгэв.

-За сайн байна. Гэрээний үүргээ бид бараг биелүүлжээ. Гэвч нэг хүн үлдсэн байна. Бид түүнд заавал хүрэх болно гэж Малей дүгнэн хэллээ.

* * *

Полунинд Динамовскийн гудамжинд орж спорт клубт ойрхон очих боломжгүй байв. Зогсоолд тавьсан түрүүчийн машинуудаас гадна цагдаа болон түргэн тусламжийн машинууд нэмэгдэн ирж бараг тэр дүүргийг бүхэлд нь бүслэн хаажээ. Полунин машинаасаа гарч бохь зажлан, зогсож байгаа хүмүүсийн дундуур чихэлдэн явсаар хашлага болгон татсан туузанд хүрч очлоо. Тэнд болсон үйл явдлын байдлыг хараад Полунин балмагдан гайхаж хөшиж орхилоо. Ямар нэгэн мөчид тэрээр ийм юм харж байгаадаа итгэхгүй өөрийнхөө ухаан мэдрэл муудчихсан юм биш биз гэж бодож амжлаа. Эмнэлгийн сувилагчид “Зенитийн” хаалгаар дамнуурт тавьж брезентээр битүү хучсан хүүрүүдийг дамжлан гаргасаар байгаа нь харагдана.

Полунин түргэн тусламжийн машинд ачиж байгаа цогцсуудыг багцаалан тоолж арваас доошгүй байгааг тогтоов. Тэгснээ Полунин туузан хашлагыг даван өнөөдөр байранд нь уулзаж байсан мөрдөн байцаагчийн зүг явж очлоо.

-Владимир Иванович! Та энд юу хийж яваа юм бэ? гэж тэрээр асуув.

-Би энэ хүмүүстэй уулзахаар ирж явсан юм гэж Полунин хариулав.

-Та өнөөдөр тэр хүмүүстэйгээ учирч ч салж ч чадахгүй болж дээ хэмээн мөрдөн байцаагч хэлээд, цагийн өмнө урьд өмнө манай хотод гарч байгаагүй том аллага болоод байна. Арван нэгэн хүн алуулжээ гэв.

-Амьд үлдсэн хүн байна уу? гэж Полунин асуув.

-Та гайхах байх гэж мөрдөн байцаагч инээмсэглэн хариулаад тэдний нэг нь үхэж болохгүй байсан бололтой. Тэр залуугийн толгой руу буудсан боловч сум хуйхыг нь зүсэн гарч шархтуулахад ухаан алдсан байжээ гэж хэлэв.

-Хэн юм бол?

-Николай Батурын гэгч залуу. Тэрээр орох хаалган дээр сууж байсан юм байх.

Тэр залуу спорт клубт зааварлагч хийдэг байсан гэж би мэдсэн.

-Одоо тэр хаана байна?

-Тэнд. Клубийн танхимд.

-Би түүнтэй ярьж болох уу?

-Юу ярих гэж? гэж мөрдөн байцаагч мөрөө хавчин, та хууль сахиулах байгууллагын ажилтан юм уу? гэж асуув.

-Ер нь таны нэрийг хэн гэдэг юм бэ? гэж Полунин түүнээс дургүйцэн асуулаа.

Өмнө нь зогсож байгаа прокурорын ажилтан бол өндөр нуруу, туранхайвтар биетэй, хурц байрын зэвхий царайтай, дөрвөлжин эрүүндээ жижигхэн хонхорхой бүхий хүн байв. Түүний хүйтэн цэнхэр нүд ярианых шиг нь увайгүй шинжийг илтгэнэ.

-Хотын прокурорын албаны мөрдөн байцаагч Воронков Илья Игоревич гэдэг. Би өнөөдөрхөн хүртэл өөрийгөө танд танилцуулж байсан шиг санагдана гээд түүний нүдэнд бага зэрэг гэгээ гэрэлтэх шиг болоод, намайг эргэж санахгүй байгаад чинь би огт гайхахгүй гээд “Зенитийн” хаалга руу дохиод, оч, оч Владимир Иванович залуустай ярилц. Ямар нэгэн юм мэдэгдэж юу магад гэлээ.

Полунин спорт клубийн орцоор ортол эхлээд Батуринтай тааралдав. Тэр залуу түшлэгтэй сандал дээр боолттой толгойгоо ганзагалан сууж байлаа. Боолтноос цус нэвчсэн байдлыг ажвал сум түүний зүүн чихний дээхнүүр толгойг нь шүргэн өнгөрсөн бололтой.

-Үнэхээр үхэж болохгүй төрсөн хүн юм даа хэмээн Полунин Батуринг харж дуу алдлаа. Тэгснээ залууд тулж очоод:

-Тэр алуурчдыг мэдэж чадав уу? гэж асуув. Тэрээр дуугүй толгой сэгсэрснээ:

-Гэхдээ би тэдний нүүрийг эргээд танина гэлээ. Орцны хонгилд зогсож байсан нэг цагдаа:

-Владимир Иванович та энд байж болохгүй. Танхим руу ор. Манай дарга нартай уулз гэв.

Полунинг танхимд ороход тэнд дэд хурандаа Бирюков тэргүүтэй мужийн дотоод хэргийн удирдах газрын хэдэн ажилтнууд байв. Танхимын хулдаасалсан шал олон газар цусанд будагдсан харагдана. Шалаар дүүрэн хагархай шил, нурсан хананы шавар хөглөрнө. Биеийн тамирын дасгалын тоноглолууд дэлбэрэлтийн цохих долгионд хөмрөн унаж хэмхэрчээ.

Полунин Бирюковт ойртож очоод:

-Юу болж байна вэ, чөтгөр ав? гэж асуув. Бирюков зөвхөн мөрөө хавчаад:

-Владимир Иванович та бидэнтэй хамт хэсэг рүү явах хэрэгтэй байна. Тэнд бид ярилцъя. Первухин та Владимир Ивановичийг ойрхон байгаа хэсэг рүү хүргээд өг гэлээ.

-Би өөрөө машинаараа очъё.

-Тэгвэл сайн байна. Харин энэ Первухиныг авч яваарай гэж Бирюков хэлээд бусадтайгаа ярихаар эргэлээ.

* * *

Хориод минутын дараа Полунин машинаа цагдаагийн хэсгийн үүдэнд тавиад нэгэн өрөөнд орж эхлээд ёс төдий асуултууд асууж байсан ахмад Первухины өмнө байцаагдан сууж байв.

Первухин өөрийн шөфийг хүлээзнэн ингэж цаг нөхцөөж байгаа мэт санагдана.

-За тэгэхлээр Владимир Иванович дахин хэлээдхээч, та тэдэнтэй хэдэн цагт уулзахаар тохирсон юм бэ? Аллага үйлдэгдэх үед та хаана байсан юм бэ? гэж Первухин асуув.

-Хүүр хадгалах газар хэмээн Полунин хөмсөг зангидан хариулаад түүнийг ширтсэнээ, аллага үйлдэгдэж байх үед би хүүр хадгалах газар байсан юм. Өнөө өглөө миний эхнэр болон найз минь алагдсан. “Зенит”-ийн уулзалтын хувьд тодорхой цаг товлоогүй юм. Спорт клубт би алагдсан залуустай орой уулзаж алагдсан найз Сеницыны талаар ярилцах ёстой байсан юм. Таны шөф Бирюков намайг Сеницыны залуустай уулзаж ямар нэгэн эрсдэлтэй, болгоомжгүй алхам хийхгүй байхыг сануулаарай гэж хүссэн гэж хариулав.

Намхан нуруутай, үл ойлгогдох царай саарал өнгийн нүдтэй Первухин түүний үгийг тайван сонсож сууснаа:

-Уучлаарай Владимир Иванович, асуулт тавих нь миний ажил юм даа. Танд юу тохиолдоод байгааг бид ойлгож байна. Гэвч та бидний ажил ийм гэдгийг ойлгоно биз. Шаардлагатай гэж үзсэн ямар ч хүнээс мэдээлэл авсны үндсэн дээр алуурчдыг эрж олох хэрэгтэй байдаг гэж эелдэгээр тайлбарлав.

-Та сонсож бай, нөхөр ахмад аа. Магадгүй таныг бага сургуульд явж байх үед би анх удаа мөрдөн байцаагчид байцаагдаж байсан байх. Тэр цагаас хойш байцаагчийн ажил ямар байдгийг мэдэх болтлоо мөн ч олон удаа тэдэнтэй учирч явлаа. Тийм учраас та надаас бүү зов. Асуух юмаа шуудхан асууж үз гэж Полунин хэлэв.

Тэгтэл тэдний сууж байсан өрөөний утас дуугарлаа.

-Тийм ээ.. Би сонсож байна... За тэгье... Ойлголоо гэж Первухан утсаар хариу хэлэв. Тэрээр утсаа тавиад Полунинг анхааралтай ажиглав.

-За яав, ахмад аа. Өөр ямар нэгэн асуулт байна уу? Байхгүй бол яриагаа дуусгах уу даа.

-Тийм ээ. Яриагаа дуусгая гэж Первухин бодлогошрон хариулаад, харин та өнөөдөр эндээс гарч болохгүй гэлээ.

Полунин түүнийг гайхан ширтээд

-Яагаад тэр билээ? гэж асуулаа.

-Владимир Иванович таныг хууль бусаар зэвсэг хадгалж байсан гэж саатуулж байна гэж Первухин түүнийг ноцтой ширтэн хариулав.

Полунин ахмадын хэлсэн энэ үгийг сонсоод нүдээ аньж хуруугаараа сормуусаа даран арчлаа. Энэ үед түүнд эмгэнэлт явдал мөхөл сүйрлээр дүүрэн энэ өдөр хэзээ ч дуусашгүй нь гэж бодогдож байсан юм. Тэр хүнд өөрийн сэтгэл хөдлөлийн бүрэн хоосролын улмаас бүх юманд яаж ч хандсан хамаагүй мэт бодогдож байв. Тэрээр нүдээ нээснээ:

-Та үүнийг үнэнээсээ хэлж байна уу? гэж асуув.

Хариуд нь ахмад зөвхөн мөрөө хавчлаа.

-Та ямар зэвсгийн талаар ярьж байна вэ? Та нар миний машинд бууны сум тавьчихсан юм биш биз? гэж Полунин гайхан асуув.

-Үгүй дээ, Владимир Иванович. Бидэнд тэгэх ямар ч шаардлага байхгүй. Өнөөдөр өглөө та “беретта” системийн гар буу хэрэглэснийг бид эд мөрийн баримт болгон хурааж авсан шүү дээ гэж ахмад хэллээ.

Энэ үед Полунин гэнэтхэн өөрийн мэдэлгүй хилэгнэн дэлбэрэх мэт уурлан тэр Первухиныг бариад авмаар санагдлаа. Түүнийг байдаг хүчээрээ ширээ шаахад тавцангий нь зах ховхорч орхив.

-Би тэр бууны чинь хүчээр өөрийн эхнэр хүүхэд найзынхаа амийг аврах гэж оролдсон юм гэж Полунингийн хилэгнэн хашгирахад Первухины хэнэггүй царайд эмээн сандрах өнгө тодорлоо. Полунин үргэжлүүлэн, чи муу цагдаагийн оронцог намайг гэр бүлээ хамгаалах гэж оролдсоны төлөө шоронд хийх гээ юу? Тэгэх тусмаа бүр эхнэр болон найзаа алуулж хагацал зовлон тохиолдоод байгаа энэ өдөр үү? Та нар намайг шоронд хийвэл өнчрөөд байгаа хүү минь хэнтэйгээ үлдэх болж байна? гэж хашгиран асуулаа.

Тэгтэл өрөөний хаалга гэнэтхэн онгойж гурван цагдаа гүйлдэн орж ирмэгцээ гарыг барьж ард нь мушгилаа. Цагдаагийн ахмад уужран санаа алдаад хүзүүгээ эргүүлэн хөдөлгөөд:

-Тайвшир, Владимир Иванович. Ингэж хилэгнэсний хэрэггүй. Бид таныг зөвхөн саатуулж байна. Надад ингэхийг үүрэг болгосон дарга нарын тушаал бас прокурорын тогтоол байна. Ингэснээр таны болон бидний амь насанд аюул багатай байх болно. Энэ хотод юу болж байгааг та харж байгаа биз дээ гэв.

-Юуны учир? хэмээн Полунин ахмад руу дахин хилэгнэн давшлаад, муу новшнууд та нар яагаад намайг цоожтой хаалганы цаана суулгах гээ вэ? Би талийгч эхнэрээ ч оршуулалгүй энэ хотоос зугтаж явах юм гэж үү гэлээ.

Первухин дахин өөрийн мэдэлгүй гэдэргээ ухран хоолой нь зангирч шүлсээ залгиад зангиагаа суллан Полунинг барьж байсан цагдаа нарт хандан:

-Аваачиж хий. Тэнд очоод тайвшраг. Маргааш ярилцъя гэх нь тэр.

Таван минутын дараа Полунин шалнаас дээш хагас метр орчмын өндөрт бэхэлсэн модон наар,, болон бие засах савнаас өөр юмгүй ганцаар хорих жижиг өрөөнд түгжигдэж орхилоо.

Полунин наар руу ядрангуй байдалтай очиж хажуу ирмэг дээр нь суумагцаа зангиагаа суллаж хувцсаа ч тайлалгүй гэдэргээ харан хэвтэж нүдээ анив.

Өглөөхөн нь эхнэр болон сайн нөхрөө ямар ч тусламж үзүүлж чадалгүй алагдахыг хараад орой нь өөрөө баривчлагдан шоронд орох шиг тийм эмгэнэлтэй хувь тавилантай учрах юм гэж тэрээр яагаад ч төсөөлж чадахгүй байсан юм.

Тэглээ ч гэсэн өөрийг нь баривчилсан явдал бол энэхүү эмгэнэлт бөгөөд аймшигт хэргийн зөвхөн нэгэн үзэгдэл биш гэдгийг тэрээр сайтар ойлгож байлаа. Өөрт нь учирсан энэ санаанд оромгүй золгүй явдал, бие мах бодь сэтгэл санааны ядаргаа өөрийн ид шидийг үзүүлж Полунин нойрсох нойрсохгүйн хооронд тарчилж байхад хаалганы түгжээ дуугарав.

Тэрээр тохойгоороо тулан арайхийн өндийгөөд ядарч туйлдсанаас бас нойр муутай хоносноос болж улайж хавагнасан нүдээр онгойж буй хаалганы зүг харахчаан болов. Полунин өрөөнд орж ирж байгаа хүнийг хараад ойлгомжгүй байсан олон асуултынхаа хариуг нэгмөсөн авах шиг болжээ.

* * *

Полунингийн өмнө Сергей Романенков зогсож байлаа. Тэрээр халаасандаа гараа шургуулаад Полунингийн хямралын түвшинг мэдэхийг хичээх мэт түүнийг анхааралтай ширтэж байв.

-Сайн уу, Владимир Иванович гэж тэрээр мэндлээд, миний ирсэн явдалд гайхаж байна уу? хэмээн асуулаа.

-Үгүй, гайхахгүй байна гэж Полунин ядрангуй дуугаар хариулаад, юунд ч юм би чамайг хүлээж байсан мэт санагдана. Гэвч би чамтай тамд уулзвал илүү таалагдах байсан юм гэж эмгэнэн хошигнов.

-Яриа алга хэмээн Романыч мушийн инээмсэглээд, тэнд чинь хэзээ нэгэн цагт уулзаж л таараа. Тамд бидний олон найз нөхөд хүлээж байх болно гэлээ.

-Чи газрын тосны компанийн хувь нийлүүлэгчдийг хэлж байна уу?

-Харин тийм гэж Романыч хэлээд, харин чи бид хоёр компаниа тийш нь аваачиж чадахгүй нь харамсалтай. Тийм учраас түүнийг энэ газар дээрээ хувааж авах нь зүйтэй. Чухам энэ асуудлаар чамтай ярилцах гэж би ирлээ гэв.

Романыч ойртож ирээд Полунинтай зэрэгцэн суулаа. Хойноос нь харж байсан цагдаагийн түрүүч түүн рүү толгой дохиод гарч хаалгыг нь хаан цоожлов.

-Сатаров та хоёр намайг ийш нь хийхийг цагдаа нарт ятгаа юу? гэж Полунин асуув.

Романыч толгой дохисноо:

-Чиний жилийн өмнө мэргэн аргагүй бидний тор руу хийсэн бөмбөлөгийг буцааж өгснөөрөө бид муугүй шавь нар гэдгээ харуулж байгааг чи мэдэж байгаа хойно доо гэж хэлээд тэгэхэд бид хожигдсон. Одоо чиний өөрийн чинь ээлж ирээд байгаа гэдгээ хүлээх хэрэгтэй гэв.

Тэгснээ тэрээр хүрэмнийхээ хажуугийн халааснаас эвхсэн хуудас цаас гарган Полунинд өглөө.

-Юу юм? гэж Полунин цаасыг авах зуураа асуув.

-Бууж өгөх бичиг хэмээн Романыч хэлээд энэ бол чиний болон Самбист бидний компанийн үнэт цаасыг наймаалах гэрээ байгаа юм гэж хариулав.

Полунин тэр цаасыг нь дэлгэж харснаа Романенков руу ёжтой ширтсэнээ:

-Та нар арай бага үнэ тогтоож байна. Үнэт цаасны үнийг арав дахин багасгажээ гэж хэллээ.

-Бүү хошигно, Иваныч. Ийм байдалд орчихоод байгаа чамд наймаалцах гэсний хэрэггүй. Хожигдсон хүнд энэ чинь хүрэлцээтэй их үнэ гэж Романыч хэллээ.

Полунин тэр хуудас цаасыг үг хэлэлгүй буцааж өгөв. Тэгснээ шийдмэг байдлаар:

-Би энэ дайнд хэтэрхий том хохирол амслаа. Та нар надаас бас зоос хожих гэсний хэрэггүй. Үнийг шуударгаар тогтоох ёстой гэж хэлэв.

-Сайн байна. Тэгвэл бид энэ үнийг хоёр дахин нэмье. Түүнээс илүүгүй гэж Романыч хэлэхэд Полунин халааснаасаа тамхиа гарган яаралгүй асааж сорлоо.

-Ямар байна? гэж Романыч дахин асуув. Полунин түүнд эвгүй харц чулуудаад

-Ямар ч юм алга. Тэгж тохирохгүй гээд буруу харав.

-За чи больдоо, Иваныч хэмээн хэлээд Романыч бага зэрэг гайхаж, чиний ар бөгс чинь ямар болоод байгааг чи гүйцэд ойлгохгүй байна. Бидний саналыг хүлээж автлаа чи эндээс гарахгүй. Энэ тоглоомын явцыг бид удирдаж байна. Цагдаа нар ч гэсэн биднийг дэмжиж байгаа. Тийм ээ. Чи тэднийг талдаа авч байсан үе байсан, харин одоо бидний ээлж. Чи одоо бидний гарт ороод байна. Чамд алдчихад хайран юм байгаа гэдгээ өөрөө мэдэж байгаа. Хагас өнчрөөд байгаа хүүгээ бүтэн өнчрөөх гээгүй биз дээ? Тийм учраас бидний өгсөн мөнгийг дуугүй аваад эндээс холдож үз! гэж сүрдүүллээ.

Тэгтэл Полунин тамхиныхаа ишийг шалан дээр нулимж орхиод цахилгаан цахих мэт хурдаар хөдлөн баруун гараараа Романенког барьж аваад хүзүүгий нь базан дарлаа. Тэрээр эсэргүүцэж хөдлөх нь бүү хэл хашгирч ч амжсангүй.

-Одоо чи намайг сонсож бай, гөлөг минь гэж Полунин тайван дуугаар хэлээд хүзүүгий нь атгасан гараа улам чангалав. Романенкогийн нүүр нь зэвхийрч нүд нь ухархайгаасаа гарах дөхөн бүлтийлээ.

Полунин үргэлжлүүлэн, байдал хэрхэн огцом өөрчлөгдөж байгааг харж байна уу, чиний ганцхан буруу алхам, хэлсэн алдаатай үг чинь чамайг эвгүй төгсгөлд хүргэж чадна. Тэгэхлээр хэн маань хэн дээрээ сууж байна. Би чам дээр үү, эсвэл чи над дээр үү. Миний ганцхан хөдлөхөд чамд ямар ч үнэт цаас, мөнгө хэрэггүй болно гэж хорсолтойгоор зандрав.

Романенко айснаасаа болж Полунинг бүлтийн ширтэж өчүүхэн төдий болгоомжгүй хөдөлгөөн түүний хувьд эмгэнэлтэйгээр төгсөж болохыг ойлгож байлаа.

-Яагаад бидний хооронд ямар ч мөнгөний асуудал байхгүйг одоо би чамд тайлбарлаж өгье, өмхий нохой минь. Та нарын тарьсан хэргийн төлөөсийг зөвхөн Сатаров та хоёрын толгойгоор нөхөж болно. Сатаровын толгой эхний ээлжинд байгаа учир би одоо чиний толгойг тасчиж авахгүй байна. Миний хэлсэн энэ үгийг тэр зулбадастаа очиж дамжуул, мэдэв үү? гэж Полунин хилэгнэн зандарлаа.

Романенко үгийг нь хүлээн авч нүдээ сандран анивчуулав. Дараа нь Полунин гараа тавьж мань эрийг заамдан авч угзран хөл дээр нь босгов. Тэгснээ түүнийг хүнд зовлогоороо хаалга мөргөтөл ар ууц руу нь өшиглөж орхилоо. Хэдэн мөчийн дараа өрөөний хаалга онгойж хоёр цагдаа үсрэн орж ирэв. Нэг нь тэр хоёр руу ээлжлэн харж

-Юу болов? гэж яаран асуулаа.

-Энэ хүний бие нь базаахгүй байна. Толгой нь өвдөө юу, эсвэл хамрын ханиад хүрэв үү? Магадгүй ууц нь эвгүйцсэн ч байж болно гэж Полунин хариулав.

Романенков ум хумгүй хонгилд гараад өвдсөн хүзүүгээ илэн бахардаж унах дөхөн:

-За гайгүй дээ. Чамайг номхруулах цаг ирнэ дээ? гэж гонгинов. Полунин шалан дээр хэвтэж байгаа хуудас цаасыг авч Романенковын араас шидэж:

-Май, ноолийн цаасаа ав! гэж зандарлаа.

-Эсвэл чи наадах дээрээ мутраа тавь, эсвэл бид энд чинь чамайг жорлонгийн ус руу хийж орхиё гэж Романенко хашгирав. Тэгснээ тонгойж тэр цаасаа авч хонгилоос гарч явлаа.

Дараа нь цагдаа нар гарч түүнийг дахин ганцаарангий нь орхиж гаднаас нь цоожлов. Тэрээр дахин янжуураа гарган амандаа зуун асаагаад толгойн өвчнөө намжаахын тулд нэг гараараа хөлстэй духаа иллээ.

“Тэгэхлээр Сатаровын ажил. Романенко түүний залуус сургамж авсан гэж хэлдэг нь зөв. Тэд намайг бодвол хол явжээ. Урхийг тун чадварлаг тавьсан байна шүү. Би Сатаровыг тэгнэ гэж санасангүй” гэж Полунин бодсоор суув.

Юутай ч гэсэн Романычийн ууцанд гутлынхаа улыг наах нь одоогоор түүний өөрийн бухимдал гашуудлыг дарахын тулд хийж чадах цорын ганц ажил байлаа. Түүнд энэ эмгэнэлт байдлаас гарч болох боломж бараг байхгүй байв. Самбист болон түүний бүлгийн ихэнх залуус алуулсан. Өөрөө баривчлагдан хоригдож байгаа. Гол нь цагдаагийнхан Сатаровын талд

зогсож байгаа зэрэг нь түүнд ямар нэгэн найдвар төрүүлэхгүй байв. Хэрэв тэрээр тэр бичгэнд гарын үсгээ зурчихвал Сатаров компанийг бүрмөсөн бүхлээр нь эрхэндээ оруулах байв. Хэрэв гарын үсгээ зурахгүй бол тэр одоо хэний ч асрамжгүй байгаа хүүг нь барьцаалан авах болно. Хэрэв тэрээр эрх чөлөөтэй байгаа бол бас ч багагүй асуудлыг шийдэх боломж байсан юм. Гэвч түүнийг эндээс суллахгүй, суллалаа ч гэсэн цаашид амьд явах магадлал багатай. Тэгтэл өрөөний хаалганы цоож дахин дуугарч базаахгүй бодлыг нь саатуулав. Энэ удаа дэд хурандаа Бирюков орж ирлээ.

-Би энэ бүхнийг огт ойлгохгүй байна гэж Полунин хүйтнээр инээмсэглэн дуугараад, энэ чинь нэг хүнийг хорих өрөө юу эсвэл иргэдийг хүлээн авах байр юм уу? Тийм зориулалтаар таны албан газрыг түрээсэлсэн юм гэж би дуулаагүй юм байна гэж асуулаа.

-Та биднээр дэмий тоглоом хийж байна Владимир Иванович гэж Бирюков хөмсөг зангидан хэлээд, асуудал тоглож суумааргүй тун ноцтой болоод байна. Тэгэх тусмаа таны хувьд гэж хариулав.

-За яахав гайхаад байх юм надад алга гэж Полунин дуугараад, түрүүний ирдэг хүн мөн адил миний байдал хүнд байгаа, инээдэм биш ханиад гэсэн. Тэр хүн бүр надад тусламж үзүүлье гэсэн боловч би тэр Самарын “сайхан санаатай” иргэний саналыг хүлээж аваагүйгээр барахгүй далд ор гэсэн юм гэлээ.

-Та хэрэггүй ингэжээ гэж Бирюков хэлээд, түүний санал бүгдэд чинь нийцэх байсан юм. Хотын доторхи мөргөлдөөнийг цэглэх хэрэгтэй гэв.

-Тэр мөргөлдөөнийг би өдөөгүй гэж Полунин дургүйцэн дуугаар хариулав.

-Гэвч та тэр мөргөлдөөнийг зогсоож чадна хэмээн Бирюков тулгаад, түрүүнд би ноён Томашевскийтэй уулзаж ярилцахад танд үнэт цаасны чинь хөлсөнд чамгүй их хөлс төлнө гэж байна билээ. Тэр мөнгөөр та өөр ямар нэгэн хотод бүр болж өгвөл гадаадын ямар нэгэн оронд насныхаа эцэс хүртэл тайван бөгөөд элбэг хангалуун амьдарч чадна гэв.

-Таны наад үг чинь “өөр ертөнцөд” гэх шиг сонсогдож байна гэж Полунин егөөдөн хариулаад, Сатаров Томашевскийтэй тохирсон нь санаанд оромгүй явдал. Тэр хоёр хуйвалдан миний эхнэр, найз нөхдүүдийг минь хүйс тэмтрээд одоо болоход намайг аль хөлс илүү төлдөг түшмэлүүдийн өмнө бөхөлзөж байдаг зусар амьтан болгохыг санаархаж байна гэлээ.

Бирюковын царай бухимдсанаасаа болж зэвхийрэн:

-Таны энэ цагаа олоогүй ёж үгийг сонсож залхлаа Владимир Иванович гуай. Энэ хотод хэмээс хэтэрсэн үймээн самуун, цуст мөргөлдөөн гаргуулахгүй төлөө би өөрөөсөө хамаарах бүх аргыг хэрэглэх болно. Хэрэв та тэр бичгэн дээр гарынхаа үсгийг зурчихвал та маргааш гэхэд эндээс гарч би таныг манай хотоос аль болох хурдан зайлж явахад чинь хяналт тавих болно. Хэрэв гарын үсгээ зурахгүй бол та өөртөө гомдоорой... гэж сүрдүүлж байтал:

-Дарга минь та сонсож бай. Чи энэ өрөөнөөс өөрөө гарч явах уу. Эсвэл би түрүүний “элч” шиг гаргаж өгөх үү? хэмээн Полунин үгийг нь таслав. Дэд хурандаа нуруугаа тэнийлгэн

Полунинг хорсолтойгоор ширвэн хараад шүдээ зуун:

-Сайхан мэдээрэй, новш минь. Би чамд бодох хэдхэн цагийн хугацаа олгоё. Харин маргааш өглөө гэхэд чамайг мужийн урьдчилан хорих өрөөнд аваачна. Тэнд би чамтай шал өөрөөр ярилцах болно гэж сүрдүүллээ. Тэгснээ дороо эргэж шийдмэг алхлан өрөөнөөс гарч явлаа.

Энэ бүх хугацаанд дэд хурандаагийн ард зогсож байсан том биетэй өтгөн хар сахалтай түрүүч Полунин өөд бодлогоширсон харц чулуудсанаа хэлхээтэй түлхүүрүүдээ харжигнуулан хөдөлгөөд өрөөнөөс гарч цоожилж орхилоо.

Полунин цагаа харвал шөнийн гурван цаг арван таван минут болж байлаа. Тэрээр хөлөө агийлган гараа дэрлэн наар дээр хэвтэж бага зэрэг нойр авах гэсэн боловч болсонгүй. Толгойд нь өөрийн болон ялангуяа хүүгийн нь ирээдүйн тухай түгшүүртэй бодол эргэлдсээр байв. Энэ бодол нь өнгөрсөн цагийн гэнэтийн дурсамжаар үе үе тасалдаж байсан юм.

Гурван жилийн өмнө ганцхан удаа гэр бүлээрээ Кавказ очиж байсан билээ. Тэрхүү арван хэдэн хоног Полунинд багагүй уйтгартай санагдаж байсан бөгөөд харин тэр үед гуравхан настай байсан хүү Антон нь одоо тэр тухай эргэж санахгүй байгаа биз. Харин одоо тэр үе нь түүний хүнд хэцүү амьдралын хамгийн жаргалтай өнгөрөөсөн мөч байжээ гэж Полунинд өөрийн эрхгүй бодогдож байв. Тэрээр унтаж чадалгүй элдэв бодолдоо дарагдан эргэж хөрвөөсөөр хэвтгэл хэдийнээ өглөөний таван цаг болж өрөөний хаалга дахин онгойлоо. Өрөөнд түрүүний Бирюковтой хамт байсан өтгөн хар сахалтай бүдүүн эрээс гадна мөрөндөө автомат буу өлгөсөн, өндөр нуруутай, түрүүч цолтой залуу орж ирлээ.

-Босноо, Полунин гэж хар сахалт бүснээсээ гав салгангаа хэлээд таныг өөр газар шилжүүлж байна гэв.

Полунинг босоход гарыг нь ердийнхөөр ард нь бус урд нь бариулж гавлав. Харин автоматтай залуу нь юу ч хэлэлгүй ажиглан зогсож байлаа. Тэр гурав өрөөнөөс гарсны дараа залуу нь:

-Арай эрт байгаа юм биш үү? Машин ирээгүй байна шүү дээ? гэж асуув.

-Нааш нь машин явуулсан гэж жижүүрт утасдсан. Энүүнээс хэдийчинээ эрт салах тусмаа бидэнд амар байхсан гэж хар сахалт нь хариулав. Тэд байшингийн богино хонгилоор явж нэгэн шатанд хүрч ирэх үед залуу түрүүч гэнэтхэн:

-”00”-д орохыг хүсэж байгаа бол энэ хаалга нь байна гээд нэгэн хаалга руу заагаад, дараа нь усаа асгасангүй, бас юу ч гэх юм билээ, дэмий цаг алдах болно гэлээ.

Полунин “00”-д орохыг огтхон ч хүсээгүй байсан бөгөөд бас түрүүч залуугийн энэхүү “халамж” нь сэжигтэй санагдаж байсан боловч тэр өрөөний хаалгыг татан орж явчихлаа. Араас нь сахалт тэр түрүүч дагалдан оров. “00” өрөө нь хоёр бүү хэл ганц хүнд давчидмаар байсан учир автоматчин залуу гадаа нь үлдлээ. Полунин сахалтай түрүүч хоёр хоёулхнаа болмогц тэрээр том алгаа Полунины мөрөн дээр нь тавьж чихэнд нь ойртон,

-Май, энэ гавны түлхүүр. Сэмхэн салгаарай. Хонгилд гараад чамайг суулгах үед зөвхөн би,

автоматтай залуу, шилэн цонхны цаана байгаа зэвсэггүй жижүүр бид гурав л байх болно. Чиний гол зорилго бол залуу түрүүчийг зэвсгээс нь салгах явдал юм. Тэгсний дараа намайг хөнгөн маягаар өшиглөж орхиорой. Тэгээд зам чинь чөлөөтэй болно. Эндээс тавин метрийн зайд чамайг цэнхэр өнгийн “Жигули” хүлээж байх болно хэмээн тамхины эхүүн үнэр сэнгэнүүлэн шивнэх нь тэр.

-Таныг хэн явуулав? гэж Полунин асуутал тэрээр хариу хэлэхийн оронд бүдүүн хуруугаа уруулдаа нааж гавны хоёр дахь түлхүүрийг өглөө. Тэр хоёрын “00”-ын өрөөнөөс гарахад залуу автоматчин хонгилоор сэжиг авсан шинжгүй хойш урагш тайван алхалж байв. Тэд гурвуулаа жижүүрийн хүлээн авах өрөөнд орлоо. Тэр өрөө нь хоёр тасалгаатай гэмээр шилэн ханаар заагласан нэгэнд нь хижээл насны хошууч сууж байв. Хошуучийн эсрэг талын өрөөнд байгаа сандал дээр Полунин болон дагаж яваа түрүүч нар хуваагдан суув.

-За яаж байна, машин чинь тэгээд ирэх нь үү? гэж сахалтай түрүүч хошуучаас асуув. Цаадах нь хариу хэлэхийн өмнө өмхөрсөн шар шүдээ гарган залхуутайгаар эвшээлгээд,

-Утасдаад ирнэ гэсэн гэв.

-Энүүнийг ийм эрт аваачиж ямар чөтгөрөө хийх нь вэ? Хошууч Полунинг ширтсэнээ:

-Тэдэнд чи чухал хэрэгтэй юм байлгүй. Чухал яаралтай ажил чамайг хүлээж байгаа биз гэлээ.

Полунин хариу хэлэлгүй сахалтай түрүүч рүү хартал тэрээр босож жижүүрийн цонх руу очоод

-Степаныч, тамхи байна уу. Минийх дуусчихаж гэв.

-Май, дараа нь хоёр болгоод өгөөрэй гээд хошууч хайрцагтай тамхиа өгөв.

Яг энэ үед Полунин залуу түрүүчид мэдэгдэлгүйгээр гавныхаа нэг талын түгжээг мултлаад гараа чөлөөлөн тэр залуугийн өвдөг дээр байгаа автоматыг харж буу нь хамгаалалтын түгжээндээ тавиастай байгааг мэдэж авав. Энэ агшинд сахалтай түрүүч хөгшин хошуучийн өгсөн тамхийг авахаар гараа сарвайхдаа өөрийн том биеэр хошуучийн харааны хүрээг таглаж өглөө.

Полунин баруун гарынхаа огцом хөдөлгөөнөөр баруун талд нь сууж байсан автоматчины чамархай руу нударга зангидан буулгаж орхиод зүүн гараараа бууны гол төмрөөс атган мөрнөөс нь мулт татан авлаа. Тэгснээ ухасхийн босож алганыхаа ирмэгээр залуугийн хүзүү рүү цохиж муужруулан унагаалаа. Ард чимээ гарахад сахалтай түрүүч эргэж харсан боловч гэдэс рүүгээ өшиглүүлжээ. Полунин өшиглөлтийн хүчээ сааруулсан боловч сахалт түрүүч эвхрэн нүүрээ шаланд наан унаж орхилоо. Балмагдсан хошууч утсаа шүүрэн автал Полунин:

-Бүү хөдөл! хэмээн зандарч автоматын амыг түүн рүү чиглүүлэв. Цагдаа өвгөн нэгэнд нь хайрцаг “Цагаан далайн суваг” бариастай хэвээр хоёр гараа дээр гэгчийн өргөхөд толгой руу нь тамхиууд цувран асгарч унах нь харагдана.

Полунин гарах хаалганд хүрч дугуу онгойлгон гадагш харвал гудамжинд амьд амьтан үл үзэгдэнэ. Гадаа дөнгөж үүр цайж байв. Тэрээр хаалгыг нь саван хааж сахалт түрүүчийн заасан зүг рүү байдаг хурдаараа харайлгалаа. Тавиад метрийн зайд нөгөө цэнхэр өнгийн “Жигули” үнэхээр зогсож байх бөгөөд дотор нь нэгэн эрэгтэй хүн сууж байх ажээ.

Полунин машинд дөнгөж үсрэн ормогц тэр хүн газраа огцом гишгэн магадгүй нэгэнт түгшүүр зарлан түргэн авчихаад байгаа цагдаагийн хэсгээс өндөр хурдтай давхин зайллаа. Хотын гурав, дөрвөн дүүрэг өнгөрмөгц тэр эр нэгэн булан тойрч гараад машинаа огцом тоормозлон зогсоож

-Түргэл! Миний араас! гэж тушаав.

Тэр хоёр машинаас гарч эсрэг талын гудамжинд гүйж гараад тэнд хүлээж байсан салхины өнгөт шилэн цонхтой өөр нэгэн “Волга”-д орж суулаа. Тэгснээ нөгөө хүн тэр даруй удирдлагын самбарт суурилуулсан цэнхэр өнгийн гэрлэн дохиог авч цонхоор гараа гарган бүхээгэн дээр тавьчихлаа.

-За боллоо. Одоо биднийг зогсоогоод байх нь юу юм? хэмээн жолооч эр царгиа дуугаар хэлээд машинаа зугуухан хөдөлгөв.

Полунин одоо л нэг юм өөрийн дагалдагчийг тайван харах боломжтой боллоо.

Энэ бол өндөр туранхай биетэй анхааралтай цэнхэр нүдтэй үсээ нямбай засуулсан эелдэг байрын царай бүхий дөч орчим насны гэмээр харьцангуй залуу эр байлаа. Тэрээр шаргал өнгийн зуны костюм цагаан цамц өмсжээ. Тэр хүн Полунин руу нэг ч удаа харахгүй зөвхөн урдахь замаа ширтэн суух боловч өөрөөс нь мөчийн төдий ч анхаарлаа салгахгүй байгааг Полунин мэдэж байв.

-Надад ямар нэгэн асуулт тавих боломж байна уу? гэж Полунин сонирхлоо.

-Зөвхөн хамгийн ерөнхий асуулт байж болно гэж тэр эр хариулав.

-Тэгвэл уучлаарай. Би хэнтэй харьцаж байгаагаа мэдэхсэн болов уу?

-Николай Ивановичтай.

Полунингийн нүүрэнд егөөтэй инээмсэглэл тодрон:

-Петр Петрович эсвэл Григорий Григорьевич гэвэл дээргүй юу? гэж асуучихав.

-Намайг үнэхээр Николай Иванович гэдэг.

-За яахав. Тийм болог. Тэгвэл Николай Иванович минь, та юу хийдгээ, энэ бүхэн танд ямар хэрэгтэй юм гэдгээ надад тайлбарлаж өгнө үү?

-Би танаас дэлгэрэнгүй асуулт тавихгүй байхыг хүссэн шүү дээ хэмээн тэр хүн үрчийж хэлээд, энэ асуулт чинь хэтэрхий нарийвчилсан хариулт өгөхийг шаардана. Гэвч би товчхон

хариулахыг оролдоё. Жишээлбэл ингэж би өнөөдрийн энэ хэмээс хэтэрсэн эмх замбараагүй байдлыг үзэн ядаж боломжийнхоо хэрээр тэмцэж байдаг хүн. Өнөөдөр харин зарим боломж олдож байна гэлээ.

-Та тэгвэл энэ байдалтай ажил үүргийнхээ хувиар тэмцэж байна уу, эсвэл өөрийн хувийн санаачилгаар уу? хэмээн Полунин асуулаа.

-Аль алинаар нь. Өөр юу сонирхож байна? гэж тэр хүн хариуллаа.

-Намайг оргуулах нь танд ямар хэрэгтэй юм бэ? хэмээн Полунин асуув.

-Та тэртэй тэргүй шоронгоос гарч чадахгүй байсан юм гэж Николай Иванович хариулаад, ямар ч байсан ойрын хэдэн жилд. Тэгэхлээр энэ чинь таны хувьд ер нь гарч ирэхгүй гэсэн үг. Таныг шоронд хийх гэсэн хүмүүс бол тэгж зохион байгуулна гэсэн үг. Эрх чөлөөтэй бусдын хараат бус бид чинь тэдэнд аюултай хүмүүс юм гэв.

-Тэгж бодох ямар үндэслэл байгаа юм?

-Та сонсож бай, Владимир Иванович. Юм ойлгохгүй дүр бүү эсгэгтүн. Би таныг сайн судалж мэдсэн юм. Та бол чадварлаг бөгөөд ухаантай хүн учраас өөрийгөө ямар байдалд ороод байгаагаа мэдэхгүй байхын аргагүй. Тэд ямар ч нөхцөлд таныг шоронд хийж таны Сеницын болон өөрийн хувьцааны тасалбарыг өгтөл тэндээс гаргахгүй. Таны дайснуудын нэгэн адил бид Сеницын та хоёрын нэг чинь нас барвал өөрийн хувьцааг үлдсэндээ өвлүүлэн үлдээх гэсэн гэрээтэй гэдгийг мэдэж байна гэж Николай Иванович тайлбарлав.

-Тэгэхлээр танд миний хувьцаа дайснуудын минь нэгэн адил сонирхогдож байгаа гэсэн хэрэг үү? Гэтэл та шударга хэргийн төлөө тэмцэгч гэж өөрийгөө танилцуулсан.

-Тийм ээ. Нэгд шударга хэргийн төлөө тэмцэхэд мөнгө мөн адил хэрэгтэй хэмээн Николай Иванович ноцтой өнгөөр дуугараад, хоёрт, хувьцаа бол бидний сонирхож байгаа нэн тэргүүний зүйл ч биш. Зүгээр л газрын тосны “Аркада” компанийн эргэн тойронд болж байгаа үйл явдал энэ хотын болон түүнээс гадна байгаа олон хүний сэтгэлийг зовоож бас сонирхлыг нь татаж байгаа юм. Далиманд хэлэхэд өнгөрсөн шөнө тэр компанийн захирлуудын зөвлөлд шинээр өөрчлөлт гарсан гэж тэрээр ярилаа.

Полунин өөрийн ярилцагчаа анхааралтай ширтсэнээ:

-Ямар өөрчлөлт гараав? гэж асуулаа.

-Коля Решето алагдсан гэж Николай Иванович хариулаад тэрээр шөнийн хоёр цагийн орчимд баарнаас гарч яваад мэргэн буучийн суманд өртсөн. Алуурчин мэргэжлийн хүн байсан бололтой. Тэр мэргэн буучийн винтовоор толгойг нь алдалгүй оносон байсан гэнэ билээ. Мэдээж ийм тохиолдолд бууг нь олсон боловч алуурчинг олоогүй аж гэв.

Полунин өөрийн ярилцагчийн мэдээллийг юу ч хэлэлгүй хөмсөг зангидан сонсож суулаа. Тэгсний эцэст дуугарч:

-Одоо бид хаашаа явж байна? гэж асуув.

-Удахгүй та мэдэх болно гэж Николай Иванович хариулаад, бүү санаа зов, бүх юм хэвийн. Та найдвартай хүмүүстэй хамт байгаа гэлээ.

Полунин гэнэтхэн эргэн тойрноо ширвэн харснаа түүнд хандан:

-Машинаа зогсоо гэлээ.

-Яагаад? Бид очих газраа хүрээгүй байна гэж тэр хүн Полунинг хялайн харж хэллээ.

-Хоёр удаа би давган хэлэхгүй гээд Полунин өвөр дээрээ байсан автоматын түгжээг мултлав.

Николай Иванович хоёр удаа давган хэлүүлдэггүй хүн байсан бололтой машиныг огцом тоормозлон явган хүний замд шахан зогсоолоо.

Тэд нэвт гарсан хаалга хонгилууд элбэгтэй хоёр, гурван давхар байшингууд голдуутай хотын нэгэн хуучин дүүрэгт хүрч ирээд зогсож байв.

-Цааш би өөрөө явна гэж Полунин машины хаалгыг онгойлгох зуур дуугарлаа.

-Өөрөө л мэд. Дараа нь бүү харамсаарай гэж түүний дагалдагч хүйтнээр сануулаад, бид танд туслах гэсэн юмсан гэлээ.

-Баярлалаа. Би өөрөө хичээе гээд Полунин машинаас нэгэнт гарч байхад нь

-Алив, хүлээж бай гэж Николай Иванович хэлж түүнийг зогсоолоо.

Тэгснээ пиджакныхаа энгэрийн халааснаас хатуу цаасан дээр зөвхөн утасны дуугаар бичсэн өөрийн нэрийн хуудсыг хоёр хуруугаараа нямбай сугалан гаргаж Полунинд өгөөд

-Энүүнийг авна уу? Аюулгүй болсныхоо дараа энэ дугаараар яриарай. Надад тантай ярих зүйл байна гэв.

Полунин нэрийн хуудсыг нь авч халаасандаа хийгээд богино голтой автоматаа пиджакан дотроо нуусаар ойрхон байх байшингийн хонгилоор гарч явав. Таван минутын дараа тэрээр хэд хэдэн хонгил өнгөрөн нэгэн гудамжинд гарч утасны автоматын бүхээгэнд ороод хэрэгтэй дугаараа эргүүлэн:

-Шакирыч, би байна. Хоёрдугаар засварын газарт яаралтай уулзъя. Араас чинь “сүүл” дагаж магадгүй. Анхааралтай яваарай гэв.

Зургаадугаар бүлэг

Хотын баруун хойд дүүрэгт хувийн гараашийн салаалсан байрууд олон байдаг ажээ. Энэ нь өөрийн гудамж талбай нэг буюу хоёр давхар тоосго, бетонон хавтан, төмөр зэрэг материалаар баригдсан байруудаас бүрдсэн бага хэмжээний хот маягийн дэд бүтэц бүхий дүүрэг юм. Хоорондоо ханаар тусгаарласан тийм хоёр гарааш Полунинд байдаг байлаа. Энэ гарааш нь агуулах болон хамгийн гол нь хулгайлагдсан машиныг хадгалах байр болдог байв.

Чухам ийш нь тэдний хулгайлсан машиныг авчирч өөрчлөн тоноглоод худалддаг байв. Гарааш нь сайн тоноглогдсон бөгөөд зөвхөн Шакирыч, Болдин хоёр ажилладаг техникийн үйлчилгээ хийдэг жижгэвтэр газартай төстэй байлаа. Гэвч энэ нууц станц анхныхаа зориулалтаар ажиллаагүй уджээ. Энд их биш хэмжээний сэлбэг материал зэргийг хадгалдаг болсон байв.

Саатуулсан цагдаагийн газраас зугтаж гарсныхаа дараа чухам энэ газраа Полунин хоёр дахь удаагаа Шакирыч, Болдин нартай уулзахаар ирсэн байлаа. Полунин зугтаж гарсныхаа дараахан тэдэнтэй энд анх удаагаа уулзсан ажээ. Түүнээс хойш арван өдөр өнгөрчээ. Зөвхөн энэ арван өдөр өнгөрсний дараа Полунины нуугдаж байсан энэ гараашид Шакирыч, Болдин нар хүрэлцэн иржээ. Полунин нөхдүүдээ гараашийн байранд оруулаад хаалгаа түгжсэний дараа,

-Араас чинь ямар нэгэн ажиглалт байгаагүй гэдэгт итгэлтэй байна уу? гэж шууд асуув.

-Итгэлтэй байна гэж Шакирыч хариулаад, ажиглалт хийхээ зогсоосноос хойш хэдийнээ хоёр гурван өдөр болж байна.

-Тийм ээ гэж Болдин батлан хэлээд чиний зугтаж гарсан анхны өдөр нэг алхам ч явахыг андахгүй мөрдөж байсан юм. Мөн цагдаагийн газраас дуудаж чамайг хаана байгааг байцааж байсан. Харин зодож тамлаагүй шүү. Бид ингэж байгаад чиний байгаа газрыг зааж өгнө гэж бодсон бололтой. Миний утас ч гэсэн одоо хүртэл чагнагдаж байгаа гэж бодож байна. Тэд чамайг барьж авахын тулд хичнээн их мөнгө зарж байгааг чи төсөөлж байна уу Иваныч минь? гэж ярилаа.

-Тэгэхлээр асуудал ойлгомжтой. Би ч чамгүй үнэд хүрч байгаа бололтой гээд Полунин инээд алдав.

-Харин Анна, Синицын нарыг оршуулсны дараа бидний хойноос ажиглалт хийх нь багасаж ирсэн юм гэж Шакирыч мэдэгдээд магадгүй тэд чамайг хотоос зайлж явсан гэж бодсон ч байж болно гэлээ.

Оршуулгын талаар сонсоод Полунины нүүрээр гашуудлын сүүдэр тусаад авах шиг боллоо. Үүнийг ажигласан Болдин яаран

-Иваныч минь, сэтгэлээ чанга барь. Чи оршуулгад очоогүй чинь зөв байсан. Тэнд чинь отолт хийж оршуулгын газрыг бүсэлчихээд чиний ирэхийг тун их хүлээж байсан юм гэж онцлон хэллээ.

Шакирыч Полунингийн хажууд дунд зэргийн багтаамжтай аяны цүнх гаргаж тавиад,

-Энд замд хэрэглэх юм цэвэр дотуур хувцас, ор хөнжлийн ээлжийн даавуу, чиний хэлсэн хэмжээний мөнгө байгаа. Мөнгийг би өөрсдийн дундын хөрөнгөнөөс авсан гэж хэллээ.

Полунин нөхдийнхөө авчирсан цэвэр хувцсыг тэр даруйд нь солин өмслөө. Энэ бол хүний нүдэнд содон тусахааргүй жирийн хийцтэй өмд цамц байв. Бас бүдүүн ширхэгтэй даавуун зузаан хүрэм байв.

-Дулаан хувцас хэрэггүй гэж Полунин хэлээд, би хамгийн хэрэгтэйг нь мөнгө, бууны хамтаар авья гэлээ. Болдин цамцныхаа дотуур гараа шургуулан гар буу “ТТ” гаргаж Полунинд өгөв.

Полунин гар бууг авч өмднийхөө тэлээнд хавчуулаад шаардлагатай хувцас, гурван боодол долларын дэвсгэрт, боолттой хүнсний зүйл, халуун сав зэргийг цүнхэнд хийлээ.

-За тэгээд замд гарахын өмнө хэдэн мөч сууцгаах уу? гэж Шакирыч хэлээд засварын сандлын хажууд байсан модон хайрцаг дээр суулаа.

Полунин Болдин нар сандал дээр сууцгаалаа.

Шакирыч цүнхнээсээ лонх архи хуванцар аяга гаргаж ирээд архиа аягалан нөхөдтэйгөө тулгаад

-Алив Иваныч бага зэрэг гэв. Тэд аягатай архиа ууж, Шакирычийн авчирсан зуушнаас амссаны дараа Полунин

-Антон яаж байна? гэж асуув.

-Зүгээр хэмээн Шакирыч хариулаад миний эмгэнтэй хамт гэртээ сууж байгаа гэлээ.

-Би чамаас хичээнгүйлэн гуйх юм байна гэж Полунин хэлтэл Шакирыч яаран дохиж үгийг нь таслан-Хүүгийнхээ төлөө бүү санаа зов. Би түүнийг ямар ч тохиолдолд орхихгүй гэв.

Полунин Болдин руу эргэж хараад:

-Би чамд бас их найдаж байна. Одоогийн хялбар бус нөхцөлд чи өөрсдийнхөө бизнесийг ганцаараа хариуцах боллоо. Энэ хотод бидний нөхдөөс цөөхөн хүн үлдсэн. Үлдсэн нь ч гэсэн айж болгоомжлон чамд туслах гэж яарахгүй болсон. Тийм учраас чамд ажиллахад тийм ч хялбар бус болсон гэж захилаа.

-Ойлголоо Иваныч. Ямар ч гэсэн хөл дээрээ тогтох л болно гэж Болдин хариулаад, хүнд асуудлуудтай анх удаагаа тулгарч байгаа биш. Харин чи өөрийн төлөвлөгөөг бидэнд хэлэх юм биш үү? гэж хүслээ.

-Славка минь одоогоор надад төлөвлөсөн юм юу ч байхгүй гэж Полунин уйтгартайгаар дуугараад, одоогоор миний зорилго бол энэ хотод тайван болтол хүлээж нуугдах явдал юм. Дараа нь юм төлөвлөх болно. Энэ утгаар бол та нар надад туслах ёстой болж байна. Энд юу

болж байгаа тухай мэдээлэл надад хэрэгтэй болно. Харин чи шинэ гар утас худалдаж авсан уу? хэмээн Шакирычаас асуув.

-Тийм ээ. Энэ дугаар нь байна? гээд Шакирыч тоо бичсэн цаас түүнд өгөөд, энэ дугаарыг би хөндлөнгийн үл таних хүнээс авсан учир хэн ч мэдэхгүй. Энэ дугаараар зөвхөн та хоёр л утасдаж болно. Бид хоёр чамд өөрөөр яаж тусалмаар байна?

-Та хоёр зөвхөн хоёр зүйлээр л надад тусална. Хүүгийн минь асарч хамгаалж байх. Мэдээлэл цуглуулах.

-Чи чухам юуны талаар тодорхой мэдээлэл авах гэсэн юм бэ? гэж Шакирыч асуув.

-Би радиогоор ярихыг сонслоо хэмээн Полунин жижгэвтэр хүлээн авагч руу толгой дохиод, хөлсний алуурчид урьдын адил хулгайн машинаар ажиллагаагаа явуулж байна. Нэг нь саарал “9” нөгөө нь ухаа шаргал өнгийн “8” байсан бөгөөд номеруудыг нь өөрчилж дарсан байсан. Өөрөөр хэлбэл өмнө нь хулгайлагдсан машинууд байсан гэж цагдаагийн газраас ярьж байна гэлээ.

Шакирычийн жижигхэн нүд улам онийж бодлогоширсноо:

-Тэд манайхаас гарсан машинууд гэж чи хэлэх гээ юу? гэж асуув.

-Тун төстэй. Бид нэлээд хэдэн “жигули”-ийн захиалга авсан. Тэр машинуудыг нэгэн Кавказын иргэн захиалж Ваня Лаптев зуучилж өгсөн. Тэр хүнийг чи мэдэх ёстой.

-Мэдэлгүй яах вэ? хэмээн Шакирыч хэлээд, Север гэдэг тосгонд түүний засварын газар байдаг гэв.

-Би Лаптевтой харьцаж ажиллахгүйг хичээсэн. Чи өөрөө мэдэж байгаа шүү дээ. Өөрийн хотод хулгайн машиныг зарах нь бидний ажиллагаанд тохирохгүй. Тэгээд ч “Жигули” бидний гараар тийм ч элбэг ордоггүй. Тийм учраас энэ саарал “Жигули-9” ухаа шаргал “Жигули-8”-ыг би санаж бана гэж Полунин тайлбарлав.

-Би одоо яах ёстой вэ? Ваня Лаптевт очиж төмсөгнөөс нь барьж авах уу? гэж Шакирыч асуув.

-Үгүй хэмээн Полунин толгой сэгсрээд тэгж болохгүй. Энэ машинууд мөн эсэхийг урьдаар шалгах хэрэгтэй. Ингэхийн тулд АШБ газрын Крикуновг миний нэрийн өмнөөс ханд. Тэр бол сайн хүн. Машиныг шалгаж үзэхийг зөвшөөрнө байх гэж бодож байна гэлээ.

-За тэгье гээд Шакирыч толгой дохив.

Полунин Славкийг ширтсэнээ:

-Чи Соловейчик руу ярьсан уу? гэж асуулаа.

-Утасдсан, гэрт нь очсон. Тэр еврей газрын ангалаар орчихсон мэт олдохгүй байна. Үйлдвэр дээрээ очоогүй гэнэ. Гэр рүү нь ярих гэхэд утсаа авахгүй байна. Очиход хаалгаа онгойлгож

өгсөнгүй гэж Болдин дурамжхан хариу хэлэв.

-Чөтгөр гэж. Бас нэг юм болоо юу? гэж Полунин бухимдан дуугарлаа.

-Түүнийг барьж авсан гэдэг ч гарцаагүй байх. Харин яагаа бол?

-Сайн ч юм болоогүй байх даа гэж Славка дурамжхан дуугарлаа.

-Ямар ч байсан эрлээ үргэлжлүүл, би Гришад юу тохиолдсоныг мэдмээр байна гэж Полунин тэднээс хүсээд тэр хүн бол “Аркада” компанийн дөчин таван хувийн хувьцааг эзэмшигч “Солоком” пүүсийг үүсгэн байгуулагчдын нэг юм. Би тэр хуйвалдагчдын гараас мултарч гарсны дараа тэд хамаг анхаарлаа Гришад шилжүүлсэн байх ёстой. Бас ноён Серегинагийн хувь заяа надад сонирхогдож байна. Тэрээр захирлуудын зөвлөлд Коля Решетогийн талыг төлөөлж суудаг байсан бөгөөд хууль ёсоор манай компанийн хувьцааны арван хувийг эзэмшдэг юм гэлээ.

-Тэгье, Иваныч минь гэж Шакирыч хэлээд, харин чи одоо хаашаа явах гэж байгаагаа хэлээч гэж шаардав.

-Төрсөн нутаг руугаа гэж Полунин хариулаад, Тарасов орно. Тэнд бас надад туслах нөхөд байгаа гэв.

-Чи Изе Либерзонийн тухай ярьж байна уу? гэж Шакирыч асуулаа.

-Тэр ч байж болно. Гэвч чи энэ талаар мэдэхгүй байх чинь дээр дээ.

-Тэд биднээр оролдох нь юу л бол гэж Болдин дуугараад тиймгүй бол аль хэдийнээ оролдож эхэлсэн байхсан. Биднийг халуун зуухан дээр суулгаж дуртайгаа хэлүүлэхсэн. Тэдний дунд ямар нэгэн юм болсноос болж чи тэдэнд хэрэггүй болсон биз. Ямар ч байсан чи тэдэнд онц хэрэгтэй биш болсон байх гэв.

Хэдэн хором гурвуулаа Болдины ярьсныг эргэцүүлэн дуугүй сууснаа гэнэтхэн Полунин бүх бодлоосоо салах мэт хөдлөн хайрцган дээр тавиастай шилтэй архины үлдэгдлийг аяганд хиймэгцээ өөрийнхийгөө өргөн:

-За яахав. Сүүлчийнхийг нь тогтоочихье. Хөдлөх цаг боллоо гэлээ.

Полунин аягатайгаа хөнтөрч орхиод шийдмэг байдлаар босож байрныхаа доторхийг ширвэн хараад цүнхтэй юмаа авч хаалга чиглэн шалмаг алхлав. Шакирыч Болдин нар араас нь дагалаа. Тэд хэдэн гараашны гудмыг өнгөрөөд Шакирыч Болдин нарын сууж ирсэн хуучивгар “зургаа” хүрч ирлээ.

Шакирыч, Болдин нар Полунинг хотын захын АШБ газрын шалгах постны ойролцоох хүртэл газар хүргэж өгөв.

-Цаашаа би өөрөө явган явна гэж Полунин машинаас буух зуураа хэлэхэд Шакирыч Болдин нар дагалдан гарлаа. Шакирыч Полунинг нөхөрсөгөөр тэвэрч

-Бүү алга болчихоорой доо, Иваныч гэв.

-Би ч бүх насаараа алга болчих ажил хийж яваа хүн дээ гэж Полунин өөрийгөө цохон хариу хэлээд Славкийн мөрийг нөхөрсөгөөр алгадаад эргэж хотоос гарах зам чиглэн алхаллаа. Тэрээр АШБ газрын шалгах постыг тойрон гарч хотын захын хорооллын ажилчдын голдуу байшин барилгыг өнгөрөн их замд орлоо. Тэндээ замын машин зогсоох гэж нэлээд удаан зогсож байгаад нэгэн “Камаз” зогсоход жолоочоос нь би Тарасовын зүг явах гэсэн юм. Суугаад дөхөж болох уу? Би хөлсийг нь төлнө гэж гуйв.

Жолооч хажуу дахь хоосон суудал руугаа толгой дохиод

-Суу, суу. Харин би Тарасовын замын дундаас хойшоо эргэнэ. Тэндээс өөр машин олж суугаарай гэлээ.

Полунин машины бүхээгэнд авиран орж ядарснаасаа болж суудлыг нь налан суулаа. Шөнө болох дөхөн бороо дусалж эхэлсэн боловч машины бүхээгэнд тохилог бөгөөд дулаахан байлаа. Жолооч нь үг цөөнтэй хүн бололтой бөгөөд зөвхөн хөгжим тавьж явах нь Полунинд таалагдаж байсан юм. Тэрээр нүдээ аньж хэсэг хугацааны дараа машины өлгийдөх мэт хөдөлгөөнд сатааран унтаж орхижээ.

* * *

Шөнө орой болж байхад хотын гаднах төв замаар ар араасаа давхиж явсан хоёр гадаад хийцийн машин зэрэг шахам тоормозлон хурдаа хасаж хажуу тийшээ эргэн хөдөөний шороон замд ороод ойн гүн рүү чиглэн явлаа.

Эхнийх нь хар хөх “Вольво-740”, арынх нь мөнгөлөг өнгийн “Мерседес 600” байв. Машиныуд нэг их удалгүй явсаар нэгэн ойн цоорхойд ирж зогслоо.

“Мерседес”-ийн арын суудалд сууж явсан үйлдвэрлэлийн “Томотекс” бүлэглэлийн ерөнхийлөгч Томашевский хажуудаа суугаа хав халзан толгойтой том гэгчийн нүдний шил зүүсэн шалмаг байрын жижигхэн биетэй дөч орчим насны эрд хандан:

-Юрий Михайлович бид хүрээд ирлээ. Манай түншид яах ёстойг очиж тайлбарлаж өгнө үү гэв.

-Би биш харин танай харьяаны хүн тайлбарласан нь дээр юм биш үү гэж жижиг эр татгалзаад, би бол мужийн өмчийн санд бага биш тушаалтай улсын алба хашиж яваа албан ёсны хүн гэв.

-Тэгэх тусмаа. Албан үүргийнхээ дагууд очиж тайлбарлана уу гэж Томашевский таагүй өнгөөр дуугараад, Леонид Петрович танд туслах болно гэлээ.

“Мерседес”-ийн урд суудалд сууж явсан Томашевскийн зөвлөх Леонид Петрович бол өндөр нуруутай гөлгөр царайтай залуу ажээ. Тэрээр шефийнхээ хэлснийг сонсмогц омгорхоогоор инээмсэглээд машинаас гарч “Вольво” руу чиглэн алхав. Жижиг биетэй түшмэл дуртай

дургүй машинаас гарч өөрийн лакдсан шаахайгаар ойн цоорхойн зөөлөн хөрсийг итгэл муутай гишгилсээр залуугийн араас “Вольво” руу хүрч очлоо.

“Вольво” машины арын суудалд хоёр булиа гэгчийн залуусын дунд өөр хэн ч биш саяхан алагдсан Николай Решетовын итгэмжлэгдсэн хүн хувь нийлүүлсэн нийгэмлэг “Аркада”-ийн хувьцаа эзэмшигч ноён Серегин сууж байлаа.

Юрий Михайлович машины хагас онгойсон цонхоор шагайн түгдрэн байж:

-Ноён Серегин манай шеф таны газрын тосны “Аркада” компанийн хувьцааг өөртөө худалдан авах тухай албан ёсны санал тавьж байна. Наймааны хэлэлцээр танд маш өндөр ашиг өгөх болно. Та хувьцаагаа бидэнд худалдаалснаар ямар ч аюулгүй үлдэх болно. Таны оронд би байсан бол үг дуугүй зөвшөөрөхсөн. Тэгэхгүй бол бид таныг өөр газар шилжүүлэн суулгаснаар та ихэд харамсах болно гэж сүрдүүллээ. Серегин нүүр зэвхийрэн

-Би эсэргүүцэж байна! Энэ бол хууль бус хэрэг! гэж балмагдаж хилэгнэн хариулав.

Цагийн өмнө хоёр талд нь суугаа энэ бух шиг хоёр залуу түүнийг өөрийн нь машинаас чирэн гаргаж энэ “Вольво” руу чихэж орхиод ийш нь авчирчээ. Нааш нь авчрах замдаа тэр хоёр залуугийн нэг нь түүнийг ямар нэгэн үйлдвэрийн хувь нийлүүлэгчдийн хуралд аваачижээ явна гэсэн утгатай ойлгомж муутай юм хэлсэн ажээ.

Серегин түүний хэлснийг тааварласан бөгөөд хэзээ нэгэн цагт түүний хувьцааг хүч түрэмгийлэн авахыг оролдоно гэдгийг нэлээд эртнээс мэдэж байсан боловч өнөөдрийнх шиг ийм гэнэтийн болхи арга хэрэглэнэ гэж огт бодоогүй байсан юм. Решетовын алагдсаны дараа тэрээр хэдэн хоног зусландаа очиж нуугдан сууж байсан юм. Гэвч тэрээр бага зэрэг тайвшран сүүлийн үеийн мэдээ сонирхоод хот орж “Арлекино” ресторанд хүрч ирэхэд нь тэд араас нь дагаж явжээ. Түүнийг рестораны ойролцоох зогсоолд машинаа дөнгөж тавимагц дэргэд нь “Вольво” зэрэгцэн ирж зогсоод энэ хоёр булиа залуу гарч ирээд баривчилсан байна.

-Та нар ингэж ажиллаж болохгүй гэж Серегин дахин дуу алдан хашгираад нарийн алтан хүрээтэй нүдний шилээ засаж, энэ наймаа чинь хууль бус болно. Албан ёсны хуулийн дагуу үйлдсэн хэлэлцээр байх ёстой. Би үүнийг нягтлан бодогчийн хувьд хэлж байна гэв.

Лонид Петрович хүйтнээр инээмсэглээд:

-Ноён Серегин, би ч гэсэн эдийн засагчийн боловсролтойгоос гадна бас хуулийн мэргэжлийн хүн. Ийм учраас бид бүгдийг бодож боловсруулсан. Бидний энэ уулзалт бол байгаа газар нь ийм болохоос биш хууль зүйн хувьд ямар ч зөрчилгүй. Энд худалдан авагч худалдагч болон бидний наймааг бүртгэн авч бүрэн хүчинтэй болгох үүрэгтэй хөрөнгийн сангийн төлөөлөгч бас ирээд байна гэлээ. Серегин бухимдан уруулаа хазаж Томашевскийн зөвлөхийн үгийг сонсож сууснаа дээд зэргийн хорсолтойгоор дуу алдан:

-Би та нарын саналыг зөвшөөрөхгүй. Би ямар ч хэлэлцээрт гарын үсэг зурахгүй. Та нар намайг хэдэн хэсэг болгон тасчиж хаялаа ч гэсэн та нар юу ч олж авахгүй гэлээ.

-За та боль. Илүү юм бүү дуугар гэж зөвлөх хөмсөг зангидан зандраад та ойлгох ёстой. Энэ санал бол хүлээж авахгүй байж боломгүй зэрэглэлийн хүмүүсийнх гэж сүрдүүлэв. Тэгснээ нөгөө хоёр залууд дохио өгөөд бага зэрэг холдон тэдний жижигхэн бүдүүн Серегинийг хэрхэн машинаас чирэн гаргаж байгааг хорсолтойгоор инээмсэглэн харж байлаа. Серегин улайран эсэргүүцэж нэг дээрэмчинг нь хөлөөрөө өшиглөхийг оролдож байтал тэдний тэвчээр алдагдаж нэг нь гэдэс рүү нь нударч орхилоо. Энэ цохилт нь Серегинийг эвхрэн бөхийж нүд нь бүлтийж хэдэн хором зогсоход бүрэн хүрэлцэхүйц байв. Энэ үед нөгөө дээрэмчин нь Серегиний тэлээг тайлан түүний биенээс өмд болон трусикийг нь шувт татан тайлж орхив.

Газрын тосны хувь нийлүүлэгчийн улаан ягаан өнгийн будагтай даруухан “өрөөний” хаалга онгойж бүгдэд ил харагдах нь тэр.

-Юрий Михайлович Серегиний өгзөг, Томашевскийн туслахын нүүрийг ээлжлэн харж гайхсандаа нүд нь бүлтийн:

-Та нар ингэж яах нь вэ? Тэд түүнийг... гэж дуу алдтал:

-Үгүй, үгүй гэж Леонид Петрович яаран хэлээд, энэ бол таны бодож байгаагай огт адилгүй. Түүнийг өөр газар суулгана гэж амласан шүү дээ гэлээ.

Энэ үед нөгөө хоёр булиа дээрэмчин Серегиний хонго тохойноос нь барьж өргөөд ойролцоох байсан нэгэн модны хатсан хожуул руу авч ирлээ. Хажууд нь хүчтэй салхинаас болж хугарч унаад хатчихсан мод хэвтэх бөгөөд хугарахдаа хожуулдаа жад мэт хурц үзүүрүүд гаргажээ. “Иогуудад” зориулсан энэ сандал руу хөөрхий аз нь харьсан Серегинийг авчирлаа. Тэрээр яах гэж байгааг нь ойлгомгоцоо:

-Үгүй ээ, хэрэггүй ээ, ёо, ёо ээжээ! хэмээн орилов.

Гэвч тэр тамлагчид түүний орилохыг юмын чинээ бодсонгүй огцом хөдөлгөөнөөр энэхүү тамын суудалд суулгаж орхих нь тэр. Серегиний булбарай зөөлөн өгзөгөнд эхний “жад” орох үед газрын тосны “Аркада” компанийн үнэт цаасны асуудал шийдэгдчихлээ.

Юрий Михайлович Серегинд дөхөж очоод гэрээний бичигтэй хавгасыг нээж үзэг өгөв.

Серегин түргэн зуур салганан байж бүх бичгэнд гарын үсгээ зурсны дараа түүнийг босгон “тамын” суудлаас нь салгажээ. Түшмэл “Мерседест” хүрч ирээд машинд орж Томашевскийн дэргэд суугаад түүнд гэрээний бичгүүдийг өгч

-За ингээд болох нь тэр. Яриа тохирлоо гээд тэрээр өөрийн жижиг шар шүднүүдийг цухуйлган бялдуучлан инээмсэглэв. Гэвч Томашевский түүнийг харсан ч үгүй гэрээний бичгүүдийг нэгд нэггүй анхааралтай үзсэний дараа урд суудалд суусан зөвлөхдөө өглөө.

-Леонид Петрович гэж Томашевский хайхрамжгүй өнгөөр дуугараад, жирийн бус нөхцөлд наймааны хэргийг муугүй гүйцэтгэсний урамшлыг тооцоолон нэмж Юрий Михайловичид хөлсийг нь төлчих гэв.

Зөвлөх нь халааснаасаа дугтуйтай мөнгө гарган хөрөнгийн сангийн ажилтанд өглөө. Мөнгийг авмагц тэрээр тоолж эхэлтэл Томашевский:

-Энд биш! гэж зандрав.

-Юуг энд биш? гэж Юрий Михайлович гайхан асуув.

-Мөнгөө энд тоолж болохгүй. Та “Вольвод” очиж суу. Тэр машинаар та буцах ёстой хэмээн Томашевскийн тушаахад дуунд нь үл мэдэг үзэн ядах өнгө гарч байв.

-Намайг та хүргээд өгнө байх гэж бодож байсан...

-Үгүй хэмээн Томашевский эрс татгалзаад, та бид өөр өөр замаар явна. Таныг миний хүмүүс хүргэж өгнө гэлээ.

Түшмэл машинаас гармагц “Мерседес” зөөлөн хөдөлж эргээд их зам руу чиглэн явлаа. Дөнгөж саяхан Серегинийг хувьцаанаас нь салгаж дөнгөсөн хөрөнгийн сангийн түшмэл, өвдсөнөөсөө болж ёолсоор байгаа хэлмэгдсэн Серегин болон түүнийг тамлагч залуусыг суулгасан “Вольво” машины араас нь хөдлөв.

* * *

Полунин Сталины үед баригдсан таван давхар тоосгон байшингийн орцонд орж саяхан угаасан бололтой шатаар нь ядарсан байдалтай өгссөөр гурван давхарт гарлаа.

Тэгснээ дээр нь металл дээр “Либерзон Игорь Зямович” гэж бичсэн хаяг хадсан том бариултай царс модон өндөр хаалганы дэргэд очиж зогсов. Полунин хонх шигээ хуучирсан товчлуурыг дарвал хаалганы цаадах гүнээс хоржигнон дуугарах чимээ сонсогдлоо. Хэдэн хормын дараа хүний хөлийн зөөлөн алхах чимээ сонсогдсоноо хаалганы дунд суулгасан жижигхэн шагайвчны гэрэл унтарч цоожны хоржигнох чимээ гарч хаалга онгойв. Хаалганы цаана хав халзан толгойтой намхан нуруутай өвгөн зогсож байлаа. Тэр өвгөн өөрт нь элбэгдэж үнгэгдсэн өмд өмсөж мөн адил томдож мөр нь унжсан гараар нэхсэн ноосон цамц углажээ.

Үрчлээсээр дүүрэн хүзүү хоолой, хүрэн өнгөтэй толбоор дүүрсэн дугуй нүүр тодорч гарсан хөх судаснуудтай том гартай түүний өлгүүрт өлгөсөн мэт томдсон хувцас бух нохой шиг унжиж үрчийсэн хүзүү хоолой эрүү ам нь бүдүүн эр байснаа насны эрхэнд турсаныг гэрчилнэ.

Гэвч гүнд нь цог гэрэлтэх хурц хар нүднээс нь үзвэл тэр хөгшин өвгөн хөгширсөн ч гэсэн эрч хүч ухаан санаа нь хэвээр байгааг баталж байв. Тэрээр Полунинг хармагцаа:

-Вова! Мөчийн өмнө би түүх давтагддаг гэдэгт бүрмөсөн итгэлээ хэмээн Либерзон дуу алдаад, олон жилийн тэртээ шоронгоос хамт гарч байхдаа таныг чухам ийм байдалтайгаар төсөөлж байсан юм. Энгийн бөгөөд хуучирсан хувцас, үргэлжид ядарсан мэт харагдах ухаалаг харц... Олон жил өнгөрөхөд таны юу ч өөрчлөгдөөгүй мэт харагдаж байна гэлээ.

Либерзон Полунинд ойртон очоод цээжинд нь наалдан чанга тэвэрлээ. Полунин өвгөнийг мөн адил чанга тэврээд нам дуугаар:

-Сайн байна уу, Изя. Түүх давтагдана гэж чи магадгүй зөв хэллээ. Амьдрал тойрог замаар явж байна. Би дахиад л тусламж эрсэн хөөгдмөл тэнүүлчин боллоо гэв.

Либерзон тэр дороо Полунингаас холдон хурц нүдээрээ цоо ширтэн байснаа:

-Вова! Үнэхээр юм өөрчлөгдсөнгүй. Олон жилийн тэртээх шиг чамд юу ч тохиолдлоо гэсэн чамтай дахин уулзсанаа би тун баяртай байна гээд Полунингийн мөрнөөс тэвэрч байрандаа хөглөн орууллаа. Тэрээр:

-Вова, гал тогооны өрөөнд оръё. Манай бүх эмэгтэйчүүд хүүхдүүд зусланд гарсан. Та санаж байна уу, миний уурыг байнга хүргэдэг байсан тэр хөгийн жаал Виталка минь өнөөдөр амралтын өдөр ч гэсэн ажилдаа явчихсан. Сүүлийн үед миний огт мэдэхгүй ямар нэгэн төлөвлөгөөтэй болсон юм шиг байна билээ. Тэр хүн надад хоёр дахь удаагаа зүрхийг минь зогсоох бэлэг барих вий гэж би айж байна. Жил хагасын өмнө миний зүрх зогсож үхэх дөхсөн шүү дээ гэж дэмий ярьсаар уужим боловч элдэв юмаар дүүрсэн гал тогооны өрөөндөө Полунинд цай бэлтгэж өгөх гэж сандарч байх ажээ.

Өвгөн Полунинд цай аягалж өгөөд хэдэн ширхэг хачиртай талх хөргөгчнөөс гаргаж өмнө нь тавиад өөртөө халуун савнаас ямар нэгэн ургамлын ханд авчрав.

-За тэгэхлээр хөгшин еврей дуугүй сууж зочныхоо яриаг сонсох цаг боллоо гэж бодож байна гэж Либерзон ашгүй нэг юм асуугаад урдаас нь харан суулаа.

Полунин аягатай цайнаас балган уугаад:

-Изя, яриа минь тун урт байх болно. Би бүх үнэнийг үлдээлгүй ярина. Хэрэв чи надад туслахаар шийдсэн бол ямар хүнтэй холбогдож байгаагаа ойлгох ёстой гээд бүх явдлаа үлдээлгүй ярив.

Полунинг яриагаа дуусгасны дараа Изя хэдэн хором чимээгүй сууж хоосорсон аягаа бодлогошрон ширтэж сууснаа босож аяга тавагнуудаа эмхлэн тавьж байв. Тэгснээ гэнэтхэн Полунин руу эргэн харж:

-Би чамд юугаар тусалж чадах вэ? гэж асуув.

-Би нуугдаж хүлээх хэрэгтэй байна.

-Хэдий болтол?

-Мэдэхгүй хэмээн Полунин мөрөө хавчаад, удаан ч байж болно. Цагийн аясыг харах хэрэгтэй болно. Түүнээс гадна чи надад зарим зүйлийг тайлбарлаж өгөх хэрэгтэй байна. Эцэст нь чи хотод байгаа миний хүмүүсийг надтай холбож өгөх хэрэгтэй байна. Энэ бол тийм ч осол багатай ажил биш гэдгийг чи ойлгож байгаа биз дээ. Тийм учраас чи татгалзах бүрэн эрхтэй. Санаа бүү зовоорой. Би зөвөөр ойлгоно гэлээ.

Либерзон урдахь аягаа өөрийн эрхгүй ийш тийш нь хөдөлгөн бодлогошрон сууна. Тэгснээ сая нэг юм ам нээж:

-Олон жилийн өмнө тэр үед залуухан байсан чи нэгэн булиа дээрэмчин намайг зодох гэж байхад намайг өмгөөлөн шуудхан дайран орж тэгснээрээ өөрөө эмнэлэгт хүргүүлж байсныг чинь санаж байна. Тэгэхлээр одоо элээх насаа элээж хөгшин төгцөг болтлоо удаан амьдарсан энэ өвгөн би залуухнаараа байгаа таны амь насанд халдах гэж байгаа тэр муу сайн хөлдүүнүүдээс юундаа айх билээ? гэж асуугаад хүндээр санаа алдан үргэлжлүүлж:

-Үгүй дээ Вова минь. Би чамд бүх чадлаараа тусална. Энэ нь миний амь насанд аюултай эсэх нь огт хамаагүй гэлээ. Тэгснээ тэрээр махир бүдүүн хуруугаараа хөмсгөө маажин:

-Намайг тэр новшнуудынхаа бууны аманд зориуд тавьж өгөхгүй байх гэж таны ариун сэтгэл оюунд чинь найдаж байна гэлээ.

Полунин инээмсэглэн:

-Баярлалаа, Изя минь. Мэдээжийн хэрэг би өөрийнхөө эрх ашгийн төлөө чиний болон чиний гэр бүл найз нөхдийг чинь хэзээ ч эрсдэлтэй үйл рүү түлхэхгүй гэж амлав.

-Тэгвэл одоо өнөөдөр эндээс явах хэрэгтэй гэж Либерзон хэлээд, таныг манайд байгааг хэдийчинээн цөөн хүн мэдэж байвал төдийчинээн сайн гэлээ.

-Хаашаа явах гэж? хэмээн Полунин гайхан асуув.

-Ой руу явна. Саяхнаас би эрүүл мэнддээ бага зэрэг санаа тавихаар шийдсэн юм. Та намайг өөртэйгөө нэгэн адил эмнэлэг, эмч нарт нэг их сүржигнэдэггүй гэдгийг мэднэ шүү дээ. Нэгэн ой хамгаалагч солонгос хүн бас өвс ургамлаар эмчилгээ хийдэг юм. Тэр хүн зөвлөгөө өгч үе үе эмийн ургамал түүдэг учир би сард нэг удаа очиж хэдэн зоосоор худалдан авдаг юм. Тэгэхлээр тэр хүн нэг их хөлс нэхэлгүйгээр таныг хэдий болтол ч хамаагүй гэртээ байлгана гэж бодож байна гэлээ. Тэгснээ Либерзон дахин хөмсгөө маажин хошигнож:

-Ийм баян үйлчлүүлэгчийг олж ирсэнд минь тэр хүн надад багагүй хөнгөлөлт үзүүлэх болно гэж нэмж хэллээ.

Өвгөн Полунинд цай дахин аягалж өгөөд замд гарах бэлтгэлээ хийхээр нөгөө өрөөндөө орлоо. Хагас цагийн дараа гэхэд тэд такси хөлслөн Либерзоны хэлсэн айлд очихоор хөдөлжээ.

* * *

“Мерседес” “Нефтьоргсинтез” үйлдвэрийн хаалганд тулж очоод зогсоход Томашевский өөрийн зөвлөхийн хамт машинаас гарч хашаанд нь орохоор явлаа. Хэдэн минутын дараа тэд газрын тосны “Аркада” компанийн захирлуудын зөвлөлийн дарга Олег Сатаровын өрөөнд орж очлоо. Сатаровын хамт түүний ойрын туслах Сергей Романенков сууж байв.

Томашевский орж ирмэгц тэдэнтэй мэндлээд зөвшөөрөл авалгүйгээр зөвлөхийнхөө хамт

зөөлөн сандал дээр суулаа. Сатаров нүүрэндээ инээмсэглэл тодруулан Томашевскийг ажиглан харснаа:

-Танд надад хэрэгтэй ямар нэгэн мэдээлэл байна уу? гэж асуулаа.

-Байгаа гэж тэрээр хариулаад, тантай өөрийн баярласан сэтгэлээ хуваалцах гэсэн юм. Миний хувьцаа худалдан авах асуудал шийдэгдсэн. Өнөөдрөөс эхлэн би танай компанийн хувь нийлүүлэгчийн нэг боллоо гэв.

Хажууд нь суугаа зөвлөх нь шеф рүүгээ бага зэрэг бөхийн:

-Манай компанийн гэж залрууллаа. Томашевский талархан толгой дохиод:

-Тийм ээ. Манай компанийн гэв.

-За яахав, баяр хүргэе гэж Сатаров хэлээд инээмсэглэн, ноён Серегин энэ наймаанд чинь сэтгэл нь ханамжтай үлдсэн гэдэгт би тун их эргэлзэж байна гэлээ.

Томашевский мөрөө хавчин:

-Гэвч одоо тэр хүн ямар үлдсэн гэдэг нь хамаагүй болсон. Одоо бид таны албан ёсны хамтрагч болсон учир цаашдын ажлынхаа талаар ярилцах нь зүйтэй болов уу гэлээ.

-Би бас өөрсдийн шинэ бүрэлдэхүүний талаар танд мэдэгдмээр байна гэж Сатаров хариу дуугараад миний хяналтад компанийн хувьцааны дөчин таван хувь байна гэлээ.

-Тийм ээ хэмээн Томашевский сайшаан толгой дохиод, сайн байна. Тэгэх тусмаа одоо урьдын хэлэлцээрээ хэрхэн хэрэгжүүлэх талаар ярилцах хэрэгтэй гэв.

Сатаров мөрөө хавчин:

-Альберт Николаевич миний бодоход та бага зэрэг яараад байна. Бас Полунины асуудлыг бид шийдээгүй байна. Тэр хүн хаана юу сэдэж байгааг одоо бид мэдэхгүй сууж байна гэлээ.

-Тэр юуг ч сэдэж байлаа гэсэн компанийн хүрээнд бидэнд нэг их саад хийхгүй байх. Учир нь та бид хоёр энэ компанийн тавиас дээш хувийн хувьцааг эзэмших боллоо. Бид дайнд ялж гарлаа. Тэгэхлээр олзоо хувааж цаашид хэрхэн ажиллах тухайгаа ярилцах нь яг цагаа олсон асуудал болно. Би шуудхан өөрийн саналыг хэлье. Хэрэв би компанийн хувьцааны дөчин хувийг хяналтандаа авбал ойрын жилд чамгүй хэмжээний хөрөнгө оруулалт хийх болно. Харин мөнгө хаанаас гаргах нь цэвэр миний асуудал. Харин та компанийн дотоод асуудал болон өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна. Өөр бас нэг асуудал байна... гэж Томашевский ярьж байтал Сатаров үгийг нь таслан:

-Яарах хэрэггүй гэж бодож байна. Том асуудлыг яаран шийддэггүй Альберт Николаевич. Би болон миний орлогчид хамтран одоо бий болсон байдалд дүн шинжилгээ хийж хойшид юу хийх ямар хэмжээнд үйлдвэрлэл явуулахаа бүрэн тодорхойлж чадаагүй байна. Энэ талаар тодорхой болмогц тэр даруй танд мэдэгдэх болно гэлээ.

Томашевскийн нүдэнд бухимдал болон үл ойлгох шинж нэгэн зэрэг тодорч сууснаа:

-Энэ чинь зөв шийдвэр гэж та баттай бодож байна уу? гэж өгүүлээд энэ асуудлыг хэдийчинээ хурдан шийдвэл бидэнд болон компанид төдийчинээ ашигтай байхсан гэв.

-Бидний шийдвэр зөв гэж би баттай бодож байна гэж Сатаров шийдвэртэй мэдэгдээд, үнэхээр энэ хотод байдал бага зэрэг намжтал хүлээе. Та дөнгөж саяхан ашигтай наймаа хийлээ. Тийм учраас өөрийн үүргээ амжилттай биелүүлсэн хүний өндөр сэтгэгдэлтэйгээр төрөлх Москва руугаа харьж болно. Сарын дараа эргэж ирэхэд чинь бүх асуудлыг тайван сууж хамтран ярьж шийдье. Харин одоо Альберт Николаевич минь намайг уучлаарай. Намайг удирдах газраас дуудаад байна. Сүүлийн өдрүүдэд би тун завгүй ажиллаж орой болоход ихэд ядарч байна. Урьд нь би ингэж ачаалалтай ажиллаж байгаагүй юм гэлээ.

Томашевский яаралгүй хөдлөн босож Сатаровын зүг толгой дохин салах ёс гүйцэтгээд өрөөнөөс гарлаа. Тэд машиндаа орж суусны дараа зөвлөх нь сэтгэл ханамжтайгаар шөфдээ хандан:

-Санаа бүү зов, Альберт Николаевич. Энэ жижигхэн луйварчин хаашаа ч зайлахгүй. Мужийн захиргаа энэ заводыг авахад маань тусална гэж хатуу амласан. Харин эдний дотор удирдагч байхаар хүн байгаа юм уу? Сарын дараа эргээд ирэхэд маань эд бидэнд огт өөрөөр хандах болно гэв.

-Тийм ч байж болно гэж Томашевский машины цонхоор жирэлзэн үзэгдэх байшингуудыг бодлогошрон харж дуугараад үнэхээр сарын дараа эргэж ирэх хэрэгтэй. Тэгэхэд бүх юм нам т тайван болсон байна. Гэвч чи Лена, надад итгэ. Би амьдралдаа их юм үзлээ. Надад яагаад ч юм сарын дараа эргэж ирэхэд маань эд нар бидэнтэй өөрөөр ярилцах болно гэж бодогдоод байна. Харин бидний хүссэнээс огт эсрэгээр шүү дээ. Саратов одоо надтай ярихдаа миний хөзөр түүнд аюулгүй мэт сэтгэгдэл төрүүлж байна. Иймээс түүнд минийхээс илүү хүчтэй хөзөр байгаа бололтой гэж ярилаа.

-Тийм байж болохгүй. Орон нутгийн засаг захиргааны ноёд бидэнд тусална гэж амласан биш үү? гэж зөвлөх нь сануулаад, тэр тэдний эсрэг тэрсэлдэх нь юу л бол гэлээ.

-За яахав. Харж байж л больё гэж Томашевский дуугарлаа.

* * *

-Алив чи Владимир. Чи өнөөдөр надтай хамт загасчилахаар явах юм уу? Эсвэл дахин л гэртээ сууж үлдмээр байна уу? гэж ой хамгаалагч Ким Полунингийн өрөөнд ормогцоо асуув.

Полунин нэг гартаа асаасан тамхи барьж нөгөө гараа дэрлэн орон дээрээ хэвтэж байлаа.

-Тор авах зэрэг юмаар би чамд тусалж чадах бол явья.

-Үгүй дээ. Володя минь. Тусламж надад хэрэггүй. Зүгээр л чамайг загасчилж зугаалаасай гэсэн юм гэж Ким хэллээ.

Солонгос эр Ким намхан нуруутай хүн ажээ. Тэрээр үргэлж инээмсэглэн байх нь сэтгэл санаа нь ямагт өндөр байдгаа харуулах гэсэн мэт. Тэрээр аль хэдийнээ тавин жилийг ардаа хийсэн боловч наснаасаа залуу бөгөөд чийрэг харагдана. Давирхай мэт хар халимаганд нь ширхэг ч цагаан үс байхгүй ажээ.

-Володя минь чи юу ч мэдэхгүй мэт байх юм. Энэ хавь ямар сайхан байгальтай гэж санана. Эргэн тойрон гоо үзэсгэлэн. Удахгүй намар болох гэж байна. Хүссэнээрээ зугаал, яв, амар. Тэгэхэд чи энд тамхиар биеэ хордуулж дэмий сууж байх юм гэж тэрээр зөвлөв.

-Зугаалга амралт чинь, Ким минь хэмээн Полунин хариулаад эргэн тойрны байгалийн сайхнаас бус хүний сэтгэл санааны байдлаар хамаарна. Миний сэтгэл зүрх минь байнга хямралтай байдаг юм. Тийм учраас намайг уучлаарай. Би бага зэрэг хэвтэж үлдэе дээ гэлээ.

Ким өөрийнхөө байнгын зочныг дахин ятгаж чадахгүйгээ ойлгон дороо бага зэрэг холхиж байснаа өрөөнөөс гарч явлаа. Полунин араас нь инээмсэглэн харж үдлээ. Түүнд хоёр сар гаруй нэгэн дээвэр дор хамт амьдарсан энэхүү солонгос эр ихэд таалагддаг ажээ. Тэр хүний байшин хөдөөний замаас нэлээд зайтай ойн томхон цоорхойн захдуу байгалийн үзэсгэлэнтэй бөгөөд нам гүм газар байдаг байв. Байшин нь үүдний уужим хонгилоос гадна хоёр нэлээд зайтай өрөөтэй бөгөөд том өрөөнд нь Полунин арай багавтар өрөөнд нь гэрийн эзэн суудаг байлаа. Байшинг орос зуухаар халаадгаас гадна том өрөөнд нь хааяа ирэх зочид болон Кимтэй уулзахаар ирэгсдэд зориулсан задгай зуух хийсэн байлаа.

Оройн цагаар тэр хоёр задгай зуухаа галлан дэргэд нь сууж цай ууж, энэ тэр юм ярилцдаг байв. Ким бол хүнд юм ярихаасаа илүү хүний үгийг хүндэтгэн анхааралтай сонсож суудаг сайхан зантай хүн байлаа. Полунингийн энд амьдарч байгаа шалтгаан, түүний хаанаас ирснийг нь өөрөөс нь болон хааяа ирэх Либерзоноос нэг ч удаа асуугаагүй ажээ. Тэрээр Полунингийн намтрыг огт сонирхдоггүй байсан бөгөөд Полунин түүнд таалагддаг байлаа. Өөрийнхөө тухай солонгос эр дуртайяа ярьдаг байв. Тэрээр ой хамгаалагчаар таван жил гаруй ажиллахаасаа өмнө ойн экологийн дээд сургуульд шинжлэх ухааны ажилтан байсныг Полунин мэджээ. Учир нь тэр сургууль аль эрт хүнд байдалд орсон учир Ким өөр ажил хайхаар шийдсэн байжээ. Солонгос эр хөдөөний байгальд хэдэн жил амьдрах хугацаандаа эргээд хот газар амьдарч чадахгүйгээ ойлгожээ. Тэнд одоо түүний хийх ажил байхгүй бөгөөд хүүхдүүд нь томорч биеэ даан ач зээтэй хараахан болоогүй байв. Эхнэр нь харин хотоос өөр газар амьдарч чаддаггүй учир сард нэг удаа эргэж ирнэ.

Ким энд энгийн бөгөөд нэлээд томхон аж ахуй эрхлэх болсон байлаа. Багагүй талбайд хүнсний ногоо ургуулж хашаандаа тахиа үржүүлнэ. Түүнээс гадна загас барьж давслах, заримдаа үслэг анд явдаг байв. Энэ бүхнээс гадна хааяа ирэх анчид, жуулчид зохих хэмжээний орлого оруулдаг байлаа. Тийм учраас тэрээр хотод амьдарч байгаа гэр бүлийнхэндээ чамгүй тусалдаг байлаа.

Биологийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн Александр Петрович Ким өөрийгөө номгүйгээр төсөөлдөггүй учир бүр энд ойн манааны байрандаа хүртэл гол төлөв хотоос олж ирсэн номуудтай нилээд баян номын сантай ажээ. Чухам ийм нөхцөлд амьдарч байгаа учир Полунин Кимийн эзгүйд юм уу эсвэл завгүй байх үед голдуу ном уншиж цаг нөхцөөдөг байв. Полунинг ойн хамгаалагчийнд ирснээс нь хойш Либерзон дөрвөн удаа иржээ. Ирэх

болгондоо Шакирыч Болдин нараас авсан мэдээллээ дамжуулдаг байв.

Полунин гар утсаар Шакирычид утасдаж Либерзоны байгаа газрын солбилцлыг мэдэгдэж байсан учир бүх мэдээлэл Изю-гоор дамжин түүнд ирдэг байлаа. Мэдээллээс үзвэл түүний гарч явсан хотод үнэхээр харьцангуй тайван болж байв. Сатаров захирлуудын зөвлөлийн дарга болж түүний өмнөх өрсөлдөгчид эсвэл хяналтад нь орж эсвэл зөвшөөрөгдсөн хэмжээнд рэкэтээр оролдон ямар нэгэн эсэргүүцэл үзүүлж чадахгүй болтол нь хотын томхон нөлөөтэй хүний хэмжээнд хүрсэн ажээ. Полунин бас Решетовын арван хувийн хувьцааг Томашевский хүртсэнийг ч мэдсэн байна. Энэ бүхнийг Болдин хөрөнгийн сан дахь Полунингийн хуучин түншээс мэдэж авчээ. Мөн энэ хугацаанд компанийн ажиллагаа харьцангуйгаар сайжрах тийшээ эргэснийг Полунин мэдэж авсан юм.

Шакирыч хөлсний алуурчдын хэрэглэж байсан машиныг шалгах зөвшөөрөл Крикуновоос авч Полунингийн хүмүүсийн хулгайлж Иван Лаптевт худалдсан тэр “Жигули” машинууд байсныг тогтоож чаджээ. Гэвч Полунингийн зааваргүйгээр Шакирыч Лаптевтай ярилцахыг оролдсонгүй. Полунинд ирсэн хамгийн сүүлчийн мэдээг Болдин дамжуулсан байв. Тэрээр “Зенит” клубийн иллэгчин хүүхэн Ксения Соловейчикийн хамт хотоос зайлж явсан тухай мэдээлжээ. Хүмүүсээс сонсоход тэр хоёр Израиль руу гарч одоо тэндээ амьдарч байгаа бололтой. Энэ мэдээллийг аваад орон нутгийн болон Москва дахь еврейчүүдийн шашны газруудтай холбоотой байдаг Либерзонд хандаж тэр хоёрын хаяг, солбилцолыг олж тогтоохыг хүслээ. Либерзон энэ талаар чадах бүхнээ хийсэн боловч үр дүн гарахгүй л байв.

Өнгөрсөн бүх хугацаанд хүү нь өөрийндөө амьдарч байгаа бөгөөд эцгийгээ ихэд үгүйлж байгаа боловч түүний бие сэтгэл санааны байдал хэвийн байна гэж Шакирычаас мэдээ ирж байв. Бяцхан хүү аймшигт явдлаас болж сэтгэл санааны гүн хямралд орсон боловч тун хурдан хэвийн байдалдаа оржээ. Хүүд Шакирыч, түүний эхнэр болон Славка Болдин нар сэтгэл санааны их дэмжлэг үзүүлж байгаа гэсэн мэдээллийг Полунин тогтмол авч байлаа.

Полунин Либерзоны ирэх хугацааг ойртох тутамд ямар мэдээтэй ирэх бол гэж сэтгэл санаа нь тайван бус болдог ажээ. Үнэн хэрэгтээ тэрээр энэхүү мэдээллүүдээр амьдарч байсан юм. Мэдээлэл түүнд зөвхөн эргэцүүлж бодож дүгнэлт гаргахад нь туслаад зогсдоггүй сэтгэл санааны шаналгааг нь намжааж өгдөг байв. Тэрээр хоёр сар гаруйн өмнө хоригдож байсан үеийн мэдрэмжээс хэдийнээ салжээ. Тэнд байхад хааяа ирэх захидал илгээмж зэрэг нь үнэн хэрэгтээ хүмүүний зогсчихсон байдал дахь итгэлийн өчүүхэн гэрэл гэгээний нэг нь болж өгдөг байв. Эргээд тун удалгүй хүү болон найз нөхөдтэйгөө хамт байна гэсэн итгэл Полунинд амьдрах шинэ эрч хүч нэмэн өгч байлаа.

Байшингийн нум хэлбэрийн хөндийгөөс гүйж гараад хөлсний алуурчдад сэглүүлсэн жийпэнд байгаа талийгаачдаа харсны дараа Полунинд өшөө авах гэсэн нэгэн шинэ бөгөөд хүчтэй мэдрэмж бий болжээ. Зөвхөн хүүгээ авч нөхөдтэйгөө уулзах гэж хот руу эргэж очих бус энэхүү аллагыг зохион байгуулагчид болон гүйцэтгэгч нараас өшөөгөө хатуу авна гэдэгтээ Полунин өчүүхэн ч эргэлзэхгүй байсан билээ. Үүний зэрэгцээгээр тэр эмгэнэлт явдлын буруутнууд түүний зорилгыг мэдээж мэдэж байгаа бөгөөд эсрэг арга хэмжээнд бэлтгэж байгаа гэдгийг ч Полунин сайн мэдэж байсан юм. Энэ нь түүний санааг бага зэрэг зовоож итгэл алдуулдаг байв. Ийм ч учраас тэрээр Либерзоны ирэх болгонд түгшүүрлэдэг байсан байж болох ажээ.

Кимийн оройтож гэртээ ирэхэд Полунин өвдөг дээрээ дэлгээстэй нэгэн ном тавиад галтай байгаа задгай зуухны дэргэд унтаж байлаа. Тэрээр хийн пийшин дээр хоолоо бэлтгэж идээд задгай зуухандаа хус модны хэдэн хэрчим нэмж хийгээд загасны урагдсан тороо нөхөхөөр суув. Тэгтэл гэнэтхэн урт бөгөөд бөглүү дуугаар улих чимээ шөнийн нам гүмийг цочоолоо. Полунин хоромхон зуур үсрэн босож дэрэн дороо хийсэн буу руугаа гараа явуулав. Тэгснээ тороо оролдон тайван гэгч суух солонгос эрийг хараад тэр дороо тайвшран орон дээрээ буцаж суув.

-Чөтгөр ав... Айчихлаа... Энэ юу байсан бэ? гэж Полунин асуув.

-Чоно л биз гэж Ким мөрөө хавчин тайван хариулаад, чиний сэтгэл санаа чинь юу болчихоод байна даа, Володя минь. Урьд нь чи арай ингэдэггүй байсан биш үү гэв.

-Тийм ээ гэж Полунин хөлөрсөн духаа арчин хариулаад, өнөөдөр бүр ч зэвүүн муухай сонсогдлоо гэв.

-Зүгээр л тэр амьтан ойрхон ирсэн бололтой хэмээн Ким хэлээд, удахгүй өвөл болох нь. Ойд идэх юм нь ховордоход чоно айл амьтанг бараадаж ойртдог юм. Ер нь ч энэ жил чоно олшроод байгаа бололтой. Малчид тэдний хурга ишгийг барьсан бас нэг нохойг хүртэл барьсан гэж гомдоллож байна билээ гэв.

-Чоно барьдаг нохойтой болох хэрэгтэй. Кавказын овчарка сайн гэдэг.

-Тэр нь олдохгүй биз дээ. Тэгээд ч их үнэтэй байх л даа. Бас тэгээд чононоос хүчтэй нохой байхгүй биз. Харин сүргээрээ бол чоныг хөөж чадна. Сүрэг нохойд чоно ойртохгүй. Их ухаантай зальтай амьтан. Нутгийн ардууд тэднийг ойн хувилгаан гэж айж хүндэлдэг юм гэдэг гэж Ким ярилаа. Полунин түүнийг ширтсэнээ:

-Чи энэ ярианд нь итгэдэг үү? гэж асуув.

Солонгос эр инээмсэглэн:

-Би ямар ч гэсэн нэг муу эрдэмтэн ухаантай хүн. Би ургамал судлаач боловч амьтадын талаар бага сага гадарлана. Чоно бол маш ухаантай хийморилог амьтан. Хүнийг ч гайхуулж чадна. Үүнийг нь домог болгон ярьдаг юм. Гэвч үнэн хэрэгтээ хүнээс аймшигтай амьтан энэ хорвоод байхгүй шүү дээ гэв. Тэгснээ инээмсэглээд тороо орхиж тамхиа асаагаад төлөв болж:

-Далиманд хэлэхэд чоно энэ тухай удахгүй ойлгох болно гэв.

-Юуг ойлгох болно гэж хэмээн Полунин асуув.

-Энэ жил чоно олширсон гэж би хэлсэн. Тийм учраас анчид тэднийг үргэлж хэдэн арваар нь устгаж байна.

-Чи ч гэсэн чоно авладаг биз дээ?

-Мэдээж, энэ бол миний ажил.

-Мэргэн буучийн винтов бариад чонын сүрэг хүрч ирэхийг хүлээн бутныцаана нуугдаж суудаг уу?

-Үгүй ээ, хэмээн Ким толгой сэгсрээд, чоно бол тун зальтай амьтан. Тэгвэл хэдэн долоо хоногоор суух хэрэг гарна. Тэгээд ч ирэхгүй. Харин өөр арга хэрэглэнэ. Чоныг самнаж үргээлэг хийж авладаг юм. Эхлээд тэдний байж болох газрыг тогтооно. Тэгээд тэр газрыг нь улаан дарцагтай утас татаж бүсэлдэг юм. Энэ нь чононд аюулын дохио болж энэ бүслүүрийг хэзээ ч давж гардаггүй. Үргээлэгчдийн нэг хэсэг нь нохой дагуулан их чимээ гарган чоныг байгаа газраас нь отоож нуугдан суугаа буучид руу хөөж авчирдаг. Дарцагтай утсыг зөв тавьж үргээлэгчид зөв хөдөлж чадвал чононууд отолт руу орж ирнэ. Бүх үргээлэгчид чонын сүрэг хаашаа хөдөлж явааг холбоогоор хоорондоо мэдэгдэнэ. Ингэж авладаг юм даа гэж ярилаа. Ким Полунинг ширтэж сууснаа:

-Чи бидний чонын аванд оролцохгүй юм уу? Чамд сонин санагдана даа гэж асуулаа.

-Үгүй дээ хэмээн Полунин толгой сэгсрээд, амьтныг хөөж авчраад тулгаж буудах нь тийм ч таатай юм биш санагдана. Гүйж ирсэн чоныг буудаж чадахгүй алдчих байх гэж бодож байна гэв.

-Араатан амьтан чамд хөөрхийлөлтэй санагдаж байгаа бол чи угаасаа анчин хүн биш юм даа. Владимир минь хэмээн ой хамгаалагч дуугараад анчин хүнийг хүсэл дон хөдөлгөдөг юм. Харин чи бол энэрэнгүй үзэлтэн хүн юм гэлээ.

-Чи үнэн хэлэв бололтой гэж Полунин бодлогошрон зөвшөөрөөд, тиймгүйсэн бол би энд чиний дэргэд биш өөрийн удирддаг компанийн тансаг өрөөнд сууж байхсан гэв.

Солонгос эр төв болж Полунин руу харц чулуудсанаа ярианы сэдвийг өөрчлөн үнэнээ хэлэхэд би ч гэсэн ан хийх тийм ч дуртай биш. Миний мэргэжил буу барих бус газар шороо өвс ургамалтай зууралдаж байх явдал юм. Би энэ цоорхойд жижигхэн ургамлын цэцэрлэг байгуулж дэргэд нь мөн жижгэвтэр биохимийн лаборатори ч ажиллуулах юмсан гэж би эртнээс мөрөөдөх болсон. Ингэснээрээ мөнгө олох нь ч юу юм. Гэвч сэтгэлээ тэжээх л гэсэн юм даа гэв.

Ким энэ сэдвээрээ удаан ярьж суусан боловч Полунин яриаг нь нэг сүрхий сонсохгүй байсан юм. Ой хамгаалагчийн чонын тухай хачин яриа түүнд тохиолдсон хэдэн сарын өмнөх явдалыг дахин эргэж санахад хүргэв. Тэрээр өөрөө тэр хөөгдсөн чоно болчихсон мэт санагдаж байлаа. Түүнийг хайр найргүй чадварлаг урхиндаа оруулж “анчин” нэг сумаар хэд хэдэн асуудлыг шийдчихжээ. Тэгснээр өрсөлдөх чадвар болон эд хөрөнгөнөөс нь салгаж орхисон ажээ. “Гэвч тэд эцсийн зорилгодоо хүрч чадаагүй. Өөрөөр хэлбэл дутуу ажилласан. Харин хөрөнгийг нь авч чадсан. Одоо миний бүлгийн нэг нь ч бидний хувьцааг хянаж чадахгүй байна. Гэвч намайг тэд бие махбодийн хувьд устгаж чадаагүй” хэмээн Полунин бодсоор байв.

Өөрийг нь шоронгоос оргуулсан тэр үл мэдэгдэх Николай Иванович гэгч хэн бэ. Полунин түүнийг хэн гэгчийг нь одоо хүртэл мэдэж чадаагүй юм. Тэр хүний өгсөн утасны дугаар холбооны лавлахад байсангүй. Тэднийг сэжиглүүлэхгүйн тулд өөр шугамаар тэр хүний тухай олж мэдэхийг Шакирыч, Болдин нарт даалгаж зүрхэлсэнгүй. Полунин “чухам ямар зорилгоор

тэр хүн намайг бууны хараанаас мултлан авч аюулгүй газар нуугдахад туслав. Гэвч энэ тухай одоо бодоод хэрэггүй. Хэзээ нэгэн цагт мэдэх л болно” гэж бодлоо. Полунин хажуулдан солонгос эрийн нэг хэвийн яаралгүй ярианд өлгөйдүүлэн нойрмоглож эхэллээ. Ким Владимирын хэдийнээ унтаж эхэлснийг хараад өчүүхэн ч гомдсонгүй. Тэрээр цагаа харснаа ханын зуухны галыг хөдөлгөөд дулааныг нь нэмээд нэгэнт орой болсон учир унтаж амрахаар өрөөнөөс гарлаа.

* * *

Дараагийн өдөр үд орчимд Полунин хашааны дотор мод хагалж байгаад моторын дуу сонсож ойртон ирж яваа Либерзоны хуучивгар “Нива”-г харлаа. Машиныг урьдын адил хүү Виталий жолоодож дэргэд нь эцэг нь суусан харагдана.

Полунин хэрчим модонд сүхээ зоогоод зочдоо угтан очив. Кимийн хоёр нохой хуцан “Нива”-г тойрон гүйлдэнэ. Зочид тэдэнтэй мэндлээд Изя Владимирт хандан:

-Чамд Шакирычаас захидал ирсэн. Шинэ мэдээ байгаа байх. Бас би өөрөө бага сага юмтай ирсэн гэлээ. Үүнээс өмнө зөвхөн утсаар мэдээ өгдөг байсан Шакирыч энэ удаа захидал илгээсэнд бага зэрэг гайхсан Полунин захидлын дугтуйг задлан уншлаа.

Тэгснээ хэдэн хором өнгөрмөгц царай нь барайн хөмсгөө зангидав. Тэрээр шүдээ зуун захидлыг уншиж дуусгаад Изяд өгч:

-Май унш. Би үүнийг чанга дуудахыг хүсэхгүй байна гэлээ.

-Хэрэггүй хэмээн Либерзон хариулаад захидалтай гарыг нь түлхэн, юу бичсэнийг нь би төсөөлж байна. Энэ тухай надад арав хоногийн өмнө утсаар мэдэгдсэн. Харин чамд утсаар хэлж зүрхлээгүй юм гэлээ.

-Энэ юу болж байгааг чи ядахнаа мэдэж байна уу?

-Ойлгож байна хэмээн Либерзон толгой дохиод гэвч эцсийн эцэст тийм ч аймшигтай юм болоогүй. Хүү чинь эрүүл саруул, Зүгээр л хүүхэд асрах газар суулгасан. Эрт орой хэзээ нэгэн цагт ингэх л байсан. Хэзээ болтол өөр айлд суух юм бэ гэв.

-Үгүй ээ. Изя түүнийг авсан тэр Савеловскийн асрамжийн газрыг чи мэдэхгүй байна гэлээ.

Изя Полунинг ойлгож ядан хараад:

-Тэр чинь хүүхдийг муу асардаг газар уу? гэж асуув.

-Үгүй дээ. Тэнд хүүхдийг муугүй асардаг юм. Үүнд гол нь биш. Харин тэр газрыг миний өстөн дайсан Сатаров ноён ивээн тэтгэдэг юм. Тэгэхлээр тэд юу сэдэж байгааг чи ойлгож байна уу? гэж Полунин асуув.

-Энэ бол сануулга гэж бодож байна уу?

-Тийм ээ гэж Полунин батлан хэлээд намайг ямар нэгэн ажиллагаа хийх гэж оролдвол тэр хүүг маань барьцаанд авна гэсэн дохио өгч байгаа хэрэг гэлээ.

Эрчүүд хэсэг зуур чимээгүй болж Изя байшингийн ард зоосон урт сандал дээр сууж Полунин бодлогошрон хойш урагшаа алхална. Эцэст нь Полунин Либерзоны хажууд ирж суухад нь:

-Надад муугүй гэж хэлмээр өөр бас мэдээ байна. Би Соловейчикийн байгаа газрыг мэдсэн гэв.

Полунин түүн рүү аажим эргэн харж:

-Хаана байна вэ? гэж асуув.

-Тэр үнэхээр Израилийн Хайф хотод амьдарч байна.

-Тодорхой хаяг байна уу?

-Байхгүй гэж ямар нэгэн байдлаар эргэлзэн дуугараад учир нь тэр хүн далайн моторт завь худалдаж аваад түүн дээрээ амьдарч байгаа бололтой. Тэнгис далайд дуртай хүн юм уу даа? гэж асуув.

-Мэдэхгүй. Тийм хүн гэдгийг нь би ажиглаагүй. Харин лусын дагинад илүү дуртай хүн шиг байсан гэж Полунин хошигнов.

-Моторт завийг нь “Вента” гэж нэрлэдэг гэсэн. Байгаа газар нь Хайфийн усан буудалд бөгөөд түүнийг хүн нэг бус удаа харсан гэнэ.

-Баярлалаа, Изя гэж Полунин хэлээд

-Би чамаас хүсэх бас нэг зүйл байна гэв.

-Ямар?

-Надад гадаад паспорт хэрэгтэй байна. Чи бүтээж өгч чадах уу?

-Оролдоод үзье гэж Изя халзан духаа маажин бодлогошрон хариулаад, надад энэ талаар их юм хийдэг нэг танил бий. Харин багагүй зоос нэхдэг юм гэв.

-Зоосны талаар санаа бүү зов. Би бүгдийг төлнө. Харин хурдан тусмаа их сайн.

-Сайн байна. Хоёр долоо хоногийн дараа бүтээж өгье гэж Изя амлав.

...Либерзоны явсны дараа Полунин нөгөө сандал дээрээ дахин хэсэг хугацаагаар сууж үлдэв. Тэгтэл солонгос эр дэргэд нь хүрч ирээд шүүргүй хатуу янжуураа гарган асаагаад Владимирын уруу царайлан дугтуйтай бичиг бариад сууж байхыг хараад

-Ямар нэгэн юм болоо юу? гэж асуув.

-Тийм ээ гэж Владимир хариулаад би удахгүй явах болж байна, Саша. Гэртээ тухлуулсан явдалд чамд их баярлалаа гэлээ.

-За яахав гэж солонгос эр дурамжхан дуугараад, чамайг надтай хамт өвөлжих болов уу гэж горьдож байсан юм. Чи үг дуугарахгүй байлаа ч гэсэн чамтай хамт байхад таатай байдаг юм гээд инээмсэглэн Полунинг ширтлээ.

-Би үргэлжид дуугүй, ууртай юм шиг байдаг биз?

-Чамаас ямагт нэг л сонин өнгө төрх гарч байдаг. Журамтай хүний өнгө төрх шүү.

-Миний өнгө төрхийг мэдэх боломж чамд гараагүй дээ гэж Полунин хэлэв.

-Хотын шуугиан хүн амьтнаас хол энэ бөглүү ойд хичнээн бага харьцаатай байлаа ч гэсэн хүний зан төрхийг тун амархан таньдаг юм. Саяхан би нэгэн шинжлэх ухааны сэтгүүл уншсан. Японы эрдэмтэд ургамал ч гэсэн бас үнэрээрээ бие биетэйгээ харьцдаг гэж бичсэн байсан. Магадгүй хүн ч гэсэн сайн, муу, шуналтай, өглөгч үнэртэй байж тэр нь өөр өөрийн шинжтэй байдаг биз. Энд амьд байгаль дунд хүний үнэр мэдэх мэдрэмж илүү байж байдаг. Хэрэв чи өөрөө эсвэл найз нөхдийн хамт дахин наашаа ирвэл чинь би чамайг баяртай хүлээн авна гэж Ким хэллээ.

-Баярлалаа Саша гэж Полунин хэлээд би оргодол маягаар биш зочин маягаар эргэж ирэхийг мөрөөдөж байна. Бас хүүгээ аваад ирэхийг маш их хүсэж байна гэлээ.

* * *

Хоёр долоо хоногийн дараа Либерзон амласан ёсоороо Полунинд Борисов Андрей Дмитриевич гэдэг нэрэн дээр энгийн гадаад паспорт олж өглөө. Дараагийн өдөр нь тэндээсээ гадаад явахаар Полунин Москва руу нисчээ. Түүнийг Либерзон хүү Виталийн хамт гаргаж өглөө. Виталий онгоцны буудлын лавлах товчооноос зорчигчид онгоцонд орох газрыг асууж байх хооронд Изя нэр болон утасны дугаар бичсэн нэгэн хуудас цаасыг Полунинд дамжуулав.

-Хэний хаяг вэ? гэж Полунин гайхан асуув.

-Наана чинь бичээстэй байгаа Равшкович Семен Израилевич гэдэг хүнийх.

-Хэн юм бэ? Надад ямар хэрэг болох вэ?

-Израиль нисэхийнхээ өмнө энэ утсаар яриарай. Тэр хүн чамд хэрэгтэй хүнийг чинь олоход тусална.

-Тэр хүн яагаад надад туслах болов?

-Тэр хүн миний тусын тулд ажиллах ёстой юм гэж Либерзон хариулаад надад гурван зуугийн өртэй юм. Энэ мөнгийг нааш нь гуйвуулах их үнэтэй байдаг учир надад явуулж чадахгүй байгаа гэдэг юм. Ийм учраас надаас нэгмөсөн мянган доллар зээлдээгүйдээ харамсдаг юм

билээ. Одоо зээлдсэн мөнгөө энэ маягаар төлнө биз гэж хөмсөг зангидан хэллээ.

-Изя, харин чи одоо хүртэл яагаад Израиль яваагүй юм бэ? Чи тэнд хангалуун бөгөөд тайвнаар амьдарч болох биш үү? гэж Полунин гэнэтхэн асуув.

-Энд ч гэсэн би хангалуун амьдарч байна. Харин би өнгөрсөн хугацаанд хэзээ ч тайван амьдарч байгаагүй. Хойшид ч тайван амьдарч би чадахгүй. Дараа нь биднийг мөнхийн амгалан хүлээж байгаа шүү дээ хэмэн Изя хариулав. Тэгснээ дуугүй болж хүндээр санаа алдсанаа ухаалаг харцаар Полунинг ширтэн:

-Бас тэнд еврей олонтой учир би тийшээ явах дургүй байдаг юм гэж нэмж хэллээ.

-Изя хэмээн Полунин гайхан дуу алдаад, чи еврейн тэрс үзэлтэн болчихоо юу? гэж асуулаа.

-Чи юу асуух чинь энэ вэ? гэж Либерзон бухимдан асууснаа, дараагийн агшинд хэрэв би тийшээ явбал үнэхээр тийм үзэлтэн болчих байх гэж би болгоомжилж байгаа юм гэж тайван хариулав.

Онгоцонд суухыг чанга яригчаар зарламагц Либерзон Полунинг чанга тэврээд:

-Вова, биеэ хайрлаж яваарай. Танд ямар нэгэн муу юм тохиолдвол би их харамсах болно. Та бол надад зөвхөн сайн юм хийж явсан цөөн хүмүүсийн нэг гэж хэллээ.

* * *

Полунин Москвад ирсэн даруйдаа Кипр нисэж тэндээсээ жуулчны тийз худалдан аваад усан онгоцоор Израиль оржээ.

Долдугаар бүлэг

Полунин нэгэн нарлаг сайхан өдөр эрээн мяраан жуулчдын хамт тэдэнтэй зуны шинэхэн хувцсаараа ижилдэн Хайфийн усан боомтод бууж ирлээ. Тэрээр цагаан өмд, богино ханцуйтай цайвар саарал цамц, зуны саарал шаахай өмсчээ. Полунин зөвхөн гаалийн үзлэгээр орох үедээ нарны хар шилээ авч байв. Полунин усан буудлын байшингаас гармагцаа жижигхэн “Фиат” машины дэргэд урагш хойш алхаж байгаа өтгөн хар сахалтай, халзан толгойтой, намхан нуруутай, махлаг эрийг харж санаа нь амарлаа. Гаднах төрхөөрөө еврей гэхээсээ грузин хүнтэй илүү төстэй харагдана. Полунин тэр хүн рүү дөхөж очоод:

-Та Равикович Семен Израилевич мөн үү? Би таны улаан машинаар танилаа гэж асуув.

-Тийм ээ, би байна. Надаас өөр ямар хүн энэ оронд ийм хөгийн юмаар явах билээ дээ гэж хэлээд, харин би саяхан машиндаа салхилуулагч тавьснаас хойш гайгүй болоод байгаа юм. Өмнө нь би амь тавих гэж байлаа шүү дээ гэж тэр хүн хэлэв.

Өөрийн асуудлыг зарим нэгэн багахан хэсгээс ингэж яриад Равикович Полунинг ширтэн:

-Харин та Борисов Андрей Дмитриевич мөн биз дээ гэж асуув.

Полунин зөвхөн толгой дохив.

-Тэгвэл явъя. Та азтай яваа хүн юм. Танд бүр давхар аз тохиолоо. Нэгд, танд над шиг хүн туслах болсон байна. Тэр гурван зуун зоосорхуу юмнаас болж Либерзон миний хүндэт нэрийг нэлээд хэдэн удаа базаахгүй тийш нь дурсаж байсан боловч Израиль их биш орон тулдаа л би танд тэр завийг олж чадсанаар амласнаа биелүүлж чадлаа гэж Равикович хэллээ. Машинд суусан хойно Полунин:

-Хоёр дахь удаагаа надад ямар аз тохиов? гэж асуув.

-”Вента” одоо эндээс холгүй орших Хайфийн усан боомтод зогсож байгаа. Тийм учраас бид хүсвэл таны хэрэгтэй хүн рүү одоохон очиж чадна. Харин танд шуудхан хэлэхэд гээд Равикович үгээ гэнэтхэн тасалж Полунин руу хялайн харснаа, харин би та нарын ажлыг мэдэхгүй. Тэр хүнтэй юу ярихыг чинь ч бас би мэдэхгүй. Харин ганцхан юм хүсэхэд таныг тэр “Вента” байгаа газар хүргэж өгмөгц та миний нэр болон энд дөхүүлж моторт завийг зааж өгсөн явдлыг тас мартаж орхиорой. Тэр “Вента”-гийн эзэн залуу танай тэр Орост чинь юу үйлдчихээд энд ирснийг нь би мэдэхгүй. Оросын ч байг Израилийнх ч байг ямар нэгэн цагдаагийн газрын сонин мэдээлэлд миний нэр цухас ч болов бүү дурсагдаасай гэж би хүсэж байна гэж хэллээ.

-Санаа бүү зов хэмээн Полунин ядрангуй байдлаар хэлээд, би хөлсний алуурчин биш. Би тэр залуутай зөвхөн ярилцахаар ирсэн хүн. Тиймгүйсэн бол би танд юу гэж ингэж ил хандах билээ гэв.

-Мэдээж. Би хүнд тал бүрээр тусалдаг хүн. Үнэ хөлс тохиролцож чадвал би ямар ч

ажиллагаанд оролцож чадна. Харин би миний эхнэр хүүхэд бүү хэл өөрөө ч мэдэхгүй байгаа хэзээ нэгэн цагт Либерзоноос авсан гэх тэр гурван зуугийн талаар яриагүй байна. Тэр яах вэ. Либерзон бол сайн өвөө тул би түүнд туслахад хэзээ ч бэлэн гэж тэр хүн хэллээ.

Замын хориод минутын туршид Равикович зогсолтгүй чалчиж явсан учир машин моторт завь зогсож байгаа усан боомтод хүрч очих үед

-За хүрээд ирлээ. Завь тав дахь баганын дэргэд зогсож байна гэж ашгүй нэг хэлэхэд нь ярианд нь залхаж гүйцсэн Полунин бүр баярлах шиг боллоо.

Полунин аяны жижиг цүнхээ авч машинаас гарч жолоочтой салах ёс дуртайяа гүйцэтгээд моторт завины зүг яаран алхлаа. “Вента” тийм ч том биш Полунингийн усан цэрэг байхдаа ёслолын жагсаалд харж байсан моторт завины хэмжээтэй болов уу гэмээр завь ажээ. Полунин завийг гүйлгэж хараад түүнд ямар ч байсан хэд хэдэн өрөө бий бөгөөд бас сайн тоногдсон гал тогооны өрөөтэй юм гэж мэдлээ. Полунин тэнд хүрч очоод завь боомтын тавцан хоёрыг холбосон гүүрэн шатаар яаралгүй явсаар завин дээр гарах үед өмнө нь өтгөн хар үсэрхэг биетэй гүзээ томтой нэгэн булиа эр гарч ирээд гэдсээрээ тулан зогсов. Мангар эрийн нимгэн хүрэм баруун мөрөнд нь өлгөөтэй харагдана.

-Экскьюз ми сэр хэмээн тэрээр англи хэлээр хазгай дуугараад энэ бол хувийн эзэмшлийн хөрөнгө учир гаднын хүн зөвшөөрөлгүй орохыг хориглодог гэж тайлбарлахыг оролдов.

Полунин мөн адил англи хэлээр уучлалт хүсээд чухал ажлаар завины эзэнтэй уулзах гэснээ учирлав. Тэгээд хариу хүлээлгүйгээр:

-Май нэйми из Полунин гэв.

Булиа эр уучлалт хүсээд завинд гарч цааш явж далд оров.

Харин оронд нь бас нэгэн намхан нуруутай, өргөн цээжтэй, монхор хамартай, тамирлаг байрын залуу гарч ирээд хөндөлсөв. Тэрээр цагаан өмд цамц өмссөн агаад бүсэнд нь хуйтай гар буу дүүжлээстэй байх ажээ. Тэр залуу эрүүгээ яйжийлган байж яаралгүй бохь зажлах зуураа Полунинг сонжин ширтэнэ.

Гэнэтхэн завины доод хонгилын хаалга онгойж шатаар өгсөн гарч ирсэн Гриша Соловейчик Полунинг хармагц:

-Ухаан алдмар! Иваныч чи мөн үү? Өнөөдөр гайхмаар өдөр юм хэмээн дуу алдлаа.

Полунин түүнийг анхааралтай ажиглан харав. Соловейчик нарийн даавуугаар хийсэн босоо захтай цагаан цамц, цардмал цагаан өмд өмсөж, хөнгөн шаахай углаж, үсэрхэг цээжинд нь бүдүүн алтан гинжтэй мөн адил алтаар хийсэн Дэвид одны цутгамал дүрс дүүжлээстэй харагдана.

Полунин нарны шилээ авч түүний нүд рүү цоо ширтэн:

-Худал бүү маягла Григорий чи намайг хүрч ирнэ гэж мэдэж байсан гэлээ.

-Үгүй ээ, Иваныч хэмээн Соловейчик хэлээд чамтай энд уулзана гэж үнэхээр санаагүй юм. Харин чиний нэрийн өмнөөс хэн нэгэн ирж магадгүй гэж бодож байсан юм. Чамайг өөрөө хүрээд ирнэ гэж би бодсонгүй. Миний бодсоноор чи эрэн сурвалжлагдаж байгаа биш бил үү? гэж асуув.

Полунин энэ асуултыг нь үл хайран:

-Бид хоёр ингэж зайнаас харьцаж зогсож байх юм гэж үү? Эсвэл чи орос хүний зочломтгой зангаар гэртээ урьж оруулах юм уу? гэж асуулаа.

-Энд бол Орос орон биш. Би чамд яагаад хэрэг болов? гэж Соловейчик хайш хэрэг асуув.

-Яагаад хэрэг болсноо мэдэж байна уу. Би чамаас хоёр асуулт асууя.

-За яахав? Энэ хүнийг нааш нь оруулчих гэж Соловейчик хамгаалагч нартаа хэллээ. Тэгээд завиныхаа тавцан руу эргэн ширээ хэдэн сандал дүүжин ор руугаа сайрганан явж очив.

Полунин намхан эрд өөрийн цүнхийг өгч:

-Май үз гэв. Үсэрхэг том залуу Полунинг өөрт нь болон цүнхэнд нь хурдан гүйлгэж нэгжлэг хийсний дараа зөөлөн сандалд хэвтээ шахам суугаа Григорий эсрэг талын сандалд очиж суув. Ширээн дээр лонх виски архи хэдэн хундага тавиаастай байх бөгөөд дэргэд нь мөсөөр дүүргэсэн бага оврын зөөврийн хөргүүр байх ажээ. Соловейчик зориуд юм шиг залхуутайгаар хөдлөн архи руу зааж:

-Уух уу? гэж асуув.

-Татгалзахгүй гэж Полунинг хэлэхэд тэрээр хоёр хундаганд дундуур виски аягалаад тус бүрт нь хэсэг мөс хийлээ.

Энэ үед намхан эр шатаа сойн авч завиныхаа хүчтэй моторыг асаав.

-Бид далайгаар бага зэрэг зугаалга хийхээр завдаж байсан юм. Чи бидэнтэй хамт явахгүй юу? гэж Соловейчик санал гаргаад, Иваныч чи намайг ойлгоорой. Сүүлийн үед би далай тэнгист дуртай болчихож. Тэнд байхад бүх юм нам тайван байдаг юм гэлээ.

Полунин виски балган залгиад:

-Бас аюул багатай гэж нэмж хэллээ.

-Бас тийм.

Моторт завь алгуурхан хөдөлж задгай тэнгисийн зүг хөвлөө. Зогсоолоос нэлээд холдсоны дараа Соловейчик

-За тэгэхлээр чи надтай юуны тухай ярих гэсэн юм бэ дээ? Бодвол намайг яаж байгаад энд хүрээд ирснийг минь сонирхож байгаа биз гэж асуулаа.

-Энэнийг чинь ч сонирхож байна. Бас ямар зоосоор яаж энэ тэвш болон Давидын дүрс дүүжилсэн алтан гинжийг худалдаж аваад бие хамгаалагчдыг хөлсөлж авсныг чинь би сонирхож байна?

-Дэмий юм бүү асуу Иваныч хэмээн Соловейчик залхуурсан байдалтай гараа савчаад

-Чи миний татварын байцаагч биш. Би Израилийн бүрэн эрхт иргэн. Бүх татвар төлөөсийг нь шударгаар төлдөг. Чамаас ялгаатай нь би эндхийн засаг захиргаатай ямар ч сөрөг харьцаа байхгүй гэж цохон өгүүлэв.

Полунин хүйтнээр инээд алдан түүний өгүүлэхийг дуугүй сонсож сууна. Өөртэй нь ингэж тоомжиргүй харьцаж хувийн моторт завьтайгаа Хар тэнгист зугаалан яваа энэ цатгалан эр “Зенит” спорт клубт анх Полунинтай уулзаж байх үеийн өөрт нь таалагдахын тулд байдгаараа хичээн цүдэгнэх тэр биеийн тамирын хуучин үрчгэр трусик майктай эр хоёрын ялгаа ингэж их өөрчлөгдсөнөөс хойш тийм их хугацаа өнгөрөв гэж үү.

-Чи магадгүй бидний хуучин харьцааны талаар ярих гэсэн юм биш биз? хэмээн Соловейчик дуугараад, тэгвэл тэр чинь надад аль хэдийнээ сонирхолгүй болсон. Аз болоход миний тэр зүдэрч явсан цаг өнгөрчээ. Харамсалтай нь бид цөм мунхагууд байж хожигдсон юм гэв.

-Зарим нэг нь бүр амь насаараа хожигдож хохирсон гэж Полунин нэмж хэлэв. Тэгснээ гэнэтхэн уур хилэн нь дүрсхийн асаж орхилоо.

Тэрээр Соловейчикийг бүх юмаар уучилж чадах байсан боловч хэзээ нэгэн үед Полунин болон түүний хамтран зүтгэгч байгаад амь үрэгдсэн нөхдүүдийнхээ талаар ингэж тоомжиргүй ярьж байгааг нь тэвчиж чадсангүй.

-Алив чи сонсож бай, бүдүүн бөгст гахай минь гэж Полунин хилэгнэн зандраад түүнд бүх биеэрээ ойртон, чиний тэр тэнэгүүдэд тооцож байгаа хүмүүс чинь чамайг хөтөлж нөхдүүдтэй болгож өгсөн. Мөнгөтэй болоход чинь тусалсан Самбист бид хоёр байгаагүйсэн бол чи одоо хэн байх байсан юм. Эрт орой хэзээ нэгэн цагт Веселовский чамайг хар ажилчнаар шилжүүлэх байсан. Тэгэхэд одоо Самбист амиа алдаж, би нуугдмал хүн болоод зугтаж явахад ганцхан чи ухаантайгаараа тохилог завин дээр гүзээгээ наранд ээж сууна гэж бодоогүй биз? гэлээ.

Соловейчик айн тэвдэж завины тавцангийн хашлага түшээд зогсож байгаа бие хамгаалагч нараа хараад:

-Иваныч чи хамаагүй бүү орил. Хамгаалагч нарын маань дургүйг хөдөлгөж орхино гэлээ. Тэгснээ буутай хоёр хамгаалагч нар руугаа дахин харц чулуудаад тэгж яривал эд нар бол хуучин Израилийн тусгай албанд ажиллаж байсан хүмүүс юм. Мэргэжлийн маш өндөр түвшинд ажиллаж чадна гэв.

-Тийм үү. Тэгвэл эд нарыг чинь чамтай хамт би нулимж орхино гэж Полунин хорсолтойгоор хэлээд харин чи миний асуултад хариу өгөх чинь дээр байх. Манай хувь нийлүүлэгч бүлгээс яагаад чи ганцаараа амьд мэнд үлдээд бас энэ тэвш худалдан авч хамгаалагч нарыг хөлсөлж

чадаа вэ? Ер нь чамд энэ бие хамгаалагч нар ямар хэрэгтэй юм? Хэнээс чи ингэтлээ айгаа вэ? гэж асуув.

-Орост бизнес эрхэлж байгаа хүнд бие хамгаалагч зайлшгүй хэрэгтэй хэмээн Соловейчик асуултыг займруулан хариулаад, харин би чиний асуултад заавал хариу өгөх албагүй. Гэвч би өөрийн багц хувьцааг худалдсан юм гэв.

-Хэнд?

-Веселовскийд гэж Соловейчик бага зэрэг зовсон байдалтай хариулав.

Полунин түүнийг гайхшран ширтсэнээ:

-Веселовскийд гэж өөрийн эрхгүй давтаж орхилоо.

-Тийм. Тийм ээ Веселовскийд хэмээн Соловейчик бухимдан давтаад, би өөр яах ёстой байсан юм бэ? Самбистыг алсан, чи одоо энд зугтаж яваа боловч тэр үед чамайг шоронд хорьсон байсан. Би ганцаараа үлдээд байсан шүү дээ. Чинийхээр бол би юу хийж чадах байсан юм? Тэд хувьцаануудыг минь надаас галын дөлөөр төөнөж авахыг нь хүлээх ёстой байсан юм гэж үү? Эсвэл Самбист шиг алахыг нь хүлээх байсан уу? Харин Веселовский миний энэ байдлыг ойлгон хувьцааг минь муугүй үнээр худалдаж авахыг санал болгосон юм гэж хариулав.

-Чи намайг итгүүлэх гэж оролдож байна уу? гэж Полунин асуугаад, зөвхөн тэр мөнгөөр энд цагаачлан ирээд энэ бүхнийг олж аваа юу? гэв.

-Үгүй л дээ. Надад бас өмнө нь цуглуулсан мөнгө байсан юм.

-Больж үз Гриша минь. Чи хэний тархийг мунхруулах гээ вэ? гэж зандраад Полунин ширээ шаахад архитай лонх хажуугаараа харан унаж хаш өнгийн шингэн асгарлаа. Энэ үед хоёр хамгаалагч нь хүрч ирээд Полунингийн хажууд зогсов.

-Чи яаж байгаа чинь энэ вэ? хэмээн Соловейчик сандран хэлээд, лонхыг босгож тавиач. Энэ бол их үнэтэй архи гэлээ.

-Одоо чиний юм бүхэн их үнэтэй. Харин чи өөрөө сохор зоосны ч үнэгүй тэнэмэл гэж Полунин арга ядсан байдлаар хариулав.

-Ингэж тохирёе гэж Соловейчик шийдмэг хэлээд бие хамгаалагч нараа ширвэн харж, хэрэв чи энд дүрсгүйтээд байвал эд нар чамайг ус руу шидэж орхино. Эсвэл хашлаганд холбоод гавлана гэж сүрдүүлэв.

-Мөөн гэж Полунин гайхшран дуугараад, би чамтай ярилцах гэж ирсэн юм. Нэгэн үед чи бид хоёр хамтран зүтгэгч байсан биш бил үү? гэж асуув.

-Тэр явдал аль хэдийнээ өнгөрсөн гэж Соловейчик цохон хэлээд, тэгэхлээр бид чамайг одоо эрэг дээр буулгаж орхиё. чи тэгээд тэр Орос руугаа арилж үз. Харин одоохондоо чи миний эгдүүг хүргэхгүйн тулд хашлаганд гинжилж номхруулах нь зүйтэй байх гэх нь тэр. Ингэж

хэлэхийг нь сонсоод Полунин аажуухан гараа өргөж:

-Байз, залуус минь. Бид арай хэт бухимдацгааж байна. Алив тайвширцгаая. Тэгээд соёлтой орны жирийн иргэд шиг хэвийн ярилцацгаая гэж хэлээд сандлаа ширээнээс холдуулан яаралгүй бослоо.

Гэтэл намхан эр халааснаасаа гав гаргах зуураа ойртож ирлээ. Чухам тэр этгээд Полунингийн эхний золиос болжээ. Полунин огцом бөгөөд хурдан хөдөлгөөнөөр түүний гүзээ рүү өшиглөтөл тэрээр гав гинжээ алдан хоёр гараараа гэдсээ тэвэрч эвхрэн ойчлоо. Тэгснээ тэр Израилийн тусгай албанд байсан хүн:

-Ёо ёо алах нь! гэж цэвэр орос хэлээр дуу алдан орилов.

Өөрийн хам нь тэгж хоромхон зуур нэрвүүлснийг нь нөгөө булиа хамгаалагч хармагц буугаа хуйнаас нь суга татан гаргасан боловч ашиглаж амжсангүй. Полунин үсрэн агаарт хагас эргэж хамгаалагчийн буутай гарыг өшиглөтөл буу нь алдагдан завины тавцан дээр унаж гулган холдлоо. Буунаасаа салсан хамгаалагч Полунингийн баруун талаас цохилт хийхийг оролдсон боловч Полунин хариу өгөхөд бэлэн байв. Тэрээр хамгаалагчийн явуулсан нударган доогуур шалмаг бултан гарч түүний аюулхай орчимд хүчтэй цохилт өгчихөв. Ингэж хоёр дахь хамгаалагчийн эвхрэн нүдээ бүлтийлгэх ээлж ирэх нь тэр.

Полунин тэр даруй эхнийхийг нь заамдан авч хашлага руу чирч аваачлаа. Тэгснээ бууг нь хуйнаас нь сугалан авч өөрийг нь хашлага давуулан тэнгисийн ус руу шидэж орхилоо. Ус цалгих хүчтэй чимээ сонсогдож хэдэн хормын дараа хоёр дахь булиа хамгаалагч нь хамынхаа хойноос бас ус руу шидэгдчих нь тэр. Тэд хоёулаа бага зэрэг муужирсан байдалтай байсан учир ус залгиж живэх гэж сарвалзаж байхыг нь Полунин хараад тавцанд өлгөөтэй байсан хоёр ширхэг хамгаалах цагирагийг тэдэнд чулуудаж өглөө.

-Сэрүүцэж усан эмчилгээ хийлгэж үз, залуус минь хэмээн Полунин хэлээд эргэж зэвхий царайлсан Соловейчикт хандан: харин би та нарын ноёнтой бага зэрэг хөөрөлдөө гээд Соловейчик руу дөхөж очлоо.

-За одоо болох нь тэр. Чи одоо арай боловсон харьцах байх гэж бодож байна. Гөлөг минь чи сүүлийн саруудад яаж байснаа нэгд нэггүй ярь гэж зандрав.

-Иваныч чи намайг... чи яах нь вэ?

Полунин түүнд тулж очоод салтаа руу нь буугаа онилон:

-Завь дээр чинь өөр ямар эр хүн байна вэ? гэж хөмсөг зангидан асуув.

-Ямар ч эр хүн байхгүй гэж Соловейчик тэвдэн хариулаад, хоёр хамгаалагч минь хоёулаа завийг жолоодож чадах учир би өөр хүнийг аваагүй юм гэв.

-Завинд чинь эмэгтэй хүн байгаа юу?

-Байгаа гэж өөр газраас эмэгтэй хүний дуу гарав. Завины доод хөндийгөөс “Зенит” клубийн

иллэгчин байсан Ксения туялзан алхасаар гарч ирлээ. Тэрээр зөвхөн усанд сэлэхэд өмсдөг дотоож болон хөхний даруулгатай байх агаад алтан шаргал үсээ толгой дээрээ овойлгон боожээ.

-Би завин дээр байгаа ганцхан эмэгтэй. Гар бугаа Гришагаас холдуулахыг гуйж байна. Тэр танд ямар ч гэм хийж чадахгүй гэдэг нь харагдахгүй байна гэж үү дээ? гэж хүүхэн хэллээ.

-Тийм юм даа. Тэр надад хийх гэмээ аль хэдийнээ хийж гүйцээсэн гэж Полунин дуугараад Ксения руу эргэн инээмсэглэж:

-Мөн дөө. Бас танил нүүр байх чинь. Энэ хүнийг өөрийгөө дагуулаад явахыг ятгаж чадсан болохоор чи жинхэнэ мэргэжлийн мастер хүн юм даа. Гриша эндхийн охин бяруунууд үнэхээр чамд хүрэлцэхгүй байна гэж үү? хэмээн ёжлов.

-Та зохимжгүй доромжлолоо болиоч гэж Ксения гомдоллон хэлээд Соловейчикийн дэргэд очиж суумагц... Таны хэлсэнчилэн би зөвхөн мэргэжлийн мастер төдийгүй Гришагийн үнэнч хань байгаа юм гэлээ.

-Чи Гришагийн тухай дуртайгаа л хэл. Харин одоо бодоход Гриша Самбист бид хоёрт хэзээ ч үнэнч нөхөр байгаагүй юм байна гэж Полунин хэлэв.

-Иваныч чи дэмий ингэж ярьж байна хэмээн Соловейчик гонгиноод, чи яагаад бүх бурууг надад тохоод байгаа юм бэ? Тийм ээ би амьд үлдсэн, Тийм ээ би тэндээс зугтаж зайлсан. Тийм ээ би өөрийн хувьцааг худалдаж муугүй төвхнөж авсан. Самбист та хоёрыг бодвол би бага зиндааны хүн байсан учир тэд надаар оролдоогүй юм гэлээ.

Полунин ядрангуй байдлаар хөдөлж Соловейчикийн хажууд очиж суулаа.

-Тийм ээ. Маргах юм алга хэмээн тэрээр хэлээд чиний овор хэмжээг бус чиний хүн чанарыг чинь авч үзэх юм бол чи үнэхээр өчүүхэн зиндааны биеэ худалдагч гахай гэлээ.

-Ер нь чи намайг юугаар яллаж байгаа юм бэ? хэмээн Соловейчик гомдоллон дуу алдаад, өөрийн хувьцаагаа худалдсан гэж үү? Би тэр хувьцааг чинь өөрийн хөдөлмөрөөр олсон юм. Би амь насаараа дэнчин тавьж байж хэдэн хувьцаа цуглуулсныг минь чи өөрөө мэдэж байгаа шүү дээ гэв.

-Мэдэж байна. Гриша. Мэднэ гэж Полунин хариулаад харин би Самбист бид хоёрын хувьцааг Сатаров хэрхэн өөртөө авч чадсаныг мэдэхгүй байна. Одоо тэр хүн бид хоёрын хувьцааг өөрийн юм шиг эзэмшиж байгааг? гэж асуулаа.

-Үүнийг чинь би мэдэхгүй хэмээн Соловейчик мөрөө хавчин хариулаад, нэгэнт Самбист байхгүй болсон, чи зугтаж зайлсан болохоор тийм юм хийж чадсан байлгүй гэв.

-Бүү худал хэл. Новш минь хэмээн Полунин хилэгнэн зандраад, хэрэв чи Сатаровт бидний хувьцааг эзэмшихэд нь туслаагүйсэн бол хэрхэвч чамд мөнгө өгч чөлөөтэй явуулахгүй байсан гэлээ.

Энэ үед өөрийн нүүр царайг толинд харж хичээнгүйлэн гоодож байсан Ксения Соловейчик руу хүйтэн харц чулуудаад:

-Энэ хүн зарим юмыг чинь мэдэж байна шүү дээ. Үнэнээ хэлэх чинь дээр юм биш үү Гриша минь гэж анхааруулав.

Соловейчик хүүхэн рүү хүйтнээр харснаа Полунин руу эргэж дорой дуугаар:

-Иваныч, чи намайг уучил. Тэд намайг хүчээр тийм юм хийлгэсэн юм. Тэгээгүйсэн бол би өдийд амьд байхгүй байсан гэлээ. Тэгснээ хүндээр санаа алдан вискинээс том балгаад үргэлжлүүлэн:

-Самбист та хоёр тэгш эрхтэй оролцох ёстой байсан тэр “Солоком” компанийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд би ордог байв. Чухам тэр “Солокомд”, “Аркадийн” хувьцааны дөчин хувь ноогдож байсныг чи мэднэ. Синыцин та хоёр хувьцааны бодит эзэмшигч байхыг хүсээгүй харин албан ёсны баталгаатай журмаар хянаж байхыг илүү зохимжтой гэж гэж үзэж байсан гэж ярьтал,

Полунин өлгөж аваад:

-Удирдах бүрэлдэхүүн сарниж алга болоход чи ерөнхий захирлын эрхийн хэмжээнд Сатаровын нэрэн дээр итгэмжлэл гаргаж өгсөн гэж хэлэх гээ юу? гэж асуув.

-Тийм ээ гэж Соловейчик батлан хэлээд, энэ боломжийг Сатаров ашиглаж чадсан юм гэлээ.

-Тэгэхлээр Сатаров хувьцааны бараг ерэн хувийг хянах болсон хэрэг гэж Полунин тодруулаад, чөтгөр гэм. Би байдал ингэж эргэж болохыг урьдчилан тооцоолсон ч болоосой. Ингэсний чинь төлөө чамд хэдий хэмжээний хөлс төлсөн бэ? гэж асуув.

-Нэг их биш ээ. Гэвч энэ бяцхан завь худалдаж аваад дутагдах юмгүй амьдрахад хүрэлцэхүйц мөнгө өгсөн. Хэрэв намайг Томашевскийн нэр дээр итгэмжлэл бичнэ гэж болгоомжлоогүйсэн бол тэд надад сохор зоос ч өгөхгүй байсан гэж Соловейчик хариулав.

Полунин “Томотексийн” ерөнхийлөгч нэрийг сонсмогц хөмсөг зангидан:

-Энэ өрсөлдөөнд Сатаров Томашевский хоёр хэрхэн тохиролцож Решетов бид хоёрын эсрэг боссон явдлыг чи тодорхой мэдэж байна уу? гэж асуув.

-Би тийм ч их юм мэдэхгүй байна хэмээн Соловейчик мөрөө хавчин дуугараад, гэвч орон нутгийн захиргааны оролцоогүйгээр энэ явдал болоогүй байх. Томашевский мужийн захиргааны удирдах хүмүүст их хэмжээний хөрөнгө оруулалт амласан байж магадгүй. Тэр хүн өөрийн харьцаатай олон бүс нутагт ингэж ажиллагаа явуулдаг. Гэвч мэдээжээр амласнаасаа хэд дахин багыг өгдөг. Харин яагаад Сатаров түүнтэй холбоо тогтоосныг тааварлахад хэцүү. Тэрээр Москвачуудтай холбоо тогтоохыг эрс эсэргүүцдэг байсан шүү дээ гэж ярилаа.

-Тийм ээ. Тааварлахад хэцүү асуудал гэж чи зөв ярьж байна хэмээн Полунин түүний

хэлснийг зөвшөөрөн дуугараад гэвч энд онцгой нууцлаг юм байхгүй. Сатаров бидэнд итгээгүй учраас түрүүлж сум тавихаар шийдэж л дээ. Магадгүй тэрээр аль эртнээс өрсөлдөгч нараа зайлуулахыг төлөвлөж байсан байж ч болно гэв.

-Түүнийгээ хэрэгжүүлсэн бололтой гэж Соловейчик зөвшөөрөн хэлээд миний ойлгосноор Томашевский зөвхөн талийгч Коля Решетовын төлөөний хүн Серегины мэдлийн хувьцааны арван хувийг салгаж чадсанаар зогссон хэрэг байх гэв.

-Тэгэхлээр үнэн хэрэгтээ компанийн бүх хувьцааг Сатаров Томашевский хоёр хянаж байна гэсэн үг үү? гэж Полунин асуув.

-Арай ч тэгж хэлж болохгүй гэж Соловейчик төлөв янзаар хөмсгөө өргөн дуугараад, бүх хувьцааны асуудлыг ганцхан Сатаров шийдэж байгаа. Харин Томашевский зөвхөн түүний зөвшөөрлөөр л хувьцааны асуудалд оролцдог юм гэлээ.

Полунин бодлогошрон байснаа:

-Тэгвэл тэр хоёрыг нөхөд гэж хараахан нэрлэж болохгүй нь ээ? гэж дуугарав.

-Тэр мэдээж хэмээн Соловейчик батлан хэлээд, тэгээд ч бизнест ямар найз нөхөр гэж байх вэ дээ. Бизнест зөвхөн хувиа хичээсэн сонирхол байдаг. Тийм учраас тэд бие биенээ аль болох илүү тонохыг эрмэлзэж байдаг юм гэлээ.

Полунин Соловейчикийг муухай харцаар ширвээд автал тэрээр дахин эмээн эвгүйцэж гэмшсэн байдлаар

-Иваныч чи ойлго. Би та нарыг хаяагүй, би хүчинд автагдсан. Бид энэ дайнд ялагдал хүлээж би зөвхөн бууж өгөх гэрээнд гарын үсгээ зурсан хүн. Би чамайг энэ явдалд үнэхээр дургүйцэнэ гэж мэдэж байсан боловч өөр арга байсангүй гэж тайлбарлав.

Полунин гар бууг ширээн дээр тавиад ядарсан байдлаар сандлын түшлэгийг налан:

-Чөтгөр аваг чамайг Гриша минь. “Солокомын” удирдлагад чам шиг хүмүүсийг итгэж оруулж байдлыг ингэж цус урсгах хүртэл ноцтой хурцатгахаас урьдчилан сэргийлж чадаагүй нь миний буруу гэж хэлээд босож завины хашлагад очоод аврах цагираг углаад хөвж байгаа хамгаалагч нарыг харж зогссоноо

-Чи энэ англиар хазгай ярьдаг мөртлөө орос хэлээр сайн ярьдаг еврейн тусгай ангид алба хаасан залуусыг хаанаас олоо вэ? гэж асуув.

-Эд нар манай залуус байгаа юм. Урьд нь тэд Мурманскийн цагдаагийн газар ажиллаж байгаад наашаа цагаачилж ирсэн юм. Тэгээд дэмий хэсэж тааралдсан ажил хийж явахад нь би олж авсан юм. Тэд их хөлс нэхдэггүй, зэвсэг муугүй эзэмшиж чаддаг бололтой. Харин чи Иванов хаана ингэж нүдэлцэж сураа вэ? Чамайг ингэж зодолдож чадна гэж би санасангүй гэж Соловейчик асуув.

Полунин хариу инээмсэглээд:

-Би залуудаа боксын дэд мастер болтлоо хичээллэж байсан юм. Дараа нь тагнуулын суманд алба хааж байхдаа зодооны бусад аргыг хичээнгүйлэн сурч байсан. Туулж ирсэн амьдрал маань ч энэ урлагийг мартаж боломгүй байдлаар явж ирсэн юм даа гэж хэлэв.

-Харин та англи хэл хаана сурсан юм бэ гэж Ксения асуув.

-Бас л тэндээс, залуу насны тэртээгээс гэж Полунин хариулах зуураа шатны нэг үзүүрийг ус руу буулгаж, би зоонд байхдаа чөлөө зав ихтэй байсан учир бага сага оролдож байсан юм гэлээ.

Полунин хашлага дээгүүр тонгойн хамгаалагч нарт хандан:

-Хүүе эрчүүд минь уснаас гар. Харин бүү дүрсгүйтээрэй. Та нарын аюулгүй байдалд санаа тавьж би зэвсгийг чинь одоохондоо өөртөө авч байх болно гэж хашгирлаа. Тэгснээ эргэж ирэн сандалд суугаад инээмсэглэн:

-За яахав Гриша урилгагүй ч гэсэн ирсэн зочиндоо зориулж ширээ засах юм биш үү? Жаахан сууж юм балгаж хууч хөөрөлдье. Миний гаргасан энэ бяцхан үзүүлбэрт чи гомдчихоогүй биз дээ? гэж асуув.

-Үгүй дээ. Иваныч минь хэмээн Соловейчик төлөв байдлаар хариу хэлээд гомдоогүй. Учир нь яаж ч бодсон чи надад гомдол гаргах бүрэн үндэслэлтэй хүн гэж хариулав.

Хамгаалагч нар шатаар өгсөж тавцан дээр гараад нойтон хувцсаа тайлж ганцхан богино дотуур өмдтэйгөө үлдэв. Бужгар үст залуу нь хувцсаа хатаахаар хашлага дээгүүр өлгөн тавьж намхан нь хашлаганы хөндлөвчөөс барьж дээш доош сууж чимээ ихтэйгээр амьсгалан биеийн дасгал хийж эхэллээ.

* * *

Полунин Соловейчикийн завин дээр хоног гаруй хугацаанд байсан бөгөөд дараачийн өдөр нь усан онгоцоор Кипр рүү буцах ёстой байлаа. Энэ бүх хугацаанд Соловейчик түүнийг дээд зэргээр хүндлэн дайлж байсан ба энд ирээд төвхнөх хүртлээ хэрхэн зүдэрч явснаа удаан цагаар ярьж байсан билээ.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд зөрчил гарч эхэлмэгц тэрээр хотоос зайлж явахаар шийджээ. Энэ зөрчил туйлдаа хүрч үүнийг тайван замаар шийдэх боломж нэгэнт байхгүй болсныг Соловейчик ойлгосон байна. Тэгээд хотод буун дуу сонсогдож эхэлмэгц тэрээр биеэ авч зайлах цаг болсныг мэдсэн байна. Чухам яг энэ үед Веселовский өөрийн саналаа түүнд тулгаж бас нэг хоног өнгөрч Соловейчик аяны чемоданаа бэлтгэж байхад нь гэрт нь Сатаровын залуус дайран орж ирээд түүнийг барьж өөрийн босстоо авчирч өгсөн ажээ.

Сатаров түүний өмнө нэгэн баримт бичиг дэлгэн тавиад гарын үсэг зурахыг шаардах зуураа бас хажууд нь тавиастай байсан гар буу, боодол мөнгө хоёрыг зааж алиныг нь сонгож авахаа өөрөө шийд гэж шахсан ажээ.

Гриша удаан эргэлзэж бодолгүйгээр шуудхан үзэг авч гарынхаа үсгийг зурсан байна.

-Би чамайг муугүй мэднэ гэж дараачийн өдрийн орой тэд зоогийн ширээний ард сууж байхдаа Соловейчик үнэнээ хэлээд, энэ тулалдаанаас чи зүгээр л нэг гараад явчих хүн биш гэдгийг би мэднэ. Чи Сатаровын суудал дор нүх ухааж өөрийн эхнэр, найз Синицыны өшөөг авахын тулд бас алдсан бүхнээ эргүүлж авахын төлөө бүхнийг шургуу бөгөөд шантаршгүйгээр зүтгэх хүн гэдгийг ч мэднэ гэлээ.

-Чи тэгээд юу хэлэх гээд байгаа юм бэ? гэж Полунин гайхан асуув.

-Хамгийн хялбар, хамгийн хэцүү гэсэн хоёр бодлого байдаг гэж би хэлэх гээд байгаа юм. Хэрэв чи зүгээр л Сатаровын толгойг хага буудахаар шийдсэн бол энэ чинь хамгийн хялбар бодлого юм. Үүнийг амархан хэрэгжүүлж чадна. Хэрэв чи түүнийг уг үндсээр нь нураах гэвэл чамд их цаг хугацаа хүч ухаан хэрэгтэй болно. Чамд түүний сул талын тухай их мэдээллээс гадна хүчтэй туслагчид хэрэгтэй гэж Соловейчик зөвлөв.

-Зөвлөгөө өгсөнд чинь баярлалаа Гриша минь. Гэвч би өөрөө энэ тухай их бодсон.

-Тэгвэл би чамд зөвхөн амжилт хүсье. Яагаад гэвэл би зөвлөгөө өгөхөөс өөр юмаар тусалж чадахгүй байх даа

-Ямар зөвлөгөө?

-Чи Сатаровын санхүүгийн асуудлыг барьж ав. Тэнд түүнийг дэгээдэж болох олон булхай байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна.

-Ойлголоо гэж Полунин толгой дохиод гэнэтхэн, Гриша сонсож бай. Энд ингэж амьдрах нь чамд таалагдаж байна уу? Хувь заяа чинь ингэж эргэсэн явдалд чи юу гэж бодож байна вэ? гэж асуув.

-Үнэнээ хэлэхэд надад нэг их таалагдахгүй байна хэмээн Гриша үрчийн хэлээд, нэг л уйтгартай, нэг хэвийн. Сонин юм юу ч алга. Орост бол аюултай ч гэсэн сонирхолтой гэж хариулав.

-Тэгвэл чи надтай хамт буцах юм биш үү гэж Полунин инээмсэглэн асуугаад осолтой бөгөөд сонирхолтой амьдралыг би чамд баталгаатай амлаж байна гэлээ.

Соловейчик дахин ярвайгаад булбарай гараараа үсэрхэг гүзээгээ илж толгой сэгсрэн:

-Үгүй дээ, Иванов минь. Тавил нь хэтэрхий их юм. Миний хүч хүрэхгүй. Миний амьжиргаанд их юм хэрэгтэй гэж үү? Мөнгө байна, завь байна, Ксения хүссэн цагт минь бэлэн өгдөг. Тийм учраас би эндээ үлдсэн минь дээр. Харин чамд амжилт хүсье гэж хэллээ.

* * *

Долоо хоногийн дараа гэхэд Полунин нисэх онгоцоор Москвад ирж Израиль руу явахын өмнө байрлаж байсан “Александровская” зочид буудалд шууд хүрч ирлээ. Полунин 3 дугаар

давхарт нэг өрөө байр хөлслөн авлаа. Тэрээр буудлын доторхи багавтар бааранд орж хооллоод өрөөндөө буцаж ирэн “Прогресс” гэдэг ресторан руу утасдав.

-Рестораны захиргаа байна гэж эр хүний чанга дуу сонсогдлоо.

-Танай ерөнхий зохицуулагчтай ярих хэрэгтэй байна.

-Манай захиралтай гэсэн үг үү?

-Үгүй ээ. Надад Мироновтой ярих хэрэг байна. Утасны нөгөө үзүүрт байгаа эрэгтэй хүний дуу хэдэн мөч чимээгүй байснаа

-Өөрөө хэн бэ? Нэрээ хэлнэ үү? гэж асуув.

-Миний нэрийг Полунин гэдэг. Бас Володя, Седой ч гэсэн болно. Миронов намайг мэднэ.

-Тан руу ямар дугаараар утасдах вэ?

-Би өөрөө арван минутын дараа утасдъя гээд Полунин утсаа тавилаа. Хэлсэн ёсоороо Полунин 10 минутын дараа дахин утасдлаа. Нөгөө эрэгтэй хүний чанга дуу гарч:

-Өнөө орой найман цагт хүрээд ир. Орох хаалганы жижүүрт хэлэхэд чинь дагуулж оруулна гэлээ.

Оройн долоон цагт Полунин буудлаас гарч ойролцоох метро зүг чиглэн явлаа. Ховорхон тохиолдох дулаахан өвөл болж байв. Энэ орой хотын гудамжинд таван хэм дулаан, нойтон цас малгайлан орж байна. Полунин хотын нэгэн супермаркетаас саяхан худалдаж авсан богино пальтоныхоо захыг босгон болзсон рестораны ойролцоох метроны “Краснопрессенская” станцаас гарч явав. Ингэж тэрээр хотын дулаахан үдэш таашаалан зугаалж явсаар яг найм гэхэд “Прогресс” рестораны үүдний танхимд орж очлоо.

Полунин тэнд байгаа жижүүрт нь дөхөж очоод өөрийнхөө нэрийг хэлж ресторанд хүн хүлээж байгааг учирлав. Хамгаалалтын албаны ажилтан баймаар хижээлдүү насны ширүүн байрын эр юм асуулгүйгээр өөрийг нь дагуулан цааш оров. Тэд хоёрдугаар давхарт гараад хонгилд дэвссэн улаан өнгийн хивсэн дээгүүр чимээ гаргалгүй алхалсаар 305 дугаар өрөөний үүдэнд хүрч очив. Жижүүр хаалгыг нь тогшвол өндөр нуруутай, цайвар үстэй, хөдөлгөөнтэй онгигор нүдтэй нэгэн шөрмөслөг залуу босгон дээр гарч ирлээ.

-Энэ хүн гэж жижүүр Полунин руу дохиод, Василь Васильевичтай энд уулзахаар тохирч ирсэн юм гэлээ.

-Орогтун гэж залуу зай тавин өгөөд Полунинг үүдний жижигэвтэр өрөөнд оруулав. Энэ өрөөтэй залгаа үнэтэй тавилгатай том өрөө байх ажээ.

Өрөөний голд урд урдаас нь харуулж тавьсан арьсан бүрээстэй буйдан байх агаад нэгэн дээр нь тавь орчим насны өргөн цээжтэй эр сууж байлаа.

Цоохордуу нүүртэй, тэрээр шанааны хавь нь бууралтаж байгаа халимагаа ар тийш нь нямбай гэгчээр самнажээ. Тэртэй тэргүй сүрлэг харагдах бие төрхийг нь бараан өнгийн цардмал цамц, хар өнгийн костюм нь улам сүр жавхлантай болгожээ.

Байрны эзэн Полунинг хармагц инээмсэглэн босож угтаж ирлээ.

-Сайн байна уу? Володя? Чамтай уулзсандаа баяртай байна хэмээн бараан хувцастай эр мэндлээд чигчий хуруунд нь очир алмаас шигтгээтэй том бөгж зүүсэн том алгаа өглөө.

Полунин гарыг нь барьж:

-Сайн байна уу, Мирон гэж хариу мэндлэв.

Василий Васильевич Миронов бол Мирон гэж хочтой эрүүгийн хүрээний томоохон нэртэй төлөөлөгч, дархлагдсан том хулгайч хүн ажээ. Полунин түүнтэй урьд нь зоонд байхдаа танилцсан юм. Полунин өөр нэгэн нэртэй эрүүгийн хэрэгтэн Лена Быктэй ойр дотно байсан учир өөрийн найз Мироныг зоонд хүлээн авах цайллаганы ширээндээ Полунинг урьсан ажээ. Удалгүй Лена Бык Полунин хоёр зооноос суллагдсан байна. Дараа нь тэд олон жил хоршин ажиллажээ. Полунин автомашин хулгайлж хоршоо нөхөр Ленагаар дамжуулан борлуулдаг байв. Харин Полунин Миронтой ажиллагааны шууд харьцаатай байгаагүй юм. Гэвч тэр хоёр Москвад юм уу эсвэл Полунингийн амьдарч байгаа хотод байнга уулзалддаг байв. Тэд хэзээ ч дотнын нөхөр байгаагүй боловч бие биенээ хүндлэн үзэх үндсэн дээр сайн харьцаагаа ямагт хадгалж байхыг эрмэлздэг байлаа. Полунин өөрөө олон жил эрүүгийн ертөнцтэй холбоотой байж хууль бус бизнесээр оролдож байсан боловч хулгайчдын хаанчлалд хэзээ ч өндөр зиндаанд хүрэхийг эрмэлздэггүй байв. Тийм учраас Мирон хотын “ерөнхий хянагчаар” ажиллахыг Полунинд санал болгоход тэрээр хүлээж аваагүй юмсанжээ. Ингээд түүнтэй олон жил хамт зоонд байсан Решето Коля хотын “ерөнхий хянагчаар” ажиллах болжээ. Мирон эрт орой хэзээ нэгэн цагт алуулсан найзынхаа өшөө авах аргыг эрэлхийлнэ гэдгийг Полунин мэдэж байсан юм. Чухам ийм учраас Полунин түүнтэй уулзахаар зорьж иржээ. Эрчүүд бие бие рүүгээ харан буйдан дээр суусны дараа Мирон бие хамгаалагч руугаа дохин:

-Ямар нэгэн ам руу хийх юм бэлтгэж, дарс авчраарай. Хамгийн сайныг нь. Өнөөдөр миний хүндтэй зочин ирээд байна гээд хараагаа Полунин руу шилжүүлэн:

-Чиний хүрээд ирсэн явдалд би маш их баяртай байна. Би чамтай уулзах юмсан гэж ихэд хүсэж байлаа. Тэр ч бүү хэл цагдаагийн газраас зугтаж явсны чинь дараа би чамайг хайж байсан юм. Гэвч чи миний ч олохооргүй газар нуугдаж амжсан байлаа гэв.

Полунин тааламжтай инээмсэглэн тамхиа гарган асааж:

-Надаас урваж шарвахгүй харин надад хэзээ ч туслахад бэлэн сайн нөхөд бас үлдсэн гэж би боддог гэж хариу хэллээ.

-Эргэлзэх юмгүй гэж Мирон батлан хэлээд өөрийн чинь ажил хэрэгт туслахад бэлэн тэдний нэг чинь би байна гэлээ.

-Чи яагаад надад туслахыг хүсээ вэ, Василь хэмээн Полунин өөр тийш харан асуув.

Мирон учиртай инээмсэглээд:

-Чамайг одоо юу хийж байгааг мэдэхийн тулд хүмүүсийг хэтэрхий их судлах гэж оролдсоны хэрэггүй. Харин би чамайг өшөө авах ганцхан зорилготой амьдарч яваа хүн гэж ойлгож байна. Бодвол чи нойрсох болгондоо зөвхөн тэр хөлдүү Сатаровын толгойг авч байгаагаар зүүдэлдэг биз. Хэрэв би эндүүрээгүй бол... эндүүрээгүй гэж бодож байна... Би чамд дуртайяа туслахад бэлэн байна. Надад ч Сатаровтай хийх тооцоо бий гэж хэллээ.

Полунин утаа савсуулан хэдэн хором түүнийг дуугүй сонсож сууснаа:

-Бүх юм тийм ч хялбар зүйл биш. Василь Васильевич минь. Сатаров мэдээж төмсөгөө сугалуулах гавьяатай хөлдүү боловч алуурчдыг хөлсөлж цус урсгасан жинхэнэ эзэн нь чиний найз Коля Решето байгаа юм. Чухам тэр түрүүлж хөлсний алуурчдыг хотод дуудаж ирүүлсэн гэх мэдээлэл надад бий. Харин чи Василий Васильевич тэр алуурчдыг олоход нь найздаа тусалсан юм биш биз дээ гэж асуув.

Сэтгэлийн хөдөлгөөн нь барагтай мэдэгддэггүй Мироны нүүр энэ удаа чулуу шиг барзайн:

-Чи Володя намайг яллах гэж ирсэн юм биш биз? Хэрэггүй юмаар намайг буруутгах гээ юу? гэж Мирон илтэд дургүйцсэн өнгөөр нам дуугаар асуув.

-Бүү гомд Василь Васильевич минь. Энэ дайнд би хэтэрхий их юм алдсан. Одоо би хэтэрхий их эрсдэлтэй юм хийж байна. Би нэгэнт ийм осолтой ажил барьж авсан учир бүх үнэнийг мэдэхийг хүсэж байна. Ийм учраас энэ дайнд надад тусламж биш холбоотон хэрэгтэй.

Полунингийн ингэж хэлсний дараа Мироны харц бага зэрэг зөөлөрсөн боловч харцны нь гүнд бага зэрэг гомдлын оч сүүмэлзсээр л байлаа.

-Сайн байна гэж тэрээр эвлэрэнгүй дуугараад, би мэдэх бүхнээ цөмийг нь чамд хэлье. Гэвч харамсалтай нь мэдэх юм надад бага байгаа гэв.

Тэгснээ сандлынхаа түшлэгийг налж гүнээ санаа алдсанаа үргэлжлүүлэн:

-Коля миний найз байсан юм. Бид хоёр хэдэн жил зоонд хамт мунгинаж байлаа. Би түүнийг чадлынхаа хэрээр дэмждэг байсан юм. Тийм ээ, тэр хамгийн тэвчээртэй нь биш байсан. Зарим үед хэтэрхий огцом аашилдаг ч байлаа. Нас минь явах тусам үүнийг нь улам илүү ажиглах болсон юм. Гэвч тэр бол хэзээ ч тохиролцож болох шударга эр байсан. Үнэнээ хэлэхэд тэрээр тийм алхам хийнэ гэж би бодоогүй. Бид хоёр нэлээд удаан хугацаагаар уулзалдаагүй байтал гэнэтхэн тэрээр над руу утасдаж бий болсон байдлыг шийдэж чадах чадварлаг залуус өөрт нь хэрэгтэй болоод байна гэсэн. Түүнийг хэн нэгэн ихээхэн гомдоосон учир ингэхээр шийджээ гэж би хожим нь ойлгосон юм. Тэрээр шинээр төрөн гарч байгаа ямар ч хууль журмыг хүндэлдэггүй залуу хэт даврагчдыг үзэн яддаг байсан. Тийм залуустай чи хэлхэлдэх болсон нь түүнийг ихэд эмзэглүүлсэн бололтой.

-Мирон чи мэдэх ёстой. Решетов өөрийн сонирхлоо хадгалан үлдэхийн тулд би чадах бүхнээ хийсэн. Хэрэв би байгаагүйсэн бол тэр өөрт ноогдох хувийг авч чадахгүй байсан юм.

-Магадгүй би үүнийг чинь ойлгож үнэлэх байсан. Харин Решетовт энэ чинь хангалтгүй байж л дээ. Колягийн хувьд тэр нэр хүнд нөлөөний хүрээ ямагт халаасанд нь шажигнах мөнгөөр хэмжигддэг. Тодорхой цагт түүний зөв байж болох юм. Гэвч амьдрал өөрчлөгдөж одоо ихээхэн хэцүү болж хувираад байна гэж хэлээд Мирон өнгөрснийг эргэцүүлэх мэт хэдэн хором дуугүй байснаа үргэлжлүүлэн:

-Та нар түүнд ноогдох ашгийг нь өгөхөөс татгалзах үед Коля үүнийг чинь өдөөн хатгаж, өгнээнээсээ гаргаж хаях гэж байна гэж ойлгосон. Энэ явдалд бухимдаад хэрэггүй гэж би түүнд ойлгуулахыг ихэд хичээсэн. Володя Седой мөнгөнөөс болж буруу юм хийх хүн биш гэж би түүнд итгүүлэхийг хичээсэн. Чи түүнийг хэрхэвч орхихгүй гэдгийг би сайн мэдэж байсан юм. Надад та нарын хэрэгт оролцох боломж огт байгаагүй үед өөрт минь асуудал гарч ирсэн. Тэгэхэд Коля дэгээтэй өгөөшийг үмхэж орхисонд одоо би харамсаж явдаг. Би түүнийг тийм хилэнтэй доромжлуулсан мэт байсныг өмнө нь хэзээ ч хараагүй байсан. Хэрэв би тэр үед танай хотод очсон бол тэр мөргөлдөөнийг эвээр шийдүүлж чадах байсан гэж одоо боддог юм.

-Чиний энэ ярьсанд би огт эргэлзэхгүй байна хэмээн Полунин мөрөө хавчин хэлээд, харин чи гол юмыг хэлсэнгүй гэв.

-Юу юм бол? гэж Мирон асуув.

-Коля чамаас чадварлаг залуусыг олж өгөөч гэхэд нь чи юу гэж хариулсан юм бэ? гэж Полунин асуув.

-Ямар хариу өгсөн бэ гэж үү? гэж Мирон бодлогошрон дуугараад нэгд би энэ гуйлтад нь ихэд гайхсан, хоёрт чи хэт бүү цухалд. Чамтай аль болох тайвнаар ярилцаж учраа ол гэсэн. Тэгсэн чинь тэр чамайг сонирхоогүй байна, чамд өгөх буруу байхгүй. Надад өөр хүмүүстэй тооцоо хийх хэрэгтэй байна гэж хариулсан гэж хариулав.

-Ямар хүмүүстэй тооцоо хийх гэж байгаагаа хэлээгүй юу?

-Хэлээгүй гэж Мирон хариулаад мэдээж тэр хүн нь Сатаров гэдэг нь тодорхой гэж би бодож байна. Би өөрөө удахгүй танай хот орж та нарын тэр мөргөлдөөнийг зогсооход тусална гэж бас хэлсэн гэв.

-Ямар ч гэсэн тэрээр хөлсний алуурчдыг олж хот руу ирүүлсэн гэж Полунин хэлэв.

-Тийм ээ, тэр тэгсэн гэж Мирон өөр тийш ширтэн бодлогошрон дуугараад, хэн гэдгийг нь би бүр мэдэж байна. Решето Рязень дахь нэгэн томхон бүлэгт хандсан юм билээ. Бүлгийг Музыкант гэдэг хочтой туршлагатай алуурчин толгойлдог. Тэднийг хотод ирэхэд нь баривчлан саатуулсан гэж чи үнэн хэлж байна. Би ч энэ тухай дуулсан. Одоо хүртэл би тэдний тухай өөр юм сонсоогүй гэв.

-Хачирхалтай юм гэж Полунин бодлогошрон дуугараад хотын нэгэн цагдаагийн ажилтан

Бирюков гэгч тэднийг суллахаас өөр аргагүй гэж мэдэгдсэн юм. Учир нь тэднийг яллах тодорхой баримт нотолгоо байгаагүй юм байх гэлээ.

Мирон түүнийг дуугүй сонсож суулаа.

-Василий тэр хөлсний алуурчдын талаар тодорхойлолт өгч надад тус бол гэж Полунин хүслээ.

-Тэгье гэж Мирон зөвшөөрөөд тэд ямар нэгэн юмаараа чамд сонирхогдож байна уу? гэж асуув.

Полунин хөмсөг зангидан:

-Бүр яаж сонирхогдож байна гээч. Тэд тун сайн зохион байгуулалттайгаар аллага үйлдсэн байгаа юм. Тийм аллагыг ганц хоёр буудагчид үйлддэггүй зөвхөн өндөр мэргэжлийн чадварлаг бүлэг л чадна. Спортын клубт зөвхөн гурван буучид арван нэгэн хүнийг цааш нь харуулсан. Тэр гурвыг аллага үйлдээд гарч явахад нь хажуугийн байрныхан нь харсан юм билээ гэж хэллээ.

-Хэрэв чи намайг дайснаа бус холбоотноо гэж баттай итгэн надаас тусламж хүсэж байгаа бол өөр чамд юугаар би тусалж чадах вэ? Володя? гэж Мирон асуув.

-Надад чухам холбоотон хэрэгтэй гэж Полунин хэлээд, хэрэв чи надад туслахсан бол би ихэд баярлана. Гэвч одоохондоо юугаар тусламж хүсэхээ сайн мэдэхгүй байна гэж хариулав.

-Хэрэв чамд мөнгө юм уу хүмүүс хэрэгтэй бол асуудал байхгүй би шууд тусална гэж Мирон яаран хэлээд, одоо танай хот руу очиж байлдах гэвэл учир утгагүй хэрэг болно. Би үүнийг бас туршиж байсан юм. Тэнд мөргөлдөөн болж байгааг мэдмэгц би мэргэн буучийг явуулж үзсэн. Гэвч ямар ч ашиг гараагүй. Мэргэн бууч маань хоолойгоо огтлуулан нэгэн цэцэрлэгийн урт сандал дээр хэвгэж байсныг өглөө эрт олсон гэдэг. Түүнийг бүр зочид буудалд байхад нь мэдсэн бололтой. Уг нь тэр тун хашир туршлагатай хүн байсан юм. Тийм учраас одоо танай хот руу хүн явуулж болохгүй. Сатаров хагуу хяналт тогтоож тун сонор сэрэмжтэй байгаа. Өгөөш авсан цагдаа нар түүнд тусалж байгаа байх. Далимд хэлэхэд гээд Мирон Полунин руу үл ойлгогдох харц чулуудаад, чи тэр хотын хүн. Чамд туслах нөхөд тэнд чинь үлдээ биз дээ? гэж асуулаа.

Полунин инээмсэглээд:

-Ийм учраас чи намайг хот буцаж очоод Сатаровын эсрэг дайн эхлүүлэх цөөхөн хүний нэг юм гэж бодож байгаа биз дээ? гэж асуув.

Мирон дуугүй суух агаад Полунин яриагаа үргэлжлүүлэн:

-Василь Васильевич чи зөв ярьж байна. Би хот руу буцаж очоод Сатаровын эсрэг тооцоо хийхийг үнэхээр их хүсэж байна. Энэ утгаар чи маш зөв бодож байна. Түүний эсрэг дайныг энд Москвагаас эхлэх нь зүйтэй гэж чи бас зөв хэллээ. Яагаад гэвэл тэр довон дээрээ

хэтэрхий их хүчтэй дайсан. Сатаровыг дарж авах хүсэлтэй нэр нөлөө бүхий хүнийг энд Москвагаас олох хэрэгтэй. Чухам эндээс Москвагаас түүний эсрэг давлагааг үүсгэж тэр давлагааны цалгианаар би хот руугаа очих нь зүйтэй гэж ярилаа.

Мирон хөмсөг зангидан Полунинг сонсож чигчий хурууныхаа том бөгжийг эргүүлж сууснаа:

-Юу ярьж байгааг чинь би ойлгож байна. Володя минь. Надад цагдаагийн болон Ерөнхий прокурорын газар хэдэн танил бий. Хэрэв тэдэнд шалтаг гарган сонирхолыг нь хөдөлгөж чадвал Сатаровыг номхруулж чадах хүмүүс. Гэвч чамд үнэнийг хэлэхэд үүнийг хийх нь тийм ч хялбар бус асуудал гэлээ.

Энэ үед хаалга тогшин Мироны гарын туслах нь дарс, зууш тавьсан тэргэнцэр түрсээр орж ирлээ.

-За алив Володя. Ажлын талаар бид ярьж амжина. Уулзсаныгаа тэмдэглэж, эхэлсэн ажлынхаа амжилтын төлөө тулган дарс балгая гэлээ.

Бүр орой болсон хойно Полунин Мироны байрнаас гарч ард нь дагуул байгаа эсэхийг сайтар ажигласаар нөгөө метрогоор байрласан зочид буудалдаа хүрч ирлээ.

Тэрээр Мионовт итгээгүйдээ ингэж болгоомжлоогүй бөгөөд эхэлж буй энэ осолтой ажилд зөвхөн өөртөө болон үнэнч нөхөддөө л итгэх хэрэгтэй гэж үзсэнээс ингэж байгаа юм. Байж болох бусад холбоотнууд бол зөвхөн өөрийн ашиг тусыг бодож Полунинд тусална. Полунин энэхүү ашиг тус нь зарим үед өөрчлөгддөгийг өөрийн гашуун туршлагаас мэдэж авсан юм.

* * *

Гэвч Мирон Полунингийн цорын ганц холбоотон биш байжээ. Полунингийн Москвад байх хоёр долоо хоногийн хугацаанд цаашдын ажиллагаанд олон талаар тус болох гэнэтийн чухал уулзалт болсон юм. Нэгэн удаа бүр оройн арван цаг болж байв. Полунин Миронтой ээлжит яриагаа хийж түүнээс тэр хүн өөрийн өндөр албаны хүмүүсээс зөвлөгөө авч эхэлснийг мэдээд дөнгөж сая буудалдаа эргэж ирээд байсан юм. Өнгөцхөн бодоход тэд Мирон Полунин нарт туслах гэсэн юм шиг байв. Полунин жижүүрээс түлхүүрээ авч гурван давхарт гарлаа. Өрөөндөө орж пальтогоо тайлан хаалганы хажуу дахь шүүгээнд өлгөөд цахилгаан данхаа залгаад хажуугийн мухлагнаас худалдаж авсан сонингуудаа гарчиглахаар завдан байтал хаалгыг нь тогших чимээ дуулдаж түүнийг сэрэмжлүүлэхэд хүргэв.

Энд амьдарсан хоёр долоо хоногийн туршид хэн ч ийм орой болсон хойно ирж байгаагүй юм. Энэ бол дээд зэрэглэлийн тансаг биш боловч нам тайван буудал байлаа. Энд дунд зэргийн бэлтэй хүмүүс томилолтоор ирж байрладаг ажээ. Гудасны завсар гар буюугаа хийсэн ор руугаа яаран хүрэх зуураа:

-Хэн бэ? гэж Полунин асуулаа.

-Тух алдуулсан явдалд уучлаарай. Бид буудлын аж ахуйн хүмүүс байна. Доод давхарт чинь усны шугам гэмтээд байна. Таны өрөөг шалгаж үзэх гэсэн юм гэх эрэгтэй хүний намуухан

дуу хонгилоос сонсогдлоо.

Өөр цагтсан бол Полунин хар саналгүй тэднийг оруулах байсан боловч ийм орой болсон үед энэ бол хуурмаг үг занга гэдгийг Полунин мэдэж байв. Хонгилд гарсан эрэгтэй хүний дуу түүнд танил юм шиг санагдаж байлаа. Гэвч өмнө нь нэг бус удаа сонсож байсан тэр уянгалаг баргил дуу хэнийх гэдгийг тааж чадахгүй байв.

Тэгэхлээр энэ буудлын хүмүүсийн дуу яав ч биш. Полунин гар буугаа авч хаалга руу сэмхэн хүрч очоод замган түгжээг чимээ гаргалгүй мултлав. Дараа нь сандал дамжин хаалганы дэргэдэх шүүгээн дээр гарч нуугдаад:

-Орогтун. Би хувцсаа өмссөн. Хаалга түгжээгүй байгаа гэж хашгирлаа.

Хэдэн хором өнгөрмөгц хаалга чимээгүйхэн онгойж босго алхан хоёр эрэгтэй хүн цувран орж ирлээ. Нэг нь малгайгүй, хар халимагтай өндөр нуруутай хүн нөгөө нь дөрвөлжин хээтэй дугуй малгай өмссөн өндөр туранхай эр байлаа. Хоёулаа урт хормойтой цув өмсчээ. Сүүлд нь яваа дугуй малгайт дөнгөж босго алхмагц Полунин гараа доошлуулан бууны амыг чамархайд нь тулган нам дуугаар:

-Эргэж харалгүй хаалгаа хаа. Таван алхам урагшаа бол! Хэн нэгэн чинь эвгүй хөдөлгөөн хийвэл би хоёулангийн чинь толгойг хага буудна! гээд Полунин байдлын онц ноцтойг ойлгон бууныхаа замгийн түгжээг мултлав. Санаандгүй бий болсон осолтой байдал болон гар бууны замагны түгжээ мултлах чимээ урилгагүй зочдыг цочирдуулж алмайруулсан бололтой. Тэд хоёулаа байр байрандаа хором зуур хөшиж орхисноо арынх нь зугуухан гараа хөдөлгөн хаалгыг аяархан хаалаа.

-Одоо урагшаа бол гэж Полунин хэллээ.

Олзны хоёр хүн ерөөний гүн рүү аажуухан алхах үед Полунин шүүгээн дээрээс үсрэн буугаад хаалгаа түгжлээ. Олзлогсод таван алхам хийж зогсоход дөрвөлжин хээтэй малгайт нь:

-Одоо бид эргэж харж болох уу, Владимир Иванович? гэж асуув.

-Болохоор барахгүй тэгэх хэрэгтэй. Харин гараа ил байлгана шүү гэж Полунин хариулав.

Хоёр “зочин” бараг нэгэн зэрэг эргэж харахад нь Полунин гайхсанаасаа болж арай л исгэрчихсэнгүй. Өмнө Полунингийн бууны амыг сэжиглэнгүй харж “Нефтьоргсинтез” үйлдвэрийн ерөнхий захирал Веселовский тэгэхэд цагдаагийн газраас оргуулсан зөвхөн нэрийг нь Николай Иванович гэж тогтоож авсан тэр үл мэдэх хүн хоёр зогсож байх нь тэр. Тэр хүн түрүүлэн ам нээж:

-Биднийг ирсэн явдалд Владимир Иванович та гайхаж байгаа бололтой. Биднийг хүрээд ирнэ гэж та бодоогүй байсан биз. Гэвч би та бид хоёр эргэж уулзана гэж сануулсан шүү дээ гэж хэллээ.

-Энэ үгэнд чинь би бараг эргэлзээгүй юм хэмээн Полунин хариулаад гэвч та намайг энэ

Москвэд олж ирэх юм гэж би санаагүй юм шүү. Түүнээс гадна Сатаровын гарын үзүүрийн хүн энэ эрхэмтэй хамт хүрч ирэх юм гэж бүр ч санасангүй гэлээ. Нөгөө хүн

-Та юу юугүй шошго зүүхийг бүү яар. Тэгэхийн оронд буугаа цааш нь харуулаач. Сууж тайван ярилцъя. Бид танд муу юм санаж ирээгүй, харин туслах гэж ирсэн гэдгээ итгүүлж чадна байх гэж найдаж байна гэлээ.

Полунин инээмсэглэн:

-Намайг ийм байдалтай болгоод байхад туслахаар гараа өгөх олон хүн гарч ирнэ гэж би үнэхээр бодоогүй юм шүү. Харин тоглоомыг миний зохиосон дүрмээр явуулах ёстой. Миний хувьд та нарыг бууны хараан дор барьж ярилцах нь надад аюул багатай гэдгийг та нар ойлгоно биз гээд Полунин эрчүүдийн ард нь гарч биенд нь хатуу зүйл байгаа эсэхийг хурдан тэмтэрч үзлээ. Полунингийн санасанчлан зөвхөн Николай Ивановичаас гар буу гарлаа. Бүртгэлтэй “ПСМ”-ийг мөрөвчин оосортой гэрээс нь сугалан авч өмднийхөө халаасанд шургууллаа. Дараа нь Николай Ивановичийн хажуугийн халааснаас үнэмлэх бичиг, түрийвч зэргийг гаргаж ирэв. Тэрээр ор руугаа эргэж очоод сууж түүний үнэмлэх бичгийг нь үзлээ. Үнэмлэхний хатуу улаан хавтсан дээр “Холбооны аюулаас хамгаалах алба” гэж алтадсан үсгээр дармалдсан байлаа.

-Чөтгөр гэж хэмээн Полунин инээд алдаад, за тэр дээ. Өөр хэн намайг тэгж чадварлаг оргуулж чадах билээ гэж дуу алдав. Тэгснээ үнэмлэхний хавтсыг нээж:

-Бахметьев Николай Иванович. Холбооны аюулаас хамгаалах албаны хошууч гэж уншаад, за ингэж тантай танилцдаг байж гэлээ.

Нөгөө хүн дурамжхан царайлан дуугүй байснаа сандал авч өрөөний голд аваачиж тавиад дээр нь суулаа. Тэгснээ:

-Та миний үнэмлэх буу зэргийг эргүүлж өгөх юм биш үү гэж Полунинд хандан хүслээ. Полунин түүн рүү үнэмлэхийг нь чулуудан өгөхөд тэрээр шүүрэн авав.

-Одоохондоо үнэмлэхээ авч болно. Зэвсгээ ярианыхаа дараа аваарай. Ярианы үр дүн надад таалагдвал шүү дээ гэж Полунин хэлээд харцаа дуугүй зогсож байгаа Веселовский руу шилжүүлэв.

-Ноён Веселовский та сандал аваад хажууд нь сууна уу?

Веселовскийн хошуучийн дэргэд суусны дараа Полунин:

-За тийм байдаг байж. Одоо та нарын үгийг анхааралтай сонсьё. Ямар сонирхолтой санал гаргахаар та хоёр хүрч ирээ вэ? гэж асуув. Бахметьев:

-Та хүнд муу итгэдэг хүн юмаа даа. Владимир Иванович гээд Полунингийн гар дахь “ГТ” орон дээр тавиастай байгаа өөрийн “ПСМ” хоёрыг ээлжлэн харж яаралгүй дуугараад, яагаад та намайг ингэтлээ хардаад байна вэ? Би наад зах нь танд эрх чөлөөтэй болоход чинь

тусалсан. Магадгүй амь насыг чинь аварсан байж магадгүй гэж асуулаа.

-Та үүнийг эрх чөлөө гэж нэрлэж байна уу? хэмээн Полунин инээд алдан хэлээд, би өөр нэрэн дор анчдаас нуугдах араатан мэт амьдарч явна. Өөрийн хот орж хүүтэйгээ ч уулзаж чадахгүй байна. Эрх чөлөө гэж нэрлэвэл тун ч хязгаарлагдмал эрх чөлөө юм гэлээ.

-Эцсийн эцэст та хөдөлж, үйл ажиллагаа явуулах эрх чөлөөтэй байна гэж Бахметьев эсэргүүцэн хэлээд, энэ бол тун чухал гэлээ.

Полунин ХАХА-ны хошуучийг анхааралтай сонсож сууснаа:

-Би ажиллагаа явуулах боломжтой байх нь ямар нэгэн талаар танд ашигтай байна уу даа? гэж асуув.

-Та асуудлыг ойлгож ядаж байгаа юм шиг баашилсны хэрэггүй, Владимир Иванович минь гэж Бахметьев бухимдан сануулаад, аюултай бөгөөд хэцүү тоглоом явагдаж байна. Энэ тоглоомд оролцогчид өөр өөрийн сонирхолтой. Бүү үүнийг нуух шаардлагагүй гэж бодож байна. Тийм ээ. Би ч гэсэн өөрийн сонирхолын дагуу таныг оргоход чинь тусалсан юм. Хойшид ч гэсэн өөрийн сонирхолын дагуу танд туслах болно. Түүнээс гадна би хүний хувьд таны байдлыг ойлгосондоо ингэж байгаа юм. Таны өөрийн ойр дотнын хүмүүсээ алдаж уй гашууныг гэтлэн зүдэрсний чинь зовлонг ямар нэгэн хэмжээгээр хуваалцахыг хүсэж байна. Түүнээс гадна хэлэх юм байна гэж ярьтал Полунин үгийг нь таслан:

-Гүйцээ. Одоо болно хошууч аа! гэж Полунин Бахметьевын үгийг таслаад, дэмий сайхан үгээр юу хийхэв. Та нар надтай ажил хэргийн талаар ярилцах гэж ирсэн шүү дээ. Гол асуудлаа ярь. Миний ойлгосноор та нар Сатаровын эсрэг тэр тоглоом гэгчдээ тоглохоор бэлтгэж байна гэж болох уу. Гэвч чухам ямар хүний талд гэдгийг чинь би мэдэхгүй байна гэж асуув.

-Мэдээж шударга хуулийн талд гэж Бахметьев мөрөө хавчин хариулаад тэр даруй бухимдан үнэхээр та биднийг хөлслөгдсөн цагдаа болон дээрэмчидтэй хамтран хотын захиргааг өөрийн мэдэлд авахыг санаархаж байна гэж бодоогүй биз дээ. Тусгай албаныхан өөрийн нутаг хязгаарт хэрээс хэтэрсэн балмад явдал гаарч байхад зүгээр хараад суух эрхгүй юм. Би өөрийгөө бизнес болон засаг төрд эрүүгийнхэн нэвтрэн орохыг бүрмөсөн зогсоож чадна гэж хэлж чадахгүй. Гэвч хүчний тэнцвэртэй байдал дэг журмыг тогтоож байхад хэрэгтэй юм. Харин аль нэгэн бүлэглэл нь бусдыгаа устган ганцаараа ноёрхож бүгдийг хяналтандаа авбал хэзээ ч дэг журам тогтож шударга хууль хэрэгжихгүй гэж ярилаа.

-Ойлгомжтой хэмээн Полунин хэлээд цагдаагийнхан тусгайнхан хоёрын мөнхийн таагүй харьцаа таныг ийм алхам хийхэд хүргэв бололтой. Бас та нарын хянах боломжгүй бүлэглэл хотод бий болсон явдал ч түлхэц болсон байлгүй. Гэвч засгийн бүрэн ноёрхол өөрийн үр дүнг өгсөөр байна. Компани өрөө төлж, аажмаар хүчээ сэлбэж байгаа гэж би сонссон. Тийм учраас бүх юм ч тийм муу биш байгаа бололтой гэлээ. Ингэж хэлэхэд нь Полунингийн нүдэнд бага зэрэг дооглох байдал илрээд ирлээ.

Гэтэл Полунингийн санаандгүй байтал Бахметьевийн хажууд сууж байсан Велселовский

түүнээс гарч боломгүйгээр дүрэлзэн уурлаж:

-Энэ бүгд хөндлөнгөөс харж байгаагаас шал өөр юм. Компанийн байдал тийм ч сайн биш байгаа. Тийм ээ. Компани өрөө төлж барагдуулсан ажилчдынхаа цалинг нэмж цагт нь олгож байгаа нь сайн хэрэг. Гэвч үйлдвэрийн ашиг орлого нэмэгдэж байгаа боловч үйлдвэрийг өргөтгөн шинэтгэх ажил хийгдэхгүй байна. Ойрын хэдэн жилд ч хийгдэхгүй байх. Үүний зэрэгцээ багагүй мөнгө хилийн чанад дахь Сатаров болон түүний ойр дотныхны дансанд орж байна. Сатаров өөрөө үйлдвэрийг удирдахдаа ямар ч хүний зөвлөгөө авдаггүй, зөвхөн өөрт нь ашигтай буруу шийдвэр олон гаргадаг болсон. Тэр хүн өөрийгөө үйлдвэрийн цорын ганц эзэн мэт үзэх болоод байна.

-Тийм ээ. Тэр чинь үйлдвэрийн бүрэн эрхтэй эзэн нь юм. Гэвч та Веселовский түүний ингэж бүгдийг уландаа гишгэлж байгаа явдалтай эвлэрч чадахгүй байгаа бололтой гэж Полунин хэлэв.

-Тийм ээ. Эвлэрч чадахгүйгээр үл барам. Бүр яаж гээч хэмээн Веселовский шийдмэг хэлээд, тэр компанийн бүрэн эзэн болохын төлөө тэмцэж байхад нь би түүний үнэнч холбоотон байсан. Түүний миний зүг хэлж байсан бүдүүлэг хараалуудыг би тэвчсээр байсан юм. Хүрэх ёстой амжилтандаа хүрсний дараа намайг зохих ёсоор үнэлэх байх гэж би бодож байлаа. Гэтэл түүний том бялуунаас хумсын толионы төдий юм надад ноогдсон гэв.

-Миний мэдэж байгаагаар та үйлдвэрийн хувьцааны арван хувийг эзэмшдэг биз дээ? гэж Полунин залруулаад үүнийг чинь хумсын толионы төдий гэж хараахан нэрлэж болохгүй гэлээ.

-Тэр чинь ямар ашигтай юм гэж Веселовский улам догшрон хэлээд, тэр хувьцааны чинь ноогдол ашгийг надад өгдөггүй юм шүү дээ. Сатаров зөвшөөрөхгүй байгаа учир би хувьцаагаа худалдаж ч чадахгүй байна. Худалдаж чадлаа ч гэсэн тэр надаас боломжийн үнээр авахгүй. Учир нь үйлдвэрийн хувьцааны наян хувийг Сатаров болон түүний ойр дотныхон хянаж байдаг юм. Миний тэр бага хэмжээний хувьцаагаар бүр Томашевскийтэй хоршлоо ч гэсэн олигтой юм хийхэд хэцүү. Бид хувьцааны гучин хувь болох сөрөх чадалтай багцад хүргэж чадахгүй гэлээ. Тэгснээ дуугүй болж үгийг нь бараг сонсохгүй суугаа мэт Полунинг ажиглан харлаа.

Владимир хана түшин түүний яриаг үл хайхран өөрийн бодолдоо хөтлөгдөн зогсож байлаа. Дараа нь Полунин Бахметьев Веселовский хоёрыг гайхшран харснаа:

-Засаглах эрх өндөрсөх тутам дайсны тоо олширдог гэдгийг Сатаров мартсан бололтойдог хэмээн Полунин хэлээд миний өмнө Сатаровын талын биш хүмүүс сууж байна уу даа гэв.

-Үүнийгээ танд итгүүлж чадсандаа баяртай байна гэж Бахментьев инээмсэглэн хэллээ.

-Би яагаад та нарт хэрэгтэй болов гэдгийг мэдмээр байна гэж Полунин асуугаад хэрэв ХАХА шиг хүчирхэг байгууллага Сатаровын эсрэг хөдлөх гэж байгаа бол би хаа нэгтэй нам гүмхэн буланд нуугдан хүлээх хэрэгтэй юм даа гэв.

-Байдлыг бүү хялбарчилагтун Владимир Иванович минь хэмээн Бахметьев сануулаад, орон нутгийн ХАХА таны бодож байгаа шиг тийм хүчтэй байгууллага биш. Мэдээж бид гараа хумхин суухгүй. Бид багагүй юм хийж чадах боловч таны тусламж бидэнд зайлшгүй хэрэг болоод байна гэлээ.

Полунин Бахметьевыг доогтой инээмсэглэн ширтсэнээ,

-Та юу ярьж байна. Үнэхээр тийм гэж үү хэмээн гайхан асуугаад намайг та орон нутгийн ХАХА-ын удирдлагад оруулах гэж үнэхээр бодож байна гэж үү? Ингэж байгууллагынхаа дайчин чадварыг дээшлүүлэх гээ юу? Та намайг Жеймс Бонд эсвэл багаар яривал Рэмбо гэж эндүүрч байгаа юм биш биз гэлээ.

-Наадах ёжлолоо больж үз Владимир Иванович минь. Энэ чинь цагаа олоогүй шоглол гэж Бахметьев дургүйцэж хэлээд та намайг зөвөөр ойлгоосой гэж хүсэж байна. Би танаас өөрийн байгууллагыг хүчирхэгжүүлэхийг огт хүсээгүй. Гэвч Сатаров болон түүний хүмүүс зарим цагдаа нартай хамсан хотыг бараг эрхшээлдээ авчихаад байна. Хэрэв бид одоо тэр дээрэмчдийн эсрэг ямар нэг юм хийж эхэлбэл тэд болгоомжилж эхлэх болно. Тэгээд тэд даруй сөрөг арга хэмжээ авч энэ нь бидний ажиллагааг үр дүн муутай болгох юм уу бүрмөсөн зогсоож болно. Түүнээс гадна бид тэдний эсрэг ажиллагаагаа зөвхөн хуулийн хүрээнд явуулахыг эрмэлзэх болно. Та намайг ойлгож байна уу? гэж асуув. Полунин инээд алдаад:

-Би таныг ойлгож байна. Би хуулиас гадна оршиж байгаа учир дараа нь та нар өөрийн ажиллагаа гэж нэрэн дээрээ авч болох тийм үйл ажиллагааг намайг хийгээсэй гэж хүсэж байна уу? гэж асуув.

-Бид таны үйл ажиллагаа бидэнд туслаасай гэж хүсэж байна. Бид тантай хамтран ажиллахыг санал болгож байгаа юм гэж Бахметьев залруулав.

-Би ХАХА-г мэднэ гэж Полунин харамссан байдалтай инээмсэглээд хүний гараар могой бариулдаг газар юм гэлээ.

-Бидэнд зүгээр л албан ёсны бус ажилтан хэрэгтэй болоод байгаа юм гэж Бахметьев Полунингийн хэлснийг үл хайхран дуугараад ганцаараа бидэнд туслах дайчин хэрэгтэй байна. Бид түүнийг хамгаалалтандаа авч бүх талаар тусалж байх болно. Цагийг нь болтол бид хүлээж ил гарч ажиллагаа явуулахгүй гэв.

-Ганц дайчнаар юм бүтээхгүй гэж Полунин эсэргүүцээд та өөрөө мэдэж байгаа биз дээ. Сатаров болон түүний хүмүүсийг албан ёсоор дэгээдэж авах нь чухал. Ингэхийн тулд тэндхийн засаг захиргаатай холбоогүй Москвагийн нэр нөлөө бүхий хүмүүсийн туслалцаа авах хэрэгтэй гэв.

-Бид үүнийг сайн мэдэж байна. Тэгээд ч энэ чиглэлээр ажиллаж байна хэмэн Бахметьев хариулаад, миний Москва дахь ажил мэргэжил нэгт нөхдүүд таны хотын тэр хэргийн учрыг олуулахаар орон нутгийн засаглалаас хамааралгүй тусгай бүлэг бүрдүүлж явуулахаар бэлтгэж байгаа. Харин ингэхийн тулд ямар нэгэн шалтаг гаргах ёстой юм. Таны хэлсэнчлэн тэднийг дэгээдэж болох гогцоог олох хэрэгтэй. Энэ комисс үр дүнтэй ажиллаж болох сайн гогцоог нь

шүү. Ингэхийн тулд чухам та бидэнд хэрэгтэй болоод байна. Хэрэв та зөвшөөрвөл та их зүйл хийх хэрэгтэй болно. Харин бид танд бүх талаар тусална гэлээ.

Полунин гар буугаа дэргэдээ орон дээр тавиад яаралгүйгээр янжуур гарган асаалаа. Тэрээр тамхиа гүнзгий сорсоноо:

“За яахав. Бахметьев болон түүний хүмүүс асуудлыг надтай нэгэн адил сэтгэж байгаа юм шиг байна. Зөв алхам хийхээр бэлтгэж байна. Хэрэв түүнд Мирон тусалбал ажиллагаа улам илүү үр дүнтэй явагдах ёстой. Харин энэ ажиллагаанд оролцогчдод ямар шагнал урамшил олгох асуудал сонин байна. Тэдний ихэнх нь энэ ажиллагаа амжилттай болж төгсвөл компанийн хувьцааны тавиас доошгүй хувийг санаархаж байгаа байх. Эцсийн эцэст чухам үүний төлөө л тэд энэ дайнд орох гэж байгаа шүү дээ” гэж бодлоо.

Хэсэг зуур нам гүм байцгаав. Тэгтэл Полунин эхэлж

-Хэрэв ялалт бидний талд болвол би ямар шагнал авах юм бэ? гэж асуув.

-Би гайхсанаа нуух юун гэж Бахметьев хэлээд ямар шагналын тухай та ярьж байна вэ? Та өөрийн өстөн дайснуудтай тооцоо хийж санаагаа амраах чинь ямар нэгэн шагналаас илүү биш юм гэж үү? хэмээн асуув.

-Мэдээж илүү байхгүй яахав гэж Полунин зөвшөөрөн гэвч би бас өөрийн шударга нэр төрийг сэргээж авмаар байна. Хэрэв та нар үүнийг надад баталгаатай амлаж байгаа бол би та нартай тохиролцоход бэлэн байна гэв.

-Мэдээжийн хэрэг. Таны эсрэг хуйвалдаж хийсэн тэр баривчилгааг хүчингүй болгож нээгдсэн хэргийг чинь хаалгах болно гэж Бахметьев амлав.

“Одоохондоо энэ хүмүүстэй үүнээс илүү юм тохиролцох боломжгүй юм даа. Цаашид юу боловч харан байж болохоос биш” хэмээн Полунин бодсоноо тамхиа дахин гүнзгий сорж:

-Таны саналыг хүлээн авахын өмнө бас нэг асуулт асууя гэв.

-Ямар?

-Та хоёр намайг энд байгааг яаж мэдэв?

-Үнэнээ хэлэхэд бид таныг нэлээд хугацаагаар эрсэн боловч олоогүй. Гэхдээ таныг удаан хугацаагаар нуугдаж суухгүй гэдгийг мэдэж байсан. Эрт орой хэзээ нэгэн цагт та хөдөлж эхлэн хаа байгаагаа мэдэгдэх болно гэж бодож байсан юм гэж Бахметьев хариулав.

-Би энд байгаагаа яаж мэдэгдэв ээ? Би энэ буудалд бусдын нэрээр байрлаж байгаа шүү дээ гэж Полунин асуугаад юу гэж хариулахыг нь хүлээн Бахметьевыг цоо ширтэн суулаа.

-Израилаас мэдсэн гэж Бахметьев инээд алдан хариулав.

Полунин хөмсгөө өргөн гайхаж:

-Гриша юу? гэж самгардан асуув.

Энэ үед тэрээр өөрийн дайснуудтай тэмцэхийн тулд Москвагаас нэр нөлөөтэй том албаны хүмүүстэй танилцаж ойртох хэрэгтэй. Сатаровыг дэгээдэхийн тулд түүний мөнгө санхүүгийн асуудлыг гохдож авах нь зүйтэй гэж Соловейчик зөвлөж байсныг саналаа. “Түүний овсгоо самбааны учир энд байх нь” гэж Полунин бодов.

-Үгүй дээ. Соловейчик энд огт хамаагүй хэмээн Бахметьев толгой сэгсрэн хэлээд, таны тухай бидэнд өөр хүн мэдэгдсэн. Ер нь манай дүрмээр мэдээлэгчийг хэлэх ёсгүй байдаг боловч энэ удаа зөрчихөөс биш дээ. Таны тухай мэдээлж одоо хэрэглэж яваа нэрийг чинь хэлсэн хүнийг Ксения гэдэг. Урьд нь түүнийг тун хэцүү байдалд ороод байхад нь бид тусалсан юм. Тэгээд тэр бүсгүй одоо хүртэл биднийг мартдаггүй, холбоотой байдаг гэж тайлбарлав.

-Тэгэхлээр та “Аркада” компанийн хувь нийлүүлэгчдийн хооронд бий болсон байдлыг тэр хүүхнээс мэдээ юу? Эсвэл таны бас нэг төлөөний нууц албат ноён Веселовский танд мэдэгдээ юу? гэж Полунин асуулаа.

-Та энд буруу ойлгож байна. Ноён Веселовский энэ тухай бидэнд саяхан мэдэгдсэн юм. Өөрийгөө тусгүй нөхдүүдтэй холбоотой болсон байна гэж ойлгоод бидэнд хандсан хэрэг гэж Бахметьев тайлбарлаад, гэвч бид өөрт нь туслах санаагаа урьд гаргасан боловч тэрээр хүлээж аваагүй юм гэлээ.

Полунин гэнэтхэн инээд алдаж орхилоо.

-Юу гэсэн үг вэ? “Тусгүй хүмүүстэй холбогдсон” гэнэ үү гэж Полунин үгийг нь давтан хэлээд тодруулж хэлбэр Сатаров өөрийг нь мөнгөнөөс нь салган хөөж зайлуулна гэдгийг ноён Веселовский ойлгосон хэрэг байх нь уу. Тэгээд таны тусламжтайгаар Сатаровын эсрэг дайрах гэсэн юм биз дээ. Харин эрхэм Веселовский та зоригтой хүн юм хэмээн Полунин үйлдвэрийн ерөнхий захирлыг учиртай ширтэн өгүүлэв.

Веселовский дурамжхан байдлаар хөмсгөө хөдөлгөн:

-Би тэр дээрэмчинг тэгнэ байх гэж урьдчилан тааварласан юм. Одоо надад алдах юм байхгүй. Би зөв сонголт хийсэндээ итгэлтэй байна гэлээ.

-Та баашилж байна Веселовский гэж Полунин доогтой инээмсэглэн дуугараад, танд алдах юм тун их бий. Гэвч та өөрийг чинь нэг ч удаа мэхэлж байгаагүй үнэрлэх эрхтэндээ итгэлтэй байгаа бололтой. Та миний бодсоноор живэхгүйгээр бүтээгдсэн хүн юм Сатаровын унасны дараа та өөрийн суудалдаа үлдэнэ биз гэв. Тэгснээ хараагаа шилжүүлэн:

-Та шинэ овог нэрээр минь бүх зочид буудлыг нэгжиж эндээс намайг олсон байна гэж хэлэв.

-Яг тийм гэж Бахметьев толгой дохилоо.

-Тэгэхлээр одоо би нуувч болон овог нэрээ дахин өөрчлөх хэрэг гарлаа гэж Полунин дүгнэн хэллээ.

-Өөрөө мэд. Гэвч бид тантай тогтвортой холбоотой байх ёстой хэмээн Бахметьев хариулаад, тэр тэмдэглэлийн дэвтрийн завсар миний гэрийн болон Москвагийн утасны дугаар бичээстэй байгаа. Та нуувч болон нэрээ солихын шаардлагагүй гэж бодож байна. Бид танд итгэж байгаа шиг та бидэнд итгэх ёстой. Тэгэхгүй бол үр ашигтай хамтын ажиллагаа болохгүй гэв.

Полунин хариу хэлэхийн оронд түүний гар бууг авч суудлаасаа босож өөрт нь өгөөд өөрийн “ТТ”-г хувцсандаа далд хийв. Энэ бол биеэр үзүүлсэн итгэлийн дохио байлаа. Тэгснээ Полунин эргэж суудалдаа суугаад зочдоо ширтэн-Одоо цаашдын ажиллагааныхаа талаар нарийн тодорхой ярилцаж тохирёе ноёд оо. Бид их ажил хийх хэрэгтэй учир одоо ч гэсэн цаг алдсаны хэрэггүй гэж албаны өнгөөр санал болгов.

Наймдугаар бүлэг

-Миний ойлгож байгаагаар хотод бий болсон энэ холион бантан чиний хийж байгаа ажил бололтой хэмээн дуугүй сууж байсан Лобников гэнэтхэн асуув.

-Мэдээж хэмээн ядрангуй инээмсэглэн Полунин хариулаад энэ ажиллагаанд гар бие оролцоогүй гэж хэлбэл мунхаг хэрэг болно. Би үүнээс их юм хэлж чадна. Сатаровын дорхи суурийг нь төнхөж байгаа хамгийн идэвхтэй хүний нэг нь би байгаа юм. Тэдний дотроос мөнгө, ашгийн төлөө бус өш хонзонгоо авахын төлөө тэмцэж байгаа цорын ганц хүн бол би юм. Ийм учраас миний холбоотнууд цөм надад ямар ч эргэлзээгүй итгэсэн. Олон үйлдвэрийн эздийн айдсыг төрүүлж энэ хотод шалгалт хийж байгаа комисс ажлаа зүгээр л хоосон хөрсөн дээр эхлээгүй юм. Би өөрөө хотод өнгөрсөн намраар ирмэгцээ зөвхөн танай бүлэглэлийн эсрэг баримт нотолгоо цуглуулах ажлыг хийж ирсэн. Тэр үед та нар ямар ч сэжиг аваагүй хотын чанад дахь байрандаа янхнуудтай наргиж эсвэл тансаг амралтын газруудад гүзээгээ наранд ээж хэвтсэн байх. Тэр үед би танай бүх сул газрыг олж судалж мэдсэн. Нэг бус удаа би хилийн чанад гарч та нарын мөнгө санхүүгийн хуудуутай ажиллагаанд нэвтрэн орох албан ёсны болон албан ёсны бус алхмуудыг хийж байлаа гэж ярилаа.

-Зүгээр л тэр хөлсний алуурчдаар Сатаровыг цааш нь харуулчихвал хялбар байсан юм биш биз? гэж Лобников хорсолтойгоор асуув.

-Би эхлээд мөн адил тэгж бодож байлаа. Гэвч ажиллагаа минь гүнзгийрэх тусам энэ нь асуудлыг гүйцэд шийдэж чадахгүй гэдгийг би ойлгосон гэж Полунин итгэлтэйгээр хэлээд Сатаровын ард нэр нөлөөтэй хүмүүс үүнийг дэмжиж зогсож байгаа. би тэдэнд хүрч очих ёстой гэв.

-Муу нохой чамайг үзэн ядаж байна! хэмээн Лобников орилоод чамаас болж миний гэр бүлийнхэн амиа алдах нь. Хэний ч хамаагүй амийг золиослон өөрийн зорилгодоо хүрэхийг чи бодож байна. Чи Сатаровыг намнахдаа бусдын амиар дэнчин тавьж байгаагаа ухаарахгүй байна гэж үү? Чи зөвхөн амиа бодож дайснаа устгахыг хүсэж байна гэлээ.

-Сайхан сэтгэмж байна хэмээн Полунин түүний хилэгнэлийг үл хайхран хэлээд, миний эхнэрийг хөнөөсөн тэд удахгүй энд хүрээд ирнэ гэв.

Лобников дуугүй болж Полунинг алмайран ширтэж суув. Тэгснээ:

-Бидэн рүү ирэх гэж байгаа тэр хөлсний алуурчид Самбистыг алсан гэж чи хэлэх гээд байна уу? гэж асуув.

-Яг тэгж хэлэх гээд байна гэж Полунин батлан хэлээд тэд ямар ч гэмгүй хүмүүсийг золиосонд гаргах хүмүүс. Тэр үед Самбистын машин дотор миний эхнэр хүүхэд сууж явсан юм. Харин хүү минь азаар амьд үлдсэн гэв.

Лобников зай завсаргүй тамхиа сорж хэдэн хором чимээгүй суулаа. Гэвч дотор нь буцалж байсан сэтгэлийн нь хямрал дахин саган гарч:

-Ямар ч байсан энэ чинь шударга бус явдал. Чиний ажиллагаанаас болж миний эхнэр охин хоёр хэлмэгдэх ёсгүй. Мөн чамаас болж Леха Петров, Капустин нар үхэх ёсгүй байсан! Биднийг тэгж устгахаар муу юм чамд хийгээгүй. Чиний өөрийн чинь хэлж байгаа шиг бид мөн адил ямар ч гэмгүй чиний золиосны хүмүүс болоод байна гэж гомдоллоо.

-Дэмий юм чалчихаа боль! гэж Полунин тэвчээр алдан зандраад айж балмагдсанаасаа болж чи удахгүй ухаан чинь муудаж, өөрийгөө сахиусан тэнгэр гэж өргөмжлөх гэж байна. Чи ямар хүнтэй холбогдсоноо, ямар тоглоомд орооцолдсоноо, Сатаровын дайсан олон гэдгийг чи мэдэж л байсан шүү дээ. Гэтэл та нарыг би биш Сатаров чинь буудаж алахыг алуурчдад тушаасан. Түүний хөлсөлж авсан алуурчид танай босс болон ивээн тэтгэгчдийн булхайг илрүүлэхгүй гэж бохирыг нь цэвэрлэж байгаа юм. Харин чиний эхнэр хүүхдийн хувьд бол зөвхөн би л аварч чадна гэдгийг ойлго! гэв.

Лобников дахиад л түүнийг итгэлгүй байдлаар гайхан хараад:

-Чи тусалсныхаа хөлсөнд юу авах юм бэ? гэж асуув.

-Москвагаас ирсэн шалгалтынханд өгөх ёстой энэ данс бүртгэлүүдээс гадна чи өөрөө Сатаров болон түүний хамсаатнуудын эсрэг гэрч болж мэдүүлэг өгөх ёстой.

-Дараа нь намайг суллаж тавих уу? Эсвэл би Леха Петров шиг хаа нэгтээ булшлагдан алга болох уу? гэж Лобников асуув.

-Леха Петров амьд аль хэдийнэ Москвагийн комисст мэдүүлэг өгч эхлээд байгаа...

* * *

Славка Болдин гараашийн хаалгыг онгойлгон орсноо модон орон дээр хэвтэж байгаа Полунинг харан хэсэг зуур гайхан дуугүй зогслоо. Тэгснээ:

-Сайн байна уу, Иваныч! хэмээн дуу алдан мэндлээд түүн рүү үсрэн очлоо. Полунин орон дээрээс босож Славкийг чанга тэврэн хүлээж аваад:

-Сайн, сайн Славик минь! гэлээ.

-Ингээд хүрээд ирэх гэж! Бид чамайг хичнээн хүлээв ээ?

-Та нар намайг бүрмөсөн эргэж ирэхгүй болов уу гэж бодож байсан биз? хэмээн Полунин тоглон асуув.

-Юу ярина вэ чи хэмээн Славка толгой сэгсрэн гомдоллоод надад итгэ. Бид чамайг хэзээ нэгэн цагт хүрээд ирнэ гэдэгт бүрэн итгэлтэй байсан юм гэлээ.

-Итгэж байна. Итгэлгүй яахав Славка минь гэж Полунин инээд алдан хариулаад, тэр даруй Шакирыч хаана байна? гэж асуув.

Славка гараа дэлгэн:

-Урьдын адил, ерөнхий постондоо байгаа. Түүнийгээ ховорхон орхиж гардаг хүн шүү дээ гэж хариулав.

-Сайн байна гэж Полунин түүнийг сайшаан хэлээд тэр хэзээ ч найдвар алдахгүй. Харин Николай хаана байна? Чи түүнтэй холбоо барьсан уу? гэж асуув.

-Тэр одоохон хүрээд ирэх ёстой. Удалгүй гараашийн хаалга тогших чимээ гарч Славка Самбистын ойрын туслах байсан Николай Батуриныг оруулж ирлээ. Николай Полунинг хармагц байрандаа хөшиж орхилоо. Тэрээр хэдэн хором Полунинг түгшин ажиглаж байснаа түүний ширүүн харцанд хүүхдийнх гэмээр инээд тодрон:

-Сайн байна уу? Иваныч? Хүрээд ирсэнд чинь баяртай байна гэж сая нэг биеэ эзэмдэн мэндлээд тэгэхлээр одоо бид гол ажиллагаандаа орох боломжтой боллоо гэж дуу алдав.

-Чи зөв хэлж байна, Николай, одоо бидний хийх ажил хүрэлцээтэй их байх болно. Ойртоод суу зарим нэгэн зүйлийг зөвлөж ярилцъя гэж Полунин хэлэв.

Николай Полунин хоёр шахмал кардонон хайрцгийг уруу нь харуулж дээр нь хатуу гөлгөр хавтан тавьж тогтоосон ширээний ард сууцгаалаа. Полунин халааснаасаа хоёр гэрэл зураг гаргаж Николайг өмнө тавиад

-Энэ хоёр хүний зураг байгаа юм. Бид ойрын үед эдэнтэй хамгийн түрүүн нягт ойртож ажиллах болно гэж хэлээд намхан нуруутай махлаг залуугийн зургийг хуруугаараа хатган заалаа.

-Эднийг далд оруулах хэрэгтэй юу? гэж Николай асуув.

-Үгүй ээ, Коля. Тэд бидэнд амьдаараа хэрэгтэй...

Полунин өөрийн хамтрагчиддаа тус тусдаа юу хийх ёстойг товч тодорхой тайлбарлаж өгөв. Полунинг зааварчлага өгч дууссаны дараа Болдин:

-Хаанаас ийм сайн буулгасан зураг олоо вэ? гэж асуув.

-Хоёуланг нь гудамжинд авсан юм. Миний нөхдүүд ингэж хичээсэн хэрэг гэж Полунин хариулаад, миний зарим холбоотнуудад зураг сайн авах болон яриаг чагнах хэрэгслүүд байдаг юм гэлээ.

-Өнөөдөр бид юу хийх вэ? гэж Славка асуув.

-Өнөөдөр нэгэн чухал уулзалт болох ёстой. Би үүнийг жил гаруй хойшлуулж байсан юм гэж Полунин хариулав.

* * *

-Вова... Седой... мөн дөө ямар учралаар хэмээн ажлын бохир комбинзонтой өндөр нуруутай халзан эр уулга алдан дуугарлаа.

Халзан эр гараашийн үүдэнд зогсоод тос болсон ясархаг том гараа арчиж байв.

-Сайн уу. Лопать хэмээн Полунин хүйтнээр мэндлээд Болдин Батурин хоёрын хамт орж очлоо. Ваня Лаптевийн гонзгойвтор бөгөөд сахал самбаандаа баригдсан нүүрэнд нь бараг тал нь гэмтсэн шар шүд гаргасан зусар инээмсэглэл тодрон байлаа. Тэрээр гараа сарвайтал Полунин хүлээж авалгүй түүн рүү нүүгэлтэн ойртсоор байв.

Лаптевын нүүрний инээмсэглэл тэр даруй арчсан мэт алга болж оронд нь зөвхөн гэнэтийн явдалд балмагдсаны илэрхийлэл болох эвдэрхий шар шүд гаргасан муруй ам үлдлээ.

-Вов, чи яах гэж байна хэмээн тэрээр өөрийн эрхгүй болгоомжтой дуугараад засварлаж байгаа машин зогсож байсан гараашийн гүн рүү ухран,

-Надтай уулзсандаа баярлахгүй байна уу? гэж ямар хариу хэлэхийг нь бараг гадарлан асуув.

-Чи яав, Ваня. Би их баярлаж байна гэж Полунин зориут дуугараад, яаж баярлаж байгааг минь мэдэж байна уу? Би чамтай уулзах гэж олон сар хүлээсэн гэлээ.

Энэ үе Славка гараашийн хаалгыг хааж түгжээд гэрлийг нь асаав.

-Эрчүүд минь яаж байна? гэж Лаптев ойлгож ядан асуугаад айсан нүдээр тэднийг ээлжлэн харлаа.

-Ваня тун илэн далангүй ярих юм байна гэж Полунингийн хэлэхэд Лаптев гэдэргээ ухарсаар машинд тулж очоод суучихав.

-Юуны тухай вэ? Ойлгохгүй байна?

-Би чамайг хэдийнээ ойлгож байгаа гэж бодож байна гэж Полунин хэлээд ард нь байгаа “ес” дахь загварын машин руу дохиод

-Бизнес чинь амжилттай биз? Машины наймаа хийсээр байна уу? гэж асуув.

-Хийсээр байгаа.

-Хулгайн машин авч байна уу? гэж Полунин дахин асуув.

Авах тохиолдол байдаг гэж Лаптев хөмсөг зангидан хариулаад, чи тэгэхлээр цагдаа нарын талд ажиллаж байгаа юм уу? гэж асуув.

-Би өөрийнхөө талд ажиллаж байна, Ваня. Харин чи жилийн өмнө хулгайн хоёр машиныг дамлан худалдахдаа хэний талд ажиллаж байсныг чинь мэдмээр байна.

-Чи ямар хоёр машины талаар ярьж байна вэ?

-Шакирыч бид хоёр чиний захиалгаар чамд өгсөн хоёр машины тухай ярьж байна. Саарал “9” дэх загварын, ягаан “8” хоёрыг чи хэнд худалдсан бэ?

-Бидний өгсөн машин гэж чи юу ярьж байна. Ижил машинууд зөндөө байдаг шүү дээ гэж Лаптев хэнэггүй байдал гаргахыг хичээн хэлэв.

-Больж үз, Лаптев минь. Бүү баашлаад байгаарай. Ялангуяа “Жигулийн” наймаа чи бид хоёр тийм ч их хийж байгаагүй, нэг нь саарал нөгөө нь ягаан өнгийн хоёрхон “жигули” машины наймаа хийсэн. Чи тэр машинуудыг хэнд худалдсан бэ? гэж Полунин тулган асуув.

-Санахгүй байна гэж Лаптев мөрөө хавчин хариулаад, аль эрт болсон явдал. Ямар нэгэн Кавказаас ирсэн хүмүүс байсан гэв.

-Чи бид илэн далангүй шударгаар ярьж чадахгүй нь гэж Полунин ширүүн дуугараад, ярианыхаа өнгийг өөрчлөх хэрэгтэй болж дээ гэж сүрдүүлэв. Тэгснээ Полунин түүн рүү тулж очоод элэг рүү нь хүчтэй дэлсэж орхилоо.

Лаптевийн амнаас хөөс сахран хоолойноос нь үргэлжилсэн хоржигнох дуу гарах нь тэр. Тэрээр халзан толгойгоороо Полунингийн цээжинд тулан хагас эвхрэн зогсож байлаа. Полунин түүний хоёр чихнээс нь барьж биенээсээ зайлуулмагцаа нам бөгөөд заналтай дуугаар:

-Би чамтай хүүхэлдэйн тоглоом тоглоогүй байна гэдгийг одоо ойлгов уу? Хэрэв ойлгоогүй бол чинь сүүлчийн удаа дахин нэг сануулъя. Дараа нь би чамд юу ч ярихгүй, зөвхөн чиний яриаг сонсох болно. Үнэнийг чи жирийн байдлаар ярих уу? Эсвэл орилон чарлаж ярих уу гэдгээ өөрөө сонго! гэж сануулав. Лаптев юу ч хариулалгүй хүндээр амьсгаадан баруун хажуугаа гараараа даран сууж байлаа.

-Чи тэр машинуудыг хөлсний алуурчдад зарсан. Дараа нь тэд миний эхнэр болон найз нарыг минь алсан. Тэр чиний алуурчдад өгсөн машинуудыг чинь Шакирыч шалгаж үзээд чиний надаас авсан машинууд байсныг тогтоож чадсан, за ийм байна. Одоо чи үнэнээ хэл гэж Полунин шаардав.

-Тэр чинь аль эртний явдал Вова минь. Би тэр талаар юу ч санахгүй байна. Тэгээд ч алуурчид ямар машинтай явсан нь ямар ялгаа байна. Чиний нөхдийг алуулах гэж тэднийг би явуулаагүй шүү дээ гэж Лаптев хариу хэлсний дараа Полунин дагуулж яваа хоёртоо хандан дохио өгөв. Нөгөө хоёр залуу Лаптевт тулж очоод гарыг нь ард нь мушгиад машин дээр өөд нь харуулан тэлж хэвгүүлэв.

Тэгтэл Полунин хийн гагнуурын хушууг авч крантыг нь бага зэрэг онгойлгон тамхины асаагуур ойртуулан асаалаа. Хийн дөл хүчтэй цоргилон гарч ирэх нь тэр.

Полунин галтай хушууг барьж Лаптев руу ойртон ирэхэд

-Үгүй ээ! Хэрэггүй ээ Вова минь. Чамаас гуйж байна! хэмээн тэрээр орилоод би бүх үнэнийг хэлье. Би үнэхээр чиний өмнө буруутай. Гэвч би зориуд тэгээгүй юм. Тэд юуны тухай ярьж байгааг нь би ойлгоогүй. Над руу Романыч хүрч ирээд хямдхан үнэтэй хоёр машин хэрэг болоод байна гэж хэлсэн. Харин тэр машин авъя гэж байсан Кавказынхан дахиж ирээгүй. Тэгээд л би гараашид байсан хоёр машиныг Романычид худалдсан юм.

-Машиныудыг тэр өөрөө ирж авсан уу? гэж Полунин асуув.

-Үгүй. Машиныудыг алуурчид өөрсдөө ирж авсан. Тэгээд өөрсдийн ажиллагаандаа ашигласан юм билээ. Тэд эндхийн хүмүүс биш гэдгийг би ойлгосон. Дараа нь би тэднийг Тамбовоос юм уу, Рязаниас ирсэн гэдгийг сонссон. Үүгээр зогссонгүй саяхан тэд дахин хүрч ирээд бас хэдэн машин худалдаж аваад байна гэж Лаптев хариулав.

-Ямар машинууд байсан бэ? Ямар өнгөтэй, ямар номертой?

-Гурван “Жигули” хүрэн “5”, хар саарал “9”, интоорын өнгөтэй “6” гэж Лаптев хариулаад номерууд нь надад бичээстэй байгаа. Чамд өгч болно гэв.

Полунин хушуувчийн дөлийг унтрааж шалан дээр хаяж орхилоо.

-Түүнийг тавь гэж залуучууддаа хэлээд, чи өөрийн энэ сүүлчийн мэдээллээрээ арьсаа бүтэн авч үлдлээ. Харин санаж ав. Биднийг энд ирсэн тухай ер нь биднийг харсан гэж хэн нэгэнд үг алдвал чинь би эргэж ирээд энэ хийн гагнуурын хушуувчаар хоёр хөлийг чинь тайрч хаяна гэж сануулав.

Полунин нарыг гарч явсны дараа Лаптев ядарсан байдалтай машинаа түшин шалан дээр суугаад духныхаа хөлсийг арчин:

-Өнөөдөр ингээд өнгөрлөө. Хойшид нэг хоёр сар нуугдаж суух хэрэгтэй боллоо. Хотод дахин томоохон мөргөлдөөн гарч эхлэв бололтой хэмээн өөрөө өөртөө дуугарав.

* * *

-Тийм ээ. Олег Григорьевич, би таныг ойлголоо. Бүх юмыг таны хэлснээр гүйцэтгэнэ. Бичиг баримтуудын хувьд бүх юм хэвийн. Сэжигтэй гэсэн бүх материалыг ялган авч таны хүмүүст өгнө. Одоохондоо би ямар зорилгоор шалгах гэж байгааг нь мэдэхгүй байна. Гэвч би тэр шалгалтад орох бэлтгэлээ бүрэн хангасан... Тийм ээ... Тэгье... гэж хэлээд Алексей Петров утсаа тавилаа. Тэрээр хэсэг зуур бодлогошрон утасны аппаратыг ширтэж сууснаа цагаа харвал оройн есөн цаг болж байв.

-Сонин л юм. Сатаров өөрөө ингэж санаа зовж шалгалтын талаар урьдчилан сануулна гэж санасангүй. За яахав харих цаг боллоо. Маргааш энэ бүгдийн учир олдоно биз хэмээн тэрээр өөрөө өөртөө бухимдан дуугараад хуруугаараа ширээ тогшиж суув. Тэгснээ гэнэтхэн босож ялгаж авсан хэдэн хавгастай бичиг баримтуудыг цүнхэнд хийж бариад өрөөнөөс гарлаа.

Нарийн бичигч аль хэдийнэ гэртээ харьж ээлжиндээ гарсан харуулаас өөр ямар ч хүн үлдээгүй ажээ. Петров харуулд баяртай гэж хэлээд байшингаас гарч ойролцоох тавиаастай машин руугаа хүрч очлоо. Тэрээр өөрийн шинэхэн “Рено Мегонд” орж суугаад аажуухан хөдөлж хөдөлгөөн зогссон харанхуй гудамжинд ороод мөн адил аажуухан хурдаа нэмлээ.

Петров замын уулзварын улаан гэрлэн дохиогоор зогстол ар талд нь ямар нэгэн шаржигнах чимээ үл мэдэг сонсогдлоо. Тэрээр сандран ард нь юу байгааг арын толиндоо харав. Яг энэ

агшинд ар дагз руу нь төмөр бололтой хатуу юм тулах нь тэр. Петровын бүх биеэр хүйт оргин тэр хатуу юм нь гар бууны ам гэдгийг ойлгов. Энэ үед ногоон гэрэл асаж арын суудлаас эрэгтэй хүний үл таних дуу гарч:

-Томоотой суу. Замаа хар. Тэр ногоон гэрэл аслаа гэв.

-Та яагаад миний машинд орж ирэв хэмээн Петров өөрийн мэдэлгүй дуу алдав. Тэгснээ машинаа хөдөлгөн цааш бага хурдтай явлаа.

-Танд юу хэрэгтэй юм? гэж тэрээр сөөнгөтсөн дуугаар асуув.

-Чи замын энэ уулзвар дээр зүүн гар тийшээ эргээд тавиад метр яваад зогс. Томоотой байвал чинь бүх юм зүгээр өнгөрнө хэмээн үл таних эрэгтэй хүний дуу гарч урьдын адил бууны амыг дагзанд нь тулгасаар байв.

Петровын анхны айдас намжсаны дараа шийдмэг дуугаар:

-Алив чи сонсож бай. Чи ядахнаа хэнтэй яаж харьцаж байгаагаа ойлгож байна уу, тэнэг минь? Намайг хэний талд ажилладгийг мэдэх үү? Миний толгойноос ганц ширхэг ч болов үс унавал чамайг газрын гаваас ч олно. Элдвээр аашлах гээд байвал одоо чи өөрийгөө хүүр болсонд тооц гэж томров.

-Чи хэний талд ажилладгийг чинь би мэднэ гэж үл таних эр тайвнаар хариу хэлээд чухам тийм учраас чи тайван сууж миний юу хэлэхийг анхааралтай сонс. Яагаад гэвэл би энэ алхмыг тохиолдлоор бус ухамсраараа хийж байгаа юм. Замын дунд зогсохыг би хүсэхгүй хэмээн сануулав.

Үл мэдэх тэр хүний үг Петровыг бий болсон нөхцөл байдалд захирагдахаас өөр аргагүйд хүргэж байв. Түүний энэ шинэхэн “Рено” аймшгийн сав мэт санагдаж байлаа. Тэрээр тэр хүний хэлснээр машинаа залж нэгэн харанхуй гудамжинд ортол нөгөө үл таних дуу Петровыг машинаас гарахыг тушаав.

Петров машинаас гарч амжаагүй байхад гэнэтхэн бараан өнгийн “Форд Скорпио” зэрэгцэн ирж зогсоод жолоочийн нь хажууд сууж байсан залуу түүний зүг гар буу онилон:

-Орж арын суудалд суу! гэж зандрав.

Хэдэн хормын дараа Петров “Форд Скорпио”-гийн арын суудалд гар буутай хоёр залуугийн дунд сууж байлаа.

Жолооны ард ямар нэгэн үл ялиг шинжээрээ танил юм шиг санагдах нэгэн эр сууж байв. Машины хаалга дөнгөж хаагдмагц тэр хүн Петров руу эргэж:

-Сайн байна уу Алексей? Намайг таньж байна уу? гэж асуув.

Тэр хүний дуу Петровт танил юм шиг санагдаж байсан боловч машины бүхээгт харанхуй байсан учир нүүрийг нь харах боломжгүй байв. Үүнийг ойлгосон тэр хүн дотор гэрлээ асаав.

Петров түүнийг шууд таньж:

-Сайн байна уу? Владимир Иванович хэмээн балмагдан дуу алдаад яагаад ийм юм хийж байгаа юм бэ? Яагаад намайг баривчлах болов? гэж асуулаа.

-Чи энэ тухай өөрөө бодоход чинь хагас цагийн хугацаа өгье гэж Полунин инээд алдаад энэ хугацаанд бид тохирсон газраа хүрч очно. Хэрэв чи өөрөө тааварлаж мэдээгүй бол тэнд очоод би бүгдийг тайлбарлаж өгнө. Харин одоо уурлаж бухимдалгүй элдэв юм асуулгүй чимээгүй сууж бай гэлээ.

Тэгж хэлмэгц хажууд нь сууж байсан Славка Болдин Петровын толгойд ноосон малгай өмсгөн доош нь дарж нүдийг нь таглаж орхив. Бүр ямар нэгэн байранд орсны дараа Петровын малгайг авчээ. Энэ бол байшингийн доод хонгил бололтой бөгөөд дулаахан боловч чийг ханхална. Энд буйдан ор, ширээ хоёр сандал өрөөний буланд тавиур дээр телевизор байх ажээ. Петровыг малгайг нь авсны дараа орон дээр суулгалаа. Өрөөнд ганцхан Полунин үлдэж нөгөө хоёр залуу нь гарч явав.

-Юу болж байгаа нь энэ вэ? Владимир Иванович, би тэгэхлээр таны олзны хүн болж байна уу? Намайг ингэх ямар шалтгаан байгааг тайлбарлаж өгнө үү? гэж Алексей Петров асуув.

-Сүүлчийн асуултын чинь хувьд хариулт нь өөрөөс чинь хамаарна гэж Полунин хариулаад өмнө байгаа сандал дээр суунгаа, ер нь цөмийг эхнээс нь дэс дараатай ярилцъя. Чи түр зуур олзны хүн байх болно. Ийм байдлаар чи бид хоёр ярилцахад амар байх болно. Өөрөөр хэлбэл ямар ч байсан чи надад анхааралтай хандах болно. Чамайг ингэх шалтгааныг тайлбарлах нь илүүц биз? Чи үүнийг сайн мэдэж байгаа. Би Сатаровын бүлэглэлийн эсрэг ажиллаж байгаа хүн. Би түүнийг дарахын төлөө юунаас ч буцахгүй.

-Харин би Сатаровын талд ажиллаж байгаа хүн шүү дээ гэж Алексей мөрөө хавчин хэлээд, би түүнд ямраар хандаж байсныг үл харгалзан тэрээр намайг нэг ч удаа хохироож байгаагүй юм гэж боддог. Би түүний эсрэг ямар нэгэн юм хийхийг хүсэхгүй байна гэлээ.

-Чи аль хэдийнэ түүний эсрэг хийх юмаа хийчихээд байна гэж Полунин гэнэтхэн хэллээ.

-Та юу ярьж байна? гэж Алексей сэжиглэн асуув.

-Энүүний тухай ярьж байна гэж Полунин бодлогошрон дуугараад наандаж энүүний тухай ч байж болно гээд нэгэн бичиг данс гарган Петровт өглөө. Петров түүнийг авч уншаад тавгүйтэн хөмсөг зангидав. Тэнд “Бензин нийлүүлэх гэрээ”... “Гринальс” пүүс... “Мальти экспорт” пүүс гэх мэтчилэн хаяг бичээстэй байх нь тэр.

-Энэ бол хуурамч гэрээ хэмээн Полунин тайлбарлаад тэр “Мальти экспорт” пүүс чинь мөнгө дамжуулах ажлаас өөр юу ч хийдэггүй юм. Энд бичигдсэн өндөр асалттай бензинийг төмөр замаар онцгой нууцлан Балтийн тэнгис орчмын нутаг руу нийлүүлж байсан гэдгийг би мэднэ. Тэнд тэр нийлүүлсэн бензинийг чинь өндөр үнээр худалдан авч байв. Тэр гэрээнд компанийн захирлуудын зөвлөлийн дарга Сатаров гарын үсгээ зурсныг чи анхааралдаа авав уу? гэж хэллээ.

-Та хаанаас энэ гэрээг олоо вэ? Эдгээр бичиг баримтууд хэрхэн таны гарт орчихоо вэ? гэж Петров гайхаж асуув.

-Үүнд л хамгийн сонирхолтой учир байна гэж Полунин инээд алдан хариулаад, миний ойлголтоор ажилбар явагдаж дууссаны дараа ийм баримт бичгүүдийг тэр даруй устгадаг юм. Ингэхийн тулд чи бичиг баримтуудыг Сатаровын бичиг хэргийн албанд өгөх ёстой. Банктай хийсэн гэрээний дагуу нарийн бичгийн дарга нарын баталсан хуулбар нь тэнд хадгалагдана. Энэ нь тэр банкинд зарим талаар осолтой боловч сүйрлийн аюул байхгүй. Тийм учраас хуудуутай ажиллагааг илрүүлж болох бичиг баримтууд өөр хаана ч байх ёсгүй.

-Үүнтэй холбогдуулан та юу хэлэх гээд байгаа юм бэ?

-Энэ бүх данс бүртгэл, бичиг баримтууд чинь цөм хуурамч, эдгээрийг чамаас салгаж авсан юм гэж Полунин хэлэх нь тэр.

Алексей Петров бичиг баримт руу алмайран гайхаж харснаа дахин Полунин руу хараагаа шилжүүлэн:

-Энд байгаа гарын үсгүүд гэж дуугартал Полунин залгаж аваад:

-Тийм ээ, Алексей. Гарын үсгүүд Сатаровын биш. Гарын нь үсгийг дууриалган нарийн үйлдсэн хуурамч гарын үсэг юм. Үүнийг чамаас салгаж авсан байгаа юм Алексей минь гэлээ.

-Та тэгээд юу хэлэх гээд байгаа юм бэ? Хэн эдгээрийг авсан юм бэ? гэж Алексей болгоомжлон асуулаа.

-Би чамд энэ тухай хэлж чадахгүй гэж Полунин хариулаад тэр хүн надад туслахыг хүссэн юм. Ингээд тэрээр гэрээний хуурамч хуулбарыг чамд орхиж жинхэнэ эхийг нь авсан. Гэтэл гайхмаар юм болж чиний тэр жинхэнэ эх бичиг баримтууд бас биш байсныг мэджээ гэж хэлэв.

Өрөөнд түгшүүртэй нам гүм хэсэг үргэлжилж Полунин Петровыг сонжин ширтсээр байв. Харин Петров бодлогошрон алмайрч бичиг баримтуудын хавтсыг гартаа хий дэмий эргүүлж суув.

-Одоо чи жинхэнэ эх бичиг баримтууд хаа байгааг хэл. Хааш нь чи нуусан бэ?

-Би таны юу ярьж байгааг ойлгохгүй байна. Таны асуултад хариулахыг огт хүсэхгүй байна гэж Алексей яаран хариулав.

-Больж үз, Алексей минь гэж Полунин ядрангүй байдлаар хэлээд, бид энд ямар цагдаагийн байцаалтад байгаа биш. Би чамаас үнэн хариулт авахын тулд ердийн бус арга хэрэглэж болох биш үү. Гэвч тэгэхийг би хүсэхгүй байна. Яагаад гэвэл бид хоёр хэл амаа ололцоно байх гэдэгт найдаж байна гэв.

-Та ямар асуудлаар надтай тохиролцох гэсэн юм гэж Алексей дахин айсан шинжтэй нүдээр ширтэж асуув.

-Чи энэ сөргөлдөөнд Сатаровын эсрэг миний талд оролцохыг би хүсэж байна.

-Та юу ярьж байна вэ? Галзуурав уу хэмээн Алексей орилоод таны тал гэж юу байдаг юм! Та хэн болоод ийм юм ярьж байна. Та бол найз нөхөд танил талгүй болсон эрэн сурвалжлагдаж байгаа хүн шүү дээ. Харин Сатаров бол зөвхөн компанийг ч бус бараг хотыг өөрийн эрхшээлдээ аваад байгаа хүн. Түүний эсрэг тэмцэнэ гэдэг чинь амиа хорлосонтой адил болно гэлээ.

-Яаран дүгнэлт хийхээ азна, Алексей чи бүхнийг хараахан сайн мэдээгүй байна. Удахгүй “Аркада” компанийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхээр Москвагаас тусгай комисс ирэх гэж байна гэдгийг чи мэдэж байгаа байх.

-Тэгээд юу гэж? гэж Алексей уцаарлаад тийм комиссууд бишгүй л явдаг юм. Тэдний алийг ч гэж Сатаров мөнгөөр худалдан авч дөнгөнө гэв.

-Бүгдийг арай чадахгүй байх шүү гэж Полунин хэлээд зарим нэгэн юмыг бас үйлдвэрийн хувьцаагаар худалдаж болно. Тухайлбал өөрийн эрх чөлөө, аюулгүй байдлыг. Харин Сатаровын эрх чөлөө аюулгүй байдал нь ихэд үнэтэй байх болно. Компанийг бүхэлд нь өгөөд ч барахгүй болов уу гэж бодож байна гэв.

Алексей түүнийг хөмсөг зангидан сонсож суулаа. Тэгснээ Полунин дэмий юм яриагүй үнэхээр удахгүй Сатаровт хүнд хэцүү цаг тулгарах болно гэдгийг ойлгох шиг болж:

-Баримт бичгийг хэн солих гэснийг би тааварлаж байна. Тэр бол өөр хэн ч биш Веселовский л байж таарна гэлээ.

-Энэ хэлснийг чинь би ямар нэгэн тайлбаргүй орхиё гэж Полунин мөрөө хавчин дуугараад, харин чи өөрөө дүгнэлт хийнэ биз гэв.

Дүгнэлт бараг тодорхой байлаа. Веселовский шиг хүн Сатаровын эсрэг тал руу шилжиж байгаа бол Сатаров нэлээд хүнд байдалд орсныг гэрчилж байгаа хэрэг.

-Үүнээс гадна чамд өөр сонголт байхгүй гэж би бодож байна хэмээн Полунин түүний бодлыг дахин тасалж дуугараад хэрэв чи Москвагийн комисст туслахгүй ч байсан Сатаров чамайг эргүүлж авах нь юу л бол. Олег Сатаров буруутанг хэзээ ч уучлахгүй. Тэр их муу санаатай хүн гэдгийг чи ч би ч мэднэ. Хэрэв чи түүний эсрэг материалыг далдуур цуглуулсан бол чамтай хүн нэг их агаархаад баймгүй хэрэг хийж дээ. Харин би Сатаровт үүнийг чинь мэдүүлэхийн тулд бүхнийг хийх болно. Веселовский ч надад тусална гэлээ.

Петров Полунингийн эсрэг юу ч хэлж чадахгүй дуугүй сууж байв. Тэрээр түүний бүх тансаг баян амьдрал төгсвөр болж байгааг гэнэтхэн ухаарлаа. Одоо Петров бүр базаахгүй эсвэл зүгээр базаахгүй гэсэн хоёр сонголтын аль нэгийг нь сонгон авах хэрэгтэй боллоо. Бүр базаахгүй сонголт нь Сатаровын талд уу эсвэл эсрэг үү гэдгийг мэдэх хэрэгтэй болов.

-За тэгэхлээр чиний нуусан данс бичгүүд хаана байна? хэмээн Полунин түүний нүдийг цоо ширтэн нам бөгөөд ноцтой дуугаар тулган асуув. Нөгөөх нь хариуд нь толгой сэгсрээд дорой

дуугаар:

-Би одоо ямар нэгэн шийдвэр гаргаж чадахгүй байна. Эргэцүүлэн бодох цаг хугацаа хэрэгтэй гэв.

Полунин дахин инээд алдаад:

-Эргэцүүлэн бодох цаг хугацаатай байдаг нь олзны хүний бас нэг давуу тал юм даа. Тэгвэл чи эргэцүүлэн бодох бас хүлээн авсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийхийн тулд эндээ үлдэх болно. Өөр мэдээлэл авах эсэх үүсвэр ч чамд байна гээд буланд байгаа зурагт руу толгой дохиод чи надад итгэ. Тун удахгүй зурагтаар тун сонирхолтой мэдээнүүдийг гаргах болно гэлээ.

* * *

Полунин өөрийн түр зуурын албан газрын зориулалтаар хотын захад хувийн орон сууц хөлслөн авлаа. Чухам энэ байшингийн доод хонгилд Алексей Петровыг хорьж байв. Дараачийн өдөр нь зөвхөн машины гэрлээр байшинд ойртож очихоор бүр оройн харанхуй болсон хойно нэгэн “Волга” ирж зогслоо. Машинаас Бахметьев гараад байшингийн гадна хаалганд хүрч ирлээ. Хаалгыг болзсон ёсоор тогшиход Николай онгойлгож өглөө. Өрөөнд зурагт хараад Полунин буйдан дээр сууж байв.

-Мэдээгээр онц юм гарахгүй байна гэж Полунин мэндийн оронд хэлээд босож Бахметьевыг угтан авав.

Хошууч түүний гарыг барьж мэндлээд хажууд нь буйдан дээр сууж:

-Бүү санаа зов Владимир Иванович. Хэрэв шалгалтын комисс ирэхийг тэд урьдчилан мэдсэнсэн бол комиссын ажил сохор зоосны үнэд ч хүрэхгүй байхсан. Комисс хоёр хоногийн дараа ирнэ гэж бодож байна. Та тэгээд тэр “халамжийн” хүнтэйгээ хэл амаа ололцож байна уу? гэж асуув.

-Тэр залуу яахаа шийдэж ядан бодож байгаа гэж Полунин инээд алдан хариулаад тэр эргэцүүлэн бодож нааштай хариу өгөх байх гэж бодож байна. Түүний оронд би байсан бол мөн адил сонголт хийхийн өмнө эргэцүүлэн бодох байсан. Би ч гэсэн өөрийн ажлын амжилтад төдийлөн сайн итгэхгүй байна гэлээ.

-Би чухам одоо танаас ийм үг сонсоод гайхаж байна гэж Бахметьев бас инээд алдан хэлээд, одоо бид бараг шууд барианд орох гэж байна шүү дээ. Гэтэл та ингэж эргэлзэж байх юм гэлээ.

-Николай Иванович минь би юм бүхэнд эргэлзээтэй ханддаг. Энэ нь миний төрөлхийн зан юм уу даа. Энэ маань намайг нэг бус удаа хорлож байсан боловч тэр болгондоо миний амьд явах хугацааг сунгаж байсан юм.

-Та ямар асуудалд эргэлзэж байна вэ?

-Таны тэр саяны хэлдэг шууд бариа чинь тойруу бариа болчихвий гэдэгт санаа зовж байна. Тэгвэл бид урьдчилан төсөөлөх аргагүй байдалд орно...

Бахметьев чангаар инээд алдаад

-Би таны хошигнолыг үнэлж байна, Владимир Иванович минь. Таны зорсондоо хүрэх гэж няцашгүй зүтгэдийг чинь бүр илүү үнэлж байна. Харин та дэмий санаа зовж байна. Бүх юм төлөвлөсөн ёсоор явагдаж байна. Хэрэв та өөрийн үүргээ биелүүлж асуудлыг эцэст нь хүргэж чадвал бид ч гэсэн амласандаа хүрч ажиллах болно гэв.

-Би өөрийн үүргээ хэдийнээ биелүүлж байна. Энэ чиглэлээр та урагшилж хөдөлбөл бүр сайнсан. Миний эсрэг үүсгэсэн эрүүгийн хэрэг хаагдах ёстой. Энэ бол миний ажиллах нөхцөлийг хангах гол зүйлийн нэг мөн гэж Полунин сануулав.

-Энэ асуудал орон нутгийн прокуророос ихээхэн шалтгаална гэж Бахметов хэлээд манай прокурорын газар энэ бүх хугацаанд төвийг сахиж байдлыг ажиглан хүлээж байгаа юм. Тэдэнд энд болж буй хэрэг явдал илэрхий таалагдахгүй байгаа боловч шийдвэртэй арга хэмжээ авахгүй байна. Прокурор аллагын талаар эрүү үүсгээд байгаа боловч хэргийг тууштай мөрдөхгүй байгаа юм. Одоо хүртэл зогсонги байдалтай байна. Гэвч Москвагийн комисс ирж идэвхтэй ажиллаж асуудлыг зөв тийш нь шийдэж эхэлвэл прокурорууд ч гэсэн тэр зогсонги байдлаасаа гарч бидний хүссэн чиглэлээр ажиллаж эхлэх байх гэж бодож байна. Чухам энэ шатанд бид таны эрүүгийн хэргийг хүчингүй болгоно. Би саяхан томилогдсон хотын ерөнхий прокурорын орлогч Варанковтой ярилцсан гэж ярилаа.

-Би тэр хүнийг мэднэ. Чухам тэр хүн миний эхнэр болон Самбистын алуулсан хэргийг мөрдөж байгаа юм...

-Тэр бол жирийн нэгэн биш ажлаа сайн мэддэг тун туйлбартай хүн шиг санагдсан гэж Бахметьев нэмж хэлээд, Сатаров түүнд илт таалагдахгүй байгаа бололтой. Тэрээр орон нутгийн мафийн эсрэг үүдсэн том хэргийн талаар боломж алдахгүй байх гэж бодож байна. Гэвч тэр таны асуудалд болгоомжтой хандаж байна. Таныг цагаатгах асуудлыг хөндөж ярихад минь тийм ч дуртай хүлээж аваагүй. Харин эрс тэс татгалзаагүй. Тийм учраас тууштай ажиллах хэрэгтэй. Байдал зөв тийш өөрчлөгдөн үр дүн нь заавал гарна гэв.

-Таны хэлснийг сонсоход таатай байна гэж Полунин хариу талархаад, харин холбооны комисс ямар бүрэлдэхүүнтэй ирэх вэ? гэж асуув.

-Мэдээж комиссыг прокурор ахалж ирнэ. Бүрэлдэхүүнд нь янз бүрийн хууль хяналтын газрын хүмүүс орсон. Гэвч ихэнх нь манай газрын ажилтнууд байгаа. Мөн дотоод яамныхан болон орон нутгийн прокурор, эрүүгийн цагдаагийнхан оролцож ирнэ гэж Бахметьев хариулав.

-Та тэднээс айхгүй байна уу?

-Айхгүй байна. Харин болгоомжилж байна. Удахгүй орон нутгийн цагдаа нарыг комиссын ажиллагаанд оролцуулахгүй болно.

-Тэгэхлээр комисс хэдийд хүрч ирэх вэ? гэж Полунин асуув.

-Прокурорын ахалсан үндсэн бүрэлдэхүүн нь маргааш нөгөөдрөөс ирж шууд ажилдаа орох болно гэж Бахметьев хариуллаа.

* * *

Сатаров ширээнийхээ араас босож уужим саруул өрөөн дотуураа алхалсаар үйлдвэрийн хашаан доторхи сайн харагдах цонхны дэргэд очиж зогсов. Олег Григорьевич ажилчид үйлдвэрийн нэгэн цех рүү дулааны шугам тавьж байгааг хөмсөг зангидан харж байлаа. Өвлийн бэлтгэлийн ажил ид өрнөж байв. Гэвч үйлдвэрийн бүх салаа энэ ажилд жигд ороогүй байсан юм. Жил хагасын өмнө Сатаров компанийн захирлуудын зөвлөлийн дарга болсноос хойш өөрийгөө үйлдвэрийн бүх л үйл ажиллагаанд хяналт тавьж байх үүрэгтэй гэж шийдсэн ажээ. Тэрээр компанийн бүх л үйл ажиллагааг хянаж зааварлаж байхыг хичээдэг байлаа. Гэвч тэр өөрт нь мэдлэг туршлага илт дутагдаж байгааг улам бүр ойлгох болсоор байв. Түүнд Полунин шиг эдийн засгийн мэдлэг боловсрол, бизнесийн хүрээнд хамт олныг удирдах ур чадвар илт үгүйлэгдэж байв. Тэрээр зөвхөн чадварлаг бөгөөд зоригтой дайчдаас бүрдэх хүчирхэг баг бүрдүүлэн түүнийхээ хүчээр хүч хэрэглэн зорилгодоо хүрэх авьяастай хүн байв.

Гэвч түүний сонгож авсан бизнесийн ажил өөрөөс нь огт ондоо чанарыг шаардаж байлаа. Тухайлбал эмх цэгцтэй, уян хатан мэдлэг тооцоотой, зөв зарчимч шаардлагатай, зарим үед бүр буулт хийж чаддаг байх хэрэгтэй юм. Гэвч Сатаровт тийм чанар төрөлхийн заяагаагүй ажээ. Аажмаар компанийг бүрэн захирах эрх бүхий толгойлогч болох үедээ зөвхөн өдөр тутмын асуудлыг шийддэгээс гадна ирээдүйн олон төлөвийг урьдчилан төсөөлж төлөвлөдөг олон ажилтан мэргэжилтнүүдийнхээ хамааралд улам бүр орж байгаагаа мэдрэх болсон байна.

Тэрээр өөрийн менежерийг хянах чадваргүйгээ ухааран түүнийхээ нэр хүнд, шударга занд итгэх болжээ. Энэ утгаараа Сатаров “Аркада” компанийн санхүүгийн ажиллагааг зохицуулдаг Капустин ахлагчтай голчлон залуу хүмүүсээс бүрдэх санхүүгийн бүлэг гэгчдээ ихэд итгэл хүлээлгэдэг болсон байлаа. Сатаров өөрөө компанийн аюулгүйн байдлыг биечлэн анхаарч удирддаг байв. Гэвч энэ асуудалдаа ч бизнесмений ёсоор хандаж чаддаггүй байлаа. Компанийн хамгийн өндөр албан тушаалыг авч тус хотод асар их нөлөөтэй болсон боловч тэрээр өрсөлдөгч нартайгаа бага зэрэг ч гэсэн хэвийн харьцаа тогтоож ажиллахыг хүсдэггүй байсан бөгөөд зөвхөн хатуу түрэмгий бодлого баримталж иржээ. Сатаров энэ өндөрлөгт гарахад нь их тус хүргэж хотын засаг захиргаатай дотно харьцаа тогтооход нь зуучилж өгсөн Томашевскийг үйлдвэрээс бараг шахан холдуулсан ажээ. Тэр ч бүү хэл тэрээр Москвагийн нэр нөлөө бүхий хүмүүстэй ч холбоо тогтоохыг хичээсэнгүй. Хэрэв өөрийн мэдлийн хөрөнгөнөөс бага зэргийг хүртээж тэдэнтэй ойртож чадсан бол компанийн эргэн тойронд бий болсон түгшүүртэй байдлыг зохих хэмжээгээр намжааж болох байсан юм. Эдгээр сөрөг хүчин зүйлүүд нь жил хагасын өмнө ширүүн өрсөлдөөнд ялж гарсан Сатаровыг өөртөө итгэлгүй болгожээ.

Тэрээр хүчирхэгжих тусмаа тэр хэмжээгээр итгэл нь алдарч улам муу санаатай болж байв. Түүний талаар таагүй ханддаг хүмүүсийн ярьж буй Москвагаас ирсэн мэдээ дайран дээр давс хийсэн мэт түүнийг улам бачимдуулах болов. Гэвч Сатаров бүхнээс илүү Полунингаас эмээж

байв. Тэр өөрийн нь заналт бөгөөд ухаалаг дайсан Полунин эрт орой хэзээ нэгэн цагт өөрт нь сүйрлийн цохилт өгнө гэдгийг мэдэж байсан юм.

Сатаров Полунингийн зан чанар мэдлэг чадварыг мэдэх учир тэр цохилт хаанаас ч ирж болохыг ойлгож байв. Гэвч тэрээр өөрийн хүчинд итгэсээр байлаа. Түүний санхүүгийн нөөц боломж үнэхээр их байсан юм. Сатаровын удирддаг компанийн санхүүгийн үр ашиг нь өдөр ирэх тусам нэмэгдсээр байв. Мөнгө тулгарч байсан нэг бус удаагийн хүнд асуудлыг нь шийдэж чаддаг байв. Тэгэхлээр Сатаров Москвагаас шалгалт ирнэ гэхийг сонсоод нэг их айсангүй.

-Эцсийн дүнд би тэдэнд орон нутгийн шалгалтынханд өгдөгөөс бага зэрэг илүүг атгуулах болно гэж Сатаров өөрийн мэргэжилтнүүддээ хэлэв.

Гэвч тэрээр Москвагаас ямар ч нөлөөнд үл автах хүчирхэг комисс ирэх гэж байгаа мэдээллийг авах бүртээ сэтгэл санаа нь улам тавгүйтэж байв Ялангуяа тэр комисс баян бизнесменээс их шан горьдож ирэхгүй гэдгийг сонсоод бухимдал айдас хоёр нь улам хүчтэй зовоох болов. Энэ комисс компанийг нь бүхлээр нь салгаж авах зорилготой ирж байгаа учир тэмцэл өршөөлгүй хурц ширүүн болох нь тодорхой. Энэ тулалдаанд бэлтгэхийн тулд компанийн эмзэг газрыг бэхлэх хэрэгтэй. Энэ санааг нь Алексей Петровын гэнэтхэн сураггүй алга болсон явдал улам баталж өглөө. Түүнтэй хамт компанийн санхүүгийн хуудуутай олон үйл ажиллагааг илчилж болох чухал бөгөөд ноцтой данс бүртгэлүүд алга болсон нь тун аюултай байлаа.

...Сатаровын өрөөний хаалга онгойж Капустин Романенковын хамт орж ирлээ. Сатаров хараагаа цонхноос шилжүүлж хаалганаас холгүй зогсож буй тэдэн рүү хандуулав.

-За яав? Олов уу? гэж Сатаров ширүүн дуугаар асуулаа.

-Үгүй. Одоохондоо олж чадсангүй гэж Романенков толгой сэгсрэн хариулав.

Сатаров их чимээтэйгээр гүнзгий амьсгаа авсанаа эргэж цонх руугаа хараад:

-Түүний тухай ямар нэгэн юм олж мэдэв үү гэж асуув.

-Одоохондоо тун бага гэж Романенков хариулаад, нэгэн албан газрын дэргэд байсан түүний машиныг бид олсон. Тэндхийн байрны оршин суугчид энэ “Рено” маркийн гадаад машин хэзээ хаанаас бий болсон ямар хүн хийх гэдгийг огт мэдэхгүй байна.

-Оройн есөн цагаас хойш тэнд очсон гэдэг нь тодорхой гэж Сатаров тайлбарлаад, учир нь есөн цагаас өмнө би түүнд Москвагаас комисс ирэх гэж байгааг мэдэгдээд бичиг дансаа янзал гэж үүрэг өгсөн юм гэлээ.

-Тэр ямар комисс ирэх гэж байгааг түүнд тайлбарласан уу гэж Романенков асуув.

-Үгүй, тайлбарлаагүй гэж Сатаров ярвайн хариулаад, чи намайг хэн гэж бодоо вэ? Цаг нь болоогүй байхад яагаад үүнийг хэлэх ёстой юм? гэж асуулаа.

-Тэгвэл тэр өөрөө тэр комиссын тухай мэдэж л дээ хэмээн Романенков зөрүүдлээд, магадгүй тэдэнтэй уулзахгүй байсан нь дээр гэж үзэж л дээ. Бид түүний гэрт нь очсон. Гэр нь бага зэрэг эмх замбараагүй болсон байв. Аяны чемодан нь байхгүй байгаа нь Леша нэг тийшээ нэлээд хугацаагаар холдож явсныг гэрчилж байна. Мөн гэртээ бэлэн мөнгө үлдээгээгүй байсан гэж илтгэлээ.

-Тэгвэл муу гөлөг зугтаж л дээ гэж Сатаров шүд зуун хараалаа.

Тэгснээ одоо хүртэл дуугүй зогсож байсан Капустин руу огцом эргэн нүд рүү нь өрөмдөх мэт ширтсэнээ

-Харин чи юу гэж хэлэх гэж байна? гэж асуув. Нөгөөх нь хаа нэг тийш гөлөгнөн харснаа, мөрөө хавчин:

-Би... Би мэдэхгүй байна... Яагаад зугтах болсон юм бол доо хэмээн ээрэн дуугарав.

-Хэн тэгээд мэдэх болж байна, чөтгөр аваг? гэж Сатаров хилэгнэн хашгирав. Тэгснээ Капустин руу үсрэн очоод заамдан авч:

-Тэр чинь чиний хүн шүү дээ! Чи түүний талаар цөмийг мэдэж байх ёстой. Би та нарт бусдаас илүү итгэж байсан! Нохойн гөлөгнүүд та нарыг би хүмүүсийн дунд оруулж өгсөн гэж хашгирлаа.

-Олег... Чи тайвширч үз хэмээн Капустин сандран хэлээд, бид тэрнийг заавал олно. Ямар нэгэн алдаа гаргаж л дээ. Леха ямар нэг хүүхнийд байж болох бүрэн боломжтой. Эсвэл хаа нэг газар архидаж хэвтээ биз гэлээ.

-Хүүхнийд гэв үү чи гэж Сатаров дахин орилоод, бүх юмаа аваад уу? Машинаа хаяад, гар утсаа салгаад уу? Хэдэн өдөр өнгөрөхөд нэг ч удаа утасдсангүй. Хотод байдал дахин хурцдаад байгаа үед шүү дээ. Ер нь чи намайг хэн гэж бодоо вэ, новш минь! гэлээ. Тэгснээ тэрээр Капустинг түлхэж орхиод нам бөгөөд заналтай дуугаар:

-Өнөөдөр бүх бичиг данс шүүрдэгдэн устгавал зохихыг нь Романыч өөртөө авсан байх ёстой. Тэгсний дараа энэ хотоос холдож нуугд. Миний утасдах хүртэл хоншоороо бүү цухуйлга. Тэр Лебниковыг бас хяналтандаа ав. Петров эхнэр хүүхэдгүй бол та нар тийм биш. Гэр бүлээ бүү золионд гаргаж үз хэмээн сүрдүүллээ.

Капустин айж балмагдсанаасаа болж толгойгоо ганзагалан хувхай царайлан өрөөнөөс гарч явлаа.

Романыч Сатаровг дөхөж очоод:

-Одоо юу хийх вэ, Олег? гэж асуув.

-Харин чи юу гэж бодож байна? хэмээн Сатаров хариу асуугаад хөмсөг зангидан дахин цонхоор ширтэж зогсоод

-Петровыг олж чадахгүй гэж чи үнэхээр бодож байна уу? гэж асуув.

-Тийм ээ. Тэгж бодож байна гэж Романыч батлан хэлээд тэр нохойн гөлөг зугтаж явсан нь тодорхой. Харин бүр ямар тэсрэх бөмбөг авч яваа бол. Ер нь би сайн мэдэхгүй байна. Гэвч Капустины алба бол манай хамгийн эмзэг газар гэж бодож байна. Москвагийнхан хамгийн түрүүн түүн рүү дайрах гэж байгааг нь тохиолдлын бус хэрэг. Тэд хаанаас ухаж эхлэхээ мэднэ гэлээ.

-Бидэнд айх юм алга. Данс бүртгэлүүдийг цөмийг устгасан гэж Сатаров бодлогошрон хариулав.

-Тийм ч тодорхой биш байна гэж Романенко болгоомжлон хэлээд зарим хэсгийг нь Петров өөртөө авч явсан байж болно. Зүгээр тэр зайлж нуугдсан бол ч яах вэ. Харин зангаа хувиргасан бол яана? гэж асуув.

-Чи тэгээд юу хэлэх гээд байгаа юм бэ?

-Данс бичгүүд нэг хэрэг. Гэрчүүд гэж бас бий гэж хэлэх гээд байна. Энэ эдийн засагч залуусаас илүү гэрчүүд байхгүй гэж Романенков хэлэх нь тэр.

Сатаров Романенковыг хэсэг зуур ноцтойгоор сонжин харлаа. Романенков огт дальдралгүй түүн рүү ширтсээр:

-Би аль хэдийнэ Музыкантын бүлгийг дуудчихаад байгаа. Тэд найдвартай хүмүүс гэлээ.

-Тэг гэж чамд хэн тушаав? гэж Сатаров асуув.

-Хэн ч тушаагаагүй гэж Романенков мөрөө хавчин хариулаад, юу хийхээ би өөрөө мэднэ гэлээ.

-Сүүлийн үед чи хэтэрхий их юмыг ганцаараа шийдэх гэдэг болж хэмээн Сатаров тайван боловч илт заналхийлсэн өнгөөр дуугарлаа.

Романенков түүний үгийг нэг их тоосон шинжгүй сонсож байснаа:

-Чиний аюулгүй байдлыг хангах нь миний ажил би үүнийгээ одоохондоо сайн хийж байна гэж боддог гэлээ.

Сатаров Романенковын хэлэхийг сонсоод дахин цонх руу эргэн харж зогслоо. Тэгснээ бодлогоширсон байдлаар

-Одоохондоо чиний хувьд нэг их сүрхий ажил гараагүй байна. Харин болох гэж байгаа холион бантангаас мэнд гарахын тулд юм бодох л хэрэгтэй боллоо гэж санууллаа.

-Тэгэх тусмаа шуурхай бөгөөд шийдвэртэй арга хэмжээ авах хэрэгтэй хэмээн Романенков шөфийнхээ санааг дэмжин өгүүлээд, бидний талд тууштай байгаа хүмүүс хэлмэгдэх ёсгүй гэдгийг ойлго. Тэднийг комиссынхон оролдохгүй гэдэгт тэд итгэлтэй байх ёстой. Тэд энэ

санаагаа надад тодорхой ойлгуулсан юм гэлээ.

-Чи бас тэдэнтэй зөвлөлдөөд аваа юу? гэж Сатаров инээд алдан асуув.

-Би шөнө шалгалтын комиссынхон хотод ирсэн гэж дуулаад өнөө өглөө тэдэнд урьдчилан сануулсан юм. Хэрэв бид өөрийн холбоотнуудаа илчилж өгөхгүй бол холбоотнууд маань бидэнд бүх талаар туслах болно гэж надад ойлгуулсан юм гэж Романенков хариу тайлбарлав.

-Тэд надад олон удаа тэгж ярьсан юм аа гэж Сатаров залхсан байдалтай дуугараад тэгэхээс өөр арга бидэнд байхгүй. Энэ санхүүгийн албаны гөлөгнүүдэд би хойшид хэзээ ч итгэхгүй. Хэрэв тэднийг байцааж эхэлбэл амархан бууж өгөх байх гэж бодож байна гэлээ.

-Тэгэхлээр би Музыкант руу утасдах уу?

Сатаров дуугүй толгой дохилоо.

* * *

Малеев өөрийн хүрэн өнгийн “Жигулийг” Хмельнецкий Рабочий гудамжны уулзвараас холгүй орших бэлэг дурсгалын барааны дэлгүүр “Галантериягийн” дэргэд зогсоолоо. Тэрээр жолооны ард суух агаад машины бүхээгэнд нэгэн нэрд гараагүй чавхдас хөгжмийн хамтлагийн тоглосон Вивальдийн хөгжим сонсогдох ажээ. Хийлээр тоглож буй Вивальдийн хөгжим Малеевийг бага зэрэг эзэмдэх мэдрэмж төрүүлж байлаа. Үл мэдэгдэм эмгэнэлийн өнгөтэй боловч хөгжмийн ая нь Малеевт өөдрөг санаа зоригжуулах мэдрэмжийг өгч байв. Тийм ч учраас Малеев ээлжит ажлынхаа өмнө энэ хөгжмийг сонсох дуртай байсан юм. Түүний хийдэг ажилд сэтгэл санааны хүчтэй бөгөөд дарамтлагч шинжтэй хөгжмийн ая зохиолддоггүй ажээ. Тиймээс тэрээр баргар өнгө голчилдог.

Вагнерийн хөгжмийг нэг их таашаадаггүй байв. Малеев амгалан тайван байдлаа алдаж хямралд орж хэзээ ч болохгүй тийм бизнес эрхэлдэг юм. Тийм учраас олонхи хүмүүсийн нэгэн адил түүнд сэтгэл санааны тогтмол тэжээл хэрэгтэй байдаг ажээ. Тэрээр түүнийг хөгжмийн аянаас авдаг байлаа. Машины хаалга онгойж Романенков орж суух зуураа:

-Явья гэж хэлэв.

Малеев машинаа хөдөлгөөд хэдэн хором өнгөрсөн хойно:

-Хаашаа? гэж асуулаа.

-Хаашаа ч хамаагүй. Тайван ярилцаж болмоор нам жим газар хэрэгтэй гэж Романенков хариулав.

Хэдэн минутын дараа Малеев ард нь “сүүл” байгаа эсэхийг шалгаж хараад нэгэн чимээгүй гудамжны мухарт очиж машинаа зогсоолоо. Хөдөлгүүрээ унтраагаад Романенков руу анхааран харлаа.

-Наадах ядаргаатай юмаа салгаж үзээч, бурхан минь гэж Романенков үрчийн дуугараад дуу

хураагч руу нь заав.

-Чи сонгодог урлагт дургүй хүн юм гэж Малеев хөгжмөө унтраах зуураа инээд алдан хэлээд, хийл хөгжмийн ая сонсох дургүй юм гэв.

-Би ер нь ямар ч хөгжим сонсох дургүй. Юу нь чамд тэгж таалагддагийг огт ойлгохгүй байна.

-Би ч гэсэн өмнө нь хөгжмийг ойлгодоггүй байсан юм хэмээн Малеев дурамжхан инээж дуугараад хүүхэд байхад минь эх маань намайг хөгжмийн сургуульд хүчээр оруулсан. Харин миний сонсгол маш сайн байсан юм билээ. Тэгээд би хэдэн янзын хөгжмийн зэмсэгээр тоглож сурлаа. Тэр цагаас хойш олон жил өнгөрчээ. Харин одоо би өөр зэмсэгээр “тоглож” амьдралаа залгуулж явна даа. Гэвч би хөгжимгүй амьдралыг одоо төсөөлж чадахгүй болжээ. Хувь тавилангийн хачирхалтай эргэлт байгаа биз? гэж ярив.

-Магадгүй юм. Гэвч одоо би хувь тавилангийн огт өөр эргэлтийг сонирхож байна. Би тэр эргэлтийн сөрөг урсгалд орчихгүйн тулд чамаас тусламж хүсэж байгаа юм гэж Романенков хариу хэлээд цувныхаа дотор халааснаас хүмүүсийн гэрэл зураг тэмдэглэсэн гэрийн хаяг гарган түүнд өглөө.

-Энэ өндөр хөлс авч болох ажил байгаа гээд Романенков хийх ёстой ажлыг нь хурдан боловч тодорхой тайлбарлав. Тэгснээ үргэлжлүүлэн:

-Харин бидэнд энэ хүмүүсээс хэн ч үлдэхгүй гэсэн бүрэн баталгаа хэрэгтэй. Энэ ажлыг маш яаралтай хийх нь чухал. Бид чамгүй хэмжээний хөлс төлөх болно гэлээ.

Малеев дугтуйтай зүйлийг хүрэмнийхээ дотор халаасанд далд хийгээд дурамжхан байдлаар:

-Манай бүлгийг мэдээж “цэвэрлэгээнийх” гэж нэрлэж болох боловч бид гудамжны хог цэвэрлэдэггүй. Та нарын цаасыг цуглуулах нь бидний ажил биш. Өөрийнхөө новшийг өөрсдөө мэд. Би балаанс бариулдаг таны нягтлан бодогч биш гэлээ.

-Бид сайн хөлс төлнө гэж Романенков дахин сануулав.

-Хэдийг?

-Ажлаа бүрэн гүйцэтгэж эдгээр хүмүүсийг устгаж данс бичгүүдийг бидэнд өгсний чинь дараа зуун мянган доллар төлнө...

-Гучин мянгын урьдчилгаа авна гэж Малеев яаран хэллээ.

-Мөн дөө Музыкант минь! гэж Романенков инээд алдан хэлээд чи хүнд болзол тулгаж байх чинь гэлээ.

-Энэ бол адгийн бохир ажил боловч бид цэвэрхэн ажиллаж чадна.

-Мэдлээ, мэдэж байна гэж Романенков хэлээд багц мөнгө гарган өгч, энд хорин тав байгаа. Урьдчилгаанд хүрэлцээтэй мөнгө. Ажлаа гүйцэтгэсний дараа үлдсэнийг нь нэгмөсөн

аваарай гэлээ.

Малеев юм хэлэлгүй мөнгийг авч багцаалан харсанаа халаасандаа хийв. Тэгснээ яриа дууссаны дохио болгон хөдөлгүүрээ асааж:

-Тохирлоо гэж хэллээ.

-Шаардлага гарвал надтай гар утсаар холбоо бариарай гэж Романыч хэлээд хотод юу болж байгааг чи мэдэж байгаа учир тун болгоомжтой хөдлөөрэй. Өнөөдөр манай пүүс рүү Москвагийн комиссынхон дайрч ирсэн. Бүрэн хэмжээгээрээ сэгсэрч эхлээд байна. Тэдэнд орон нутгийн аюулаас хамгаалахынхан тусалж байна гэсэн яриа байна гэв.

-Надад бүү сургамжил. Яаж ажиллахаа би өөрөө мэдэж байна гэж Малеев хүйтнээр дуугараад Романенковын машинаас буусны дараа хөдөлж явлаа.

* * *

Полунин шатаар хурдан бууж байрны хонгилын өрөөнд хүрч очоод хаалганы түгжээг онгойлгов. Петров ширээний ард сандал тавиад сууж байлаа. Царай нь зэвхийрч, нүд нь айсан мэт бүлтийж, булан дахь зурагт руу харж байлаа. Яг энэ үед зурагтын хөтлөгч ямар нэгэн баримтаг үйл явдлыг тайлбарлаж байв. Дэлгэцний голд цусандаа хутгалдан гараа алдлан өөдөө харан хэвтэж байгаа Андрей Капустин харагдаж байх нь тэр. Хажууд нь дуу намжаагч угсраастай гар буу хэвтэнэ. “Ээлжит энэ аллага түрүүчийн цуст яргануудын нэгэн адил Оросын томоохон үйлдвэр болох “Нефтьоргсинтез”-ийн эргэн тойронд бий болсон үйл ажиллагаатай холбоотой юм” гэж хөтлөгч тайлбарлаад “Энэ хохирогч Андрей Капустин бол тэр үйлдвэр харьяанд байдаг газрын тосны “Аркада” компанийн удирдлагад санхүүгийн онцгой алба хашдаг байжээ.

Мөн энэ аллага нь Москвагаас ирмэгц шууд “Аркада” компанид шалгаж эхэлсэн комиссын ажиллагаатай холбоотой гэж шинжээчид үзэж байна. Манай телекомпани ч гэсэн Капустин компанийн санхүүгийн үйл ажиллагааны ноцтой булхайнуудыг сайн мэдэх хүн учир ирээдүйд болох шүүх хурал дээр аюултай гэрч болох юм гэж үздэг байв. Тэр шүүх ажиллагаа зайлшгүй болно гэдэгт хэн ч эргэлзэхгүй байна” гэж ярьж байв. Зурагтын дэлгэцний мэдээ солигдон Полунин очиж унтраав. Тэгээд эргэж Петров руу юм хэлэхийг нь хүлээн ширтлээ. Петров урьдын адил дуугүй сууж хуруунуудынхаа өндгөөр үрчлээгүй духаа зөөлөн илж байх ажээ.

-Шийдээ хэлэх цаг чинь болсон юм биш үү, Алексей хэмээн Полунин хэлээд товчоор чи бидэнтэй хамт уу эсвэл эсрэг талд байна уу гэдгээ хэл. Тэртэй тэргүй чиний энд суух цаг чинь дууслаа. Далиманд хэлэхэд одоо би чамайг ятгах гэж чармайхгүй. Тун удахгүй чи эсвэл хөлсний алуурчидтай эсвэл хууль сахиулагчидтай учрах болно. Өөр зам чамд байхгүй гэлээ.

Петров юу ч хариулалгүй унтраасан зурагт руу урьдын адил алмайран ширтсээр суув.

-Хэрэв чи мөрдөн шалгагчдад тусалбал зэм чинь хамгийн багаар тусах болно. Түүгээр ч барахгүй чамд лав байгаа хилийн чанад дахь банкинд хадгалуулсан мөнгөө хэрэглэх боломж

Ч олдono гэв.

Петров сая нэг юм түүн рүү хараад:

-Хэрэв миний аюулгүй байдал баталгаатай бол би мөрдөн шалгагчдын талд ажиллаж мэдүүлэг өгөхөд бэлэн байна гэж зөвшөөрлөө.

-Компанийн хуудуутай ажиллагааг гэрчлэх данс бүртгэлүүд хаана байна вэ? гэж Полунин шууд асуув.

-Надад хотын гадна бусдын нэрэн дээр бүртгэлтэй байр бий. Хотоос холгүй оршдог жижигхэн байшин. Тэнд тусгай нууц газар хадгалагдаж байгаа. Би танд тийшээ хэрхэн очиж олж авах талаар тодорхой тайлбарлаж өгье гэв.

Энэ мөчид Полунингийн халаасан дахь гар утасны дохио дуулдан Николай утасдаж:

-Лобников нууцлагдсан байрандаа ирээд байна. Тэр тэндээ их удахгүй нь бололтой гэлээ.

-Ойлголоо. Би одоо очье гээд Полунин утсаа салгав.

-Та хаашаа явах нь вэ? гэж Петров асуулаа.

-Чиний хам Валерий Лобниковыг амийг аврахаар оролдье гэж Полунин хариулав.

...Хорин минутын дараа Полунин такси хөлслөн Мясницкийн гудамжинд хүрч ирээд усан борооноор эл хуль талбайд бууж түүний хүлээж байсан өнгөт салхины шилтэй “9” дахь загварын “Жигулид” орж суулаа. Жолооны ард Николай Батурин сууж байв. Николай толгойд чихэвч углаастай байх агаад хажуугийн суудал дээр орон сууцны байшин руу чиглүүлэн бэхэлсэн антентай чагнах төхөөрөмж онгорхой чемодан дотор байх ажээ.

-Чи яг цагаа олж ирлээ, Иваныч. Алив чагна. Манай үйлчлүүлэгч сонирхолтой яриа өрнүүлж байна гэж Батурин хэлээд чихэвчээ өглөө.

Полунин чихэвчийг авч чихэндээ хиймэгц л тэр даруй Лобниковын “Боль хүүхдээр бүү оролд. Би хаашаа ч явахгүй. Би та нарыг эндээ хүлээж байя” гэж орилох дуу сонсогдов.

Полунин хөлсний алуурчидтай ярьсан Лобниковын яриаг сонсоод чихэвчээ мултлан авч Николайд эргүүлж өгөөд:

-Одоо тэд энд ирэх гэж байна гэв.

-Алуурчид уу? гэж Николай асуув.

-Тийм ээ. Самбист, миний эхнэр болон Коля Решетог алсан тэр алуурчдын бүлгийнхэн.

-Чухам тэд гэж чи яагаад бодож байна? гэж Батурин бүх биеэрээ түгшин асуулаа.

-Бахметов надад мэдээлсэн. Байшингийн оршин суугчид Капустиныг алсан алуурчныг харсан гэнэ. Тэр алуурчин бүх байдлаараа миний тэр Самбистын машины дэргэд байхад нь буудсан хүнтэй төстэй байна. Тэрнээс гадна чухам тэднийг хотод дуудаж ирүүлсэн гэдгийг бид мэдэж байна. Тэднийг нэрээр нь урьж ирүүлдэггүй гэдгийг чи мэднэ шүү дээ гэж Полунин тайлбарлав.

-Тэгвэл бид тэднийг хүндэт зочид шигээ угтаж авах уу даа гэж Батурин нүүрний булчингууд нь зангиран шүд зуун дуугарав.

-Үгүй ээ, Коля. Чи эндээ сууж бай. Би дээшээ гарч тэр хүндэт зочидтой өөрөө ярилцана. Энэ бол миний өөрийн хувийн тооцоо байгаа юм.

-Чиний хэрэг бол миний ч хэрэг шүү дээ хэмээн Николай цухалдан хэлээд, Самбист миний сайн нөхөр байсан юм. Би тэднийг ирэхэд нь угтаж байгаад сөнөөж орхиё гэлээ.

-Үгүй ээ. Тэгж хэрхэвч болохгүй гэж Полунин эрс татгалзаад, бид тэднийг устгаж хэзээ ч амжина. Тэдний гарт Лебниковын гэр бүл байгааг бүү март. Бас тэд бүх бүрэлдэхүүнээрээ ирэхгүй нь магад. Үлдсэн алуурчид нь хаана байгааг мэдэх хэрэгтэй. Тийм учраас нэгийг нь ч гэсэн амьдаар нь олзолж авахыг хичээнэ гэлээ.

Тэрээр ингэж хэлээд машинаас гарч байшингийн орц руу чиглэв. Николай машинаас толгойгоо цухуйлган хойноос нь:

-Болгоомжтой байгаарай Иваныч. Ямар ч байсан би тэдний нэгийг ч эндээс амьд гаргахгүй гэж хэлэв. Полунин түүний сануулсныг хүлээн авч толгой дохиод халааснаасаа гар утсаа гарган Лобников руу залгалаа.

Есдүгээр бүлэг

Өрөөний хаалганы хонх гэнэтхэн хангинав. Цочсоноосоо болж Лобников үсрэн босоод хаалга руу айсан нүдээр бүлтийн ширтлээ. Полунин ширээн дээр байсан гар буугаа яаралгүй аваад түгжээг нь тор хийтэл мултлав.

-Бүү сандар. Аль болох тайван байхыг хичээ хэмээн Полунин Валерийд аяархан хэлж сануулаад, тэднийг том өрөөнд дагуулан ороод хайрцагтай данс бүртгэлүүдийг өг. Цааш нь яахыг би өөрөө мэднэ. Харин миний гарч ирмэгц нэг тийш үсрэн зайлж өөрийгөө халхал. Буйдангийн юм уу орны цаана ч орж болно. Миний хувьд ялгаагүй. Тэгээд цухуйлгүй хэвтэж бай гэж тушаав. Полунин хажуугийн жижиг өрөөнд орж онгорхой хаалганы цаана нуугдлаа.

Лобников гүнзгий амьсгаа аваад хонгилоор явсаар хаалганд хүрч очоод биеэ эзэмдэхийг хичээн зогтуссанаа түгжээг мулталлаа. Босгон дээр хоёр өндөр бөгөөд шөрмөслөг залуу зогсож байлаа. Тэд бол Малеевын алуурчны бүлгийн Костыль, Гаврик хоёр байсан юм. Костыль түрүүлж араас нь Гаврик орж ирээд хаалгыг хүчтэй татан хаалаа.

Костыль цувныхаа халааснаас гар буу гаргах зуураа:

-Чи ганцаараа байгаа юу гэж асуув.

-Ганцаараа гэж Лобников хариулмагцаа миний эхнэр хүүхэд хаана байна. Тэд зүгээр үү? гэж асуув.

-Хэрэв чи данс бүртгэлүүдийг цөмийг нь өгвөл тэднийг чинь яах ч үгүй. Тэр цааснууд чинь хаана байна? гэж Костыль асуув.

-Том өрөөнд гэж Лобников самгардан хариулаад саяхан Полунинтай хамт сууж байсан өрөө рүү дагуулан явлаа. Энэ зуур Костыль бусад өрөөнүүдийг шалга гэсэн дохиог Гаврикт өгөв.

Гаврик гар буугаа бэлэн бариад гал тогоо, угаалгын өрөөг шагайж харснаа унтлагын өрөө рүү орлоо. Энэ үед Костыль данс бүртгэлүүдийг хэдийнээ үзэж эхлээд байв.

Гаврик өрөөнд ормогцоо цаана нь хүн нуугдаж болзошгүй хувцасны шүүтгээг сэжиглэн харлаа. Яг энэ агшинд ард нь байсан Полунин цахилгаан мэт хурдан хөдөлж Гаврикийн хүзүүг зүүн гараараа хавчин мушгиад гар буугаа ар дагзанд тулгаж барилаа.

-Бүү дуугар! гэж Полунин чихэнд нь шивнэж зандраад хүзүүг нь хавчсан гараа улам чангалан, буугаа орон дээр хая гэж тушаалаа.

Гаврик буутай гараа аажуухан доошлуулснаа буугаа ор руу чулуудаж орхилоо. Буу орон дээрээс ойж шалан дээр торхийн чимээ гарган ойчлоо.

-Мөн хө. Муу нохой! хэмээн Полунин шүдээ сийгүүлэн шивнэн зандраад олзны хүнээ эргүүлж урдаа хийгээд том өрөө рүү орлоо. Костилын өгсөн дохио болох энэхүү бууны ойчих чимээг тэнд байсан хүмүүс зөв ойлгожээ. Тийм учраас Полунинг Гаврикийг бамбай болгон

урдаа бариад том өрөөнд ороход Костыль аль хэдийнээ тэдэн рүү буугаа онилон бариад зогсож байлаа. Гэвч Гаврик халхлагдсан Полунинг буудаж онох боломж байсангүй.

-Буугаа хая, тэнэг новш оо! гэж Полунин зандраад тэгэхгүй бол чинь чиний найзын уураг тархийг өрөөгөөр нэг цацаж орхино гэлээ. Яг энэ агшинд Лобников бие халхлахаар буйдан руу үсэрлээ. Магадгүй энэ нь тэдний нүгэлт үйлийг эцэслэх шалтаг болсон байж болох юм.

Костыль үүнийг аюулын дохио хэмээн шууд ойлгон өөрийн эрхгүй бууныхаа гохыг дарж орхилоо. Том өрөөнд гарсан эхний буун дууны дараа дахин хоёр дахь буун дуу цуурай хадлаа.

Костылийн тавьсан сумнууд Гаврикийн дух болон цээжний дээд хэсгийг цөмлөн оржээ. Дараачийн агшинд дахин гурав дахь удаагаа буун дуу сонсогдов. Энэ нь харин Полунингийн бууны дуу байсан юм. Костыль гэдэргээ саван нуруугаараа ширээ түшин ойчлоо. Түүний цээжний зүүн талаас цагаан цамцыг нь нэвгчин цус олгойдон гарч байв. Полунин Гаврикийн нэгэнт амьгүй болсон биеийг тавьтал цогцос нь хэвлийн талаараа их чимээ гарган шалан дээр тэрийн ойчив.

Буйдан дор нуугдаж байсан Лобников гарч ирээд алагдсан алуурчдыг алмайран хараад хөшиж орхилоо.

-Ээ бурхан минь гэж тэрээр дуу алдаад, та хоёуланг нь алж орхилоо гэв.

-Харин чи биднийг хоёуланг алахыг хүссэн юм уу? гэж Полунин хөмсөг зангидан асуув. Тэгснээ халааснаасаа алчуур гарган “ТТ”-гээ хичээнгүйлэн арчсанаа Гаврикийн хүүрний гарт атгуулав. Тэгснээ үргэлжлүүлэн:

-Тэгээд ч ямар ч шинжээчид тэд бие бие буудаж алсан гэж дүгнэлт гаргах болно гэж нэмж хэллээ. Полунин унтлагын өрөөнд эргэж очоод Гаврикийн хаясан гар бууг авлаа. Түүний том өрөөнд буцаж ороход нь Лобников урьдын адил балмагдан толгойгоо атган сууж байв.

-Бурхан өршөө! Та юу хийж орхих нь энэ вэ? Одоо эхнэр хүүхдийг минь яах бол гэж сандран асуулаа.

-Бүү сандар, Валерий гэж Полунин түүнийг дугтчин хэлээд, хайрцагтай бичиг дансаа ав. Эндээс хурдан зайлъя! гэж тушаав.

Тэгснээ өөрийн гар хүрсэн ширээний чийдэнг алчуураар арчаад тамхины иш үнстэй үнсний савыг цүнхэндээ хийж хаалга руу яаран алхах зуураа

-Хэрэв эндхийн хөршүүд болсон явдлыг мэдээд цагдаа дуудвал бид энд байж болохгүй. Хоёр алуурчин бие биеэ хөнөөв гэж ойлгог гэлээ.

Лобников сэхээ авсан мэт ухасхийн босож хайрцагтай бичиг дансыг авч Полунины хойноос дагав. Энд байсныгаа найдвартай нуухын тулд тэрээр хаалганы бариулыг хичээнгүйлэн арчижээ.

Хэдэн хормын дараа тэр хоёр Валерийн машинд орж суусан байв.

-Явья! гэж Полунин хэлэв.

Лобников “АУДИ”-гаа залан гудамжинд гарч явлаа. Араас нь Батурины цэнхэр “9” дагаж хөдлөв. Машиныуд байшингаас нэлээд хол явсны дараа Лобников машинаа зогсоон:

-Хаашаа явах вэ? гэж Полунингаас асуув.

-Чиний эхнэр хүүхдийг чинь барьцаалаад байгаа алуурчид руу явах нь зөв байх гэж бодож байна.

-Тэд хаана байгааг би яаж мэдэх юм бэ? гэж Лобников бухимдан дуугараад, хоёр алуурчинг нь хоёулангийг нь үгүй хийчихсэн болохоор бидэнд хэн зааж өгөх юм бэ? гэж ориллоо.

-Амаа хамхи! гэж Полунин тайвнаар зандраад, сандарч тэвдэлгүй сайн бодож үзье. Эхнэр хүүхэд чинь өнөөдөр хаана байсан бэ? гэж асуув.

-Хотын гаднах байрандаа байсан. Би тийш нь утасдаж тэндээсээ хурдан зайлж яв гэсэн юм.

-Ярьснаас чинь хойш хэдэн минутын дараа алуурчид чам руу утасдсан бэ?

-Сайн мэдэхгүй байна. Арав юм уу арван таван минутын дараа байж болох юм гэж Лобников мөрөө хавчин хариулав.

Полунин түр бодлогоширсоноо:

-Тэгэхлээр чиний эхнэр юмаа бэлтгэж хүүхдээ хувцаслаад гэрээсээ гарахад шаардагдах хугацаа юм. Тийм учраас тэднийг чинь яг гарах үед нь олзлоод шууд чам руу явсан байж болох нь гэж хэллээ.

-Тэгвэл тэд одоо тэнд байгаа гэж хэлэх гээ юу?

-Тун ч магадгүй гэж Полунин хариулаад, тэр байранд чинь хүрч очиход хэдий хугацаа хэрэгтэй вэ? гэж асуув.

-Хорь, хорин таван минут.

-Тэр алуурчид эндхийн хүмүүс биш гэдгийг тооцож үзвэл бороотой харанхуй шөнө төөрч будилах магадлалтай учир тэд Мясницкийн гудамжны байшинг шууд олж чадахгүй, тэгээд ч усан борооноор хурдан явж чадахгүй гэж Полунин тооцоолон яриад, тийм учраас тэднийг бидний хүлээсэн тэр дөчин минутад багтаж энд ирж л дээ гэж хэллээ.

-Тэгэхлээр тэд одоо манай байранд байгаа гэсэн үг үү? гэж Лобников дахин асуув.

-Тийм гэж бодож байна гэж Полунин хариулаад, чи тэр байр хүртлээ хамгийн багаар хэдэн минут явж хүрэх вэ? гэж асуув.

-Арван таван минутад амжиж очно гэж Лобников шүд зуун шийдмэг хариулав.

“АУДИ” байрнаасаа ухасхийн хөдөлж замын тойрогт арай л шарвачихалгүй хотын гудамжаар галзуу мэт хурдаллаа. Өөрийн “9”-өөр араас нь дагаж яваа Батурин арайхийн бараадаж явлаа.

* * *

Хоёр машин их замд орон арай л осол гаргачихалгүй давхисаар арван таван минутын дараа Лобниковын байр байдаг Захаровка тосгонд хүрч ирлээ. Машинууд тосгонд орж ирмэгцээ гэрлээ унтраан зөөлөн явсаар ижил баригдсан хоёр давхар улаан тоосгон байшингуудын нэгэнд хүрч зогслоо. Тэд Лобниковын байшингаас арван таван метрийн зайтай зогссоны дараа

-Тэд энд байна гэж Полунин санууллаа.

-Та яаж мэдээв гэж айж догдолсон Лобников асуув.

-Тэр гудамжны эсрэг талд хүрэн “5” зогсож байна хэмээн Полунин цаана зогсож байгаа “Жигули” руу зааж хэлээд

-Энэ бол тэр алуурчдын машин. Хэнээс худалдаж авсныг би мэднэ гэв.

Дараагийн агшинд Николай Батурин “АУДИ”-д яаран орж суулаа. Тэгснээ:

-За яая гэж бодож байна гэж асуув.

-Байшинд үлдсэн алуурчид нь байна. Бас Лобниковын эхнэр хүүхэд тэнд байгаа гэж Полунин хариулав.

Тэгтэл Николай хүрэмнийхээ дотор талаас “ТТ” шууд сугалан гаргаад түгжээг нь мултлан:

-Тэгвэл шууд орцгооё. Би аль түрүүнээс тэр залуустай уулзах хорхой минь хүрч байсан юм. Тэр Мясницкийд байсан хоёр чиний хувь байсан бол үлдсэн гөлөгнүүд нь минийх гэлээ.

-Битгий яар Николай.Тэнд эмэгтэй хүн хүүхэд байгаа.

-Юундаа чи энэ муу новшийн гэр бүлд санаа зовов? гэж Николай хилэгнэн бухимдаад, энэ зулбадаснууд чиний гэр бүлийг чинь хайрласан уу? Чиний эхнэрийг алж хүүхдийг чинь асрамжийн газар хүчээр өгөхөд энэ муу хорт могой жишим ч үгүй байсан гээд Николай гар бууныхаа амаар Лобниковын толгойг зөөлөн түлхэж орхив. Харин Лобников цочсон ч үгүй харцаа Полунингаас байрныхаа зүг шилжүүлээ.

-Би тэднээс ялгаатай нь би алуурчин зулбадас биш, Коля минь. Гэмгүй хүмүүсийг золиосонд гаргаж сэтгэлдээ сэв суулгахыг хүсэхгүй байна. Хэрэв чамаас болж бяцхан охин амиа алдвал чи хойшид сэтгэл чинь эмзэглэхгүй амьдарч чадах уу. Би л бол чадахгүй гэж Полунин хариулав.

Николай залхсан байдалтай суудлаа налаад толгой сэгсрэн:

-Тийм юм даа. Тэгсний дараа би хэвийн амьдарч чадахгүй байх. Чиний зөв, Иваныч. Одоо тэгээд яах вэ? гэж асуулаа.

Полунин Лобниковт хандан:

-Байшинд чинь нөөц орц бий юу гэж асуув.

-Байгаа. Нөгөө талд нь цэцэрлэг рүү гардаг гарц бий.

-Тэгвэл байшингийнхаа өрөөнүүдийн бүдүүвч байрлалыг хурдан зураад өг гэж Полунин тушаагаад алуурчид нөгөөдүүлээ ирэхгүй удахад нь сэжиг авч мэдэх тул яарах хэрэгтэй гэлээ.

Таван хормын дараа тэд гурвуулаа машинаас гарч цэцэрлэгийн хашаа давж орлоо. Тэд байшингийн нөөц хаалганд хүрч очмогц Лобников:

-Яанаа! Надад түлхүүр нь байхгүй шүү дээ! хэмээн шивнэн уулга алдав.

Полунин түүний хэлснийг огт сонссон шинжгүй халааснаасаа багц дэгээ төмрүүдийг гарган таарахыг нь сонгон авлаа.

Нэг минутын дараа хаалганы цоож бараг чимээ гаргалгүй онгойчихов. Полунин аль болохоор хяхатнах чимээ гаргахгүйг хичээн хүнд төмөр хаалгыг хөшин онгойлголоо. Дахин гурван хором өнгөрөхөд тэд гурав дотогш орж Полунин мөн адил чимээ гаргалгүй хаалгыг хаалаа. Полунин Лобниковт доор үлдэх дохио өгөөд Николайн хамт богино шат өгсөн хоёрдугаар давхарт гарав. Энд зочдын том танхимаас гадна хүүхдийн өрөө, гал тогооны өрөө, цэцэрлэгийн багаж зэргийг хадгалах хоёр аж ахуйн жижиг өрөө байх ажээ. Тэд аж ахуйн өрөөнүүдийн ойролцоох хонгилд орлоо.

Ойролцоох нь гал тогооны өрөө байх агаад хаалга нь онгорхой гэрэл нь асаалттай байх ажээ. Эсрэг талд орших зочдын өрөөний гэрэл мөн асаалттай байлаа. Бүр цаана байх хүүхдийн өрөөний хаалга хаалттай харагдана.

Полунин хүүхэд унтаж байгааг тааварлав. Зочдын өрөөнөөс хөгжмийн намуухан ая хүмүүсийн ярилцах чимээ соногдоно. Полунин “Оля бидэнд кофе хийж өгөөч. Гриня чамд тусална” гэх эрэгтэй хүний эелдэг дуу гарахыг сонслоо. Дараа нь хүний хөлийн чимээ гарч хонгилд одоохон хүмүүс гарч ирэх нь тодорхой боллоо. Полунин Николай хоёр бие бие рүүгээ яаран харц чулуудаж зөвхөн аж ахуйн өрөөнд нуугдаж болохыг ойлголцлоо. Азаар тэр өрөө цоожгүй байв. Николай Полунин хоёрын аж ахуйн өрөөнд дөнгөж ороод хаалга хаамагц хонгилд Лобниковын эхнэр өндөр гоолиг нуруу шаргал үстэй хүүхэн өндөр нуруутай гуч орчим насны залууг дагуулан гарч ирлээ. Полунин тэдний араас хаалганы завсраар харж байв. Гриня Ольгад тааламжтай харц чулуудан оролдох нь уу гэмээр харагдана.

Тэр хоёрын гал тогооны өрөөнд дөнгөж ормогц Полунин Николай хоёр өрөөнөөс гарч сэмхэн явсаар гал тогооны өрөөний хаалганд хүрч очлоо. Энэ үед сэтгэл санаа нь хямран нуувчиндаа тайван хүлээх тэвчээр нь алдагдсан Лобников шатаар өгсөн яваа нь харагдах нь тэр. Полунин сандран наанаа зогсож бай гэж дохио гараа сарвалзуулан өгсөн боловч нөгөөх нь гал тогооны

өрөө рүү дөхсөөр ирлээ. Тэрээр эхнэр нь ганцаараа биш эрэгтэй хүнтэй тийш орсон гэдгийг мөн ойлгосон бололтой. Дараагийн агшинд:

-Хэрэггүй ээ! Юу хийх нь вэ? болиоч гэж хашгирах Ольгагийн дуу гарлаа.

Дараа нь Гринягийн уухилан бухимдах Ольгагийн уурлан орилох дуу сонсогдов. Тэр даруй хурдан бөгөөд шийдмэг хөдлөх хэрэгтэйг Полунин ойлгов. Тэр хоёр бие биендээ дохио өгөөд шалмаг хөдлөн гал тогооны өрөөнд орж явчихлаа.

Ольга тэдэн рүү харан Гриняд нуруугаараа ширээнд шахагдан түүний тэврэлтээс мултрахыг оролдож байдаг чадлаараа эсэргүүцэж байв.

Ольга орж ирсэн үл таних зэвсэглэсэн хүмүүсийг хармагц өөрийн мэдэлгүй цочирдон хөшиж орхив. Полунин тэр даруй зүүн гарынхаа хуруугаар уруулаа дарж, чимээ гаргахгүй байх дохио хүүхэнд өглөө. Яг энэ агшинд Николай гар буугаа халаасандаа хийж орхиод гал тогооны шүүгээн дээрээс урт хутга аван Гринягийн ар нуруу руу дөхөн очлоо. Айснаасаа болж Ольгагийн нүд орой дээрээ гарах дөхөн юу болохыг ойлгож ядан бүлтэгнэж байв. Хүүхний байдал сэжигтэйгээр өөрчлөгдөхийг анзаарсан Гриня аюулыг мэдрэн огцом эргэн ширээн дээр байгаа буугаа шүүрэн авсан боловч хожимджээ. Николай шалмаг хөдлөн түүний элэг хавь руу хутгаа шааж орхилоо. Бүх юм хоромхон зуур чимээ гаргалгүй болж өнгөрлөө. Гринягийн нүд гөлрөн аяархан ёолоод шалан дээр сууж орхилоо. Тэгтэл Ольга сэтгэл санааныхаа хямралаа барьж чадалгүй дуу алдан хашгирч орхих нь тэр. Лобников өрөөнд гүйж ороод эхнэр рүүгээ үсрэн очиж тэвэрч авлаа. Харин Полунин том өрөөнд орохоор өрөөнөөс үсрэн гарлаа. Гэвч хожимджээ. Малеев айсуу аюулыг хоромхон зуур мэдэрчээ.

Тэрээр Полунингийн толгой дөнгөж цухуймагц огцом хөдлөн буугаа шүүрэн авч буудаж орхилоо. Тавьсан сум нь дөнгөж саяхан Полунингийн толгой байсан орчмын хаалганы мужийг зад татсан байв. Полунин амжиж шалан дээр хэвтээд хонгилоор зугтаж яваа Малеевын араас хариу буудлаа. Гэвч эвгүй хэвтээ байдлаас буудсан учир тавьсан хоёр сум нь байгаа оносонгүй. Хоёр дахь сум нь Малеевын үсэрч орсон хүүхдийн өрөөний хананд тусжээ. Тэгтэл Николай Лобников хоёр гүйж ирлээ.

-Тэр хаана байна? гэж Николай яаран асуув.

-Хүүхдийн өрөөнд гэж Полунин хэлээд босож айснаасаа болж нүд нь бүлтийж бие нь салганаж буй Лобниковыг хараад Валерий тийшээ бүү шагай чамаас болж зөвхөн муу л юм болно гэж тушаав. Полунин Батурин хоёр буунуудаа хүүхдийн өрөөний хаалга чиглүүлэн онилоод дөхөж очтол урдаас нь дөнгөж саяхан сэрээд байгаа охиныг урдаа бамбайлан барьчихсан Малеев гарч ирлээ.

Юу болж байгааг ойлгож ядсан охин өмнө нь зогсож байгаа үл таних зэвсэглэсэн эрчүүд цаана нь байгаа аав, ээж хоёроо нойрмог нүдээр гайхан харж байв. Тэрээр судалтай нимгэн даашинз өмсжээ.

-Зэвсгээ хая! хэмээн Малеев охины хавирга руу гар буу тулган тушаав. Энэ үед Малеев өөрийн нь толгой руу онож буудахад тун хэцүү байрлалаар охиныг барьж байлаа.

-Зэвсгээ хая! гэж хэлж байна! Тэгэхгүй бол энэ охин өнгөрөх нь тэр?

-Мөн дөө нохой минь. Бас би өмдөө тайлах уу? хэмээн Николай хилэгнэн зандрав.

-Битгий бууд. Би гуйж байна. Хүүхдийг алчихна шүү дээ гэж Ольга орилоод охин руугаа ухасхийтэл Лобников барьж зогсоов.

-Сонсож байна уу? Буугаа хая гэж байна гэж Малеев сүрдүүлэх өнгөөр зандраад та нар охиныг гэмтээлгүй намайг буудаж чадахгүй гэлээ.

-Бид энэ үгийг чинь нулимж хаяна гэж Николай хариулаад, чи эндээс амьд гарна гэж бүү горьд. Бид чамайг хэтэрхий олон хоног эрсэн новш минь! гэв.

Тэгснээ гар буугаа дээшлүүлэн Малеевын толгой руу онилон гохны хоосон явалтыг тулгалаа. Дараагийн агшинд Малеев мөн адил дуугаа дээшлүүлэн

-Залуус минь өөрсдөө мэд. Би сануулсан шүү? гэлээ.

Хонгилд аймаар түгшүүртэй нам гүм боллоо.

-Эндээс яв! гэж Полунин гэнэтхэн хэлээд бид чамд саад болохгүй гэлээ.

Николай Полунин руу хилэнтэйгээр хялайн харц чулуудаад:

-Чи яаж байна, Иваныч! Түүнийг явуулж болохгүй! Чиний эхнэр, Самбист хоёрыг энэ алуурчин хөнөөсөн шүү дээ гэж хашгирлаа.

-Тэр яваг гэж би тушааж байна гэж Полунин шийдмэг хэлээд өнөөдөр энэ хүн ямар ч саадгүй эндээс явах ёстой гэж нэмж залруулав.

Полунингийн дууны захирангуй өнгө шийдмэг байдал нөлөөлж Николай өөрийн эрхгүй бууныхаа гохноос хуруугаа салган

-За яахав, чөтгөр аваг чамайг! Гэвч би чамайг эрт орой хэзээ нэгэн цагт олохдоо л олно! гэлээ.

Малеев аажуухан ухарсаар гарах хаалга руу ойртлоо.

-Гол хаалгаар гарч яв. Тэр онгорхой байгаа. Араас чинь бид дагахгүй гэж би амлаж байна. Машинадаа орж хөдөлгүүрээ асаамагцаа хүүхдийг тавиарай. Араас чинь нэхэхгүй гэж би дахин баттай амлаж байна гэж Полунин дахин хэлэв.

Малеев үл мэдэгдэм толгой дохиод урьдын адил хаалга чиглэн ухарсаар байв. Тэрээр гол хаалгаар гарч хаалга хаагдмагц Лобников эхнэрийнхээ хамт цонх руу гүйлдэн очлоо. Малеев нарийн цементэн замаар яаравчлан явсаар хашааны жижиг хаалга онгойлгон гудамжинд гарах нь харагдлаа.

Яг энэ үед Полунин Николай хоёр мөн адил гүйж гараад хашааны явган хаалганы цаана гарав. Тэд гудманд гараад хүрэн –”Жигули” “АУДИ”, “9” хоёрын дэргэд хүрээд гэнэтхэн тоормозлов. Гудамжны нам гүмийг дөрөв дахин буудах буун дуу цочроолоо. Николай шуудхан буугаа сугалан гаргасан боловч Полунин энэ бол машинуудын маань дугуйг зад буудаж байна гэж түүнд ойлгуулав. Тэгснээ Малеевын “9” ухасхийн хөдөлж гудамжны булан тойрон алга боллоо.

-Зогсооч новш минь! Хүүхэд орхи! гэж хашгирлаа. Тэрээр ухасхийн үсэрч машины араас байдаг чадлаараа гүйлээ.

-За тэр дээ, Иваныч минь! хэмээн Батурин араас нь харайх зуураа хашгираад, чи тэр нохойд итгэж байдаг. Би түүнийг дор нь устга гэсэн шүү дээ хэмээн халаглав. Машин Полунин хоёр булан тойрч харагдахгүй болсон хойно Николай дээр Лобников Ольга хоёр гүйж ирлээ. Тэд гүйлдсээр булан тойрмогцоо гэнэтхэн Полунинг олж харлаа. Тэрээр уйлж байгаа охиныг зүүн сугандаа хавчуулан баруун гартаа буугаа барин тайван алхалсаар ирж явлаа. Охин эхийнхээ тэврэлтэд ороод тайвширч аажмаар уйлахаа болилоо.

-Тэр хүүхдийг энэ булангийн цаана суллаж тавьсан байсан гэж Полунин тайлбарлаад тэр хүүхдийг нь тавимагц араас нь буудчих байх гэж айсан бололтой гэв.

Тэгсний дараа Николай Полунин руу нухацтай боловч тээнэглзсэн харцаар хараад:

-Түүнийг тавьсандаа харамсахгүй байна уу? Одоо түүнийг хаанаас ч олохгүй биз? гэв.

Полунин буугаа халаасандаа хийгээд янжуур гарган асаагаад хэдийнээ далд орсон Малеевын зүг ширтсээр зогслоо. Тэр хүн надаас хоёр дахь удаагаа зугтаж амжлаа гэж Полунин амнаасаа тамхины өтгөн утаа савсуулан хэлээд азтай эр юм. Гэвч түүний аз хэзээ нэгэн цагт буруулах л болно доо гэв.

Тэд цөмөөрөө Лобниковын байр руу эргэж орлоо. Лобников Оля хоёр охиноо унтуулахаар өрөөнд орлоо.

Батурин гал тогооны өрөөнд ормогцоо шууд:

-Санаж ав! Тэр чоно амьд үлдсэн. Гэвч тэрний тоос хөдөлгөх цаг бага үлдсэн байх гэж бодож байна гэж цусандаа хутгалдан хэвтэж байгаа Гриня руу зааж хэллээ.

Полунин шархтай түүн рүү тонгойн:

-Чи намайг санаж байна уу? гэж асуув.

Тэрээр цусанд наалдсан уруулаа долоон

-Санаж байна. Тэгэхэд чи жийпний дэргэд Музыкантыг шархтуулсан.

-Хэн Самбистыг алах захиалга өгсөн бэ?

Гриня арай ядан толгой сэгсрэв.

-Захиалагчтай Музыкант өөрөө ярилцсан юм.

-Түүнийг хаанаас олж болох вэ?

Гриня үл мэдэгдэм инээх аядаад:

-Хаанаас ч олохгүй. Тэр хүн эндээс бүр зайлж явсан.

-Хаашаа? гэж Полунин асуув.

-Хэвийн амьдралаар амьдрах гэж. Тэгснээ инээмсэглэх гэж байгаа мэт ам нь ангайснаа тэр байдалдаа хөшиж нүд нь хөдөлгөөнгүй болон гөлөрч орхив.

-Юу ч хэлэлгүй тонилчихлоо муу нохой хэмээн Николай дуугараад түүнийг хаа нэг тийш ой руу аваачиж хаях хэрэгтэй. Би АУДИ-г хашаанд оруулж дугуйг нь сольё.

Арваад минутын дараа Гринягийн цогцсыг нийлэг уутанд хийж АУДИ-гийн тээшинд хийгээд хашаанаас гарч ойролцоох ой руу чиглэн явлаа. Том өрөөнд сууж байсан Полунин руу Лобников орж ирэв. Тэгснээ баарнаасаа лонх дарс хоёр хундагатай авчраад Полунингийн дэргэд байгаа намхан ширээн дээр тавиад хоёр хундаганд хундагалаад

-Алив, татчихъя! Владимир Иванович! гээд хундагатай дарсаа өглөө.

-Юуны төлөө?

-Юм бүхэн ингэж зүгээр өнгөрсөн явдлын төлөө ууя!

-Бүх юм өнгөрөх яагаа ч үгүй байна. Ямар ч байсан миний хувьд хэмээн Полунин инээмсэглэн хариулав.

-Миний гэр бүл амьд мэнд үлдсэний төлөө гэх гэсэн юм. Тэд минь амьд мэнд байгаа нь миний хувьд хичнээн чухал болохыг сая л би ойлголоо гээд тэрээр аягатайгаа хөнтөрч орхиод ярвайн Полунингийн архиа уухыг хүлээснээ:

-Өнөөдөр би бас өөр юмыг ч ойлголоо. Жил хагасын өмнө эхнэрээ алуулчихаад, хүүгээсээ салчихаад байхад чинь танд хичнээн хүнд байсныг одоо л төсөөлж байна. Та тэр нохойг буудсангүйгээрээ миний охины амийг аварлаа. Энүүнд чинь ч би их баярлаж байна гэж хэллээ.

-Чи юу гэж энэ бүхнийг надад ярина вэ? Чиний талархал надад хэрэггүй гэж Полунин хөмсөг зангидан дургүйцэн дуугарлаа. Лобников энэ үгийг огт тоосонгүй.

-Би шүүх ажиллагаан дээр Сатаровын эсрэг мэдүүлэг өгөх болно гэж танд хэлэх гэсэн юм. Хэрэв тэр шүүх ажиллагаа болбол түүнээс гадна хотын нэгэн банкинд нууцлагдан хадгалагдаж байгаа чухал нууц баримт бичгүүд надад байгаа. Би түүнийг өнөөдөр авсан

бичиг баримтуудын хамт танд өгнө гэж Лобников хэллээ.

-Сайн байна. Баярлалаа гэж Полунин мөрөө хавчин хэлээд хэрэв Петров та хоёр шүүх ажиллагаан дээр Сатаровын эсрэг гэрчийн мэдүүлэг өгвөл тэр хаашаа ч булгаж чадахгүй. Яагаад гэвэл гэрчийн нэг мэдүүлэг яаж ч чадахгүй. Харин би өөрийн зүгээс та нарын болон гэр бүлийн чинь аюулгүй байдлын баталгаа өгч байна гэж амлав.

-Би зөвхөн үүнийг л танаас хүсэж байна гэж Лобников хүслээ.

Хагас цагийн дараа Николай Батурин хүрч ирлээ. Тэрээр зочдын өрөөнд орж ирээд Полунин руу асуух мэт хараад:

-Одоо юу хийх вэ? гэж асуув.

-Валерий бидэнтэй хамт явна. Тэр Москвагийн комиссынхонд мэдүүлэг өгөх болно. Николай мушилзан инээмсэглээд:

-Тэгвэл одоохон явъя. Цаг алдаж болохгүй гэв.

-Харин чи хамгаалалтынхан иртэл хүлээж бай гэж Полунин түүнд тушаагаад гарах хаалга руу явлаа. Тэгтэл Лобниковын халаасан дахь гар утас дохилоо.

Лобников утсаа авч чагаснаа гайхширсан байдалтай Полунинд өгөв.

-Сатаров байна. Тангай ярина гэнэ гэлээ.

Полунин утсыг нь шүүрэн авлаа.

-Сайн байна уу, Иваныч хэмээн Сатаровын танил дуу сонсогдов.

-Би чамайг сонсож байна гэж хуурай хөндий хариулав. Сатаров:

-Намайг утасдана гэж санаагүй биз хэмээн даажигнах өнгөөр асуув.

-Чамаас ямар ч өөдгүй юм ирж магадгүй гэж хүлээж байсан юм гэж Полунин хариулаад, ярих юмаа түргэн ярь. Бүү дөлөөд бай гэв.

-Миний хуучин нөхөд Лобников, Петров нарын ачаар миний эсрэг чи багагүй юм цуглуулаад байна гэж дуулдах юм.

-Яг тийм шүү хэмээн Полунин шийдмэг хэлээд, маргааш би Москвагийн прокурорт нэлээд хүчтэй бөмбөг аваачиж өгнө. Тэр бөмбөг дэлбэрэхдээ чамайг бусад нөхөдтэй чинь хамт оршуулах болно гэлээ.

-Чиний хүүтэй хамт оршуулах болно гэж Сатаров хэлээд чи тэр өөрийн эмзэг газраа мартчихсан бололтой гэв.

Полунингийн царай зэвхийрэн нүд нь хилэнтэйгээр гялалзав.

-Чи муу зулбадас өөрсдийн маргалдаанд хүүхдийг ашиглахаар шийдэв үү? хэмээн хилэгнэн асуув.

-Бидний энэ асуудал маргааш биш. Харин үхэх сэхэхээ үзэж байгаа дайн юм. Би энэ дайнд ялагчаар гарахыг хүсэж байна. Чиний юу хийх нь хамаагүй харин тэр баримт бүртгэлүүд цөмөөрөө ойрын үед надад хэрэгтэй. Харин тэр Петров, Лобников хоёрыг авч яваарай. Яаравчилж үз. Иваныч. Чамд цаг тун бага байна. Би чамайг Глинск дахь байранд чинь хүлээж байя...

Сатаров утсаа салгасны дараа Полунин утсыг нь Лобниковт буцааж өгөөд хүндээр санаа алдан:

-Муу нохойнууд хүүг минь барьцаалж авсан байна гэлээ.

* * *

Савеловскийн хүүхэд асрах гурван давхар тоосгон байшингийн явган хашааг тойруулан барьсан төмөр хашааны дэргэд хар өнгийн жийп “Гранд Черок” ирж зогслоо.

Машинаас хар костюмтай шөрмөслөг байрын хоёр залуу гарч ирээд хаалганд хүрч ирэв. Бух нохойн хоншоортой эрэмгий хүчийг илэрхийлсэн царайтай, шар үстэй залуу нь хананд байх товчлуурыг үл хайхран хашааны хаалгыг нүдэх нь тун түрэмгий шинжтэй.

Шөнийн нам гүмд төмөр хаалгыг балбах чимээ гарч нэгэн мөч өнгөрсний дараа хаалганы жижиг цонх онгойн манаач өвгөний нүүр цухуйлаа.

Энэ бол жар орчим насны өвгөжөөр эр байлаа. Түүний өтгөн сахалтай, өргөн нүүр цонхоор бүрэн харагдахгүй байсан боловч түүний тунгалаг хурц нүд цэвэрхэн хувцастай үл таних залуус болон цаана нь зогсож байгаа гоё машиныг анхааралтай ажиглах ажээ.

-Та нар юу гэж явна вэ? гэж өвгөн паргиа дуугаар асуугаад, өнөөдөр асрах газар хаалттай байна. Ямар ч хүнийг хүлээж авахгүй. Хэрэв та нар өнчин хүүхдүүд бол маргааш ирж бүртгүүл гэв.

Цагаан үстэй цайвар царайт нь өндөр нуруутай шар үстдээ хандан нүд ирмсэнээ хараагаа өвгөн рүү шилжүүлж:

-Мөн дөө, хөгшин төгцөг минь! гэж нам дуугаар зандраад цонх руу гараа шургуулан өвгөний сахлаас шүүрэн авч чангаатал:

-Тавиачээ. Наадах чинь наамал биш! гэж өвгөн өвдсөндөө болж орилов.

Гэтэл энэ нь цагаан үст залууд дутуудсан юм шиг гар буугаа хуйнаас нь сугалан гаргаад цонхоор нь өвгөний нүүр рүү онилон:

-Алив бушуу хаалгаа тайл! Хөгшин ухна минь! хэмээн зандрав.

-Жижиг хаалга онгойлгож өгье гэж өвгөн сандарсан шинжгүй хариуллаа. Залуус бие биесээ хараад авсанаа цагаан үст нь:

-Тэг! хэмээн толгой дохив.

Хормын дараа түгжээ тайлдах дуулдан хаалга онгойж өвгөнийг хажуу тийш болгон хоёр залуу хашаанд орж ирэв. Манаач өвгөн нуруугаа эгцлэн элэгдсэнээсээ болж гялгар өнгөтэй болсон бүдүүн иштэй шүүр бариад зогсож байв. Тэрээр нэлээд өндөр нуруутай булиа байрын хүн агаад ажлын хувцас өмсөж хормогч зүүсэн харагдана. Толгойдоо нэхмэл ноосон малгай өмссөн бөгөөд нүүрийн нь ихэнх хэсгийг гишгэдэг хүрз мэтээр засуулсан сахал далдалсан ажээ.

-Чамайг хэн гэдэг вэ? Өвөө минь гэж цагаан үст асуув.

-Хүүхдүүд намайг Эльдар өвөө гэдэг.

-За тэгэхлээр Эльдар өвөө минь. Бид чамайг Эля эмээ болгочихоогүй байгаа дээр нэгэн жаал хүүг зааж өг. Бид түүнийг чинь авч явна.

-Тэгж болохгүй. Хүүхдийг бид зөвхөн төрөл төрөгсдөд нь өгдөг юм гэж манаач татгалзав.

-Би тэгвэл наадах шүүрний чинь ишийг бөгс рүү чинь шааж орхиё гэж цагаан үст ярзайв.

-За, за ойлголоо гэж манаач хэлээд ямар хүүхэд вэ? гэж асуув.

-Полунин Антон Владимирович гэдэг хэмээн тэр залуу хариулав.

-Тийм хүүхэд байдаг хэмээн өвгөн хөмсөг зангидан дуугараад, дуу цөөнтэй, томоотой хүүхэд. Та нар түүний юу нь вэ? гэж асуув.

-Түүнд төрөл төрөгсдөөс нь ч илүү хүмүүс байна гэж цагаан үст хариулаад, бид түүний аавын нь сайн найзууд байгаа юм. Алив бушуул, хожуул шиг бүү зогсоод бай! гэж зандрав.

Манаач дуртай дургүй хөдөлж шүүрээ ардаа чирсээр тэднийг байшин руу дагуулан явлаа. Тэр гурав байшинд орсны дараа манаач гэнэтхэн зогсож тэдэнд хандан

-Та нар жижүүрийн хүмүүжүүлэгчид хандах нь зүйтэй байх. Тэр хүний зөвшөөрөлгүй хүүхэд өгч болдоггүй юм гэлээ.

-Тэгвэл энд чинь чамаас өөр бас хүмүүжүүлэгч байгаа юу? гэж шар үст залуу асуув.

-Байлгүй яахав? гэж өвгөн баярлан хариулаад тэр хоёрдугаар давхарт 205 дугаар өрөөнд байгаа. Тэр та нарт хүүхдийг өгнө гэв.

Дээрэмчид дахин бие биен рүүгээ харснаа шар залуу нь:

-За яахав? Тэр хүнтэй чинь ярилцъя гэлээ.

-Тэр чинь зөв. Сайн байна залуус минь гэж хүүхэд хулгайлуулсан хариуцлагаас мултрах болсондоо баярласан манаач өвгөн залбиран дуу алдав.

Тэд гурвуулаа ширмэн шатаар өгсөн хоёрдугаар давхарт гарлаа. Манаач 205 дугаар өрөөнд хүрч очоод хаалгыг нь хагаас онгойлгон:

-Вячеслав Евгеньевич тан дээр зочид ирлээ гээд залууст зай тавин өгч өрөөнд орууллаа.

* * *

Сатаров, Романенков хоёр Сатаровын гурван давхар зуслангийн зочдын өрөөнд сууж байтал утас нь дуугарлаа. Үе үе мартин дарс балган өрөөн дотуураа бухимдан холхиж байсан Сатаров утсаа шүүрэн авлаа.

Тэр эхлээд тайван сонсож байснаа гэнэтхэн барьж байсан савтай дарсаа цалгиулан агдас хийгээд:

-Яагаад тэр вэ? Юу болов оо новшнууд минь. Одоо тэд хаана байна чөтгөр аваг! хэмээн хилэгнэн хашгирлаа. Сатаров яриагаа дуусгаж утсаа тавьсны дараа Романенков руу ууртай харан:

-Тэд даалгавар биелүүлж чадсангүй гэв.

Романенков түүнийг түгшүүрлэн харж:

-Юу болоов? гэж асуулаа.

-Юу ч болоогүй гэж Сатаров гэнэтхэн тайвширч хариулаад, зүгээр л тэд надаас түрүүлж чадсан байна. Харамсалтай нь би урьдчилан тооцоолж чадсангүй. Энэ бүхнийг тэр л хийж чадаж байна гэлээ.

-Тэр гэж чи хэнийг хэлж байна? гэж Романенков гайхан асуув.

-Полунинг ярьж байна гэж Сатаров хариулаад цонх руу очиж мартин дарснаасаа балгаад хэрэгт татах баримт бичгүүд түүнд байна. Бас түүний ачаар Лобников амьд үлдсэн байна гэж бухимдав.

-Яагаад ийм юм болов? гэж Романенков асуув.

-Үүнийгээ чи магтаж гайхуулаад байсан тэр Резаний алуурчдаасаа асуу. Тэднээс чинь ганцхан Музыкант амьд үлдсэн бололтой. Чи тэднийг хотод дуудан авчирч Полунингийн идэш болгосон байна.

-Бидэнд бас нэг сөрөг цохилтын нөөц хувилбар байгаа шүү дээ гэж Романенков сануулаад, одоо би хүүхдийн асрамжийн газар руу хүмүүсийг явуулъя. Уг нь үүнийг бид түрүүний

хийдэг байж гэлээ.

-Яаравчил гэж Сатаров тушаагаад жаалыг нь найдвартай газар нуу. Тэгсэн цагт бид Полунингаас авах юмаа авах болно гэв.

-Та санаа бүү зов. Хүүхдийн асрамжийн газарт эндээс ердөө л арваад минут яваад хүрнэ...

Романенков зочдын өрөөнөөс гараад хүлээлэгний өрөөнд сууж байсан Сатаровын бие хамгаалагч хоёр залууд үүрэг өгөөд буцаж орж буйдан дээр дахин ирээд суув. Хоёр эр өөрсдийн явуулсан залуусаас ямар мэдээ ирэхийг хүлээж хэсэг хугацаагаар чимээгүй суулаа. Гучаад минут өнгөртөл Сатаровын утас дуугарч Романыч утсыг авлаа.

-Сайн байна, залуус минь. Хүүхдийг Панфиловын гудамжны байшингийн хонгилд аваачаад бидний утасдтал тэнд нь харж бай! гэж Романенков хэлээд Сатаровыг тааламжтайгаар ширтээд:

-Полунингийн бацаан бидний гарт. Тэгэхлээр түүний аав гуай танд саад хийхгүй болсон гэв.

Сатаров хариу хэлэлгүй утсаа авч Лобниковын гар утас руу залгав. Утсыг Валерий өөрөө авлаа.

-Мэнд хүргэе Валерий. Сатаров байна. Чиний хажууд Полунин байгаа бол утсаа өгчих...

Хэдэн минутын дараа Сатаров утсаа тавиад сэтгэл хангалуун байдлаар:

-Тэр өөрөө бидэнд шаардлагатай бичиг баримтуудыг цөмийг нь аваад хүрээд ирнэ. Хүүгээ аврахын төлөө тэр бүгдийг хийх болно...

Утас дахин дуудлаа. Сатаров утсаа авч:

-Таныг сонсож байна гэв.

-Тэгвэл чи тун анхааралтай сонсож бай хэмээн утасны нөгөө үзүүрээс эрэгтэй хүний дуу гарч, өнөөдөр чиний түнш Петров гэгч “Советская” зочид буудалд очиж Москвагийн мөрдөгийн комиссынхонд мэдүүлэг өгсөн байна. Тэр гар хоосон очоогүй гэж ярилцах юм. Ямар нэгэн данс бүртгэлүүдийг авч очсон юм байх. Энэ чинь юу болж байгааг чи ойлгож байна уу? гэж асуув.

-Бүү сандар хэмээн Сатаров хариулаад ялангуяа Петров шиг ганц гэрч хэзээд ч гэрч болж чадахгүй. Би бүх асуудлыг өөрийн хяналтандаа авч байгаа гэв.

-Чи нэгэнт ийм алдаа гаргаж байгаа учир чи юу ч хяналтандаа авч чадаагүй байгаа чинь энэ гэж нөгөө эр дургүйцэн хариулаад, миний мэдээгээр зочид буудал руу чиний бас нэг албаны чинь түнш Лобников утасдаж тэд нарт туслая гэж байна гэж сонслоо. Хэрэв тэгвэл яах бол...

-Яах ч үгүй. Бүү тэгтлээ зов. Би бүгдийг зохицуулсан гэж Сатаров тайван хариулав.

-Чи зохицуулсан гэж дэмий юм бүү донгос! гэж утасны нөгөө үзүүрээс хашгираад, би чамд бүх боломжоороо туслахыг хичээсэн. Тэгсэн чинь юу болов? Хотод Полунин хүрч ирээд байна гэж чи мэдсэн үү? Тэр хүн чиний эсрэг тун идэвхтэй ажиллаж байна. Чухам тэр л Петровыг тийм ажилд түлхэж чадсан гэж бухимдав.

-Тэр чинь Лобниковыг ч элсүүлж чадсан гэж Сатаров хэлээд, гэвч бид тэр Полунинг атгандаа оруулсан. Түүний хайртай ганцхан хүү нь бидний гарт байгаа. Тийм учраас түүгээр бид байдлыг эргүүлж хуучин хэвэнд нь оруулуулна гэв.

Нөгөө хүн хэдэн минут чимээгүй байснаа, Олег чи ингэж болхи ажиллаад байвал байдлыг эргүүлэх энэ боломжоо ч алдах болно гэв.

-Полунин миний гарт байгаа. Тэр удахгүй хүрч ирнэ гэж Сатаров хариулав.

-Байдал ингэж хурцдан хяналтаас хальж байгаа учир би чамд дараахь зүйлийг хэлэх гэсэн юм Олег. Чи цаашид юу хийх чинь надад хамаагүй. Харин Капустины хүмүүс бидний эсрэг мэдүүлэг өгч эхэлбэл чи тэдэнтэй зэрэгцэн сууж байцаагдах болно гэдгээ сайн ойлго. Миний юу хэлж байгааг чи ойлгож байгаа гэдэгт итгэж байна.

-За чи дэмий юм бүү донгос! гэж хараагаад Сатаров утсаа чулуудав.

* * *

Полунин өөрийн “АУДИ”-г Сатаровын байшингийн хашааны хаалганы дэргэд зогсоов. Тэрээр машины богинохон дуут дохио өгөөд машинаасаа гарч ирэхэд нь төмөр хаалга онгойн хар костюмтай зангиа зүүсэн харуул нь гарч ирлээ. Гартаа ямар нэгэн зэвсэг барьжээ.

-Миний нэрийг Полунин гэдэг хэмээн Владимир өөрийгөө танилцуулаад дөхөж очлоо. Харуул дуугүй толгой дохиод хаалга руу заав.

Полунингийн араас хаалга дөнгөж хаагдмагц бас нэгэн харуул хүрч ирээд түүнд нэгжлэг хийж эхэллээ. Хоёр мөчийн дараа тэрээр Полунингийн “Макаров” бууг авч үг дуугүй өөрийн хувцасны халаасанд хийж орхив. Харуул нэгжлэгээ хийж дуусгаад:

-Орж болно гэлээ.

Полунин тамхиа гарган асаагаад байшингийн зүг яаралгүй алхлаа. Харуул араас нь дагалаа. Хэдэн хормын дараа Полунин байшингийн нэгдүгээр давхрын уужим өрөөнд орж очиход тэнд түүнийг Сатаров, Романенков хоёр хүлээж байв.

Полунин хамгийн сүүлд жил хагасын өмнө уулзсанаасаа хойш өөрийн дайснуудтай анх удаа нүүр тулан уулзаж байгаа нь энэ ажээ. Өнгөрсөн энэ хугацаанд Романенков бараг өөрчлөгдсөнгүй. Харин энэ хугацаа Сатаровын хувьд нэлээд нөлөөтэй байсан нь шууд нүдэнд тусаж байв. Сатаров урьдын адил дэгжин хувцаслажээ. Тэрээр чөлөөтэй эсгэлттэй цайвар өнгийн костюм, үнэтэй торгомсог даавуугаар оёсон босоо захтай цамц өмссөн агаад үсээ урьдын адил цэмцийтэл тайруулан засуулжээ. Гэвч түүний үсэнд урьд нь байгаагүй хэд хэдэн

цагаан үс санчиг хавьд нь бий болсныг Полунин ажиглав. Нүдний нь эргэн тойрон үл мэдэгдэм хар тойрог бий болсон нь харагдана. Түүний зөв хэлбэрийн нүүр царай нь бага зэрэг өөрчлөгдөн тогтвор муутай санаа сэтгэлтэй хүнийх шиг ширүүн төрхтэй болжээ. Тэрээр

-Сайн уу, Иваныч хэмээн хайнга дуугаар мэндлээд урьдын адил цонхны дэргэд зогссоор ажээ. Буйдан дээр налан суух Романенков Полунинг үзэн ядах мэт хүйтнээр ширтэн дуугүй байна.

-Сайн байна уу, Олег гэж Полунин мэндлээд сорсон тамхиныхаа утааг үлээн гаргав. Тэгснээ зочдын өрөөний үнэтэй гоёмсог тавилгуудыг нь тойруулан харснаа:

-Миний явснаас хойш чи их юм амжуулсан бололтой дог. Мундаг болжээ хэмээн ёжлов.

-Тийм ээ гэж Сатаров хариулаад мөн, олон ч юмыг алдсан. Сүүлийн үед бий болсон байдлаас болж бас багагүй юмыг алдах болоод байна. Энүүнд чи тун идэвхтэй гар бие оролцож байгаа гэж сонслоо гэж хэлээд нүүрэнд нь инээмсэглэл тодорч байв.

-Би чамд илэн далангүй шударгаар хэлье гэж Полунин хэлээд, тийм ээ энэ өнгөрсөн бүх хугацаанд би чухам ингэхийн төлөө бүх хүчээ дайчлан ажиллаж байна. Зарим нэгэн муугүй үр дүн ч гарч байгаа гэв.

Сатаров хариу юу ч хэлэлгүй өрөөн дотуураас холхиж байснаа гэнэтхэн зогсож:

-Чи мэдэж байна уу Иваныч. Би чамтай уулзсандаа бүр их баяртай байна гээч. Өөрийн дайсантай нүүр тулан байлдах нь хэзээ ч амархан байдаг гэж дэмий үг биш юм. Би өнгөрсөн бүх хугацаанд чамаас ямар нэгэн булай юм гарч ирнэ гэдгийг мэдэж байсан. Чамайг хэзээ ч тайвширч чадахгүй гэдгийг чинь ч мэдэж байсан юм. Гэвч чамайг арай хялбар юм хийх байх гэж бодож байлаа. Тухайлбал автомашиныг дэлбэлэх юм уу эсвэл мэргэн буучийг хөлслөх гэх мэт. Гэтэл чи арай өргөн хүрээтэй ажиллаж байна. Чи намайг бүр бүх үндсээр минь устгах зорилготой хүн юм гэлээ.

-Бүх үндсээр нь шаардлагагүй гэж Полунин хариулаад чамайг бие хүний чинь хувьд устгах хэрэггүй. Учир нь чи надад бие хүнийхээ хувьд аль хэдийнэ юу ч биш болсон гэж Полунин хэлэв.

Сатаровын царай уурласандаа болж зэвхийрэн шүдээ зууж байсан боловч биеэ барьж юм хэлсэнгүй. Харин Романенков хилэгнэн ярианд оролцож:

-Чи амаа татсан чинь дээр байх Иваныч. Чи бидэнтэй ингэж ярих болоогүй гэв. Гэтэл Сатаров:

-Зүгээр ээ. Ярьж л байг. Миний тухай энэ хүн юу гэж бодож байгааг нь би мэдмээр байна. Урьд нэгэн цагт энэ хүн миний удирдагч байсан юм. Би энэ хүнээс их юм сурч авсан гэлээ.

Полунин өрөөн дотуур явсаар буйданд очиж Сатаровын эсрэг талд суулаа. Тэгснээ:

-Би чиний багш байсандаа харамсаж байна гэж Полунин инээд алдан хэлээд, харин чиний

сүүлийн жилд хийсэн новшийн ажилд чинь би сургаагүй юм шүү. Өөрийн ажил төрлийн түншүүдээ алж устгах нь бүү хэл холдуулж зайлуулах нь миний зан огт биш гэв.

-Чиний ярианаас сонсоход чи өөрийгөө сахиусан тэнгэр гэж өргөмжилж байх шив гэж Сатаров доогтой инээд алдаад “Оливер” рестораны дэргэд чи биднийг буудаагүй, бас чи биднийг саатуулж цагдаа нарт барьж өгөөгүй юм шиг ярьж байна гэлээ.

-Харин чи амьд мэнд эрүүл саруул байна шүү дээ хэмээн Полунин хариулаад, тийм ээ та нартай байлдахын төлөө биш хэлэлцэхийн төлөө би цагдаа нартай ярьж тохиролцсон. Ингэсний үр дүнд бид хэлэлцэн тохиролцож хамтарч ажиллах болсон гэлээ.

-Тийм ээ, гээд Сатаров том жүнзнээс дарс балгаад тэгэхэд бид ярьж тохиролцсон. Би чамд итгэсэн юм. Дараа нь чи зангаа хувиргаж бидэнтэй шударгаар харьцахаасаа татгалзсан. Эхлээд чи Томашевскийтэй сүлбэлдэж намайг бизнесийн ажлаасаа зүгээр л гаргаж хаяхыг бодсон. Дараа нь чи Решето Колятай хамтран намайг устгахын тулд Музыкантын бүлгийг дуудаж авчирсан. Тэгэхлээр намайг муугүй мэдээлэлтэй байгаа гэдгийг чи мэдэж байгаа биз гээд Сатаров том жүнзиндээ дахин дарс хийв.

-Балай юм. Бүрмөсөн балайрч байна гэж Полунин эсэргүүцээд, чи бүрмөсөн будилж булан бүхний цаана урвагч байна гэж сэжиглэх болжээ. Чи улсын ерөнхийлөгчөөс олон бие хамгаалагчтай болсон байна гэлээ.

-За больж үз Иваныч. Онгон юм шиг бүү аашил. Бид чиний тухай цөмийг мэднэ гэж Романенков үзэн ядсан өнгөөр дуугараад чи биднийг зайлуулж цөмийг өөртөө авахыг санаархсан. Гэвч бид түрүүлж Коля Решето та хоёрт цохилт өгсөн гэлээ.

Полунин хараагаа Сатаров руу шилжүүлж:

-Чи бас тэгж бодож байна уу? Намайг та нарыг устгах гэсэн зорилготой байсан гэж чи бодож байгаа юм биш биз? гэж асуув.

-Үүнийг чинь бодоод байх юм байхгүй гэж Романенков хөндлөнгөөс хариулаад, бид Музыканттай өөртэй нь уулзаж ярилцсан юм. Бирюков түүнийг саатуулсныхаа дараа суллаж бидний гарт өгсөн юм... гэтэл Сатаров өлгөж аваад, намайг устгахын төлөө өөрийг нь хотод дуудаж авчирсан гэж тэр хэлсэн. Тэр алуурчинг чи болон Решето захиалж ирүүлсэн гэж тэр хэлсэн гэв.

-Үүнийг мэдээд бид Музыкантыг өөрийг нь бид хөлслөж авахаас өөр аргагүй болсон юм гэж Романенков хэлэв.

Тэгтэл Сатаров ч Романенков ч тэгнэ гэж санаагүйгээр Полунин дэлбэрэн хилэгнэж үсрэн босож суусан сандлаа хөмрүүлж орхиод:

-Яана гэнээ муу зулбадас! Чухам чи тэр цагдаад саатуулагдсан тэнэмэл алуурчны үгээр ямар ч гэмгүй хүмүүсийн цусыг урсгасан! Чи ердөө л сэтгэцийн архаг өвчтөн юм! гэж хашгирав.

Сатаров түүний хилэнтэй үгийг дуугүй сонсож байснаа том жүнзтэй дарснаасаа том балгаад царс модон шүүгээнээс нэгэн хавгас гарган ширээн дээр шидэж орхив. Тэгснээ.

-Чи бүү орил, Иваныч. Энэ бол чиний юу хийх гэж байгааг чинь батлах бас нэг баримт байна гэлээ.

Полунин ширээнд дөхөж очоод хавтсыг авч

-Энэ чинь юу юм? гэж асуув.

-Энэ бол намайг бүр сөрөх багц хувьцаагүй болсон нэгэн жижиг хувь нийлүүлэгч болгохыг санаархсан чиний компанийн удирдлагыг өөрчлөх төлөвлөгөө байгаа юм. Үүнийхээ дагуу Томашевский та хоёр ихэнх хувьцааг өөртөө худалдаж авахыг зорьсон. Энэ ажлаа хэрэгжүүлэх дэс дараатай арга хэмжээгээ нарийн тусгасан байна. Төгсгөлд нь чиний гарын үсэг зурагджээ. Одоо болохлоор чи миний эсрэг юу ч хийгээгүй гэж хэлж байна? гэж Сатаров ярилаа.

Полунин хавгастай бичиг рүү харж байснаа Сатаров руу хандан:

-Энэ төлөвлөгөөг хэн чамд өгөв? гэж асуув.

-Би гэх хүний дуу гарахад Полунин эргэж харвал цагдаагийн хурандаа Бирюков зогсож байв. Тэрээр:

-Энэ төлөвлөгөөг чинь би түүнд дамжуулсан юм гээд өрөөн дотуур явж Сатаровын дэргэд ирж зогслоо.

-Та үүнийгээ тэр үед Томашевскийтэй хамт сууж байсан мужийн дэд захирагч Симоновын өрөөнд танилцуулахаар орхисон байсан гэв.

Полунин гэнэтхэн инээд алдаад:

-Жил хагасын туршид тоглосон энэ жүжгийн гол найруулагч нь хүрч ирэв бололтой. Үүнийг би зөвхөн сая мэдэж байгаадаа ичиж байна. Үүнээс өмнө би зөвхөн тааварлах төдий эргэлзэж явсан юм гэлээ.

-Та энэ бодлоо өөртөө үлдээж үз, Владимир Иванович! гэж Бирюков хүйтнээр дуугараад өнгөрсөн тэр явдлыг одоо ярих газар, ярих цаг ч биш. Өөрсдийнхөө ирээдүйн тайван амьдралыг хангахын тулд бидэнд их юм хийх цаг хугацаа хэрэгтэй байна гэв.

-Яагаад тэр билээ? Константин Матеевич, би ирээдүйд итгэхгүй байгаа учраас зөвхөн өнгөрсөн үйл явдлаар тэжээгдэн амьдарч байна. Таны энэ хотод тайван амьдралыг хангана гэж нэг бус удаа надад болон бусдад амлаж байсныг би байнга санаж явдаг юм гэв.

-Тийм ээ. Үнэхээр би тэгж хүсдэг хэмээн Бирюков батлан хэлээд, би өөрийн чадах чинээгээрээ ингэхийн төлөө зүтгэх болно гэлээ.

-Тэгэлгүй дээ Константин Матвеевич хэмээн Полунин инээд алдаад, тэгэхийн төлөө зүтгэхгүй байна гэж таныг хэн ч буруутгахгүй. Гэвч таны тэр амлаж байгаа тайван амьдрал чинь оршуулгын газрынх гэдэгт олон хүн эргэлзэхгүй байдаг гэж хэлснээ уур нь улам шатаж нүдэнд нь үзэн ядахын гал дүрэлзэн, чухам тэр газарт чинь жинхэнэ тайван амьдрал байна. Та тийш нь өөрт таалагдаагүй буюу саад болсон олон хүнийг явуулсан гэж хэллээ.

Бирюковын нүүр хилэнгээсээ болж зэвхийрэн цайж, хамрын нь хямсаа чичигнэн:

-За болоо! гэж зандраад би энэ балай үгийг чинь бишгүйдээ л нэг сонслоо. Одоо хүрэлцээтэй. Таны авчрах ёстой тэр бичиг баримтууд хаана байна? Бас Лобников хаана байна? Түргэн хэл! гэж тушаав.

-Энд чи бүү захиргаад Костя гэж Сатаров Бирюковт хандан хайхрамжгүй хэлээд, энэ бол миний гэр. Энд зөвхөн би тушаана. Тийм учраас энэ хүн ярих юм аа яриг! гэлээ.

Сатаровын дуунд дарсанд нэлээд халсан хүний агсамдуу бөгөөд захирангуй өнгө илэрч байв.

Романенков Сатаровыг дургүйцсэн шинжтэй харснаа:

-Би чиний хувьд Костя чинь биш. Чи энд аль хэдийнэ эзэн биш болсон. Хэн нэгэн чамайг энэ дүрд тавьсан бол чамтай яриад байх зав, хүч надад байхгүй. Хэтэрхий олон хэцүү асуудлыг шийдмээр байна. Энэ бичиг баримтуудыг бид авах эсэхээс олон нэр нөлөө бүхий хүмүүсийн цаашдын хувь заяа хамаарна.

-Чи муу цагдаагийн новш юу яриад байгаа юм бэ? гэж Сатаров Бирюков руу давшлан би чиний эврийг хуга цохьчихье. Муу нохой чамайг чиний тэр Симоновтой хамт бас тэр ноёнцоруудын чинь хамт өнгөрсөн бүх хугацаанд тэжээж ирсэн. Би одоо болоход чамд чичлүүлэхийн тулд мөнгө өгч байсан уу хэмээн хилэгнэв.

Бирюков Сатаров хоёр бие биеэ арай л барилцан зодчихоогүй зогсож байлаа. Энэ үед хөндлөнгөөс хараад зогсож байсан Романенков Бирюковын дэргэд очиж зэрэгцэн зогсоод хүйтнээр дуугарч:

-Чи дэмий хилэгнэж байна. Энэ чинь цагаа олоогүй явдал. Константин Матвеевич зөв ярьж байна. Эхлээд хийх юмаа хийе. Дараа нь ярилцъя гэхийг Сатаров сонсоод гайхаж орхив.

-Мөн дөө! Чи муу нохой бас түүний талд байна уу? хэмээн Сатаров цухалдан хашгираад би одоохон хамгаалагчдыг дуудая. Тэд та хоёрыг Иванычийн нүдэн дээр янзалж орхино гэлээ.

-Хамгаалагчид зөвхөн миний үгэнд орно гэж Романенков тайван хариулаад, би чамд сүүлчийн удаа сануулж байна. Наадахь дэмий яриагаа боль. Бодит ажилдаа орё! Тэгэхгүй бол чи бид хоёр бас Константин Матвеевич ч магадгүй хэрэгтний суудалд залрах болно гэв.

-Юу гэнээ? Би чамаас юу сонсох нь энэ вэ? Чамаас ийм үг гарна гэж би санасангүй, Романыч, гэж Сатаров хилэгнэн хэлээд жүнзтэй дарсаа балган тэгвэл би одоо ямар ч хамгаалагч хэрэглэлгүй та хоёрын тархийг хага цохьчихье. Каратэчин байсан хүнд энэ чинь

юу ч биш гээд Сатаров тэр хоёрын зүг давшилтал Полунин дундуур нь орж хориглов.

-Хэрэггүй Олег минь. Хэрэггүй гэж Полунин Сатаровт тулж очоод магадгүй чи урьд нь каратэгийн аварга байсан байж болох юм. Гэвч Бирюковын зөв. Одоо чи хэн ч биш болжээ. Чи энэ өрөөний эзэн аль хэдийнэ биш болсон бололтой гэж хэлээд хавтастай бичгүүдийг түүний гарт өглөө. Тэгээд, наадах чинь хуурамч бичиг байна, Олег. Тэр үед захиргаан дээр Симонов, Томашевский хоёрт орхисон миний тэр төсөл биш байна. Миний тэр төсөлд чиний сонирхлыг сайн тусгасан байсан юм. Гэтэл чамд сайн ажиллаж хуулбарласан хуурамч төслийг атгуулж орхижээ. Харин чи жинхэнэ эх эсэхийг шалгаж үзэлгүйгээр түүнд итгэсэн байна. Тэд чиний муу санаа болон гэнэн байдлыг чинь ашиглажээ гэв.

Сатаров гартаа байгаа бичгүүдийг гайхан харж байснаа Полунин Бирюков хоёрыг ээлжлэн ширтэх ажээ.

-Чи намайг цагдаа нартай ярилцаж тохиролцсон гэж буруутгаж байна хэмээн Полунин цохон хэлээд, тийм ээ би цагдаа нартай өөрийн зорилгодоо хүрэхийн тулд шударга журмын дагуу ярилцсан. Харин би чамаас ялаатай нь тэдний доор хэвтэж тэдэнд туслаагүй гэлээ.

Полунин Бирюков руу эргэн хандаж:

-Та зүгээр нэг түүнийг сонгож аваагүй биз дээ Константин Матвеевич? гэж асуув.

-Мэдээж гэж Бирюков баргар царайлан батлаад, би тантай хэзээ ч тохиролцож чадахгүй гэдгийг би мэдэж байсан юм. Харин Олег Григорьевич өнөөдөр хүртэл миний үгэнд орж итгэдэг байсан хүн. Бас энэ будлиан мөргөлдөөн төгсвөр болсны дараа ч тэр миний үгнээс гарахгүй хаашаа явах юм. Учир нь тэр хүн биднээс ихээхэн хамааралтай юм. Хэрэв бидний дэмжлэг байгаагүйсэн бол энэ хүн аль хэдийнэ ёроолд уначихсан байхсан... Харин одоо жинхэнэ ажлаа ярья. Бидний шаардаж байгаа бичиг баримтууд хаана байна? Тэр Лобников хаана байна вэ? гэж Полунингаас асуув.

-Бодвол Лобников Москвагийнханд мэдүүлэг өгөхөөр “Советской” зочид буудалд сууж байгаа биз...

Бирюковын нүүр бухимдлаасаа болж зэвхийрсээр байв.

-Түүнийг нааш нь аваад ир гэж бид танд тушаасан шүү дээ гэж тэрээр шүдээ зуун хилэгнэв.

-Харамсалтай нь би түүнийг захирч чадахгүй учир өөрөө мэдээд тийшээ яаран явчихсан бололтой гэж Полунин мөрөө хавчин хэнэггүй тайвнаар хариулав.

-Бичиг баримтууд хаана байна? гэж Романенков хилэгнэн уурлаж асуугаад бидэнтэй тоглох гээд байвал чинь чиний тэр пацааны толгойг бид нүд ирмэхийн зуур тасчиж хаяна гэж сүрдүүлэв. Бирюков түүний хэлснийг шүүрэн дэмжиж

-Та ойлгож байна уу, Владимир Иванович бидний сүрдүүлэг хэрэгжиж болох бүрэн үндэслэлтэй. Учир нь болж байгаа үйл явдал хэтэрхий ноцтой юм. Иймээс бид хамгийн

аймшигтай хэргийг үйлдэхээс буцахгүй. Хэрэв та хүүгийнхээ амийг аврахыг хүсвэл бидний тавьсан шаардлага бүхнийг биелүүлэх хэрэгтэй гэлээ.

-Ямар шаардлага? гэж Полунин хөмсөг зангидан асуув.

-Хамгийн түрүүн бүх данс бичгүүдийг бидэнд өг гэж Бирюков хариулав.

-Дараачийнх нь?

-Дараачийнх нь Лобников комиссынхонд мэдүүлэг өгөх ёсгүй.

-Энүүнд чинь би тэгээд юу хийх ёстой юм? гэж Полунин гайхаж мөрөө хавчин асуув.

-Тийм ээ. Юу дуртайгаа хий! гэж Романенков тэвчээр алдан орилоод, чи Петров, Лобников хоёрыг цагдаа нарт барьж өгсөн. Тэднийгээ тэндээс зайлуул! гэлээ.

-Та тун овжин ажиллаж, Владимир Иванович. Та яаж эдгээр хүмүүсийг өөртөө элсүүлж чадав? гэж цагдаагийн дэд хурандаа Полунинг хүндлэх мэт асуув.

-Ингэхэд нэг их хэцүү биш байсан. Би та нар болон та нарын ажиллах аргыг мэдэж байсан. Та нар ямар нэгэн хиншүү хярвас үнэртэж эхэлмэгц санхүүгийн олон булхайг чинь болон хилийн чанад дахь мөнгөний гүйлгээний чинь талаар их юм мэддэг аюултай гэрч нараасаа аль болохоор хурдан салахыг эрмэлзэж байсан. Олег Григорьевичийн өөрийн нь хэлсэнчилэн тэрээр орон нутгийн олон эрх мэдэл бүхий түшмэлүүдийг угжиж байсан. Тэдний дотор та болон дэд захирагч Симонов ч орно. Та нар эрсдэлээс урьдчилан сэргийлж Капустины хүмүүсийн эсрэг хөлсний алуурчдыг илгээсэн байна. Ийм юм болсны дараа ялангуяа алагдсан Капустиныг зурагтаар хараад тэд миний ямар ч ятгалгагүйгээр та нарын эсрэг талд орсон юм гэж Полунин хариулав.

-Дэмий чалчихаа боль, новш оо! гэж Романенков хашгираад тэр цааснууд хаана байна? гэж тулган асуув.

-Харин миний хүү хаана байна? гэж Полунин тайван асуугаад, би хүүтэйгээ ярьж эрүүл мэнд байгааг нь мэдэхээс нааш та нарт юу ч ярихгүй гэв.

Романенков бухимдан халааснаасаа гар утас гаргаж дугаар даран:

-Борен байна уу? Би Романенков байна. Тэнд чинь хэвийн үү? Сайн байна. Утсаа пацаанд өгчих. Эцэгтэйгээ яриг гээд гар утсаа Полунинд өгөв.

Владимир жил хагасын дараа анх удаа хүүгийнхээ дууг сонслоо.

-Аав аа, сайн байна уу? Би Антон байна!

-Сайн байна уу, хүү минь гэж Полунин хариулаад, чиний дууг сонсоод аав чинь их баяртай байна. Чи яаж байна? Зүгээр үү?

-Зүгээр ээ, ааваа. Бүх юм зүгээр. Бүх юм хараа хяналтан дор байгаа гэж дамжуул гэж эд нар хэлж байна гэж хүү нь хариулав.

Полунин инээмсэглээд:

-Сайн байна хүү минь. Хоёулаа удахгүй уулзана гэж бодож байна гээд утсыг нь Романенковт буцааж өглөө.

-Алив данс бичгүүд хаана байна? гэж Романенков тэвчээр алдсандаа дүрсхийн шатаж асуув.

Полунин тамхиа татах зуураа:

-Юу хаана гэж? Үүрэндээ байгаа гэж гэнэтхэн хариулаад чөтгөр минь чи данс бүртгэлийн оронд бөгс хошног авах болно эвэртэй мал минь! Тэр данс бүртгэлүүд чинь аль хэдийнэ прокурорын ширээн дээр хэвтэж байгаа. Петров, Лобников хоёр та нарын сүүлийн үеүдэд хийсэн бүхнийг чинь комиссынхонд нэгэнт дэлгэрэнгүй илтгэж эхэлчихээд байна гэж хэллээ.

Сатаров, Романенков, Бирюков гурвуулаа Полунинг айж самгардсан нүдээр ширтэн зогсоно.

-Юу вэ чи чинь ухаан чинь муудав уу? гэж Романенков асуугаад, бид чиний жаалыг хэрчиж ална. Чи үүнийг хүсэж байна уу? Тийм үү? Тэгвэл сайн байна. Одоо чи зарим хэсгээс нь авах болно гэж заналхийлэв.

Тэгснээ утсаа авч:

-Бүргэдүүд минь анхааралтай сонсож бай. Тэр барьцааны жаалын чигчий хурууг нааш нь явуул гэж тушаав.

Тэгснээ гэнэтхэн татвасхийн нүүрэн дээр нь гайхаж балмагдсан шинж илэрлээ.

* * *

Ээлжийн хүмүүжүүлэгчийн өрөөнд цагаан үст залуу түрүүлж орлоо. Тэгмэгцээ хаалганы дэргэд хөндөлдөн зогсож байгаа сахалт манаачийг сэжиглэн харав. Араас нь шар сахалт дээрэмчин дагаж орлоо. Гэвч цагаан үст өрөөний босгыг дөнгөж алхмагц хөшөө мэт хөшиж орхив. Өрөөнд тэдний эсрэг талд нэгэн булиа залуу тэднийг инээмсэглэн харж суух нь тэр. Гэвч дээрэмчдийн анхаарлыг тэр залуу өөрөө биш харин өвдөг дээр нь тавиастай автомат “Калашников” татаж байсан юм. Дээрэмчдийн орж ирмэгц “ээлжийн хүмүүжүүлэгч” автоматаа тэдэн рүү онилон:

-Мэнд үү, эрчүүд минь. Алив хурдан гараа ар шилэндээ барьцгаа! гэж бууныхаа замгийг тачигнуулан тушаав.

Цагаан үст нь өөрийн мэдэлгүй гараа өргөх үед ар талд нь ямар нэгэн чимээ гарч мод хугарах дуулдан ямар нэгэн зүйл их чимээтэйгээр шалан дээр ойчих нь сонсогдов.

Цагаан үст дээрэмчин самгардан эргэж харвал хам залуу нь босгоны цаана тэрийн гар хөлөө

алдлан хэвтэх агаад сахалтай булиа өвгөн шүүрний хугархай ишийг бариад зогсож байгаа нь харагдлаа.

-Тэнд чинь юу болов Шакирыч? гэж Славка Болдин урьдын адил автоматынхаа амыг дээрэмчин рүү чиглүүлэн барьж асуув.

-Шүүрнийхээ хайран ишийг хугалчихлаа хэмээн Шакирыч хэвтэж буй мулзан толгойт руу зааж хэлээд тун бөх гавалтай хүн юм даа. Шүүрний иш царс модоор хийсэн байсан юмсан гэлээ.

-Наадхиа орхи. Энэ залууг янзал гэж Болдин хэлэв.

-Яаж янзлах гэж? Мөн гавал руу нь уу? гэж өвгөн асуув. Болдин:

-Гавал руу нь хэрэггүй. Бууг нь аваад гарыг нь хүлж орхи гэлээ.

Шакирыч цагаан үстээс бүүгий нь авч халаасандаа хийгээд:

-Алив хүү минь. Уруугаа хараад хэвт гэж бараг эелдэг дуугаар тушаав.

Хэдэн минутын дараа тэр залуу гараа хүлүүлээд өрөөний шалан дээр сууж байв. Хажууд нь мөн адил гараа хүлүүлсэн шар залуу нь хэвтэх ажээ.

-За тэгэхлээр та хоёр үүргээ биелүүлсэн байна. Одоо бидний ээлж хэмээн Болдин хэлээд дээрэмчний халааснаас гар утсыг нь гарган авч, алив шөфийнхээ дугаарыг хэлээд орхи! гэв.

Гэтэл дээрэмчин залуу хариу хэлэлгүй ихэмсэг байдлаар өөр тийш хараагаа буруулав.

-Юу вэ? Шакирыч. Энэ хүүхэд энд асрамжийн газар хүүдээ туслах аав ээж нь байхгүй байгаа гэдгийг ойлгохгүй байгаа бололтой гэж Шакирычид хандан хэлэв.

-Одоо ойлгуулаад өгье гэж Шакирыч хэлээд шүүрний хугархай ишийг авч олзны залууд ойртон, энэ хугархай модыг бөгс рүү нь шургуулж орхиё. Тэгэхэд суухад нь тун эвгүй, харин тун дуртай ярих болно гэлээ.

Дээрэмчин залуу тэр хийх юмыг нь хүлээлгүй асуусан дугаарыг яаран хэлж өглөө.

Славка дугаарыг нь дарж утсыг нь залуугийн чихэнд ойртуулан:

-Одоо чи бүх юм хэвийн, пацаан бидний гарт байна. Цаашид юу хийх вэ? гэж асуу гэж тушаав.

Залуу түүний хэлснээр болсны дараа Славка буцаж түрүүний сууж байсан сандал дээрээ суув. Тэгээд

-Одоо бид цаашид байдал хэрхэн өрнөхийг хүлээе гэлээ.

Шакирыч шүүрний хугархайг гартаа эргэлдүүлэн барьж байснаа дээрэмчин залууд хандан:

-За хүү минь, хэрэв манай шепт ямар нэгэн муу юм тохиолдвол би энэ модыг чиний гэдсэнд ортол шургуулна, мэдэв үү? гэж сүрдүүлэв.

-Наадхаа орхи цааш нь. Бүү айлга Шакирыч. Тэртэй тэргүй өмдөндөө тавьчихаад арай ядан суугааг нь харахгүй байна уу? Харин Антоныг аваад ир. Гэнэтхэн хэрэг болж юу магад гэлээ.

Хэдэн минутын дараа Шакирыч Антоныг хөтлөн авчрав. Антон хүлээстэй залуусыг харснаа,

-Энэ ах нар над дээр ирсэн үү? гэж асуув.

-Тийм ээ. Гэвч дүрсгүйтээд байхаар нь ингэж хүлэх хэрэг гарсан юм гэв.

Дахин утасдах хүртэл дахиад гучаад минут хүлээх хэрэг гарлаа. Энэ удаа Романенков ярив.

Славка утсыг яаран олзны залуугийн чихэнд нааж яриаг нь чагнуулбал тэрээр:

-Эцэг нь хүүгээ яриульа гэж байна гэв.

-Бүх юм хэвийн, хамгаалалт хяналтад байгаа гэж хэл хэмээн Шакирыч хүүд хэлэв.

Антон эцэгтэйгээ ярилцаад утсаа Шакирычид өглөө. Шакирыч утсыг авч чихэндээ ойртуулмагц:

-...Жаалын чигчий хурууг нь нааш нь явуул гэх Романенковын дуу сонсогдох нь тэр.

* * *

-Харин чиний нусгай залуусын чинь төмсгийг явуулсан нь дээр юм биш үү? гэж Шакирыч Романенковг хариулах нь тэр.

Ийм хариу сонсоно гэж огт санаагүй Романенков сандран балмагдаж инээмсэглэн суух Полунин руу хараагаа шилжүүлэв. Тэгснээ,

-Хэн ярьж байна вэ? гэж тэрээр асуулаа.

-Хэрэв чи дахиад хүүхдээр оролдохыг завдвал чинь хошногыг чинь сугалж авах хүн байна гэж Шакирыч хариу хэлээд утсаа салгав.

Романенков утсаа барьсан салганасан гараа доош нь буулгав.

-Юу болов? гэж Бирюков сонирхон асуулаа.

-Энэ муу нохой биднийг залилж орхилоо. Тэд биднээс түрүүлж очоод манай хүмүүсийг барьж аваад хүлж орхижээ.

-Чи эндүүрч байна, тэнэг амьтан гэж Полунин түүнд хариулаад, миний хүмүүс тэнд тогтмол

байж миний хүүхдийг хамгаалж асарч байсан юм. Би хүүгээ хараа хяналтгүй тэнд чинь орхичихно гэж чи бодоогүй биз?

-Чи бүхнийг ингэж хяналтандаа авсан байтлаа яагаад наашаа хүрч ирсэн юм? гэж Сатаров гайхширан асуув.

-Чамтай ярилцах гэсэн юм Олег. Бүх юмыг нэгмөсөн ярьж шийдэх гэсэн юм. Тэгснээрээ би харамсахгүй байна. Өнөөдөр би их зүйлийг мэдэж авлаа гэж Полунин хариулав.

-Худал хэлж байна, новш чинь. Би үүнийг нь бүх биеэрээ мэдэрч байна. Энэ новш зүгээр л ярилцах гэж ийшээ ирээгүй гэж Романенков бухимдан хашгирав.

Бирюков ямар нэг юм бодож Полунинг ширтэж байв.

-Чи зөв ярьж байна гэж Полунин Романенковт хандан хэлээд, би энд зүгээр л хууч хөөрөлдөх гэж ирээгүй гэлээ.

Тэгснээ доошоо тонгойн баруун хөлийнхөө гутал руу зааж, энэ шаахай хөлийг минь бага зэрэг хавчаад байгаа юм. Учир нь минийх биш. Гутлын хувьд гэвэл новшийн эд гэж Полунин хэлээд, харин техникийн ололтын хувьд сонирхолтой л зүйл юм гэлээ.

Тэгтэл тэнд цугларагчид Полунингийн баруун хөлний нь гутлын оосор дор жижиг хар товч шиг юм байхыг олж харлаа.

-Энэ бол дуу хураагч байгаа юм гэж Полунин тайлбарлаад зай нь өсгийд нь байдаг юм. Тийм учраас өнөөдрийн бидний хооронд болсон яриаг нэгд нэггүй бичиж авсан байгаа. Нэгэнт яриа дууссан учир одоо та нарт нэг их таалагдмааргүй олон зочид хүрч ирнэ гэх нь тэр.

-Мөн дөө муу нохой чи биднийг барьж өглөө! гэж Романенков галзууртлаа уурлан гар буугаа гарган Полунин руу чиглүүлээд, чи өөрийгөө бүгдээс зальтай гэж бодож байна уу? Одоо би духанд чинь сум зоож орхиё. Тэгэхэд чи бүгдээс тэнэг болж хоцорно гэж зандарлаа.

-Би чамтай хамт тэнэг болж хоцрох учир надад таатай байна гэж Полунин хариулаад, үүний чинь төлөө чамд наад зах нь хорин таваас доошгүй жил өгнө. Өөрөөр хэлбэл чи өөрийн хамсаатнуудаас илүү олон жилийн ял авна. Үйлдэгдсэн бүх аллагыг чи өөртөө хүлээж шийтгүүлнэ. Чухам чи л Музыкантий шууд холбоотой байсан шүү дээ. Тиймээс чи бүх аллагын золиос болно гэлээ.

Романенков галзууран уурлаж буугаа Полунингийн толгой руу чиглүүлтэл гэнэтхэн Сатаров халамцуу хүнээс гарамгүй хурдан хөдөлж агаарт хөөрөн үсэрч хөлөөрөө Романенковын гарт байгаа гар бууг өшиглөж орхилоо. Гэвч Романенков буудаж амжсан бөгөөд сум нь хананд тусаж таазны доорхи шохой будгийг цацаж унагаав. Харин Сатаров ингээд орхисонгүй. Тэрээр дахин үсэрч түүний эрүү рүү нь өшиглөн унагаж дээрээс нь хэд хэдэн удаа нэрвэн нүдээд өөрт хуримтлагдсан уур хилэнгээ суллан гаргалаа.

-Муу нохой май чамайг! Энэ өрөөнд хэн маань эзэн гэдгийг чамд би үзүүлээд өгье гэж

Сатаров хилэгнэж хашгираад түүнийг өшиглөсөөр байв.

Сатаров Романенковын ухаан алдсаныг сая нэг юм мэдээд нүдэхээ больж хүндээр амьсгаа аван хараагаа Полунин руу шилжүүлэв. Тэгснээ:

-Уучлаарай Иваныч. Би чиний өмнө буруугаа ойлголоо. Миний хэлж чадах юм энэ л байна гэв.

-Баярлалаа Олег гэж Полунин бодлогошрон хариулаад, ингэсний чинь төлөө баярлалаа. Харин би харамсалтай нь чиний төлөө юу ч хийж чадахгүй нь гэв.

-Мэдэж байна гэж Сатаров хэлээд, баарнаасаа лонх виски гаргаж ирлээ.

Полунин энэ бүх явдлыг хөндлөнгөөс тайван харж зогсож байсан Бирюков руу хараагаа шилжүүллээ. Бирюков сая нэг юм ам нээж:

-Владимир Иванович та намайг дийллээ гэж дэмий бодож байна. Би бол барагтай хүний хүршгүй хүн байгаа юм гэв.

-Харж л байя гэж Полунин товч хариулав.

Дараачийн агшинд гаднаас харуул гүйж орж ирээд сандарсан байдлаар:

-Гадаа цагдаа нар Холбооны аюулгүй албаныхнаас бүрдэх бөөн хүмүүс ирээд байна. Тэдэнд нэгжлэг хийх прокурорын зөвшөөрөл бий гэнэ гэж мэдэгдлээ.

-Тэр зочдыг оруул! гэж Сатаров хашгираад нэгжлэг хийвэл хийг. Тэртэй тэргүй би эндхийн эзэн биш гэлээ.

Хэдхэн хормын дараа энгийн хувцастай хэдэн хүмүүс, тусгай өмсгөлтэй автомат буу агссан тусгайнхныг дагуулсан хошууч Бахметьев орж ирлээ.

-Та зүгээр үү? гэж Бахметьев Полунинд хандан асуулаа.

-Би зүгээрээ гэж Полунин хариулаад, хэрэв та нар асуудлыг эцэст нь хүртэл шийдвэл би бүр ч зүгээр байхсан. Би өөрийнхөө тавилыг хэдийнээ тоглож дуусаад байна гэв.

Тэрээр хэдэн минутын дараа өрөөнөөс гарч хашаан дотуур явсаар гудамжинд гарлаа. Тэгээд өөрийн сууж ирсэн “АУДИ” руу очиж явглаа гэнэтхэн зоогдсон юм шиг зогсож орхилоо. Нүднийхээ булангаар улаан өнгийн “НИВА”-гаас хүү Антон нь гарч ирэхийг харах нь тэр. Жаал хүү гудамж өнгөрөн гүйсээр эцэгтээ хүрч ирээд чимээгүйхэн элгэнд нь наалдаж орхилоо. Полунин хүүгээ энхрийлэн тэвэрч аваад цээжиндээ авч өргөлөө.

* * *

Полунин өөрийн нь дараа шинэ эзэн нь өөрчилж тохижуулсан хуучин өрөөндөө орлоо. Тавилга нь нэг мянгад тогтохгүй илүү үнэтэй шинэ бөгөөд орчин үеийн гоёмсог хийцтэй

ажээ. Иймэрхүү тавилгатай өрөөнд Полунин дасаагүй байсан агаад ер нь Сатаровоос ялгаатай нь илүү чамирхал түүнд үл таалагдана.

Полунин өрөөний ажлын ширээний ард байх том тохилог чамин суудал дээр суухыг хүссэнгүй. Тэрээр хурлын урт ширээний нэгэн энгийн сандал дээр сууж үнсний сав ойртуулан тамхиа татав. Энэ үед өрөөний хаалга онгойн Бахметьев Томашевский хоёр орж ирлээ.

-Өглөөний мэнд, Владимир Иванович. Та өөрийн хуучин өрөөнд дахин шинээр дасах гэж чармайж байх шиг харагдана гэж Бахметьев дуугарав.

-Үгүй дээ хэмээн Полунин хариулаад ингээд байх шаардлагагүй.

-Тийм гэж үү? хэмээн Бахметьев хөгжилтэйгөөр хэлээд Полунингийн эсрэг талын суудалд очиж суулаа.

Дуугүй байсан Томашевский дэргэд нь очиж суув.

-Үнэндээ ч энэ өрөө, энэ суудал хууль зүйн хувьд таных байх ёстой. Өөр хэний ч биш.

-Энэ бол маргаантай асуудал гэж Полунин инээд алдан хэлээд, ямар ч гэсэн олон хүн үүнд эргэлзэж байна. Та бас нэг ялагчийг танилцуулахаар дагуулж ирлээ гэж ойлгож болох уу? гэж асуув.

Бахметьев Томашевский руу зэрвэс харан инээмсэглээд Полунинд хандан:

-Одоо зовох юмгүй илэн далангүй ярьж болох байх. Тийм ээ Альберт Николаевич бүх энэ хугацаанд бидний гол холбоотон байсан хүн.

-Бас ивээн тэтгэгч ч байсан гэж хэлж болно гэж Полунин нэмж хэлээд, харин би таныг улсын байгууллагад ажилладаг гэж бодож байсан юм гэлээ.

-Энд энэ чинь ямар хамаатай юм бэ? гэж Бахметьев хөмсөг зангидан асуугаад мэдээж би улсын байгууллагад ажилладаг боловч зарим үед ердийн бус алхам хийж янз бүрийн хүмүүстэй харьцах хэрэг гардаг юм. Гадаад явахад чинь хэн ивээн тэтгэж зочид буудал, банкны түшмэлүүдийн мөнгийг төлсөн бэ? гэж асуув.

-За яах вэ? Бүү гомдоллоорой. Би таны ард ямар хүн зогсож байдгийг барагцаалж байсан учир би таныг буруутгах үндэс байхгүй гэлээ.

Полунин харцаа Томашевскийд шилжүүлж:

-Ноён Томашевский ямар нэгэн саналаа хэлэх гээд байх шиг байна гэв.

-Таны урьдчилан мэдэх мэргэн ухааныг чинь би гайхсаар байдаг юм гэж Томашевский үл мэдэгдэм доогтой инээмсэглээд таны түмэн зөв. Компанийн зөвлөлийн захирлын ажил танд хэрхэн таалагдаж байсныг би мэдэхгүй. Гэвч та энэ ажлыг үнэхээр итгэлтэй хийж байсан

гэдгийг харин мэднэ. Та энэ ажлаа дахин үргэлжлүүлж хийвэл би бүх талаар дэмжинэ. Гэвч таныг хүний зовлонгийн чинь хувьд мэдэж байна. Энэ бүх эмгэнэлт явдлуудтай нэгэнт холбоотой болсон. Энэ компанид хойшид ажиллахад танд сэтгэл санааны хувьд хүнд байх болно гэдгийг би мэдэж байна. Тийм учраас хэрэв таныг энэ хотоос явж компанийн хувьцаанаас татгалзах гэвэл... гэж ярьтал Полунин:

-Та дуртайяа худалдан авна гэж хэлэх гээ юу? гэж Томашевскийн санааг үргэлжлүүлэн хэлэв.

-Тийм ээ. Та зөв таалаа. Би бололцооны үнээр таны бүх хувьцааг худалдаж авах гэсэн юм. Та компанийн хувьцааны дөчин хувийг эзэмшдэг биз дээ? Мэдээжийн хэрэг таны тэр прокурор болон хууль сахиулах байгууллагуудтай холбоотой асуудлыг бид нэг мөр болгож хаах болно.

-Энэ үг чинь сануулга мэт сонсогдож байна гэж Полунин сануулаад мэдээж би хувьцаагаа танд худалдвал прокурор миний хэргийг тэр дор нь хааж таарна гэлээ.

Томашевский мөрөө хавчин,

-Би таны хэргийг хаалгахын төлөө бүхнийг хийх болно гэв.

-Энэ үг чинь барьцааны хэлбэртэй сонсогдож байх чинь гэж Полунин хариулаа.

-Тийм биш. Та буруу ярьж байна гэж Бахметьев хэлээд, Альберт Николаевич зүгээр л өөрийн саналыг хэлж байна. Ингэхдээ танд асуудлыг чинь шийдэхэд тусална гэж амлаж байгаа юм гэж залруулав.

-Тийм амлалт та ч гэсэн өгч байсныг би санаж байна, Николай Иванович гэж Полунин хэлэв.

-Би тэр амлалтаасаа хэзээ ч буцахгүй. Гэвч зуун хувийн баталгаа өгч чадахгүй.

-Тэгвэл Томашевский зуун хувийн баталгаа өгч чадах нь ээ гэж Полунин гайхан дуугарав.

Бахметьев дагуулж ирсэн нөхрөө хараад авсанаа толгой дохин:

-Чадна гэж бодож байна гэв.

-Харин би ингэхийн хэрэггүй гэж бодож байна гэж Полунин ширүүн хөдөлж үнсний саванд тамхиа нухаж унтраагаад үнэхээр та Альберт Николаевич намайг хувьцаагаа танд тавьж өгнө гэж бодоо юу? Надад тохиолдсон энэ бүх эмгэнэлт явдалд та ч гэсэн багагүй нэмэр хандиваа оруулсан хүн. Энэ тоглоомын үед таны хүргэсэн тус нэмэр урьдын чинь гэмийг цагаатгаж чадахгүй. Түрүүчийн холбоотнууд чинь зүгээр л таныг хаяж орхисон тул та ингэж байна гэж хэллээ.

-За яах вэ? Та надтай шинэ дайн зарлаж байгаа юм биз дээ гэж Томашевский инээмсэглэн хэлэв.

-Бурхан намайг өршөө гэж Полунин толгой сэгсрэн хэлээд би өөрийн хувьцааг аль хэдийнэ худалдсан учир та өөр надаас илүү чадалтай хүнээс л хувьцаа худалдаж ав. Ойрын үед тэр

хүний нэрийг та мэдэх болно. Гэвч эртнээс хэлэхэд тэр хүн таныг нэг их баярлуулахгүй л болов уу гэв.

-Танаас ийм үг гарна гэж мэдэж л байсан юм гэж Томашевский харамсан бувтнаад та намайг дөнгөж орхино гэдгийг би тааварлаж байсан гээд босов.

-Та ингүүлэх үйл хийсэн хүн шүү дээ гэж Полунин хариулав.

-Хэрэв энэ хүн буруу юм хийсэн бол Николай Иванович тайлбарлаж өгнө үү? гэж Томашевский Бахметьевт хандан хэлээд, хэрэв та чадахгүй бол прокурор тайлбарлаж өгнө. Энэ ноёны хэргийг ухаж үзвэл нэлээд зүйл гарах байх гэв. Тэгснээ Томашевский шийдмэг босож шуудхан өрөөнөөс гарч явлаа.

-Зовох юмгүй Николай Иванович гэж Полунин хэлээд би өөрийн шийдвэрийг нэгэнт гаргасан. Намайг ятгах хэрэггүй гэв.

-Би ятгах гэж бодоогүй гэж Бахметьев гараа савчин хэллээ.

-Та ивээн тэтгүүлэх мөнгө олох хэрэгтэй биш үү? Бахметьев.

-Тэр хүн миний ивээн тэтгэгч биш гэж дуунд нь ширүүн өнгө илрэн дуугараад, хэзээ ч байгаагүй. Зүгээр л одоогийн бий болсон нөхцөлд холбоотон байсан юм. Тэр өөрөө тантай ярьж учраа олог. Үнэн хэрэгтээ шударгаар хэлэх юм бол тэр панзчид луйварчид манай энэ улсыг нураан задлах гэж аль хэдийнээ чадах бүхнээ хийж байгаа юм. Харин бид аюулгүй албаныхан тэдэнд саад хийхийн төлөө байдаг бололцоогоороо тэмцэж байна. Зарим үед тэдний хоорондын маргаан зөрөлдөөнийг ч ашиглах хэрэг гардаг. Тийм учраас тэр тантай өөрөө л яриг гэж Бахметьев ямар нэгэн эргэлзээг цэглэх мэт хагуу шийдмэг дуугараад би хувьдаа бодохдоо та энэ асуудалд өөрийгөө хамгаалж чадах байх гэж бодож байна. Таныг эндхийн прокурортой уулзсан гэж мэдсэн юм гэж хэлээд нүдэнд нь хүүхдийнх гэмээр зальжин төрх илрэв.

-Би таны ярьсныг сайн ойлгосонгүй гэж Полунин гайхан хэлэв.

Бахметьев бүр инээмсэглэн:

-Би шууд хэлэхэд Владимир Иванович та намайг нэлээд журамтай хүн гэж бодож байх шиг байна. Таны хувь заяа ингэж сөргөөр эргэсэн явдалд би туйлын харамсаж байна. Гэвч хойшид таны бүх юм сайнаар эргэнэ гэдэгт би найдаж байна. Ямар нэгэн хүнд асуудал гарвал та над руу хандаж байгаарай. Би тусалж чадах юу магад гэлээ.

Полунин гэнэтхэн инээд алдаад хуруугаа ёжтой гозойлгон түүн рүү зааж:

-Энэ чинь урвуулан хөлсөлж авах гэсэн юм шиг сонсогдож байна. Эсвэл та нарын хэлдгээр хамтран ажиллая гэсэн санал юм уу даа гэв. Бахметьев хариуд нь мөн адил инээд алдаад:

-Уучлаарай. Ингэж дадчихсан юм даа гэж мөрөө хавчин хэлээд өдөржин шөнөжин ажиллах шаардлага гарах юм... гэж хэлэв.

Хотын саяхан томилогдсон прокурор Илья Игорьевич Воронков сейфнээсээ хуудас цаас гаргаад Полунингийн өмнө тавилаа.

-Та үүнтэй танилцаад гарынхаа үсгийг зурна уу? гэж хайхрамж муутай байдлаар хэлэв.

-Энэ юу юм? гэж Полунин асуув.

-Энэ бол таны эсрэг эрүү үүсгэсэн хэргийг хүчингүй болгосон тогтоол гэж тэр тайван хэлээд энэ тогтоолыг үйлдэх нь надад тийм ч амархан байгаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй юм. Таны хувьд хэтэрхий олон юм тодорхой биш байсан. Хууль бусар баривчлагдсан тэгээд тэндээс оргосон зэрэг чинь тун ээдрээтэй асуудал. Мөн хууль бусаар галт зэвсэг хадгалж байсан. Нуулгүй хэлэхэд бидний тогтоол зөв болох эсэхэд эргэлзэж байсан юм гэж хэлэв.

-Илья Игорьевич гэж Полунин инээмсэглээд би ч гэсэн “Аркада” компанийн данс бичгүүдийг та нарт авчирч өгөх үү гэдэгтээ бас их эргэлзэж байсан юм. Гэвч би зориг гаргаж авчирч өгсөн.

Воронков инээмсэглэн:

-Бидний тохиролцож ярилцсан явдлыг та надад сануулж байна уу? Би өөрийн амлалтаа биелүүлсэн гэдгийг та харж байна шүү дээ. Таны эрүүгийн хэргийг хүчингүй болголоо гэж хариулав.

-Үгүй дээ. Та намайг буруу ойлгож байна гэж Полунин хэлээд өөрөөр тодруулж хэлэхэд та намайг гүйцэд ойлгосонгүй. Тийм ээ. Мэдээж миний тэр ташаа тогтоож үүсгэсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж дотроо найдаж би зарим данс бичгүүдийг олж авчирсан юм.

Хотын прокурорын байгууллага Сатаров нарын эсрэг хэргийн мөрдлөгөөний гадуур ажиглагчаар үлдэхийг хүсээгүй нь мэдээж. Тэгвэл бүх энэ асуудлыг Москвагийн прокурорууд дангаараа шийдэх байсан. Өөрөөр хэлбэл тэдний гавьяа болох байсан юм. Ер нь тэгээд гараа хумхин суугаагүй Москвагийнхны өмнө та өөрийн хийсэн зарим ажлаа тайлагнах л болох байх.

Воронков зориуд магтах аятай.

-Хотын захиргаа таны шударга байдал хууль сахих үйл хэргийг сэргээхэд оруулсан хувь нэмрийг чинь өндрөөр үнэлж байна.

-Гэвч энэ бол бага зүйл гэж Полунин хариулаад, танд энэ бүх данс бичгүүдийг авчирч өгч байгаа явдал бол урьдчилан сэргийлэх өөрөөр хэлбэл даатгуулж байгаа хэрэг юм. Өөр тодорхой захиалга бүхий тэр Москвагийн комиссынхонд би нэг их бүрэн итгэхгүй байна. Гэнэтхэн тэр захиалагчид нь ажлыг бүрэн хангалттай хийгдлээ гэж үзээд ажлаа зогсоочихыг би хүсэхгүй байна. Ажлыг талд нь хүргээд зогсоочихын төлөө би ингэж жил хагасын хугацаа алдаагүй юм.

-Хотын прокурорын газар ажлаа талд нь хүргээд зогсчихгүй гэсэн баталгаа гаргуулж авахыг та хүсэж байна уу?

Полунин дуугүй толгой дохив.

-За яахав. Хэрэв миний амаар хэлсэн үгэнд итгэж байгаа бол асуудлыг шүүх хүртэл шийдэж, буруутнууд зохих ялаа авах болно. Мужийн прокурор ч гэсэн миний бодолтой ижил байгаа...

-Тэгвэл би өөрийн ажлыг явж тайван үргэлжлүүлж хийе.

-Та нэг тийшээ явах гээ юу? гэж Воронков асуугаад, би таныг ойлгож байна л даа. Өөрт чинь хичнээн хүнд эмгэнэлт явдлууд тохиолдож байсан энэ хотод цаашид амьдарч ажиллахад хүнд байх нь мэдээж. За яахав тэгвэл танд амжилт хүсье гээд Полунинд гараа өгч чанга атгалаа.

Полунин хаалга онгойлгон гарахаар завдаж байтал прокурор:

-Владимир Иванович санаа бүү зов. Би хэлсэн амандаа хүрнэ гэлээ.

* * *

...Хоёр хоногийн дараа Полунин хүүгээ аваад Москва руу нислээ. Өнгөрсөн бүх хугацаанд хүүхэд асрах газар манаач, цэвэрлэгч зэрэг албан тушаалтай бүтэн хорин дөрвөн цаг тэндээс холдолгүй ажиллаж байсан Шакирыч халагдаж хэдийнээ сахлаа авахуулчихаад тэр хоёрыг гаргаж өгөхөөр онгоцны буудалд ирсэн байв. Мөн өнгөрсөн жил хагасын туршид Полунингийн үлдээсэн автобизнесийн ажлыг амжилттай үргэлжлүүлж байсан Славка Болдинг ирсэн байлаа.

-Чи тэгээд хэзээ эргэж ирэх вэ? гэж онгоцонд суухыг чанга яригчаар зарласны дараа Болдин асуув.

-Хэлж мэдэхгүй байна гэж Полунин хариулаад, бид хоёр эхлээд гадаадад гарч сайн амрахыг бодно. Бүх юм Антоноос хамаарна. Уйдаад байвал эргэж ирнэ. Энэ хүүхдийн хувьд өнгөрсөн жил хагаст хүндхэн л байсан биз.

-Чамайг би буруу бүү ойлгоосой гэж хүсэж байна. Ямар ч байсан чи бүү яар. Энэ хүү өнгөрсөн бүх эмгэнэлт хүнд явдлуудыг сайтар мартах нь чухал.

-Тэгж ч чадахгүй биз дээ гэж Полунин санаа алдан хариулаад, гэвч би бүх талаар хичээх болно гэв.

Полунин цаана бөмбөг хөөцөлдөж байгаа хүүгээ дуудан ирүүлж нөхөдтэйгөө салах ёс гүйцэтгээд онгоцны шат руу өгслөө. Тэд Москвад өглөө эрт буугаад шууд "Прогресс" ресторан руу явлаа. Полунин рестораны үүдний танхимын босгыг дөнгөж алхмагц хуучны танил жижүүр угтан хүрч ирээд:

-Владимир Иванович таныг дээр хүлээж байна гэлээ. Полунин хүүгийнхээ мөрөн дээр гараа тавиад:

-Бид шууд онгоцны буудлаас ирлээ. Өлсөж байгаа биз гэв.

-Санаа бүү зов. Би бүх юмыг зохицуулна гээд жижүүр антон руу инээмсэглэн хараад, залуу минь намайг дагаад яв. Бидний мэдэлд хамгийн амттай хоолтой хамгийн тансаг ширээ засаатай байгаа гэлээ. Жижүүр хүүг дагуулан рестораны танхим руу явсны дараа Полунин дээшээ гарч хоёр минутын дараа рестораны эзэн Мироны өрөөнд явж орлоо.

-Сайн байна уу? Василь Васильевич гэж Полунин өрөөндөө ганцаараа байсан Миронтой мэндлээд гарыг нь барьж суухыг урилаа. Тэгснээ:

-Амьд эрүүл байгаад чинь баярлаж байна гэв.

Тэд өөр өөр рүүгээ харан суусан даруйд Полунин:

-За алив Василь Васильевичминь. Бодлоо өөрчлөөгүй биз? гэж асуув.

-Үүнийг чинь харин чамаас асуумаар байна? гэж Мирон инээмсэглэн асуугаад чи тэгээд тэр хувьцаануудаасаа салахаар шийдэв үү? гэж асуув.

-Тийм ээ гэж Полунин шийдмэг хэлээд чиний хэлсэн үнэ надад бүрэн хүрэлцээтэй гэлээ.

-За тэгвэл хойшлуулаад яахав. Баримт бичгээ үйлдэж бүрдүүлье гээд Мирон босоод өрөөний цаад дахь булангийн хананы сейф хадгалах нууц хаалтыг онгойлгон бичиг баримт бүхий хавгастай жижигхэн чемодан гаргаж ирлээ.

Энэ бол Полунин Самбист хоёрт ноогдох “Аркада” компанийн хувьцааг худалдах тухай гэрээний бичиг байв. Полунин гэрээнд гарын үсэг зурсны дараа Мирон багавтар чемодантай зүйлийг түлхэж өглөө. Полунин онгойлгож үзвэл нямбайлан багцалж боосон зуун долларын дэвсгэртүүд байлаа.

-Тохиролцсоны дагуу энд найман зуун мянган доллар байгаа...

Полунин мөнгийг бодлогошрон харж байтал Мирон түүнийг харж байснаа чемоданыг хааж цоожлов.

-Би чамайг ойлгож байна гэж Мирон гашуунаар инээмсэглээд энэ новшийн цааснуудын төлөө хэрхэн хэцүү зовлон амсаж ирснээ чи бодож байгаа бололтой гэлээ.

Полунин хариу хэлэлгүй дуугүй бодлогошрон суусаар байв.

-Гэвч чамд нэг зүйлийг хэлье гэж Мирон үргэлжлүүлэн хэлээд тийм ээ. Энэ мөнгө чамд аз жаргал авчрахгүй. Гэвч чиний хүүгийн ирээдүйн амьдралд тус болно. Чи хэний төлөө амьд явааг чинь ойлгож байна. Тэр хүнд чинь хэрэг болно. Түүнээс гадна чи Самбистын төрөл төрөгсдийг мартаж болохгүй нь мэдээж гэлээ.

-Дотно үг хэлсэнд чинь баярлалаа гээд Полунин дахин чемодан руу ширтсэнээ энэ бол чиний надад өгөх юм бүгд биш гэдгийг мэдэж байгаа биз дээ гэж асуулаа.

Мирон дуугүй толгой дохив.

-Тийм ээ. Би санаж байна. Би энэ чиглэлээр ажиллаж байна. Тэгэхлээр би боломж гармагц л чам руу ярина. Одоо чи нэг тийшээ явж амрах хэрэгтэй. Тухайлбал Францад ч болно. Ницца бол манай Сочигоос дугуугүй сайхан амралтын газар гэлээ.

Полунин чемоданаа авч ресторан руу бууж хүүгийнхээ дэргэд очиж суулаа. Хүү нь тахианы мах, шарсан алимтай амтархан идэж суув.

-Аав аа наана чинь юу байгаа юм бэ? гэж хүү нь чемодан руу нь зааж асуулаа.

Владимир инээмсэглэн:

-Чиний ирээдүй байгаа юм гэж хариуллаа.

-Тийм үү? гэж хүү нь гайхан асуугаад нүд нь сэргээд ирлээ. Тэгснээ тос болсон гараа цаасаар арчаад:

-би харж болох уу? гэж асуув.

-Болохгүй. Хүү минь гэж Полунин инээд алдан хариулаад, ирээдүйгээ урьдчилан харж болдоггүй юм. Харин надад ирээдүй бий гэж итгэж явах хэрэгтэй гэлээ.

Төгсгөл бүлэг

Францын өмнөд нутгийн амралтад амарсан долоо хоног маш хурдан өнгөрлөө. Тэд Марсель болон Тулон хотоор орж Полунин хүүгээ дагуулан эх газар руу чиглэн Европ орж Париж, Мадрид, Лондон хотуудаар аялав.

Сүүлийн жилд хүүхэд асрах уйтгартай баргар газар амьдарч байсан Антон толгой нь эргэм сайхан юм үзэж явлаа. Гайхмаар сонин сэтгэгдэлтэй үлдсээр байв. Жаал хүү эхлээд танил бус амьдралын содон гоё үйл явдлуудаас болж гайхан самгардаж амархан ядарч байсан юм. Гэвч Антон аажмаар дасаж соёлтой амьдрал хөгжил дэвшил түүнд бүр таалагдаж гүнд нь өөрийн эрхгүй татагдан орж байв. Энэ бүх хугацаанд Владимир хүүгээ анхааралтай ажиглан сэтгэл санаа нь улам өөдрөг болж хөгжилтэй сэргэлэн болж байгааг ойлгон баярлаж байлаа. Хүү нь аажмаар гэсэж байгаа мөс шиг уяран дуугүй дүнсгэр байдлаасаа өөрчлөгдөн хөгжилтэй яриа хөөрөөтэй сониуч зантай хүүхэд болон хувирч байв. Бусад хүүхдүүдийн нэгэн адил тэрээр эцгээсээ ялгаатай нь орчиндоо хурдан дасаж харийн хэл яриаг хурдан сурч байв. Тухайлбал Полунин Франц хэлийг арай ядан сурахыг оролдож байсан юм. Энэ бүх хугацаанд Полунин Орос руу байнга утасдаж төрөлх хотынхоо байдлыг сонирхдог байв.

Полунингийн гадаадад гарч явсны дараа Сатаров эдийн засгийн гэмт хэргийн учир таван жилийн ял авчээ. Өөр төрлийн зүйл анги түүнд өгч чадаагүй байна. Харин Романенков үйлдсэн хэргийнхээ төлөө долоон жилийн хорих ял авчээ. Түүнийг захиалгат аллагын гол буруутан гэж шүүх баталж чадаагүй бөгөөд Полунингийн бодож байсанчлан золиосны хүн болжээ. Петров, Лобников хоёрыг мөрдлөгийн ажилд тусалсан гэж хөнгөлөн тэнсэн өгч хөрөнгөний зарим хэсгийг нь хураажээ. Харин хэрэг явдалд оролцогчид хамгийн багаар хэлмэгдсэн байна. Мужийн дэд захирагч Симонов, дэд хурандаа Бирюков нар өөрийн хүсэлтээр халагдан тэтгэвэртээ суужээ. Удалгүй мужийн захирагчийн сонгууль болж шинэ хүн сонгогджээ. Энэ хүний сонгуулийн сурталчилгаанд Томашевский багагүй мөнгө зарцуулсан байх гэж ярилцдаг ажээ.

Гэвч Полунин сонирхолтой гол мэдээг Мироноос хүлээн авсан байна. Энэ мэдээг түүний хилийн чанад гарсны дараа гурван сар болоод байхад авчээ. Владимир Швейцарын Канна хотоос дөнгөж буцаж ирээд байв. Тэд ердийнхөөрөө “Эльсинор” зочид буудалдаа байрласан ажээ. Хэдийнээ бүр орой болсон байлаа. Тэд тэндхийн жижигхэн ресторанд хооллоод өдрийн явдалдаа ядарсан Антон хүү орондоо ороод байтал хаалга тогших чимээ дуулав.

Полунин хаалга онгойлгож өгвөл босгон дээр дөч дөчин таван насны гэмээр нэгэн махлаг эр зогсож байлаа. Түүний бага зэрэг шингэрч байгаа буржгардуу хар үсээ эмх замбараагүй засуулсан нь эндхийн гудамжны уран зурагчинтай төстэй болгожээ. Хувцас нь ч гэсэн тун энгийн. Чөлөөт эсгэлттэй цайвар өмд, зузаан даавуун урт хүрэм, бага зэрэг үрчийсэн цамц өмссөн нь жирийн нэгэн франц хүнтэй төстэй. Гэтэл ярьж эхэлтэл нь өөрийн нь эх орон нэгт нь байна гэж Полунин ойлголоо.

-Сайн байна уу Владимир Иванович хэмээн үл таних эр мэндлээд, миний нэрийг Макс гэдэг гэв.

-Оройн мэнд гэж Полунин юу гэхийг нь хүлээн мэндлэв.

-Намайг Мирон явуулсан гэж Макс хэллээ.

-Ор ор гэж Полунин хэлээд зочиндоо зай тавьж өгөв.

Макс үүдний өрөөнд орсон боловч цаадах өрөөнд оролгүй зогсоод:

-Хүү чинь унтаж байна уу? гэж асуув.

-Тийм ээ гэж Полунин толгой дохив.

-Тэгвэл одоохон явах хэрэгтэй. Таны тэр эрж байгаа хүн одоо Антиб хотын нэгэн зочид буудалд байна. Хэрэв та бодлоо өөрчлөөгүй бол тэр хот хүртэл дөчин минут яваад хүрнэ.

-Би бодлоо өчүүхэн ч өөрчлөөгүй гэж Полунин шийдмэг хариулав. Тэгснээ пиджакаа өмсөж эргэж хүүхдийн өрөө рүү орж хүү нь бөх нойрсож байгааг мэдлээ.

Хоёр минутын дараа тэр хоёр зочид буудлын арын хаалгаар гарч хар ногоон өнгийн “Пежо” машинд орж суув. Жолооны ард суусан Макс машины хурдыг нэмж тун чадварлаг жолоодож явлаа. Тэд замдаа бараг юу ч ярилцсангүй. Гучин минутын дараа тэд амралт сувиллын хот “Антиб” хүрч ирээд “Лapidус” буудлын гурван давхар байшингаас холгүй машинаа зогсоов. Макс машинаа дөнгөж зогсоомогц хаанаас гарч ирсэн нь үл мэдэгдэх нэгэн өндөр залуу хүрч ирээд Макст хандан

-Үйлчлүүлэгч маань гучин хоёрдугаар өрөөнд байна. Усанд орж байгаа бололтой. Буудлын гурван хүн гурвуулаа доор байгаа гэлээ.

-Ойлголоо гэж Макс толгой дохиод чи явж болно гэв. Тэгснээ машины нууц хайрцгийг онгойлгон нэгэн ууттай юм гаргаж ирээд Полунинд өгөв.

-Энэ чинь юу юм бэ? гэж Полунин гайхан асуув.

-Энэ бол таны ажилд чинь хэрэг болох зүйл байгаа юм. Энд нүдний хар шил, хиймэл сахал, дугуй малгай байгаа. Тохиолдлоор таныг таних хүн тааралдаж юу магад. Бас хаалга онгойлгох дэгээ түлхүүрүүд, дуу намжаагчтай “Беретта” гар буу байгаа гэв.

Полунин хариу хэлэлгүй хиймэл сахлаа нааж дугуй малгай өмсөөд, нүдний шилийг зүүв. Тэгээд уутан дотроос гар бууг гарган замгийг нь сойгоод пиджакныхаа дотор талд тэлээндээ хавчууллаа. Дэгээ түлхүүрүүдийг халаасандаа хийгээд Полунин машинаас гарав.

-Би танд туслах уу? гэж араас нь Макс асуув.

-Хэрэггүй.

-Ямар ч байсан би эндээ хүлээж байя гэж Макс хэлэв.

Холдож яваа Полунин түүний үгийг сонссонгүй. Тэрээр арын хаалга дамжин байшинд орж очлоо. Гуравдугаар давхарт гарвал тэнд хэн ч байсангүй. Полунин яаралгүй алхалсаар гучин хоёрдугаар өрөөнд очиж халааснаасаа дэгээ түлхүүрүүдийг гарган хаалгыг чимээ гаргалгүй амархан онгойлгов. Полунин гар буугаа гаргаад үүдний өрөөнд сэмхэн орвол бас хэн ч байсангүй. Өрөөн дотор нам гүм байх агаад усанд орох өрөөнөөс ямар нэгэн хөгжмийн ая намуухан сонсогдоно. Том өрөө рүү нь шагайвал тэнд бүгд нам тайван учир Полунин халуун усны өрөө рүү очиж хаалганд нь хүрч чагнав. Тэндээс найрал хөгжмийн яруу тод дуу сонсогдох ажээ.

Полунин өрөөний хаалгыг хүчтэй угзран онгойлгоод гар буугаа буудахад бэлэн онилж бариад орж явчихлаа. Усны тэвшинд хэвтэж байсан Малеев мөн адил маш хурдан сэхээ авч дэргэд нь байгаа жижигхэн ширээн дээр хөгжмийн дэргэд тавиастай байсан гар буу руугаа сарвайсан боловч нэгэнт хожимдсоноо мэдлээ. Тэрээр өөр рүү нь онилоостой байгаа бууны ам руу айн ширтэж байв.

-Бүү хөдөл! гэж Полунин тушаагаад бууныхаа амыг толгой руу нь онилов.

Малеев ар тийшээ налан хөдөлгөөнгүй болоод амандаа орсон усыг хана руу тургилаа.

-Чөтгөр ав. Гайтай юм!

-Тийм ээ гэж Полунин үгийг нь дэмжээд ямар ч байсан гурав дахь оролдлогоороо чамд хүрч чадлаа гэв.

Малеев түүнийг анхааралтай ширтэж байснаа:

-Би чиний анхны оролдлогооны дараа бас тэгж бодож байсан юм гээд мөрнийхөө шархны сорвийг зааж хэллээ. Тэгснээ үргэлжлүүлэн:

-Энэ бол чиний тавьсан тэмдэг. Би чиний эхнэр, найзыг алсны дараа машин дотор амьд үлдсэн хүүг чинь чинийх гэж мэдсэний дараа чамайг заавал устгах нь зүйтэй юм гэж ойлгосон. Эс тэгвэл би бүх насаараа чамаас зугтаж явах болно. Учир нь чи хэзээ ч намайг мартаггүй нь тодорхой.

-Чи зөв ярьж байна гэж Полунин үгийг нь батлан хэлээд, би чамайг аль эртнээс хайж байсан юм. Чамайг олохын тулд би юугаа ч хайрлаагүй, цаг, мөнгө, хүч бүхнээ зориулсан юм гэв.

-Эцсийн эцэст оллоо шүү дээ гэж Малеев гашуунаар инээмсэглэн хэлээд би чиний өмнө нүцгэн ямар ч хамгаалалтгүй хэвтэж байна. Ийм байдалд орно гэж би хар дарсан зүүдэндээ ч үзээгүй гэлээ.

-Чиний тэр зүүдийг чинь би нулимж орхиё. Харин миний хүү бүх насныхаа туршид хар дарсан зүүдэндээ чиний алуурчин царайг үргэлж харж цочин сэрж байх болно. Өөрийн ээжийг алсан хүний царайг зүүдлэн харж хар даран сэрж байх болно.

-Энэ бол тохиолдол байсан юм. Эмгэнэлтэй аймшигт явдал болсон юм. Тэр машинд чиний

эхнэр хүүхэд сууж явсныг бид мэдээгүй. Би үнэн юм ярьж байна хэмээн Малеев балмагдан ярилаа.

-Одоо хэдийнээ энэ чинь хамаагүй болсон. Одоо чи энэ хэргийнхээ шийтгэлийг авах болно.

Малеев үрчийн инээмсэглээд:

-Бирюковын зөв байсан юм. Чам руу нисэж ирж яваа сумтай ярьж тохиролцдоггүй юм. Харин чадвал бултаж чадах хэрэгтэй. Би чиний сумнаас хоёр дахин бултаж чадсан. Гурав дахь удаагаа хувь заяа минь эргэжээ.

Полунин хөмсөг зангидан:

-Чи миний эхнэр, Самбист хоёрыг алсныхаа дараахан Бирюковтой ярьсан уу?

-Тийм ээ гэж Малеев батлан хэлээд, харин энэ бүх заваан үйл явдлыг хэн эхлээд үүсгэсэн юм бэ? Чи энэ бүхнийг Сатаров хийсэн гэж бодож байна уу? Тэр цагдаанцарын зааваргүйгээр тэр юу ч хийхгүй байсан юм.

-Тэр Бирюков та нарын захиалагч байсан юм уу?

-Тэр аллагын захиалгыг өөрөө хийгээгүй. Романенковоор дамжуулж хийлгэсэн юм. Романенков ер нь бүх муу юмыг хүнээр хийлгэдэг хүн. Өөрөөр хэлбэл хүний гараар могой бариулж сурсан хүн юм.

-Чи яаж түүний гарт орсон юм бэ? гэж Полунин асуув.

-Би Коля Решетогийн дуудлагаар хотод ирэхэд биднийг түүнд барьж өгсөн юм.

-Хэн барьж өгсөн гэж?

Малеев Полунинг зальтайгаар ширтэн харсанаа:

-Намайг олоход тусалсан тэр хүн чинь.

-Мирон уу? гэж Полунин гайхан асуув.

-Өөр хэн байх юм? Коля Решето аллага үйлдэх гэж байгааг тэр мэдсэн юм. Тэгээд ятгаж хориглох гэтэл Коля Решето үгийг нь хүлээж аваагүй юм. Тэгэхлээр нь Мирон заль гаргахаар шийдсэн. Тэгээд цагдаагийн газар мэдэгдсэн учир бидний энд ирэхэд цагдаагийнхан хүлээж байсан юм...

-Цааш нь юу болсон бэ? гэж Полунин асуув.

-Цааш нь уу гээд Малеев инээд алдаад, цааш нь Бирюков надад ажил санал болгосон юм. Би зөвшөөрөхөөс өөр аргагүй болсон. Үнэндээ хэнийг цааш нь харуулах нь надад ямар ялгаа байх вэ дээ. Одоогийн захиалагчийг уу эсвэл түрүүчийнхийг нь үү ялгаагүй. Гол нь мөнгө л

илүү төлж байвал болох нь тэр. Чи намайг ойлгож байна уу. Би бүх насаараа энэ бузар ажлыг хийж мөнгө цуглуулж байсан. Би аль хэдийнээс тэр дээрэмчин Орос орноос зайлж эцсийн эцэст хэвийн оронд очиж жирийн иргэн шиг амьдрахыг хүсэж байсан юм. Энэ мөрөөдөлдөө хүрлээ гэж бодож байлаа. Гэтэл чи намайг олж ирлээ. Миний хийсэн нүгэл энд учирдаг байна гэж ярив.

Полунин хуруугаа бууныхаа гохны хоосон явалтад хүргэлээ.

-Хүлээж бай! гэж Малеев хэлэв. Тэрээр нүднийхээ булангаар хөгжим рүүгээ харсанаа:

-Энэ хөгжмийн аянд үхэхэд тийм ч муу биш. Би Моцартад дуртай. Түүний хөгжмийн ая уулын тунгалаг горхи шиг тунгалаг байдаг. Дууг нь арай чангална уу? гэж хүсэв.

Полунин Малеевын зүг буугаа онилсоор хөгжимд нь ойртож очоод гараа сунгах үед сүүлчийн мөчид өөрийн амийг аврах оролдлого хийж үл мэдэгдэм хөдөлгөөн хийж түүн рүү үсрэхийг завдлаа. Полунин огцом хөдөлгөөнөөр хөгжмийг нь усны тэвш рүү нь түлхэж унагаав. Дараачийн агшинд усан дотор цахилгааны богино холбоо үүсэж писхийх чимээ гарч усан дээгүүр уур утаа савслаа. Уснаас гарч амжаагүй Малеевын ам нь ангалзан нүд нь бүлтийж орхих нь тэр. Түүний гар нь чичигнэн салганаж усны тэвшнээс зууран авахад нь савны паалан ховхрох мэт санагдлаа. Энэ явдал хэдхэн мөчийн дотор болж Малеев савны ирмэгнээс барьсан чигээрээ эвгүй байдалтай гөлөрч орхилоо.

Полунин буугаа өмднийхөө бүсэнд хавчуулаад алчуур гарган ванны өрөөнөөс гарлаа. Тэгснээ эргэж үхсэн Малеевыг дахин нэг хараад өрөөний нь хаалгыг хааж хаалганы бариулыг хичээнгүйлэн арчлаа. Байрнаас нь гарахдаа мөн адил хаалганы нь бариулыг сайтар арчив.

Минутын дараа тэрээр арын хаалгаар гудамжинд гараад Максын “Пежод” орж суув.

Макс юм асуулгүй машинаа асааж хөдөллөө. Тэд бүр хотын гудамжинд орсны дараа,

-За яав? гэж Макс асуув.

-Бүх юм хэвийн гэж Полунин хариуллаа.

Полунин гар буугаа гарган сайтар арчиж цэвэрлээд Максын хажууд тавиад:

-Энэ хэрэг болсонгүй гэж хариулав.

-Яаж бүр үү? гэж Макс гайхаж асуулаа.

-Бүр гэж Полунин хариулаад манай тэр нөхөрт золгүй явдал тохиолдсон. Цахилгаан хэрэгсэл нь устай тэвшинд нь уначихсан. Тэр хүн хөгжимд маш их дуртай харин хүмүүст маш дургүй хүн байсан юм гэв.

Макс хариуд нь мушийн инээмсэглэх аядав.

-Тэгвэл оршуулгын хөгжимд бас дуртай байх нь ээ...

Полунин сахлаа ховхлон авч буу, дугуй малгай, нүднийхээ шилний хамт нууц хайрцганд хийгээд тамхиа гарган асаав.

Макс дахин юу ч асуусангүй. Тэд эргэж Канна орох үед Полунин машинаа зогсоохыг хүслээ. Тэрээр

-Далайн эргээр бага зэрэг зугаацмаар байна гэж хэлэв.

Макс толгой дохилоо. Владимир машинаас гарах үедээ:

-Би танд хөлс төлөх үү? гэж асуув.

Нөгөөх нь толгой сэгсэрлээ.

-Надад урьдчилан сайн хөлс төлсөн. Миний босс тэр алуурчинтай урьдын тооцоотой байсан юм билээ...

Макс явсны дараа Полунин далайн эргээр үүр цайтал дэмий явлаа. Тэрээр өөрийгөө эзэмдэн өнгөрсөн явдлуудыг эргэцүүлэн бодохыг оролдож явав. Гэвч ямар нэгэн сэтгэлийн хүчтэй хөдөлгөөн байхгүй байгаа юм шиг байхад нь өөрийгөө гайхаж байв.

Эхнэр, нөхдөө алуулсан өстнөөсөө хариугаа авч түүнийг хөнөөж эцсийн зорилгоо биелүүлсэн явдал ямар нэгэн ханамж болон харамсал төрүүлэхгүй байв. Харин сэтгэлийн нь гүнд хөндий зай бий болчихсон юм шиг мэдрэмж төрж байлаа.

Гэвч Полунин гэнэтхэн өнгөрсөн бүх хугацаанд зөвхөн энэ өш хонзонгоо авахын төлөө амьдарч байсан мэт санагдлаа. Одоо энэ зорилгоо биелүүлсний дараа хөнгөн харамсал ч юм уу балмагдал ч гэмээр мэдрэмж төрсөөр байв. Гэвч тэр дороо хилийн чанад гарахын нь өмнө Мироны хэлсэн үг санаанд нь орлоо.

“Мироны зөв гэж Полунин бодоод, би хэний төлөө амьд явах ёстой вэ? Тийм ээ тэр хүн чинь надад байгаа. Миний хүүд надад тохиолдсон шиг ийм зовлон тохиолдох ёсгүй. Би үүний төлөө амьд явж ажиллах ёстой”, “Тэр миний бяцхан хүү багагүй зовлон үзлээ. Миний энэ өнгөрөөсөн будилаантай явдал хүүд минь нөлөөлөх ёсгүй” гэж бодсоор явав.

Тэрээр халааснаасаа тамхиа гаргахдаа Максын өгсөн дэгээ түлхүүрүүд байгааг мэдлээ. Полунин түлхүүрүүдийг харж инээмсэглэн гартаа эргүүлж байснаа холын хол далай руу чулуудаж орхилоо. Тэгээд зочид буудал руугаа эргэж алхлав. Тэрээр байрандаа орж цонхны дэргэд зогсож тамхиа татаж байтал хүүгийнхээ сэрж орон дээрээ хөлбөрөхийг мэдлээ. Аав нь эргэж Антон руу харж инээмсэглэвэл хүү нь хэдийнээ орон дээрээ сандайлан суучихаад бяцхан бөөрөнхий нударгаараа нүдээ нухалж сууна.

-Өглөөний мэнд, хүү минь гэж Владимир хэлээд, сайхан нойрсов уу? гэж асуулаа.

-Сайхан нойрслоо гэж хүү нь хариулаад, өнөөдөр бид хаашаа явах вэ? гэж асуув.

-Чиний л хүссэнээр болно. Усан онгоцонд суугаад Итали ч орж болох юм. Машинаар Голланд

ч орж болох юм...

-Аав аа. Бид хэзээ Орос руу гэртээ харих юм бэ? Бид хоёр гэртээ харина биз дээ? гэж хүү нь асуух нь тэр.

Полунин гуниглан инээмсэглээд эргэж цонх руу харсанаа:

-Мэдээж гэртээ харих болно. Заавал эргэж харина. Тэнд чинь бидний найз нөхөд үлдсэн шүү дээ. Бид чинь орос хүмүүс. Орос хүн зөвхөн Орос оронд л жинхэнэ сайхан амьдарна гэж хэллээ.

Орос хэлнээс орчуулсан:

Мухагчин С.ДЭМБЭРЭЛ

Бэрх хотхон 2005 он

Зохиолын тухай

Полунин тэнгисийн цэрэгт алба хаасан, хэсэг зуур нарсанд өнгөрөөсөн, хориотой бизнес хийж явсан зэргийг нь тооцож үзвээс эрүүгийн ертөнцөд муугүй нэр нөлөөтэй цаашид овсгоо самбаатай ухаалаг зөв хөдөлж дэвжин дээшлэх чадал бүхий нэгэн юм. Гэвч Владимир Полунин хэзээ болтол хууль хүчний байгууллагаас болгоомжлон цэрвэж явах билээ. Тэгээд ч ойр дотныхоо хүмүүсийг ч хайрлах хэрэгтэй. Ингээд тэрээр тогтсон журам, зөвшөөрлийн дагуу ил ажиллахаар шийджээ. Гэвч бизнест тайван бөгөөд шулуун зам байдаггүй. Тэдний нэгэн гишүүн болсон газрын тосны нэгэн компанийн хувьцаа эзэмшигчид балар шугуйн араатнууд мэт арсалдан тэмцэлдэх болжээ. Эцсийн эцэст тэд хөлсний алуурчдаас тусламж авдаг болов. Үүний үр дүнд Владимир хуулиар хамгаалагдаагүй хүн болж хувиран зарим хамтран зүтгэгч хувь нийлүүлэгчид нь цагдаагийн газартай хуйвалдан араас нь намнах болжээ.

Зөвхөн өөрт нь бус түүний бяцхан хүүд нь хүртэл аюул заналхийлэв. Гэвч хуучны дайчин усан цэрэг зовлон үзэж зоонд суусан хашир бөгөөд ухаалаг зоригтой эр өөрийн төрөлхийн шийдмэг тууштай зангаараа тэдний цохилтыг тэсвэрлэж чадсанаар үл барам хариу цохилтыг амжилттай өгч ялагч болж чадсан ажээ.

Table of Contents

Оршил бүлэг
Нэгдүгээр бүлэг
Хоёрдугаар бүлэг
Гуравдугаар бүлэг
Дөрөвдүгээр бүлэг
Тавдугаар бүлэг
Зургаадугаар бүлэг
Долдугаар бүлэг
Наймдугаар бүлэг
Есдүгээр бүлэг
Төгсгөл бүлэг